СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

# СҮХБААТАР ДҮҮРГИЙН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО

Улаанбаатар хот
2022 он

## ДҮҮРГИЙН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО

2022 оны 11 дүгээр сарын 14 Улаанбаатар хот

| № | Агуулга | | Бүгд | НЭГ. "Ковид-19" цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого | ХОЁР. Хүний хөгжлийн бодлого /эрүүл мэнд, боловсрол/ | ГУРАВ. Эдийн засгийн бодлого /өсөлтийг өрх бүрд/ | ДӨРӨВ. Засаглалын бодлого /нээлттэй хариуцлагатай дүүрэг/ | ТАВ. Ногоон хөгжлийн бодлого /амьдрахад таатай дүүрэг/ | ЗУРГАА. Нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлого |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Нийт заалтын тоо** | | 253 | **5** | **84** | **7** | **101** | **46** | **10** |
| 2 | "Үр дүнтэй" | 100% | 208 | 3 | 72 | 7 | 73 | 44 | 9 |
| 3 | "Тодорхой үр дүнд хүрсэн" | 70-99% | 32 | 2 | 7 | | 23 | | |
| 4 | "Эрчимжүүлэх шаардлагатай" | 31-69% | 10 | | 3 | | 4 | 2 | 1 |
| 5 | "Үр дүнгүй" | 0-30% | 1 | | | | 1 | | |
| 6 | Биелэлт гаргаагүй | | 2 | | 2 | | | | |
| | Нийт хувь | | 95.7% | **94.0%** | **94.0%** | **100.0%** | **94.0%** | **97.0%** | **95.0%** |

# СҮХБААТАР ДҮҮРГИЙН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2022 оны 11 дүгээр сарын 11 Улаанбаатар хот

| № | Зорилт /бодлогын үндэслэл/ | Төсөл, арга хэмжээ | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | | 2022 онд шаардлагатай хөрөнгө | | Хэрэгжүүлэх байгууллага | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хөрөнгийн хэмжээ /мянган төгрөг/ | Санхүүгийн эх үүсвэр | Үндсэн Хамтрагч | |
| | | | | | 28,977,751.00 | | | |
| НЭГ. "КОВИД-19" ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ,НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | | | | | | | | |
| 1.1 Иргэд олон нийтийг "Ковид-19" цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж, нөөцийн бэлэн байдлыг хангана. | | | | | | | | |
| 1 | НЗДҮАХ-1.1.1 ДЗДҮАХ-1.1.1 | Цар тахлын үеийн эрсдэлийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, ААНБ-ын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад дэмжлэг үзүүлнэ. | Худалдаа, үйлчилгээний 2800 гаруй ААНБ-ын үйл ажиллагаанд ариутгал, халдвар хамгаалал, үйлчилгээнд тавигдах тусгай нөхцөл шаардлагыг мөрдүүлэн ажилласан. | Худалдаа, үйлчилгээний 2800 гаруй ААНБ-д цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээлэл хүргүүлж, хяналт тавьж ажилласан байна. | 3,000.00 | Дүүргийн төсөв | ХХҮХ МХХ, ЦГ, ОБХ, ХЗДАА | 100% |
| | | НОК-ын шуурхай штабын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 20 дугаартай албан бичгийн хүрээнд дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран 2022 оны 01 дүгээр сарын 26-31-ний өдрүүдэд нийт 14 зах, худалдааны төвийн үйл ажиллагаанд дүүргийн Онцгой комиссын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 Албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. Шалгалтад хамрагдсан зах, худалдааны төвд шаардлага хангасан халдваргүйтгэлийн бодисоор цэвэрлэгээ үйлчилгээ хийх, агаар сэлгэлтийг 2 цаг тутамд 10-15 хүртэл минутаар хийх, хүн хоорондын зай бариулах, шаардлагатай тохиолдолд дүүргийн шуурхай штабтай холбогдон эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ДОК-ын 01 Албан даалгавар, НОК, НМХГ-аас гаргасан зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. ААНБ-ууд Цасны хачир ХХК-иар гэрээний дагуу ариутгал халдваргүйтгэлийг хийлгүүлж, хог тээврийн компаниар хуваарийн дагуу хогоо тээвэрлүүлж хэвшсэн байна. Зөвлөн туслах хяналтын ажлын явцын мэдээг өдөр бүр дүүргийн Шуурхай штабт мэдээлж, дүүргийн sbd.gov.mn цахим хуудас болон пейж хуудсуудаар сурталчлан ажилласан.<br>Худалдаа, үйлчилгээний салбарын нийт ажиллагсдыг дархлаажуулалтын бүрэн тунд хамруулах ажлыг эрчимжүүлж, УОК, НОК, ДОК-оос гаргасан үүрэг чиглэл, зөвлөмжийг ААНБ-дад СБД хоол үйлдвэрлэл, үйлчилгээ фэйсбүүк групп, СБД-Худалдаа, СБД-Зах, худалдааны төвүүд, СБД-үйлдвэрүүд, SBD food чат групп, ХХҮХ-Хороод бүлэг, СБД-ийн 1-10 дугаар хороо, Хойд хороод 11-20 дугаар хороодын мессенжерийн бүлгүүдээр хүргүүлж, дархлаажуулалтын ач холбогдол, үр нөлөөг байнга сурталчлан, дүүргийн дархлаажуулалтын цэгүүдийн мэдээллийг тогтмол хүргүүлэн ажиллаж байна. Томоохон зах худалдааны төв, үйлчилгээний байгууллагуудын ажиллагсдын 90 гаруй хувь нь дархлаажуулалтын 3-р тунд хамрагдсан. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | | Гэр хорооллын, айл өрх, нийтийн эзэмшлийн бохирдсон хөрстэй гудамж талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг гүйцэтгэнэ. | Гэр хороололд 19957 айл өрхийн жорлон, бохирын цооног байна. | Хөрсний бохирдол багасаж халдварт өвчнөөс урьдчилан сэргийлсэн байна. | 700,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |
| | | " Хаврын ариутгалыг 2 багц болгон тендер болгон зарлан "Улаанбаатар ариутгал" ХХК нь Гэр хорооллын айл өрх, нийтийн эзэмшлийн бохирдсон хөрстэй гудамж талбайд ариутгал халдваргүйтгэл хийх ажлын хүрээнд 14639 нүхэн жорлон, 10173 бохирын цооног, ойролцоох 29278 мкв$^2$ талбайд нийт 19 ажилтан, Жавелион, Гипохлорид кальци гэсэн бодисууд болон тоног төхөөрөмжүүдийг ашиглан халдвар хамгааллын дэглэм баримтлан гүйцэтгэн хяналт тавин ажилласан болно.<br>Баян дэмбэрэл ХХК нь Гэр хорооллын айл өрх, нийтийн эзэмшлийн бохирдсон хөрстэй гудамж талбай үерийн далан, гуу жалга, шар усны үертэй холбоотой хальж урссан 169,173м2 нийтийн эзэмшлийн талбайд ариутгал халдваргүйтгэл хийх ажлыг 2022 оны 05-р сарын 03-ны өдрөөс 2022 оны 05-р сарын 10-ны өдрүүдэд ариутгалын 5 баг томилон, Зориулалтын мананцар үүсгэгч 5 тонн хэмжээтэй цистерн автомашин, 5 суудлын жижиг тэрэг, 1 портер, 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ.<br>Намрын ариутгал халдваргүйтгэлийг Баяндэмбэрэл ХХК нь ариутгах шаардлагатай нийт гэр хорооллын 14007 айл өрхийн бохирын цооног, гуу далан жалга 169,179м2 талбай, хүүхдийн тоглоомын талбай 187960м2 талбайд ариутгал халдвагүйтгэлийг 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс, 10 дугаар сарын 25-ны өдрийн хооронд ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэсэн болно. Нийт 700,000,000 төгрөгийн санхүүжилт зарцуулсан. | | | | | | |
| 3 | | Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, автобусны буудлуудад тусгай зориулалтын ариутгал халдваргүйтгэл хийнэ. | Сүхбаатар дүүргийн 1-20 дугаар хороодод нийт 21 рейсээр 105 тонн ариутгал халдваргүйтгэлийн уусмалаар 336942.0м.кв талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн. | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлсэн байна. | 10,116.00 | Дүүргийн төсөв | ТНААХ Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ | 100% |
| | | Хариуцсан бүсийн хогийн сав, бункерын ариутгал халдваргүйжүүлэлтийг 2022 оны 03 дугаар сараас эхлэн Сүхбаатар дүүргийн 4, 5, 6, 7, 8, 10, 11, 12, 13, 18, 19, 20 дугаар хороодын нутаг дэвсгэрт байрлах, нийтийн эзэмшлийн хогийн сав, бункерын ариутгал халдваргүйжүүлэлтийг нийт 6 удаа зохион байгуулж ажилласан. | | | | | | |
| 4 | НЗДҮАХ 2.1.1.1, ДЗДҮАХ-1.1.2, 1.1.3 | Цочмог халдварт өвчин, шинэ сэргэж буй халдварт өвчний тандалт, сэргийлэлт, урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, өвчлөл голомтлон гарсан үед хариу арга хэмжээг шуурхай зохион | Дүүргийн Засаг даргын 8 удаагийн захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын 3 удаагийн тушаалаар нэг удаагийн хамгаалах хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлсэн. | Шуурхай хариу арга хэмжээний багийг сургаж дадлагажуулах арга хэмжээ зохион байгуулж, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлсэн байна. | 30,000.00 | Дүүргийн төсөв | НХХ ЭМТ, ОБХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах, чадавхыг бэхжүүлнэ. | | | | | | |
| | | Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, идэвхжил, дэгдэлтийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 удаа тодотгов. Дүүргийн хэмжээнд коронавируст халдвар батлагдсан 56668 тохиолдол бүртгэгдсэнээс 56458 тохиолдол эдгэрч, 125 эмнэлгийн болон гэрийн нас баралт бүртгэгдэж, 85 тохиолдол гэрээр хянагдаж байна.<br>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/282, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/96 дугаар тушаалын дагуу Шангри-ла резиденсид 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс 6 дугаар сарын 30-ны хугацаанд Коронавирусийн халдварын эсрэг дархлаажуулалтын түр цэг ажиллуулж, 176 иргэнийг Ковид-19 халдварын эсрэг дархлаажуулалтад хамруулсан.<br>Сувиллын газарт 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд УОК, ЭМЯ-ны шийдвэрийн дагуу гадаад улс орноос ирж, тусгаарлалтын хугацаанд Ковид-19 халдвар батлагдсан 120 иргэнийг хэвтүүлэн эмчилсэн.<br>Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 01 албан даалгаврын дагуу Сүхбаатар Эрүүл мэндийн төвд Молекул биологийн лаборатори шинээр байгуулж, 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд нийт 96033 ПГУ-ын шинжилгээ хийж, 7984 эерэг тохиолдол илрүүлсэн.<br>Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/521 дүгээр тушаалын дагуу ПГУ-ын шинжилгээний сорьц цуглуулах цэг болон Өрхийн эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан нийт 241606 иргэнийг шинжилгээнд хамруулсан. | | | | | | |
| 5 | | Халдварт өвчний хяналт, тандалт, сэргийлэлт, шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангана. | Халдварт өвчний хяналт, тандалт, сэргийлэлт, шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, бэлэн байдлын төлөвлөгөөний биелэлт 95%. | Шуурхай хариу арга хэмжээний багийг сургаж дадлагажуулах арга хэмжээ зохион байгуулж, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлсэн байна. | 80,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>ЭМТ, ОБХ | 100% |
| | | Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдал эрсдлийн шар түвшинд шилжүүлсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн төвийн шуурхай штабын төлөвлөлт, зохицуулалтын бүлгийн ажиллах түр журмыг Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны А/41 дүгээр тушаалаар батлан, холбогдох эмч, эмнэлгийн ажилтныг томилон үүрэгжүүлсэн. Ковид-19 халдварын тандалт шуурхай хариу арга хэмжээ, хүн амын нас хүйс эрүүл мэндийн эрсдэлд суурилсан эрт илрүүлгийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.<br>Дүүргийн хэмжээнд гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургууль зохион байгуулж, мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах алба хаагч, аж ахуйн нэгж байгууллага, иргэд, нийт 2500 гаруй хүн оролцсон.<br>55 сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар илэрсэн үед авах арга хэмжээний талаар 2 удаа сургалт зохион байгуулж, сурагчдыг хүлээн авах бэлтгэл хангах зөвлөгөө, зөвлөмж танилцуулсан. | | | | | | |
| ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО /ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ | | | | | | | | |
| 2.1 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, "ИРГЭН ТӨВТ" үйлчилгээг нэвтрүүлнэ | | | | | | | | |
| 6 | МУХТ-2.1.6, НХТЖҮЧ-2.11.1 НЗДҮАХ- | Дүүргийн Эрүүл мэндийн төвийг эрүүл мэндийн салбарт шинээр нэвтэрсэн оношилгоо, шинжилгээ, эмчилгээний | Дүүргийн төсвөөс 2020 онд 167,257.85 төгрөгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл олгосон. | Шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг үе шаттайгаар хангасан байна. | 200,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>ЭМТ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.1.8 ДЗДҮАХ-2.1.2 | техник технологи, шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангана. | | | | | | |
| | | Дүүргийн Засаг даргын 2022 оны А/171 дүгээр захирамжаар 20 хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 0-17 насны хүүхдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд шаардагдах 3 төрлийн 7,4 сая төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл шийдвэрлэсэн.<br>Шинээр баригдаж байгаа Нэгдсэн эмнэлэгт үйл ажиллагаа эхлүүлэхэд шаардлагатай угаалгын 6 нэр төрлийн 7 төхөөрөмж, гал тогооны 51 нэр төрлийн 95 ширхэг тоног төхөөрөмж, техник, хэрэгслийг нийт 500 сая төгрөгөөр худалдан авсан. | | | | | | |
| 7 | МУХТ-2.1.6, НХТЖҮЧ-2.11.1 НЗДҮАХ-2.1.6 ДЗДҮАХ-2.1.3 | Дүүргийн Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн дарга, Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нартай гүйцэтгэлийн 3 талт гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллана. | Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1333, дүүргийн Засаг даргын 2020 оны А/420 дугаар захирамжаар Бүрэн хангалттай, хангалттай үнэлгээгээр үнэлэгдсэн 16 Өрхийн эрүүл мэндийн төвд 2020 оны санхүүжилтийн 5 хувийн мөнгөн дүнгээр буюу нийт 193,879,600 төгрөгийн урамшуулал олгогдсон. | Гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэсэн байна. | 16,000.00 | Дүүргийн төсөв | НХХ ЭМТ, ӨЭМТ | 100% |
| | | Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Журам, гэрээний загвар шалгуур үзүүлэлт батлах тухай" А/104 дүгээр тушаал, нийслэлийн Засаг даргын 2021 оны "Гүйцэтгэлийн гэрээний дүнг батлах тухай" А/1007 дугаар захирамж, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны "Гүйцэтгэлийн гэрээ байгуулах тухай" А/95 дугаар тушаалын хүрээнд дүүргийн Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн дарга, 16 Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар гүйцэтгэлийн 3 талт гэрээ байгуулсан. Гүйцэтгэлийн гэрээний 2022 оны эхний хагас жилийн үнэлгээгээр А буюу Бүрэн хангалттай 6, В буюу Хангалттай 7, С буюу Ажил сайжруулах 3 Өрхийн эрүүл мэндийн төв байна.<br>Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/179 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/104 дүгээр тушаалын дагуу Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд дэмжлэгт хяналт хийх, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах эмч, эмнэлгийн ажилтны ажиллах журмыг Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны А/39 дүгээр тушаалаар шинэчлэн баталж, 2022 оны эхний хагас жилд 1 удаагийн дэмжлэгт хяналт, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн. | | | | | | |
| 8 | | Стандартын шаардлага хангасан байртай Өрхийн эрүүл мэндийн төвийн тоог нэмэгдүүлж, шинээр барих барилгын газрын асуудлыг шийдвэрлэнэ. | Дүүргийн 1, 2 дугаар хорооны "Ачит гар" Өрхийн эрүүл мэндийн төвийн шинээр баригдаж буй барилгын ажил 70%, 6 дугаар хорооны "Сайн наран" Өрхийн эрүүл мэндийн төвийн | 1 цогцолбор байр баригдах ажил эхэлсэн байна. | | | НХХ ЭМТ | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | барилгын ажлын явц 40%-ийн гүйцэтгэлтэй байна. | | | | | |
| | | Дүүргийн 2 дугаар хорооны Ачит гар Өрхийн эрүүл мэндийн төв, хорооны Цогцолбор шинэ барилгын ажлын гүйцэтгэл 100%, Улсын комисс хүлээж авахад бэлэн болсон.<br>Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 224 дүгээр албан бичгийн дагуу дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 306 дугаар албан бичгээр 11 дүгээр хорооны Өрхийн эрүүл мэндийн төвд шинээр цогцолбор байр барих хүсэлт уламжилсан.<br>Улсын төсвийн 37,637,295,879 төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2018 онд дүүргийн 6 дугаар хорооны Сайн наран Өрхийн эрүүл мэндийн төв, хорооны Цогцолбор барилгын ажлыг Тамгат тайж констракшн ХХК 40% гүйцэтгэж, зоорийн давхрын хана, хучилтын армартур, хэв хашмал угсрагдаж дууссан. Тамгат тайж констракшн ХХК нийт санхүүжилтийн 62%-ийг авсан болович тодорхойгүй шалтгааны улмаас барилга угсралтын ажлыг хаяад явсан тул Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас хуулийн байгууллагад шилжүүлсэн. | | | | | | |
| 9 | | Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн урсгал засвар хийх, тогтмол зардлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ. | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 14, 17, 19 дүгээр хорооны Өрхийн эрүүл мэндийн төвд 157,5 сая төгрөгийн санхүүжилтээр цэвэр усны шугамд холбох, сантехник, цахилгаан, дээвэр, дотор засвар, гадна тохижилтын ажил хийгдсэн. | Шаардлагатай Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн урсгал засвар хийж, тогтмол зардлыг шийдвэрлэсэн байна. | 320,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>ЭМТ | 100% |
| | | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/174, А/367 дугаар захирамжаар 1-10 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн барилгын засварт 500 сая төгрөг, 8 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвд 173 сая төгрөг шийдвэрлэж, засварын ажлыг гүйцэтгэсэн.<br>Дүүргийн Засаг даргын 2022 оны А/206, А/325 дугаар захирамжаар 17 дугаар хорооны Увидаст од Өрхийн эрүүл мэндийн төвийн байрны цахилгааны төлбөрт 15,567,226 төгрөгийг, 20 дугаар хорооны ӨЭМТ-ийн дээврийг 19,500,000 төгрөгөөр засварлаж эмнэлгийн хэвийн үйл ажиллагааг хангалаа. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 18 дугаар хорооны Гэрэлт манал Өрхийн эрүүл мэндийн төвийн сантехникийн засварын ажлыг дүүргийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэв. | | | | | | |
| 10 | МУХТ-2.1.26, НЗДҮАХ-2.1.5 ДЗДҮАХ-2.1.4 | Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд Онол практикийн хурал зохион байгуулах, судалгаа эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлнэ. | 2021 оны онол практикийн хуралд 17 илтгэл хэлэлцүүлсэн. | Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд Онол практикийн хурал зохион байгуулсан байна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>ЭМТ | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын 2022 оны А/99 дүгээр захирамжаар хүн амын өвчлөлийн бүтэц, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох, оношилгоо, эмчилгээний шинэ арга, технологийн үр дүнг хэлэлцүүлэх зорилгоор Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэндийн төвүүд, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эмч, мэргэжилтний дунд Онол практикийн хурал зохион байгуулж, судалгааны нийт 38 илтгэл хэлэлцүүлэв.<br>Эрүүл мэндийн төвийн төлөвлөгөөт 21 сургалтад 816, төлөвлөгөөт бус цагийн үеийн асуудлаар зохион байгуулагдсан 24 сургалтад 829, 6 удаагийн журнал клубт 113, нийт 51 удаагийн сургалтад 1742 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдсан. | | | | | | |
| 11 | МУХТ-2.1.19, НХТЖҮЧ-2.8.1, НЗДҮАХ-2.1.4 ДЗДҮАХ-2.1.5 | Идэвхтэй дасгал хөдөлгөөн, иог, бясалгал, чийрэгжүүлэлт, эрүүл зөв хооллолтыг дэмжих, сурталчлах төвийг нээж, иргэдийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлнэ. | ЭМС-ын 2020 оны А/38 дугаар тушаалаар батлагдсан "Нийгмийн эрүүл мэндийн төвийн дүрмийг батлах тухай" тушаалын дагуу бүтэц, орон тоог шийдвэрлэсэн байна. | Нийгмийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг эхлүүлсэн байна. | 50,000.00 | Дүүргийн төсөв | НХХ ЭМТ | 80% |
| | | Шинээр баригдаж буй Салбар амбулатори 1-ийн барилгыг түшиглэн Эрүүл мэндийг дэмжих төв байгуулахаар төлөвлөсөн ба уг барилга 2,6 тэрбум төгрөгийн өртөгтэй, 25мх15м хэмжээтэй 5 давхар, барилгын ажлыг 2020 оны 6 дугаар сараас эхлэн Кенжүки ХХК гүйцэтгэж байна. Барилгын карказ угсралт, шавар, өрлөгийн ажил дууссан, гадна тохижилт, дотор засал, цахилгаан, сантехникийн ажил үлдсэн. Барилгын ажлын явц 80%-тай байна.<br>2022 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Салбар амбулатори 1 болон Эрүүл мэндийн төвд 1,970 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалт хийхээр нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар 7 багц тендер зарлаж, гэрээ байгуулсан. | | | | | | |
| 12 | | Эрүүл мэндээ дээдлэгч байгууллага, өрх, иргэн шалгаруулна. | 2019 онд Эрүүл мэндээ дээдлэгч 3 иргэн, 3 өрх, 3 байгууллага шалгаруулсан. | Дүүргийн хэмжээний эрүүл мэндээ дээдлэгч байгууллага, өрх, иргэний тоог 2019 оноос бууруулахгүй. | 5,000.00 | Дүүргийн төсөв | НХХ ЭМТ | 100% |
| | | Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны Эрүүл мэндээ дээдлэгч өрх, иргэн шалгаруулах болзол, журмыг шинэчлэн батлах тухай А/84 дүгээр тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу Эрүүл мэндийг дэмжигч байгууллагаар 16, 17 дугаар цэцэрлэг, Эрүүл мэндээ дэмжигч өрхөөр 16 дугаар хорооны иргэн Ц.Очирхуяг, 15 дугаар хорооны иргэн Н.Энхтайваны гэр бүл, Эрүүл мэндээ дэмжигч иргэнээр 2 дугаар хорооны Б.Должинжав, 6 дугаар хорооны Ж.Саранцэцэг, 9 дүгээр хорооны Д.Алтанцэцэг, 11 дүгээр хорооны О.Чимэдсамбуу нар дүүргээс шалгарч, материалыг нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн. | | | | | | |
| 13 | НХТЖҮЧ-2.6.1, НЗДҮАХ-2.1.2. ДЗДҮАХ-2.1.6 | "Иргэн төвт" арга хэмжээг Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн мобайл технологийг түшиглэн 0-5, 5-18 насны хүүхэд, Насанд хүрэгчдийн насны бүлгээр эрт илрүүлгийн үзлэгт хамруулж, илэрсэн өвчлөлийг эмчилгээний хяналтад авна. | Ковид-19 халдварын нөхцөл байдалтай холбогдуулан тус арга хэмжээг хойшлуулсан. | Зорилтот бүлгийн хүн амын 20-оос дээш хувийг хамруулсан байна. | 10,000.00 | Дүүргийн төсөв | НХХ ЭМТ, ӨЭМТ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Журам батлах тухай" А/139 дүгээр тушаал, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны "Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоо зохион байгуулах тухай" А/77, Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2022 оны А/171 дүгээр захирамж, дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны А/38 дугаар тушаалын дагуу иргэдийг Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Улсын Нэгдүгээр төв эмнэлэг, Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Сөүл эмнэлэг, Рехамид эмнэлэгтэй хамтран 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн багц үзлэгт хамруулсан. 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 0-17 насны 50613 хүүхдээс 18971 хүүхэд буюу 37.4%-ийг, 18-аас дээш насны 93929 иргэнээс 6867 иргэн буюу 8%-ийг, нийт 144542 иргэнээс 22889 буюу 21%-ийг эрт илрүүлгийн багц үзлэгт хамруулж, хавдрын 57 сэжигтэй тохиолдол илрүүлсэн. | | | | | | |
| 2.2 Иргэн бүрд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ | | | | | | | | |
| 14 | МУХТ-2.1.6, НХТЖҮЧ-2.11.1 НЗДҮАХ-2.1.7 ДЗДҮАХ-2.2.1 | Албан хаагчдыг эрүүл мэндийн багцын үзлэг, шинжилгээнд хамруулах арга хэмжээ зохион байгуулна. | Урьдчилан сэргийлэх багц шинжилгээнд 85 албан хаагч, цэцэрлэгийн хамрагдвал зохих 1342 багш, ажилтнаас 1095 /81,5%/, ерөнхий боловсролын сургуулийн хамрагдвал зохих 3093 багш, ажилтнаас 1533 /49,5%/ хамрагдсан. | Багцын үзлэгийн хамралтыг жил бүр 3-5%-иар нэмэгдүүлсэн байна. | 32,000.00 | Дүүргийн төсөв | НХХ ЭМТ | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 64 ажилтан, албан хаагчдыг коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор COVID-19 Ag түргэвчилсэн оношлуураар коронавируст халдварыг илрүүлэх шинжилгээ авлаа. Батлагдсан 3 өөрөг тохиолдлыг халдвар хамгааллын дэглэм баримтлах, дархлаа дэмжих бүтээгдэхүүн, зөв хооллолтын талаар зөвлөмж мэдээлэл өгч, харъяа Өрхийн эрүүл мэндийн төвийн хяналтанд өгсөн. Мөн чихрийн шижин илрүүлэх шинжилгээнд 45 албан хаагч хамрагдлаа.<br>Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт ерөнхий боловсролын сургуулийн 3233 багш, ажилтнаас 2587 буюу 80%, цэцэрлэгийн 1478 багш, ажилтнаас 1264 буюу 83%, нийт хамрагдвал зохих 4711 багш, ажилтнаас 3851 буюу 82% нь үзлэгт хамрагдсан. | | | | | | |
| 15 | | Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан эрт илрүүлэг үзлэгт хамруулах арга хэмжээг идэвхжүүлнэ. | 2020 онд АГЭИҮ-68%, ЧШӨЭИҮ-68,4%, УХХЭИҮ-67%-тай байна. | АГЭИҮ-72,4% ЧШӨЭИҮ-75% УХХЭИҮ-70% | - | | НХХ ЭМТ | 80% |
| | | Дүүргийн хэмжээнд артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт 25987 иргэн буюу 27.6%, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 24428 иргэн буюу 52.5%-ыг тус тус хамруулж, өмнө оны мөн үеэс артерийн гипертензийн эрт илрүүлэг 0.2%-иар буурч, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг 0.1%-иар нэмэгдсэн. | | | | | | |
| 16 | МУХТ-2.1.19, НХТЖҮЧ-2.8.1, НЗДҮАХ-2.1.4 | Амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2-12 насны хүүхдийг жил бүр үе шаттай хамруулах, өвчилсөн хүүхдийг эрүүлжүүлэх, эрүүл | 2021 оны эхний хагас жилд 2-12 насны 1595 хүүхэд үзлэгт хамруулсан нь дүүргийн зорилтот насны хүүхдийн 3,9%-ийг | Зорилтот насны хүүхдийн 30-аас доошгүй хувийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, өвчилсөн тохиолдлын | 5,000.00 | Дүүргийн төсөв | НХХ ЭМТ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ДЗДҮАХ-2.2.2 | мэндийн боловсрол олгох арга хэмжээ зохион байгуулна. | ээлж, коронавируст халдвараас шалтгаалан үзлэг өмнөх оноос 40%-иар буурсан байна. | 25-аас доошгүй хувийг эрүүлжүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаанд 15%-ийг хамруулсан байна. | | | | |
| | | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаал, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/77 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2022 оны А/171 дүгээр захирамжийн хэрэгжилтийн хүрээнд 0-17 насны хүүхдийн эрт илрүүлгийн үзлэгт зорилтот бүлгийн 50613 хүүхэд хамрагдахаас 2022 оны 11 дүгээр сарын 07-ны байдлаар 24564 хүүхэд буюу 53%-ийг хамруулсан. Эрүүл мэндийн төвийн шүдний кабинетаар 2-12 насны 1054 хүүхдийг үзлэгт хамруулж, өвчлөл илэрсэн 998 хүүхдээс 830 буюу 83%-ийг эрүүлжүүлж, 136 эцэг эх, 285 хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгох ганцаарчилсан зөвлөгөө өглөө. Эрүүлжилт өмнөх онтой харьцуулахад 13%-иар өссөн. | | | | | | |
| 17 | НХТЖҮЧ-2.6.1, НЗДҮАХ-2.1.2. ДЗДҮАХ-2.2.3 | Сүрьеэгийн эрсдэлт бүлгийн хүн амыг сүрьеэгийн эрт илрүүлэгт явуулын хэлбэрээр хамруулж, эрт илрүүлгийн хувийг жил бүр нэмэгдүүлэх, оношлогдсон тохиолдлыг эмчилгээнд бүрэн хамруулах арга хэмжээ зохион байгуулна. | Дүүргийн зорилтот бүлгийн 3600 иргэн эрт илрүүлэг үзлэгт хамрагдахаас 2903 бүртгүүлж, рентген үзлэгт 2887, цэрний шинжилгээнд 45 хүн хамрагдаж, 5 иргэн сүрьеэгийн халдвартай оношлогдож, эмнэлгийн хяналтад эмчилгээнд байна. | Өмнөх оноос эрт илрүүлэг 5%-иар нэмэгдсэн байна.Оношлогдсон тохиолдлыг эмчилгээнд бүрэн хамруулсан байна. | 7,000.00 | Дүүргийн төсөв | НХХ ЭМТ | 100% |
| | | Сүрьеэгийн далд халдварыг илрүүлэх зорилгоор 11-20 дугаар хорооны эрсдэлт бүлгийн 160 иргэнд сүрьеэгийн арьсны сорил тавьж, 143 иргэнд үзлэг хийж, далд халдварын 4 тохиолдол илрүүлж, эмчилгээнд хамруулсан. Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоотой хамтран сүрьеэгийн тархалтыг бууруулахад тулгамдаж буй асуудал, хэрэгжүүлэх ажлын санал, үр дүн гаргах нөлөөллийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох удирдлагууд, 1-20 дугаар хорооны Засаг дарга, Өрхийн Эрүүл мэндийн төвийн дарга нар, эмч мэргэжилтэн 52 хүн оролцлоо. Тайлангийн хугацаанд сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх үзлэгт архины хамааралтай, орон гэргүй иргэн, их, дээд сургуулийн дотуур байрны оюутан, 2020, 2021 онд халдвартай хэлбэрийн сүрьеэгээр өвдсөн иргэдийн өрхийн болон ойрын хавьтлын 3068 иргэн хамрагдсанаас сүрьеэгийн 6 тохиолдол илрүүлж, 5 тохиолдлыг эмчилгээнд оруулаа. | | | | | | |
| 18 | НХТЖҮЧ-2.6.1, НЗДҮАХ-2.1.2. ДЗДҮАХ-2.2.4 | Зонхилон тохиолдох халдварт өвчний эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулах, БЗДХ-ын сэжигтэй тохиолдлыг молекул биологийн шинжилгээгээр онош | 10 сард тэмбүү 78 тохиолдол буюу 5,4, заг хүйтэн 37 тохиолдол буюу 2,6, трихомониаз 8 тохиолдол буюу 0,6 промиль байна. Өмнө оноос тэмбүү 10,1, заг хүйтэн 2,5, трихомониаз | Суурь түвшинг 5%-иар ахиулсан байна. | 10,000.00 | Дүүргийн төсөв | НХХ ЭМТ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | баталгаажуулж, эмчлэн эрүүлжүүлнэ. | 3,3 промилиор тус тус буурсан. | | | | | |
| | | Дүүргийн Засаг даргын 2022 оны А/243 дугаар захирамжаар цэргийн жинхэнэ албаны татлагаар эрүүл мэндээр тэнцээгүй залуучуудын эрүүл мэндийг сайжруулах аян зохион байгуулж, 5,900,000 төгрөгийг зарцууллаа.<br>ХДХВ, тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд 4115 иргэн хамруулснаар тэмбүү 52, заг хүйтэн 29, трихомониаз 4 тохиолдол бүртгэгдсэн. Тэмбүүгийн эмчилгээнд хамрагдалт 52/100%, хавьтлын шинжилгээнд хамралт 48/92,5%-тай байна.<br>Сайн дурын шинжилгээнд 436 иргэн хамрагдаж, тэмбүүгийн 5 тохиолдлыг хавьтлын хамт эмчилж бүрэн эдгээсэн. | | | | | | |
| 19 | МУХТ-2.1.6, НХТЖҮЧ-2.11.1 НЗДҮАХ-2.1.12 ДЗДҮАХ-2.2.5 | Тарилгат халдварт өвчний тандалт, сэргийлэлт, товлолын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлнэ. | Дархлаажуулалтын хамралт 94%-тай байна. | Суурь түвшингийн үзүүлэлтээс жил бүр 0.5%-иар нэмэгдсэн байна. | - | | НХХ ЭМТ | 100% |
| | | Дүүргийн хэмжээнд Ковид-19 халдвараас сэргийлэх дархлаажуулалтын 1-р тунд 109105, 2-р тунд 98206, 3-р тунд 44402, 4-р тунд 5781, 5-р тунд 19 иргэн буюу 1-р тунд 94.1%, 2-р тунд 84.2%, 3-р тунд 42.0%, 4-р тунд 5.5%-ийг хамруулсан.<br>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/512 дугаар тушаалын дагуу улирлын томуугийн вакцинд хамрагдвал зохих 26050 хүнээс 2022 оны 11 дүгээр сарын 01-ний байдлаар 6304 буюу 24.2%-ийг вакцинжуулсан. Товлолт дархлаажуулалтад 9972 хүүхэд буюу 92%-ийг хамруулсан. | | | | | | |
| 20 | МУХТ-2.1.6, НХТЖҮЧ-2.11.1 НЗДҮАХ-2.1.6 ДЗДҮАХ-2.2.6 | "Иргэн төвт" арга хэмжээнд ажил эрхэлдэггүй, дунджаас доогуур орлоготой иргэдийг хамруулна. | Эрүүл мэндийн даатгалгүй 2000 иргэнд хепатитийн В, С вирүс илрүүлэх түргэвчилсэн шинжилгээ авч, В вирүсийн 43, С вирүсийн 57 тохиолдол илрүүлэн, тусламж үйлчилгээнд шилжүүлсэн.<br>Коронавируст халдвараар өвчилсөн эрүүл мэндийн даатгалгүй 2482 иргэнийг Өрхийн эрүүл мэндийн төвүүд гэрийн тусгаарлалтад хянаж ажилласан. | Зорилтот бүлгийн хүн амын 5 хүртэлх хувийг ажил эрхэлдэггүй, дунджаас доогуур орлоготой иргэдийг хамруулсан байна. | 6,000.00 | Дүүргийн төсөв | НХХ ЭМТ, ӨЭМТ | 90% |
| | | "Өвчтөн нийгмийн төлөөллийн зөвлөл, элэг бүтэн Монгол" НҮТББ-тай хамтран "Элэг бүтэн Монгол" үндэсний хөтөлбөрийн хүрээнд дүүргийн 15-аас дээш насны 2004 иргэнийг В,С вирусийн илрүүлэг шинжилгээнд хамруулснаас эрүүл мэндийн даатгалгүй 33 иргэн байна.<br>Эрт илрүүлэг шинжилгээгээр 30 иргэн буюу 1.9%-д С вирус, 35 иргэн буюу 2.2%-д В вирус илэрч, С вирусийн ачаалал тоолох шинжилгээнд 29, В вирусийн ачаалал тоолох шинжилгээнд 27 иргэн илгээсэн. С вирусийн эсрэг эмчилгээнд 8, В вирусийн эсрэг эмчилгээнд 8 иргэнийг хамруулж, эмчилгээний үр дүн 98,2%-тай байна. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | МУХТ-2.1.6, НХТЖҮЧ-2.11.1 НЗДҮАХ-2.1.13 ДЗДҮАХ-2.2.7 | Сувиллын газарт MNS 6801:2019 стандартын дагуу хүний нөөц, тоног төхөөрөмж, эмчилгээ, оношилгоог үе шаттай нэмэгдүүлэн, хүртээмжийг сайжруулна. | Дүүргийн төсвөөс чийрэгжилтийн тоног төхөөрөмж хэрэгсэл олгосон. 70% | Сувиллын газар нь Сэргээн засахын төв болохтой холбогдуулан MNS 6801:2019 "Сэргээн засах төвийн бүтэц, үйл ажиллагаа" стандартад хэрэгжилтийг 85%-д хүргэсэн байна. | 40,000.00 | Дүүргийн төсөв | НХХ ЭМТ | 75% |
| | | Сувиллын тусламж үйлчилгээг уламжлалт эмчилгээний 10, сэргээн засах эмчилгээний 8 төрлөөр үзүүлж байна. Сувилаллын газрын "Сэргээн засах төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6801:2019" стандартын хэрэгжилт бүрэн хангалттай үнэлэгдэж, 2022 оны 10 дугаар сарын 14-ны өдөр магадлан итгэмжлэлээ 2 жилийн хугацаатайгаар сунгууллаа.<br>Одоо явуулж буй хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээнд нэмэлтээр сэргээн засах уламжлалт 21 төрлийн өдрийн эмчилгээний үйл ажиллагааны чиглэлээ өргөжүүлэх орны хүсэлтээ нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлж, шаардлагатай 17 төрлийн багаж, хэрэгслийн төсвийн саналаа 2023 оны Сүхбаатар дүүргийн Хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан. | | | | | | |
| 22 | МУХТ-2.1.19, НХТЖҮЧ-2.8.1, НЗДҮАХ-2.1.3 ДЗДҮАХ-2.2.8 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн салбар Комиссын үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | Сард 2 удаа ХБХ-ийн асаргаа тогтоох, бэрхшээлийг тодорхойлон дүгнэлт гаргадаг. | Комиссын үйл ажиллагааг дэмжин ажилласан байна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | НХХ | 100% |
| | | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын 14 удаагийн хурлаар 195 хүүхдийн өргөдлийг хүлээн авч, шинээр тогтоосон-74, сунгасан-94, цуцалсан-5, онош тодорхойгүй-8, тодорхойлолт авсан-11 асуудлыг шийдвэрлэсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай хэрэгслийн хөнгөлөлтийг 26 хүүхдэд, рашаан сувиллын 100 хувийн хөнгөлөлтийг 13 хүүхдэд 5,725,500 төгрөг, асран халамжлагчид 50%-ийн хөнгөлөлтийг 11 иргэнд 2,883,250 төгрөг олгосон.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын байгууллагад холбон зуучлах, оношлох, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд Европын холбооны MELINC төслийн зохицуулагч МУБИС, Нагоя Их сургуулийн Хүүхдийн хөгжлийг дэмжих төвтэй хамтран ажиллалаа. Хөгжлийн бэрхшээлтэй 292 хүүхэд тэгш хамруулан сургах хөтөлбөрөөр сургууль, цэцэрлэгт хамрагдаж байна. | | | | | | |
| | | **2.3. Иргэдийг нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангана.** | | | | | | |
| 23 | НХТЖҮЧ-3.5.1, 3.5.3 НЗДҮАХ-2.2.1 ДЗДҮАХ-2.3.1 | Дүүргийн хэлтэс, албад, хороодын дунд спорт наадам, өдөрлөгүүд зохион байгуулна. | Жил бүр дэргэдэх хэлтэс, албад, ЗДТГ-ын ажилтан албан хаагчдын спорт тэмцээнийг зохион байгуулж байна. | Уралдаан, тэмцээнд оролцогчдын тоог нэмэгдүүлж, нийслэлийн тэмцээнд амжилттай оролцуулсан байна. | 28,000.00 | Дүүргийн төсөв | НХХ БТСХ | 100% |
| | | Дүүргийн дэргэдэх 16 хэлтэс, албадын 650 гаруй ажилтан, албан хаагчдын дунд Засаг даргын нэрэмжит "Спорт наадам 2022" тэмцээнийг сагсан бөмбөг, волейбол, дартс, боулинг 4 төрлөөр зохион байгуулж, төрөл бүрээр 1, 2, 3-р байрыг шалгаруулан, багийн дүнгээр шилжин явах цом, мөнгөн шагналаар шагнан урамшууллаа. | | | | | | |
| 24 | | Ахмадын хавар, намрын өдөрлөг, хөгжлийн | 2019 онд ахмадын хавар, намрын спорт наадамд | Ахмад настан, хөгжлийн | 15,000.00 | Дүүргийн төсөв | НХХ БТСХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бэрхшээлтэй иргэдийн спорт өдөрлөг зохион байгуулна. | нийт 350 гаруй ахмад настан оролцсон. | бэрхшээлтэй иргэний идэвх санаачилга сайжирсан байна. | | | | |
| | | -Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 116 дугаар сургуулийн 6-11 дүгээр ангийн сурагчдын дунд хонхот бөмбөг, суугаа волейболын тэмцээн зохион байгуулж, 12 багийн 48 сурагч, 120 гаруй тамирчид оролцлоо.<br>-Булган аймагт зохион байгуулагдсан Монголын Үндэсний пара хөнгөн атлетикийн улсын аварга шалгаруулах тэмцээний Т-53, 54 тэргэнцэртэй 800,1500 метрийн зайн төрөлд оролцсон 14 дүгээр хорооны иргэн Б.Даваасүрэнг дэмжин санхүүгийн асуудлыг шийдвэрлэсэн.<br>-Алхацгаая-Гүйцгээе аяны хүрээнд 1-20 хороодын ахмадын дунд 3 төрлөөр Үүргэвчтэй аялал тэмцээнийг зохион байгуулж, 112 ахмад оролцсон.<br>-Баянхонгор аймагт зохион байгуулагдсан Мастеруудын холбооны 6 дугаар спортын их наадамд шатар, теннис, дартс, гранд гольф, софт волейболын төрөлд 50 тамирчин оролцож, 60-65, 70+ насанд софт волейболын төрөлд мөнгөн медаль 2, хөнгөн атлетик, дартс төрөлд хүрэл медаль 2 хүртэж, гранд гольф тэмцээнд 10 ахмад Алтан бөмбөгийн шагнал авлаа.<br>-Энэ онд нийт 650 ажилтан, албан хаагч, 168 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 162 ахмадын дунд 7 удаа тэмцээн, уралдаан зохион байгуулж, бие бялдрын хөгжлийг дэмжиж ажилласан. | | | | | | |
| 25 | НХТЖҮЧ-3.5.4<br>НЗДҮАХ-2.2.2<br>ДЗДҮАХ-2.3.2 | Өсвөрийн шигшээ багийг спортын 10 төрлөөр өргөтгөн зохион байгуулж, багш дасгалжуулагчдыг урамшуулах, баг тамирчдыг хот, улс, олон улсын тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ. | Өсвөрийн шигшээ багийг спортын 10 төрөл /шатар, зуун буудалт даам, ширээний теннис, дугуй, хөл бөмбөг, сагсан бөмбөг, чөлөөт бөх, жүдо бөх, тэшүүр, гандбол/-өөр хичээллүүлсэн. | Олон улсын чанартай тэмцээн уралдаанд оролцож, амжилт гаргасан байна. | 85,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>БТСХ | 100% |
| | | Өсвөрийн ширээний теннисний аварга шалгаруулах тэмцээнд 4 насны ангиллаар 12 сургуулийн 72 тамирчин, 100 буудалт даамны 4 насны ангиллаар 15 сургуулийн 82 сурагч, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнд 32 багийн 128 тамирчин оролцсон.<br>Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 8 төрлөөр зохион байгуулж, 3858 хүүхдийг хамруулсан бөгөөд улсын аварга шалгаруулах тэмцээнээс алт-2, хүрэл-4, нийслэлийн тэмцээнээс мөнгө-5, хүрэл-1 медалиудыг хүртсэн амжилт үзүүлсэн. | | | | | | |
| 26 | | Өсвөрийн шигшээ баг тамирчдыг спортын, хэрэглэл материалаар хангах, бэлтгэлийн орчинг сайжруулах арга хэмжээ авна. | | Бэлтгэлийн орчин, нөхцөл сайжирч, тамирчдын амжилт ахисан байна. | 20,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>БТСХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өсвөрийн шигшээ багийг спортын 10 төрлөөр (хөнгөн атлетик, таеквондо, чөлөөт бөх, жүдо бөх, дугуй, ширээний теннис, сагсан бөмбөг, волейбол, бокс) өргөтгөн зохион байгуулан, тамирчдын тоглолтын өмсгөлийн загварыг баталж сагсан бөмбөг, волейбол, хөлбөмбөгийн багийн тамирчдын 78 ширхэг тоглолтын хувцас, хэрэглэлтэй болсон. | | | | | | |
| 27 | НХТЖҮЧ-3.5.1, 3.5.3 НЗДҮАХ-2.2.1 ДЗДҮАХ-2.3.3 | Иргэдийн, Монголын бүх ард түмний спартикад зохион байгуулна. | Спорт наадмуудад амжилттай оролцож байна. | Оролцогчдын тоог нэмэгдүүлж, уралдаан тэмцээнд амжилт гаргасан байна. | 80,000.00 | Дүүргийн төсөв | НХХ БТСХ | 100% |
| | | Үндэсний спортын VII их наадмын анхан шатны тэмцээнүүдийг 9 төрлөөр зохион байгуулж, тэргүүн байрт шалгарсан баг, тамирчид шигшээ тэмцээнд оролцож 1-мөнгөн медаль, 2-хүрэл медаль хүртсэн.<br>Монголын бүх ард түмний спортын XV наадмын анхан шатны тэмцээнийг 8 төрлөөр зохион байгуулж, тэргүүн байрт шалгарсан баг тамирчид шигшээ тэмцээнд оролцож, Алтан медаль-1, Мөнгөн медаль-1, Хүрэл медаль-3 хүртсэн.<br>Дүүргийн Засаг даргын нэрэмжит иргэдийн спортын X наадмыг спортын 8 төрлөөр зохион байгуулж, спорт явган аялал, ширээний шагайн наадгай, хийн дасгал, аеробик, волейбол, олс таталт, софт волейбол, сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж, шигшээ тэмцээнд оролцох бэлтгэл хангасан. Үндэсний спортын VII их наадам, Монголын бүх ард түмний спортын XV наадам, Иргэдийн спортын X наадмыг 25 төрлөөр зохион байгуулж, нийт 4408 иргэн хамруулсан. | | | | | | |
| 28 | НХТЖҮЧ-3.5.1, 3.5.3 НЗДҮАХ-2.2.1 ДЗДҮАХ-2.3.4 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит "Хүн амын бие бялдрын чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-д иргэдийг өргөнөөр хамруулна. | Бүх нийтийн бие бялдрын чийрэгжилтийн түвшинг тогтоож, идэвхтэй дасгал, хөдөлгөөнд өргөнөөр хамруулан ажиллаж байна. | Хүн амын бие бялдрын түвшинг тогтоосон байна. | 2,000.00 | Дүүргийн төсөв | НХХ БТСХ | 100% |
| | | Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг хуваарийн дагуу дүүргийн дэргэдэх хэлтэс, албадын 16 байгууллагын 6061 хүнээс авлаа. Үнэлгээнд хамрагдсан иргэд A-950, B-2059, C-1493, D-877, F-353 үнэлэгдсэн. | | | | | | |
| 29 | | Бүх нийтийн спорт өдөрлөг, спорт явган аялал, марафон зохион байгуулна. | Дэлхийн алхалтын өдрийг 2020 оны 10 сард Циркийн хойд талбайгаас Зайсан чиглэлд зохион байгуулж, 1000 гаруй иргэн оролцсон. | Бүс, нийслэлийн тэмцээнд оролцогчдын тоог нэмэгдүүлсэн байна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | НХХ БТСХ | 100% |
| | | "Улаанбаатар марафон-2022" олон улсын гүйлтийн тэмцээнд 14 байгууллага, ерөнхий боловсролын 26 сургууль, 6 их, дээд сургуулийн нийт 46 байгууллагын 4500 хүн бүртгэл хийлгэж, 2000 иргэн оролцсон.<br>"Алхацгаая гүйцгээе" аянд Ахмадын холбоо, 1-20 дугаар хорооны 3-85 насны 1900 гаруй иргэд хамрагдсан.<br>Ерөнхий боловсролын 16 сургуулийн бага ангийн болон 27 цэцэрлэгийн багш нарын дунд спортын 5 төрлөөр, дунд ахлах ангийн багш нарын дунд спортын 2 төрлөөр тэмцээн зохион байгуулж, 75 багийн 456 гаруй багш-ажилтнууд оролцсон.<br>Бүх нийтийн спорт өдөрлөг, спорт явган аялал, марафон аянаар 11000 иргэнд амьдралын зөв дадал хэвшил олгож, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжиж ажиллалаа. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 30 | МУХТ-2.2.2, НХТЖҮЧ-3.5.2 НЗДҮАХ-2.2.3 ДЗДҮАХ-2.3.5 | “Спорт цогцолбор”-ын барилгын ажлын явцыг эрчимжүүлж, ашиглалтад оруулна. | Барилгын ажлын гүйцэтгэгч ХХК одоогийн байдлаар нийт 2.8 тэрбум төгрөгийн санхүүжилт авч, барилгын ажил 40 хувьтай явагдаж байна. | Иргэд, хүүхэд залуучууд спортоор хичээллэж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл бүрдсэн байна. | - | | НХХ БТСХ | 40% |
| | | А блокын ажил эхлээгүй, Б блокын 800 хүний суудалтай, спорт заалны 3 давхар карказ угсарсан, В блокын фитнес, жижиг заал, албан конторын өрөөнүүдийн карказ угсарсан.<br>2022 онд 2,8 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдвэрлэсэн боловч гүйцэтгэгч компани дахин магадлангаар орох санал ирүүлж, захиалагч байгууллага Биеийн тамир спортын улсын хороо Сангийн яаманд гүйцэтгэгч байгууллагыг өөрчлөх санал хүргүүлсэн. Барилгын ажил зогссон, 40%-ийн гүйцэтгэлтэй. | | | | | | |
| | | 2.4 Сургалтын чанарыг сайжруулж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ | | | | | | |
| 31 | МУХТ-2.3.9, 2.3.11, 2.3.17 НХТЖҮЧ-2.2.1 НЗДҮАХ-2.3.2. ДЗДҮАХ-2.4.1 | Төрийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилгыг мэргэжлийн хяналтын газрын дүгнэлтэд үндэслэн зураг, төсөв боловсруулж дахин төлөвлөх, өргөтгөх, шинээр барих ажлыг улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар шийдвэрлүүлнэ. | 2021 онд 4 /25, 68, 143, 299 дүгээр цэцэрлэг/-ийн барилга ашиглалтад орж, орны тоо 580 нэмэгдэж, шинээр 200 хүүхэд цэцэрлэгт хамруулсан. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2960 хүүхдийн суудалтай 6 сургуулийн барилга, 54, 149, 281, 282 дугаар цэцэрлэгийн 710 хүүхдийн ортой 4 цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулна. | | | ТГХШХ | 100% |
| | | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1, 159-р сургууль, 54, 216, 281-р цэцэрлэгийг ашиглалтад оруулж, 1280 суудал, 680 орны хүчин чадлаар нэмэгдүүлсэн. Шинээр 10 дугаар хорооны 243-р цэцэрлэгийн 200 ортой өргөтгөл барих 4.6 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлж, худалдан авах ажиллагааг хэрэгжүүлсэн. | | | | | | |
| 32 | | Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр цэцэрлэгийн барилга барих, орны тоог нэмэгдүүлэхэд хамтран ажиллана. | 2021 онд Азийн хөгжлийн банкны хөрөнгөөр 68 дугаар цэцэрлэг, Арабын Эмират улсын хөрөнгө оруулалтаар 25 дугаар цэцэрлэгийн барилга баригдсан. | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 6 дугаар сургууль, 17, 160 дугаар цэцэрлэгийн өргөтгөл барихаар худалдан авалтыг зохион байгуулж байна. | - | | НХХ БХ | 70% |
| | | 12, 13, 16, 18-р хороонд баригдаж буй 2320 хүүхдийн суудалтай 4 сургуулийн барилгын ажлын явц 67%, 4,10,18 дугаар хороонд баригдаж буй 670 хүүхдийн ортой 3 цэцэрлэгийн барилгын ажлын явц 70%-тай байна. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 159 дүгээр сургуулийн барилгын ажил дууссан болович бохирын шугамд холбох ажил санхүүжилтгүйгээс зогссон гүйцэтгэл 90%, 12-р хороонд баригдаж буй 720 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын гүйцэтгэл 80%, 71-р сургуулийн өргөтгөлийн барилгын явц 70%, 16 дугаар хороонд баригдаж буй 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын гүйцэтгэл 30%, 282-р цэцэрлэгийн барилгын гүйцэтгэл 70%, 149-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын гүйцэтгэл 70%, 17 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын гүйцэтгэл 70%-тай байна. Энэ оны 3 дугаар улиралд 216, 54, 281 дүгээр цэцэрлэгийн 680 хүүхдийн ортой 3 цэцэрлэгийн барилгыг ашиглалтад хүлээн авсан. | | | | | | |
| 33 | МУХТ-2.3.9, 2.3.11, 2.3.17 НХТЖҮЧ-2.2.1 НЗДҮАХ-2.3.2. ДЗДҮАХ-2.4.2 | Төрийн бус өмчийн цэцэрлэгийн нэмэлт элсэлтийн үйл ажиллагааг дэмжин ажиллана. | Үрэл хотхон, Хөгжил, Эрдмийн цацраг, Гандирсын хүүхдүүд, Ногоон төгөл, Номт сансар, Цасангоо нарын 7 цэцэрлэгт 148 хүүхдийг цэцэрлэгт хамруулах ажлыг зохион байгуулсан. | 279 хүүхэд цэцэрлэгт хамруулсан байна. | - | | НХХ БХ | 100% |
| | | 2021-2022 оны хичээлийн жилд төрийн өмчийн цэцэрлэгийн 2 настай хүүхдийн цахим бүртгэл, элсэлтийг зохион байгуулж, шинээр 2 настай 904 хүүхдийг хамруулан, цахим элсэлтийн хяналтын тоондоо хүрээгүй цэцэрлэгүүдэд нэмэлтээр 2 настай 242, 3 настай 362, 4 настай 88, 5 настай 72 хүүхдийг буюу нийт 1668 хүүхдийг хамруулсан. Төрийн бус өмчийн 7 цэцэрлэгт 148 хүүхэд нэмэлт элсэлтээр суралцсан. Нийтдээ төрийн өмчийн 35, төрийн бус өмчийн 29 цэцэрлэгт 9531 хүүхэд буюу нийт хүүхдийн 73.4 хувь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан.<br>2022-2023 оны хичээлийн жилд E-mongolia системээр төрийн өмчийн 34, төрийн бус өмчийн 28 цэцэрлэгийн элсэлтийг 3 удаа зохион байгуулж, 11805 хүүхдийг бүртгэж, хүүхдийн хүсэлтийг 100% шийдвэрлэсэн. | | | | | | |
| 34 | | Байгууллагын дэргэдэх цэцэрлэг, салбар бүлгийн үйл ажиллагааг дэмжин ажиллана. | 16 дугаар цэцэрлэгт Гадаад харилцааны яамны ажилтнуудын хүүхдийн салбар 3 бүлэгт 50, Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газрын түрээсийн байранд 1 бүлэг 25, Номт сансар цэцэрлэгийн түрээсийн байранд 3 бүлэгт 75, нийт 150 хүүхэд байгууллагын дэргэдэх цэцэрлэгт хамрагдсан. | 1 цэцэрлэгт 150 хүүхэд хамруулсан байна. | 15,000.00 | Дүүргийн төсөв | НХХ БХ | 100% |
| | | 16 дугаар цэцэрлэгийн Гадаад харилцааны яамны байгууллагын дэргэдэх салбар 3 бүлэгт 72 хүүхэд, Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газрын 1 бүлэгт 19 хүүхэд, Номт сансар цэцэрлэгийн 6 бүлэгт 148 хүүхэд, 135 дугаар цэцэрлэгийн Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийн салбар 2 бүлэгт 40 хүүхэд, 234 дүгээр цэцэрлэгийн 534 дүгээр байрны 2 бүлэгт 67 хүүхэд тус тус хамрагдаж байна. Байгууллагын дэргэдэх цэцэрлэгийн 20 бүлэгт 541 хүүхэд хамрагдсан. | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 35 | ДЗДҮАХ-2.4.3 | Ёс зүйн ур чадварыг хөгжүүлэх сургалтыг зохион байгуулна. | Төрийн өмчийн 19 сургуулийн захирал, 35 цэцэрлэгийн эрхлэгч хамрагдаж, харилцааны сэтгэл зүй, сэтгэл хөдлөлөө удирдах ур чадвар, багийн хөгжил, бүтээмж нэмэгдүүлэх, цагийн менежментийн хөтөлбөрт хамрагдсан. | Жил бүр 100 багшийн ур чадварыг хөгжүүлсэн байна. | 3,000.00 | Дүүргийн төсөв | НХХ БХ | 100% |
| | | Ерөнхий боловсролын сургуулийн 25 захирал, 35 цэцэрлэгийн эрхлэгч, 56 сургалтын менежер, 35 арга зүйч, 33 нийгмийн ажилтан, 22 бичиг хэргийн ажилтнуудад зориулсан "Ажлаас халшрах хам шинж, түүнээс урьдчилан сэргийлэх ба хариу арга хэмжээ", Сэлбэ сургуультай хамтран "Байгууллагын соёлд цахим засаглалын нөлөө" сэдэвт сургалтуудыг зохион байгуулж, ёс зүйн ур чадварыг хөгжүүлэх 2 удаагийн сургалтад 291 багш, ажилтан хамруулсан. | | | | | | |
| 36 | | Удирдах ажилтан, багш, ажилтан ажиллагсдыг ажлын үр дүнгээр дүгнэж, урамшуулах ажлыг тогтмол зохион байгуулна. | ЕБС-ийн 15 багш, цахим сургалтын үед манлайлан ажилласан цэцэрлэг, сургуулийн 20 багш, коронавируст халдварын үед орон нутагт дэмжлэг үзүүлж, идэвх санаачилгатай сайн ажилласан 5 цэцэрлэг, 6 сургууль зэрэг 47 хүнийг урамшуулсан. | Тэргүүний сургууль, цэцэрлэг, багш ажилтнуудыг урамшуулах, дэмжих, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | 20,000.00 | Дүүргийн төсөв | НХХ БХ | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн Боловсролын байгууллага, багш, ажилтнуудын ажлын үр дүнг дүгнэх үйл ажиллагаа зохион байгуулах тухай А/368 дугаар захирамжаар 2021-2022 оны хичээлийн жилд хүүхдийн хөгжлийг дэмжин бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, манлайлан ажилласан 2 захирал, 2 сургалтын менежер, 3 арга зүйч, 2 нийгмийн ажилтан, 17 багш, цэцэрлэгийн 6 туслах багш, 1 номын санч, 2 эмч, 6 цэцэрлэгийн тогоочийг шалгаруулан дүүргийн Засаг даргын Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.<br>Дүүргийн тэргүүний цэцэрлэгээр С.Одсүрэн эрхлэгчтэй 175 дугаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиар Д.Оюунгэрэл захиралтай 35 дугаар сургууль, М.Мөнхбаатар захиралтай МУБИС-ын Ерөнхий боловсролын сургууль, Э.Золбоо захиралтай Сэлбэ сургуулиуд тус тус шалгарсан. Боловсролын байгууллага, багш, ажилтнуудын ажлын үр дүнг дүгнэж, урамшуулах үйл ажиллагааг зохион байгуулахад 22,697,000 төгрөгийг мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас гаргаж ажилласан. | | | | | | |
| 37 | | Мэргэжлийн багшийн заах арга зүй, ур чадварын уралдааныг жил бүр зохион байгуулан үр дүнг | Дүүргийн хэмжээнд зохион байгуулсан эрдэм шинжилгээний илтгэл шалгаруулах байгууллагын түвшний | Жил бүр 20 багшийн ур чадварыг хөгжүүлэн урамшуулсан байна. | 10,000.00 | Дүүргийн төсөв | НХХ БХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тооцож, дэмжин ажиллана. | шалгаруулалтад 35 цэцэрлэгийн 210 багш оролцож, 2 дугаар шатны буюу хэсгийн шалгаруулалтад 35 багш оролцохоор бэлтгэл хангаж байна. | | | | | |
| | | Сургуулийн багш, удирдах ажилтны дунд "Багш нарын мэргэжлийн өсөлтөд ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх нь" сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг Боловсролын үнэлгээний төвтэй хамтран зохион байгуулж, судлагдахуун бүрээр нийт 90 илтгэл оролцож, 30 илтгэл шалгарч, 26 багш, ажилтан илтгэлээ толилуулснаас 1 дүгээр байрт Шинэ үе сургуулийн математикийн судлагдахууны багш нарын багийн илтгэл шалгарч, улсын уралдаанд оролцох эрх авсан. Шагналт байранд орсон 15 багш, ажилтныг урамшуулсан. Мэргэжлийн багшийн заах арга зүй, ур чадварыг нэмэгдүүлэх илтгэлийн уралдаанд 90 багш оролцлоо. | | | | | | |
| 38 | | Сургууль, цэцэрлэгийн залгамж холбоог сайжруулан сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангаж ажиллана. | - | 1 цэцэрлэг, 1 сургуулийн залгамж холбоог сайжруулах үйл ажиллагаа зохион байгуулсан байна. | 9,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>БХ | 100% |
| | | Сургуультай танилцах өдөрлөгийг 2022 оны 5 дугаар сард төрийн өмчийн 12 сургууль, 35 цэцэрлэгийн дунд зохион байгуулж, 2398 хүүхэд хамруулж, сургууль, цэцэрлэгийн залгамж холбоог сайжруулан сургуульд бэлтгэгдсэн байдлыг дэмжин ажилласан. | | | | | | |
| 39 | ДЗДҮАХ-2.4.4 | Цэцэрлэгийн хүүхдийн хөгжлийн явцын болон үр дүнгийн үнэлгээг жил бүр тогтмол хийж, хөгжлийн ахицыг тооцон багшийг дэмжиж ажиллана. | БСШУСС-ын 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/280 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам"-аар хүүхдийн хөгжлийн үнэлгээг явцын болон үр дүнгийн үнэлгээгээр дүгнэхэд дүүргийн хэмжээнд хөгжлийн ахиц 23%-иар өссөн байна. | "Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам"-аар хүүхдийн хөгжлийн үнэлгээг явцын болон үр дүнгийн үнэлгээгээр дүгнэхэд дүүргийн хэмжээнд хөгжлийн ахиц 5%-иар өссөн байна. | 12,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>БХ | 100% |
| | | Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журмын хэрэгжилтийн хүрээнд төрийн өмчийн 34 цэцэрлэгийн 7285 хүүхэд, хүүхдийн хөгжлийн үр дүнгийн үнэлгээнд хамрагдсан. Үүнд бие бялдар дунджаас доогуур 188 хүүхэд 3%, дундаж 1671 хүүхэд 23%, хангалттай 5426 хүүхэд 74%, танин мэдэхүй дунджаас доогуур 288 хүүхэд 4%, дундаж 1874 хүүхэд 26%, хангалттай 5123 хүүхэд 70%, нийгэмшихүй дунджаас доогуур 247 хүүхэд 3%, дундаж 1439 | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хүүхэд 20%, хангалттай 5599 хүүхэд 77%-ийн үзүүлэлттэй үнэлэгдлээ. Нийтдээ дунджаас доогуур 242 хүүхэд 3%, дундаж 1659 хүүхэд 23%, хангалттай 5384 хүүхэд 74%-тай тус тус үнэлэгдсэн. | | | | | | |
| 40 | | Боловсролын чанарын үнэлгээнд дүн шинжилгээ хийж, сурлагын амжилтыг ахиулна. | ЕБС-ийн сурагчдын хичээлийн агуулгын хоцрогдол, нөхцөл байдлыг тодорхойлох, дэмжлэг үзүүлэх, зайн сургалтын үе дэх сургалтын бэрхшээлийг илрүүлэх зорилгоор Оношлох үнэлгээнд түүврийн аргаар сонгогдсон 34 сургуулийн 2-12 дугаар ангийн 78052 сурагч хамрагдсан. | Боловсролын чанарын үнэлгээнд хамрагдах сурагчдын тоог нэмэгдүүлж, сурлагын амжилтыг ахиулсан байна. | 20,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>БХ | 100% |
| | | Элсэлтийн ерөнхий шалгалтанд 58 сурагч 800 оноо авсан ба дүүргийн дундаж үзүүлэлт 546,5-д хүрч нийслэлийн үзүүлэлтийг тэргүүлж өнгөрсөн оноос амжилтаа ахиулсан.байна. Шавиа амжилттай бэлтгэсэн 24 багшийг алдаршуулан, дүүргийн Засаг даргын Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав. | | | | | | |
| 41 | | Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнг тооцож, урамшуулах ажлыг зохион байгуулна. | 2021 оны элсэлтийн ерөнхий шалгалтын онооны дундаж 540,1 хүрч өнгөрсөн оноос 7,5 оноогоор өссөн. | Элсэлтийн ерөнхий шалгалтын оноог бууруулахгүй. | 10,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>БХ | 100% |
| | | Төгсөх ангийн сурагчдын сурлагын амжилтыг ахиулах зорилгоор 2409 сурагчдыг танхимын, ELAB төслөөр 17 сурагчийг 6 хичээлээр цахим давтлагад хамруулсан.<br>Элсэлтийн ерөнхий шалгалтад 10 судлагдахуунаар 40 сургуулийн 2351 суралцагч хамрагдсан. Орос хэл, Физик, Биологи, Хими, Нийгмийн тухай мэдлэг, Англи хэл, Математик 7 хичээлээр нийт 58 сурагч 800 оноо авсан. Дүүргийн дундаж 546.57 болж өнгөрсөн оноос 5 оноогоор өссөн. | | | | | | |
| 42 | МУХТ-2.3.8, НХТЖҮЧ-2.1.1, НЗДҮАХ-2.3.1 ДЗДҮАХ-2.4.5 | Иргэдэд амьдрах ухааны, иргэний, гэр бүлийн, гоо зүйн, ёс суртахууны, шинжлэх ухааны зэрэг боловсрол хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, сургалт зохион байгуулна. | Нийт 80 цагийн сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг бэлтгэсэн. | 2021 онд 25 иргэнд танхимаар, 11610 иргэнд онлайн буюу зайнаас, онлайн видео хичээлээр 2426 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. | 17,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>БХ | 100% |
| | | Насан туршийн боловсролын төвд 151 суралцагч боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн сургалтанд хамрагдан, бага боловсролд 16, суурь боловсролд 60, бүрэн дунд боловсролд 72 суралцагч суралцаж, бага боловсролыг 4, суурь боловсролыг 23, бүрэн дунд | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | боловсролыг 39 суралцагч эзэмшин төгсөж, суурь, бүрэн дунд боловсролын үнэмлэх авч, 6 суралцагч элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн.<br>"Хүүхэд эрхэм хэрэглэгч аян"-ы хүрээнд Электрон тамхины хор нөлөөллийн судалгаанд Насан туршийн боловсролын төвийн багш, ажилчдын 30%, сургалтад төрийн өмчийн сургуулийн 74 сурагч, 10 багш хамрагдсан.<br>Иргэдийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр танхимын 11 төрлийн 71 удаагийн давтамжит сургалтыг 1522 иргэдэд зохион байгуулж ажиллалаа. | | | | | | |
| 2.5 Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, хүүхэд, эцэг эх, багшийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ | | | | | | | | |
| 43 | ДЗДҮАХ-2.5.1 | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлаар мэдээллийн сан үүсгэж баяжуулна. | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын атрибут мэдээлэл мэдээллийн санд бүртгэгдээгүй байна. | Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн нэгдсэн мэдээллийн сан үүссэн байна. | 40,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ<br>НХХ | 100% |
| | | Дүүргийн 1-20 дугаар хороонд Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 173 байршлын 153 ширхэг сүүдрэвч 4405 м2 хүүхдийн тоглоомын талбай, 380 чийрэгжүүлэлтийг төхөөрөмж , 801 ширхэг сандал, 425 ширхэг хогийн сав, 16786 м2 спорт талбайн мэдээллийн санг үүсгэсэн.<br>1-20 дугаар хорооны 2320 ААНБ-аар Хог хаягдлын нэгдсэн мэдээллийн санг үүсгэсэн. | | | | | | |
| 44 | | Дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт засвар үйлчилгээ, тохижилт хийнэ. | - | Сургууль, цэцэрлэгт засвар, тохижилтын ажил хийгдэж, хүүхдүүд аюулгүй орчинд сурах боломж хангагдсан байна. | 1,500,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>ТГХШХ | 100% |
| | | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 1, 2, 11, 31, 35 дугаар сургууль, Насан туршийн боловсролын төв, 14, 42, 159, 160, 166, 171, 175, 216 дугаар цэцэрлэгүүдэд нийт 1,734,197.8 мянган төгрөгөөр дээвэр, фасад, сантехник, цахилгаан, дотор засварын ажлын 15 төсөл, арга хэмжээг 100% бүрэн хэрэгжүүлж, 6 сургууль, 8 цэцэрлэгт хүүхдийн суралцах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлсэн. 1 тэрбум төгрөгөөр сургууль, цэцэрлэгүүдэд шаардлагатай тавилга, хэрэгслээр ханган ажилласан. | | | | | | |
| 45 | НХТЖҮЧ-2.4.3<br>НЗДҮАХ-2.3.7<br>ДЗДҮАХ-2.5.2 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн бүсэд аюулгүй байдлыг хангахад чиглэсэн "Гэртээ харих гэрэлтэй зам" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Гэртээ харих гэрэлтэй зам арга хэмжээний удирдамжийг боловсруулан Засаг даргын захирамжаар батлуулсан. | Эцэг, эх олон нийтийн оролцоотойгоор сургууль, цэцэрлэгийн эргүүл зохион байгуулан дэмжлэг үзүүлж ажиллах, сургуульд сэтгэл зүйч ажиллуулах, сургуулийн автобусны шинэлэг үйлчилгээ | 15,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>БХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | нэвтрүүлэх, хүүхдийг зам тээврийн осол, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилласан байна. | | | | |
| | | Дүүргийн Засаг даргын 2022 оны А/88 дугаар захирамжаар 13 сургууль, 35 цэцэрлэгийн хамран сургах тойргийг тогтоож, Нийслэлийн Боловсролын газарт хүргүүлэн батлуулсан.<br>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийж, 7 сургууль их эрсдэлтэй, 10 цэцэрлэг дунд эрсдэлтэй үнэлэгдсэн.<br>Ерөнхий боловсролын төрийн өмчийн 19 сургуульд сэтгэл зүйчийг ажиллуулахаар орон тоог баталж, 25,35 дугаар сургуульд сэтгэл зүйн зөвөлгөө өгөх төвийг байгуулсан.<br>Хүүхдийг аливаа төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Эергээр нөлөөлье” соён гэгээрүүлэх, нөлөөллийн аяныг 2 сарын хугацаанд зохион байгуулж, 4000 гаруй хүүхдийг оролцуулсан.<br>Хүүхдийг зам тээврийн осол, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд Замын хөдөлгөөний цагаан толгой тэмцээнийг зохион байгуулж, 25 цэцэрлэгийн 300 хүүхэд, эцэг, эхийг хамруулсан.<br>Төрийн өмчийн 6 сургууль, 1 цэцэрлэгийн 11 автобусаар 266 сурагч, төрийн бус өмчийн 9 сургуулийн 25 автобусаар 759 сурагч, нийслэлийн нийтийн тээврийн 5 чиглэлд 4 сургуулийн 264 сурагч, нийт 20 сургуульд 39 автобус үйлчилж, 1289 хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан.<br>Гэртээ харих гэрэлтэй зам арга хэмжээний хүрээнд 7 ажил төлөвлөн ажиллаж, нийт 40 гаруй мянган хүүхдийн сурах аюулгүй орчинг бүрдүүлсэн. | | | | | | |
| 46 | ДЗДҮАХ-2.5.4 | Үндэсний номын санг түшиглэн Номын баяр, өдөрлөг, арга хэмжээ зохион байгуулж, 3, 5, 12, 16 дугаар хороодын номын буланд баяжилт хийнэ. | 2020 онд 58 дугаар сургуулийн номын санг түшиглэн Номын баяр өдөрлөг зохион байгуулж 200 гаруй сурагчид хамрагдсан. 2019 онд дүүргийн Засаг даргын захирамжаар 3.5.12.16 дугаар хороодод номын булан шинээр байгуулсан. | Хороод дахь номын буланд баяжилт хийн байнгын ажиллагаатай болгоно. | 8,000.00 | Дүүргийн төсөв | НХХ Үндэсний номын сан, Хороод | 100% |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Монголын Үндэсний номын сан, Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Хүүхдийн төв номын сан, төрийн болон хувийн их, дээд сургуулийн номын сангууд “Koha”, “Lib4U” програмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, цахим үйлчилгээ үзүүлж байна.<br>Д.Сүхбаатарын талбайд 2022 оны 5, 9 дүгээр сард зохион байгуулагдсан "Номын баяр 2022” олон улсын номын баярт 10 хорооны 22 зохиолч, орчуулагч, 1000 гаруй иргэд оролцлоо.<br>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/58 дугаар тушаалаар 3,5,12,16 дугаар хороодын номын булангийн үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулан номын баяжилтад зориулан Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор, профессор Ц.Балхаажав гуайн бүтээж туурвисан “Хүн хорвоогийн нэг хэлтэрхий Монгол” 100 ширхэг ном гардууллаа. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 47 | ДЗДҮАХ-2.5.6 | Ерөнхий боловсролын сургууль бүрт сэтгэл зүйч ажиллуулахад дэмжлэг үзүүлнэ. | Ерөнхий боловсролын сургуульд сэтгэл зүйчийн орон тоо байхгүй. | Ерөнхий боловсролын 71, 45, ӨЗБЛАС-д сэтгэл зүйч ажиллуулна. | - | | НХХ БХ, ГБХЗХХ | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/327 дугаар захирамжаар төрийн өмчийн 19 сургуульд сэтгэл зүйчийн орон тоог баталж ажиллуулсан. Төрийн өмчийн 12 сургуульд, төрийн бус өмчийн Сэлбэ, Логарифм сургуулиудад сэтгэл зүйч ажиллаж байна. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран сургуулийн насны 48 хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлсэн. | | | | | | |
| 48 | МУХТ-2.3.19, НХТЖҮЧ-2.4.2 НЗДҮАХ-2.3.5. ДЗДҮАХ-2.5.8 | БСШУЯ-аас хэрэгжүүлж буй ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийн "Загвар" төсөл хэрэгжиж буй сургуулиудын гал тогооны тоног төхөөрөмжийг сайжруулахад хамтран ажиллана. | Дүүргийн ерөнхий боловсролын 58 дугаар сургуулийн гал тогоо нь стандартын шаардлага хангасан. | Хоол үйлдвэрлэлийн Загвар төсөл хэрэгжүүлж буй 5 сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн байна. | 160,000.00 | Дүүргийн төсөв | ХХҮХ МХХ | 50% |
| | | Ерөнхий боловсролын сургуулийн цайны газрын үйл ажиллагааг сайжруулах, хоол үйлдвэрлэлийн стандарт шаардлага хангасан "Жишиг" цайны газар байгуулах ажлын хүрээнд сургууль бие даан цайны газрын үйл ажиллагаагаа явуулахаар шийдвэрлэсэн 1, 16, 45 дугаар сургуулиудийн цайны газрын үйл ажиллагаатай танилцаж, хүний нөөцийн болон тоног төхөөрөмжийн хангамж, зай талбайн хүрэлцээ зэрэг бусад шалгуур үзүүлэлтийг харгалзан үзэж, ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн хичээлийн төв байрны цайны газрыг сонгон төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Тус сургуулийн цайны газарт нэн шаардлагатай 66 төрлийн тоног төхөөрөмж, эд хэрэгслийг худалдан авахад шаардлагатай 80 сая төгрөгийн үнийн саналыг хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нийлүүлдэг 2 аж ахуйн нэгжээс авч, санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. | | | | | | |
| 49 | ДЗДҮАХ-2.5.9 | Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад хог хаягдлын хор уршиг, түүнийг хэрхэн бууруулах, дахин ашиглах, хогийг ангилан ялгах дадал зуршлыг бий болгох талаар сургалт, сурталчилгаа хийж, таниулах ажлыг зохион байгуулна. | 200 иргэн, 50 ААН-д зохион байгуулсан. | Төрийн өмчийн 32 цэцэрлэг, 19 Ерөнхий боловсролын сургуульд сургалт зохион байгуулсан байна. | 20,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ ТГХШХ, СТСХ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хоггүй аялал", "Хотын түүх, соёлоо танин мэдэцгээе" аяны хүрээнд Дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсээс 2022 оны 2, 4, 5 дугаар сард Ерөнхий боловсролын 131, 58 дугаар сургуулийн 4-5 дугаар ангийн нийт 113 хүүхдэд "Дүдү музей" болон "Монголын үндэсний музей" үзүүлэн, түүхийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлж хоггүй аялах талаар уриалж ажилласан болно. | | | | | |
| 50 | ДЗДҮАХ-2.5.10 | Ерөнхий боловсролын 1 сургууль, 1 цэцэрлэгт эко, ногоон орчинг бүрдүүлэхэд шаардлагатай зураг төсөв хийлгэнэ. | - | Сургууль, цэцэрлэгийн талбайд тохижилтын зураг, төсөл хийсэн байна. | 50,000.00 | Дүүргийн төсөв | ТГХШХ | 100% |
| | | Дүүргийн 16, 150 дугаар цэцэрлэг, 6-р сургуулийн гадна орчны тохижилтын ажлын зураг төслийг боловсруулж, батлуулсан. | | | | | |
| 2.6 Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлж, тусламж үйлчилгээг сайжруулна | | | | | | | |
| 51 | МУХТ-2.5.10, 2.5.14, НХТЖҮЧ-3.1.1, 3.2.1 НЗДҮАХ-2.4.1 ДЗДҮАХ-2.6.1 | Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулан иргэдэд түргэн шуурхай, ил тод үйлчилгээг хүргэнэ. | 2021 онд нийгмийн халамжийн 76 үйлчилгээнээс 28 үйлчилгээ "Ehalamj.mn" систем рүү цахим хэлбэрт шилжиж, хүсэлт гаргасан 23977 иргэний банкны дансыг холбож, 100 хувь үйлчилгээг цахимжуулсан. | "Ehalamj.mn" халамжийн нэгдсэн системийн үйл ажиллагааг жигдрүүлж, халамжийн үйлчилгээг цахимаар иргэдэд үзүүлсэн байна. | - | | НХХ ХӨХҮХ | 100% |
| | | Нийгмийн халамжийн 13 төрлийн 215 үйлчилгээ Ehalamj.mn системрүү цахим хэлбэрт шилжиж, хүсэлт гаргасан иргэний банкны дансыг холбох үйлчилгээг 100% цахимжуулсан. Нийгмийн халамжийн сангаас халамжийн тэтгэвэр 14943 иргэнд 4,224,799,262 төгрөг, халамжийн тэтгэмж 524230 иргэнд 50,391,694,848 төгрөг, эмнэлгийн хяналтанд байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхдэд олгодог эмний хөнгөлөлт 19546 иргэнд 1,729,369,286 төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 7719 иргэнд 1,309,277,166 төгрөг, онцгой тохиолдол мөнгөн тэтгэмж 25 иргэнд 30,000,000 төгрөг, Жирэмсний тэтгэмж 7293 иргэнд 262,302,128 төгрөг, алдарт эхийн 1, 2 одонгийн тэтгэмж 8456 иргэнд 1,023,200,000 төгрөг, алдар цолтой ахмад 36 иргэнд 11,438,650 төгрөг, Насны хишиг тэтгэмж 17184 иргэнд 1,416,870,000 төгрөг, Цалинтай ээж хөтөлбөрт 42381 иргэнд 2,068,587,139 төгрөг, өрх толгойлсон эх,эцэг тэтгэмж 518 иргэнд 210,810,859 төгрөг, ихэр хүүхдийн мөнгөн тэтгэмж 26 иргэнд 52,000,000 төгрөг, ахмадын хөнгөлөлт 3642 иргэнд 563,574,700 төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмж 469709 иргэнд 46,970,900,000 төгрөг нийт давхардсан тоогоор 539173 иргэнд 54,616,494,110 төгрөгийн үйлчилгээг түргэн шуурхай, ил тод хүргэж ажиллалаа. | | | | | |
| 52 | МУХТ-2.5.10, 2.5.14, НХТЖҮЧ-3.1.1, 3.2.1 НЗДҮАХ-2.4.1 ДЗДҮАХ-2.6.2 | Зорилтот бүлгийн иргэдэд амьжиргааны бодит туслалцаа үзүүлнэ. | 2021 онд дүүргийн Засаг даргын захирамжаар нийт 8 өрхөд гэр, 16 иргэнд мөнгөн тусламж олгосон. | Зорилтот бүлгийн иргэдийн амьжиргаа дээшилсэн байна. | 40,000.00 | Дүүргийн төсөв | НХХ | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын захирамжаар 11 иргэнд 5 ханатай иж бүрэн гэр, хүнд өвчтэй, эмчилгээнд зардалд хүссэн 7 иргэнд 15,000,000 төгрөгийн буцалтгүй мөнгөн тусламж олгож , харж хандах хүнгүй ганц бие 5 ахмад настан, бүтэн өнчин 1 хүүхэд, эрх нь зөрчигдсөн 2 хүүхдийг асрамжийн газарт асруулахаар шилжүүллээ. Мөн 55 хүүхдийг үрчлүүлж, 48 хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настанд асран хамгаалагч, харгалзан дэмжигч томилон, хамтран ажиллах гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 53 | ДЗДҮАХ-2.6.3 | Иргэдийн амь нас амьжиргааг гамшиг ослоос урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангах, гамшгийн хариу арга хэмжээ, нөхөн сэргээх үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлнэ. | Гамшгийн үед хариу арга хэмжээ авах сургалтыг хийж, гамшигт өртсөн иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, хэрэгцээнд нь тулгуурлаж хүмүүнлэгийн тусламжийг хүргэж ажилласан. | Дотоодын шилжин суурьшигчдад чиглэсэн үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлсэн байна. | 80,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>УЗХ, ХЗДАА | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар 13, 14, 15, 16, 17, 19 дүгээр хороодын галд өртөж орон гэргүй болсон 7 иргэнд гэр олгосон. 1-20 дугаар хорооны зорилтот бүлгийн 220 өрхөд хүнсний багц тараасан. | | | | | | |
| 54 | | Нийгмийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг олон нийтэд тулгуурлан хэрэгжүүлж, хүчирхийлэлгүй, энх амгалан нийгмийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна. | Халдварт ба халдварт бус өвчин, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх анхан шатны сургалтыг зохион байгуулж, үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлсэн. | Усны эрүүл ахуйн талаарх олон нийтийн мэдлэг, хандлагыг сайжруулсан байна. | | | НХХ<br>УЗХ, ХЗДАА | 100% |
| | | Болзошгүй осол гэмтлийн үед үзүүлэх анхны тусламжийн 100 багцийг цэцэрлэгүүдэд хүлээлгэн өгч, анхны тусламжийн мэдлэг, чадвар олгох 4 удаагийн сургалт зохион байгуулж, 250 орчим ажилтан хамруулав.<br>Хүн амын дунд сайн дурын, авлигагүй донорын хөдөлгөөнийг сурталчилж, аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор их, дээд сургууль, томоохон аж ахуйн нэгж байгууллагуудын дунд донорын өдөрлөгийг 20 удаа зохион байгууллаа. | | | | | | |
| 55 | НХТЖҮЧ-3.1.1<br>НЗДҮАХ-2.4.2<br>ДЗДҮАХ-2.6.4 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана. | Дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийг байгуулан ажиллаж байна. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийг дэмжин ажилласан байна. | 15,000.00 | Дүүргийн төсөв | НХХ | 100% |
| | | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран 47 төрийн бус байгууллага, иргэдэд сургалт зохион байгуулж, 1-20 дугаар хороо, ӨЭМТ, томоохон зах, худалдааны төвүүд, хоолны газар, зочид буудлуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчүүлэх таатай орчныг сайжруулах арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж, уриалга хүргүүллээ.<br>Дүүргийн Засаг даргын 2022 оны "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулах тухай" А/167 дугаар захирамжаар 631 иргэнд төрийн үйлчилгээг хүргэн, зөвлөгөө мэдээлэл өгсөн.<br>Нийгмийн даатгалын багц хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд тохируулан, дохионы орчуулгатай, урсдаг хадмалтай, дуу дүрс бүхий видео танилцуулга бэлтгэн иргэдэд хүргэсэн.<br>"Монгол Абилимп–2022" мэргэжлийн ур чадварын анхдугаар уралдаанд массаж, маникюр, цэцэрлэгжүүлэлтийн төрлөөр хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэн оролцож, маникюрийн төрөлд Б.Сэргэлэн шалгарч, Олон Улсын ур чадварын уралдаанд оролцох эрхээ авсан. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 2022 оны 09 дүгээр сарын 07, 08-ны өдрүүдэд онлайнаар, хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 09 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдэд танхимаар зохион байгуулж, 22 иргэн хамрууллаа.<br>Хөгжлийн бэрхшээлтэй 319 иргэнд үнэмлэх шинээр олгож, 208 үнэмлэхний хугацааг сунгасан байна.<br>Дүүргийн Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хурал 27 удаа хуралдаж, 401 иргэний өргөдлийг хүлээн авч шинээр тогтоосон-77, сунгасан-306, цуцалсан-18, шилжсэн-3 иргэн, эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд асарч байгаа 7195 иргэнд 1,168,316,030 төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 115 иргэний ортопед, портез, тусгай хэрэгсэл авахад 19,243,400 төгрөг, рашаан сувиллын хөнгөлөлтийг 51 иргэнд 11,079,500 төгрөг олгосон. | | | | | | |
| | | **2.7 Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, дэмжин ажиллана** | | | | | | |
| 56 | ДЗДҮАХ-2.7.1 | Чуулга уулзалтыг зохион байгуулж, татвар төлөгч байгууллагыг урамшуулна. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан дүүргийн Ажил олгогчдын уулзалтыг 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж, үзэсгэлэн гаргалаа. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байраар хангасан байна. | 2,000.00 | Дүүргийн төсөв | НХХ ХөХҮХ, ААНБ | 100% |
| | | Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэстэй хамтран ажил олгогчдын чуулга уулзалтыг 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Новотел зочид буудлын хурлын танхимд зохион байгуулахаар бэлтгэл ажил бүрэн хангагдсан. Чуулга уулзалтад нутаг дэвсгэрийн 50 аж ахуйн нэгж байгууллага хамрагдана. | | | | | | |
| 57 | НХТЖҮ-3.4.1, 3.4.2, 3.4.3, 3.4.4 НЗДҮАХ-2.5.2. ДЗДҮАХ-2.7.2 | Мэргэжил олгох давтан сургалтад зорилтот бүлгийн иргэдийг хамруулна. | Ажил, мэргэжлийн чиг баримжааны ганцаарчилсан зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээг 543 иргэнд үзүүлсэн. | Зорилтот бүлгийн иргэдээс тухайн жилд батлагдан ирсэн квотоос хамааран сургасан байна. | - | | НХХ ХөХҮХ ХЗДАА | 100% |
| | | Мэргэжлийн болон давтан сургалтад хамрагдах хүсэлтэй 128 иргэнийг мэргэжил олгох сургалтад хамруулж, хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэнийг тогоочийн мэргэжил олгох сургалтад хамруулж ажлын байраар хангасан. Аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 540 сул чөлөөтэй ажлын байранд 350 ажил хайгч иргэнийг зуучлав. Нийтдээ 459 шинээр ажлын байр бүртгэн, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг 230 иргэнд хүргэн ажилласан.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих "Ногоон ажлын байр хөтөлбөр"-ийн хүрээнд 6,9,12,13,14,17 дугаар хороо, Эрин өөд ТББ, Цэвэрч 16 бүлэг, Мятав сан ТББ, Ногоон хөгжлийн төлөө ногоон гэрлээр хамтдаа ТББ, Баганаран хамтдаа ТББ-ын ажилгүй, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 267 иргэнийг 14 удаа нийтийг хамарсан ажилд хамруулж, 80,784,000 төгрөгийн ажлын хөлс олгосон. | | | | | | |
| 58 | | Өрхийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж, 20 өрхийн амьжиргааг дэмжинэ. | Хөдөлмөрийн насны 4 иргэнийг байнгын ажлын байранд, 17 иргэнийг түр ажлын байраар хангаж, нийт давхардсан тоогоор 105 иргэнд ажил мэргэжлийн чиг | Зорилтот бүлгийн 5 өрхийн хөгжлийг дэмжсэн байна. | 50,000.00 | Дүүргийн төсөв | НХХ ХөХҮХ ХЗДАА | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | баримжаа олгох зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | | | | | |
| | | Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 70 төсөл ирснээс 42 иргэний 270,000,000 төгрөгийн, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 50 төсөл ирснээс 41 иргэний 205,000,000 төгрөгийн төсөл дэмжигдсэн. Ажлын хэсгийн шийдвэрээр 38 иргэнд 349,2270,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. | | | | | | |
| 2.8 Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ. | | | | | | | | |
| 59 | НХТЖҮЧ-3.4.4, НЗДҮАХ-3.5.1 ДЗДҮАХ-2.8.1 | Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний зах зээлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, "Сүхбаатар дүүрэгт үйлдвэрлэв" борлуулалтын цэгийн үйл ажиллагааг өргөжүүлнэ. | Борлуулалтын 1 цэг ажиллуулж, 40 үйлдвэрлэл эрхлэгчийн бүтээгдэхүүнийг борлуулсан. | Дүүргийн үйлдвэрлэл эрхлэгч 50 иргэний бүтээгдэхүүнийг борлуулсан байна. | 15,000.00 | Дүүргийн төсөв | ХХҮХ ЖДҮДТ | 100% |
| | | Сүхбаатар дүүрэгт үйлдвэрлэв борлуулалтын цэгт 50 гаруй үйлдвэрлэл эрхлэгчийн үндэсний болон европ загварын хувцас, эсгий таавчиг, арьсан гутал, цүнх, ноос ноолууран хувцас, хүүхдийн болон том хүний биеийн тамирын хувцас, бэлэг дурсгалын үнэртүүлэгч лаа зэрэг 70 гаруй нэр төрлийн 1150 бараа бүтээгдэхүүнийг байршуулж 4,635,000 төгрөгийн борлуулалт хийж, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажилласан. | | | | | | |
| 60 | | Сургалт мэдээллийн төвөөр дамжуулан үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлах цахим хуудсыг идэвхтэй ажиллуулна. | Цахим хуудас ажиллуулж эхэлсэн. | Үйлдвэрлэл эрхлэгч 50-60 иргэний бүтээгдэхүүнийг танилцуулсан байна. | - | | ХХҮХ ЖДҮДТ | 100% |
| | | Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг технологийн шийдлээр дэмжиж, бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах зорилгоор дүүргийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/410 дугаар захирамжаар дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн албан ёсны Sbd.sme.ub.gov.mn вэб хуудсыг Модив ХХК-аар хийлгүүлсэн ба цахим хуудсыг бий болгосноор дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн үйл ажиллагаа, хөнгөлөлттэй ажлын байр, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих талаар төрөөс баримталж буй бодлого, хууль эрх зүйн баримт бичгүүд, үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний талаарх мэдээллийг авах боломжтой болсон.<br>Цахим хуудсанд дүүргийн 48 иргэн, ААН-ийн бичил, жижиг, дунд үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн арьс шир, ноос ноолуур, үндэсний хувцас болон европ хувцас, алт мөнгөн эдлэл, бэлэг дурсгал, органик гоо сайхны бараа бүтээгдэхүүнийг байршуулан зах зээлд сурталчлан ажилласан.<br>НЖДҮҮДТ-н байранд 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан "Япон улсад жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулах нь" сэдэвт уулзалтад 30 иргэн, ААН-ийг оролцуулж, HIS Mongolia ХХК-тай хамтран www.story.com сайтад бараа бүтээгдэхүүнээ хэрхэн байршуулж борлуулах талаарх мэдээллийг өгч, 2 үйлдвэрлэл эрхлэгчийн бараа бүтээгдэхүүний мэдээллийг байршуулсан. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 61 | | Үйлдвэрлэл эрхлэгчдийн бүртгэлийг шинэчилж, интернэт орчны үйлчилгээ үзүүлэх "Хамтын оффис"-ын үйл ажиллагааг өргөжүүлнэ. | Дүүргийн 300 үйлдвэр эрхлэгчийг бүртгэсэн. | Давхардсан тоогоор 260 үйлдвэрлэл эрхлэгчдэд "Хамтын оффис"-ын үйлчилгээг үзүүлсэн байна. | - | | ХХҮХ ЖДҮДТ | 100% |
| | | Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бүртгэлийг тогтмол хийж, шаардлагатай интернэт орчны үйлчилгээ үзүүлэх "Хамтын оффис"-ыг ажиллуулж, давхардсан тоогоор 260 гаруй иргэнийг хамруулсан. НЖДҮҮЭ-ийн Хөгжлийн төвийн болон ЖДҮДТ-ийн байранд нийт 390 гаруй иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | | | | | | |
| 62 | МУХТ-4.4.1, НХТЖҮЧ-4.1.1 НЗДҮАХ-3.1.1 ДЗДҮАХ-2.8.3 | Зорилтот бүлгийн болон үйлдвэрлэл эрхлэгчдэд ажлын байрны болон тусгай төрлийн тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй түрээсийн үйлчилгээ үзүүлнэ. | Дүүргийн 30 үйлдвэрлэл эрхлэгч, зорилтот бүлгийн 1 иргэнд ажлын байрны хөнгөлөлттэй түрээсийн үйлчилгээ үзүүлж, 53 иргэнийг ажлын байраар хангасан. | Үйлдвэрлэл эрхлэгч 50-аас доошгүй иргэн, зорилтот бүлгийн 2 иргэнийг ажлын байраар хангаж, 20 иргэн, аж ахуй нэгжид тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ үзүүлсэн байна. | - | | ХХҮХ ЖДҮДТ | 100% |
| | | Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвд 30 үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэнтэй хөнгөлөлттэй нөхцлөөр ажлын байрны түрээсийн гэрээ хийж, 53 иргэнийг ажлын байраар хангаж, "Сэлбийн рашаан" хадгаламж зээлийн хоршоо, "Итгэлийн оч, гал, дөл" ТББ-ын үйл ажиллагаа эрхлэгч 30 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үйлдвэрлэлийн ажлын байраар /2 өрөө/ хангаж хөнгөлөлттэй түрээсийн үйлчилгээг үзүүлсэн.<br>Тусгай төрлийн тоног төхөөрөмж /хатгамлын машин/-ийн түрээсийн үйлчилгээг 23 иргэнд хүргэж, үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний өнгө үзэмж, төрлийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжсэнээр 2,623,000 төгрөгийн борлуулалт хийсэн. Тус тоног төхөөрөмж нь бүх төрлийн даавуу, ноос, ноолуур сүлжмэл, цэмбэн материал дээр байгууллагын лого, зураг, хээ угалз, бичвэрийн хатгамал хийх үйлчилгээг хөнгөлөлттэй нөхцлөөр үзүүлж, канза машины оёдлын үйлчилгээг үзүүлсэн.<br>Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банктай хамтран хэрэгжүүлж буй "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд 2022 оны 01 дүгээр сарын 04-28-ны өдрүүдэд нийслэлийн бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх татвар, нийгмийн даатгал, сошиал медиа маркетинг, хүний нөөц, санхүү, менежментийн чиглэлээр 8 удаагийн сургалтад 40 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулж Азийн хөгжлийн банкнаас 6 иргэнд хүнсний болон оёдлын машины 60,000,000 төгрөгийн тоног төхөөрөмжийн буцалтгүй тусламжийг авсан.<br>Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр Инвескор ББСБ-ын зээлийн хөтөлбөрт нийт 15 иргэн, ААН-ийг бүртгэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагын зээлийн хүсэлтийг НЖДҮҮДТ-д уламжилж, 3 үйлдвэрлэл эрхлэгч 90,000,000 төгрөгийн зээлийг авч үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажилласан.<br>НЖДҮҮДТөв, Богд банк хамтран жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан 100 тэрбум төгрөгийн зээлийн хөтөлбөрт дүүргийн 55 иргэн, ААН-ийн хүсэлтийг хүлээн авч, зээлийн хүсэлтийг НЖДҮҮДТөвд хүргүүлэн ажилласан бөгөөд дүүргийн 55 ААН, иргэн нийт 17,033,609,000 төгрөгийн зээлд хамрагдсан байна. ХөХҮХ-ийн 7 хөтөлбөрт 4 үйлдвэрлэл эрхлэгч хамрагдаж 18,000,000 төгрөгийн зээлийг авсан. | | | | | | |
| 63 | ДЗДҮАХ-2.8.4 | Үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхжуулах зорилгоор | 10 удаагийн танхимын болон цахим сургалтад | 10 удаагийн сургалтад 280, | 8,000.00 | Дүүргийн төсөв | ХХҮХ ЖДҮДТ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бизнесийн чиглэлээр танхимын болон цахим сургалтад хамруулж, туршлага солилцох бизнес аяллыг зохион байгуулна. | давхардсан тоогоор 500 гаруй иргэнийг хамруулсан. | танилцах аялалд 50 бизнес эрхлэгчийг хамруулсан байна. | | | | |
| | | Жижиг, дунд үйлдвэрийн газар, Зээлийн батлан даалтын сан, Нийслэлийн бизнес инновац хөгжлийн газар,НЖДҮҮДТ, Сүхбаатар дүүргийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Сүхбаатар дүүргийн Насан Туршийн Боловсролын төв, "Бодлогын шийдэл" ТББ, Best хөтөлбөр, Жайка ОУБ, GIZ олон улсын байгууллага, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Монголбанк, СЗХ, ХДК, ЖДҮГ, НЖДҮҮДТ, ЗБДС, МБХ, МҮХАҮТ, ХДК, Шинлэх ухаан технологийн сан, Мэдээлэл технологийн үндэсний парк, Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран танхимын 24, цахим 29, нийт 53 удаагийн сургалтад 415 иргэн, аж ахуй нэгжийг хамруулсан.<br>Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 15 иргэн, ААН -ийн төлөөллүүд 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр арьсан гутлын томоохон үйлдвэрлэл Хүүгийн гутал ХХК-ийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлтэй танилцах биенес аялалд хамрагдан, харилцан санал солилцож, туршлага судаллаа.<br>2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулагдсан "Цар тахлын нөлөөнд өртсөн Улаанбаатар хотын ЖДҮҮ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх богино хугацааны төлөвлөгөө"-ний сургалтад 15 үйлдвэрлэл эрхлэгчийг хамруулсан.<br>НЗДТГ, НЖДҮҮДТ, Бизнес академи хамтарсан 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Ковидын дараах бизнесийг эрчимжүүлэх менежментийн хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын дэмжлэгтэйгээр 70%-ийн хөнгөлөлттэй үнээр хамрагдах сургалтад 6 бизнес эрхлэгчийг оролцуулсан. | | | | | | |
| 64 | | Мэргэжлийн холбоодтой хамтран тэмцээн уралдаан, уулзалт, арга хэмжээг зохион байгуулж, шилдэг үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг сурталчлан, урамшуулах ажлыг зохион байгуулна. | 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, 50 гаруй үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулсан. | 120-аас доошгүй иргэнийг хамруулж, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлсэн байна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | ХХҮХ ЖДҮДТ | 100% |
| | | Соёлын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч уламжлалт гар урлалыг дэмжих, хөгжүүлэх боломж, шийдэл - 2022 нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдах чадавхжуулах сургалт, үзэсгэлэн худалдаа, форум хэлэлцүүлэг, шилдэг иргэн, ААН-ийг шалгаруулалт 11 дүгээр сарын 7,8,9-ний өдрүүдэд болсон арга хэмжээнд дүүргийн 130 гаруй гар урлаачдыг оролцуулан, бараа бүтээгдэхүүнийг танилцуулан, борлуулалтын сувгийг нэмэгдүүлж ажилласан.<br>Монгол Улсаас БНХАУ-ын Шанхай хотод суугаа Ерөнхий консулын газар болон "Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв" НӨҮГ-с хамтран 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан "ЖДҮҮ эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг БНХАУ-д экспортлох нь" сэдэвт хэлэлцүүлэгт бараа бүтээгдэхүүнээ экспортод гаргах сонирхолтой дүүргийн 10 бизнес эрхлэгчийг танхимаар, 26 бизнес эрхлэгчийг цахимаар оролцуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Монгол-ОХУ хоёр орны хүнсний бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ, барилгын дулаалгын чиглэлийн "Азия", "Байкал экспо", "Трубофлекс" компаниуд, ОХУ-ын Буриадын Экспортыг дэмжих төв болон дүүргийн ЖДҮДТ-ийн хамтран зохион байгуулсан 2 удаагийн хэлэлцүүлэг, бизнес уулзалтуудад нийт 60 гаруй жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хамруулж, санал солилцлоо. | | | | | | |
| 65 | НХТЖҮЧ-3.4.4, НЗДҮАХ-3.5.4 ДЗДҮАХ-2.8.5 | Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, дотоод гадаадын үзэсгэлэн, яармаг худалдаанд хамруулж, бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг нэмэгдүүлнэ. | Гадаад, дотоодын 11 удаагийн үзэсгэлэн худалдаанд 92 үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин оролцуулсан. | Дотоод, гадаадын үзэсгэлэн худалдаанд 60 үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин оролцуулсан байна. | 15,000.00 | Дүүргийн төсөв | ХХҮХ ЖДҮДТ | 100% |
| | | Нийт 14 удаагийн үзэсгэлэнд 88 үйлдвэрлэл эрхлэгчид оролцож 113,446,000 төгрөгийн борлуулалт хийж, борлуулалтын сувгийг нэмэгдүүлсэн.Үүнд:<br>- Цагаан сар бараа бүтээгдэхүүний худалдаа-2022 үзэсгэлэн худалдаанд 13, 18-р хорооны ноос ноолуур, үндэсний хувцасны чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгдийг оролцуулж, 15,120,000 төгрөгийн борлуулалт хийсэн.<br>- Нийслэлийн ЗДТГ-аас Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан Их хотын бүсгүйчүүд 2022 арга хэмжээний үеэр зохион байгуулсан үзэсгэлэнд 3, 13 хорооны ноос ноолуур, органик гоо сайхан, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 1 иргэн, 1 ААН-ийг оролцуулж, 890,000 төгрөгийн борлуулалт хийсэн.<br>- Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, 2 удаа зохион байгуулсан Амралтын өдрийн худалдаа, Дээлтэй монгол наадам, Нүүдэлчин монгол 2022 Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулагдсан нийт 6 удаагийн үзэсгэлэн худалдаанд 40 гаруй үйлдвэрлэл эрхлэгчид 60 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнтэйгээр оролцож, 40,561,000 төгрөгийн борлуулалт тус тус хийсэн.<br>- Жижиг дунд үйлдвэрийн өдөр 2022 үзэсгэлэн худалдаанд дүүргийн 9 үйлдвэрлэл эрхлэгч 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнтэй оролцож 12,962,000 төгрөг, Ардын хувьсгалын 100,101 жилийн ой, Үндэсний их баяр наадмын үзэсгэлэнд 10 үйлдвэрлэл эрхлэгч 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 21,113,000 төгрөгийн борлуулалттай ажилласан.<br>Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төвөөс зохион байгуулсан Days4sme expo-2022 үзэсгэлэн худалдаанд Монгол үндэсний хадлан дээл, эмийн ургамал, жимс жимсгэнэ, цагаан идээ, эмэгтэй бэлэн хувцас, ноос ноолуур, зөгийн бал үйлдвэрлэгч 10 иргэн, ААН-ийг хамруулж, 21,730,000 төгрөгийн борлуулалттай ажилласан. | | | | | | |
| 2.9 Соёлын үйл ажиллагааг дэмжиж, түгээн дэлгэрүүлнэ. | | | | | | | | |
| 66 | НХТЖҮ-3.4.1, 3.4.2, 3.4.3, 3.4.4 НЗДҮАХ-2.5.2. ДЗДҮАХ-2.7.4 | Ажлын байр бий болгосон байгууллагыг дэмжин урамшуулна. | 2021 онд "Мөнхцаглашгүй" ХХК, "Универсум" ХХК–ууд зорилтот бүлгийн ажил хайгч 2 иргэнийг ажилд авч, ажил олгогчийг дэмжих гэрээ байгуулсан. Хөтөлбөрийн дагуу | Оюутан залуучуудын ажлын байрыг нэмэгдүүлсэн байна. | - | | НХХ ХөХҮХ ХЗДАА | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эдгээр иргэдийг 12 сараас дээш хугацаагаар ажиллуулсан тохиолдолд, гэрээг 2022 онд дүгнэж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр ажил олгогчид нарт олгоно. | | | | | |
| | | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд цэргээс халагдсан залуусыг ажилд зуучлах, хөтөлбөр танилцуулах өдөрлөг зохион байгуулж, 84 залуусыг ажлын байранд зуучлах, сургуульд суралцах боломжуудын талаар зөвлөгөө, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн талаар мэдээлэл өгч, хөдөлмөр эрхлэлтийн "Загвар төв"-ийн сургалтанд хамрууллаа. Үйлдвэр үрлалын политехник коллежтой хамтран 100 оюутан, залууст өдөрлөг зохион байгууллаа. | | | | | | |
| 67 | НХТЖҮЧ-3.4.4, НЗДҮАХ-3.5.4 ДЗДҮАХ-2.8.2 | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж байгууллагуудыг хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгт хамруулна. | "Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээ"-ний жижиг зээлийн хүрээнд нийт 61 иргэн төсөл ирүүлснээс 52 төслийг "ХААН" банканд уламжилж, 20 иргэний төсөл дэмжигдэж, 181,500,000 төгрөгийн санхүүжилт авсан. Санхүүжилт олгогдсоны үр дүнд 34 ажлын байр хадгалагдаж, шинээр 6 ажлын байр бий болсон. | Хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгийн тоо, хувийг нэмэгдүүлнэ. | - | | НХХ ХөХҮХ | 100% |
| | | Жижиг зээлийн төслийн талаар 36 иргэнд мэдээлэл өгснөөс 6 иргэний бизнесийн төслийг хүлээн авч 5 төсөл дэмжигдэн, Хаан банканд хүргүүлж, зээлийг судалж байна.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг хүссэн 70 иргэн төслөө ирүүлснээс ажлын хэсгийн шийдвэрээр 42 иргэний 270,000,000 төгрөгийн төсөл дэмжигдсэн. Мөн санхүүгийн дэмжлэг авахаар төсөл өгсөн 70 иргэнд аж ахуй эрхлэлтийн зээлийн өмнөх нэг өдрийн сургалт зохион байгуулах 2 сургалтын байгууллагыг сонгон гэрээ байгуулсан. Гэрээний дагуу 60 иргэн сургалтад хамрагдаж, сургалтын зардалд 1,020,000 төгрөг зарцуулагдсан. | | | | | | |
| 68 | НЗДҮАХ-2.6.1. ДЗДҮАХ-2.9.1 | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд "Хүрэл тулга", "Уран | 2019 онд Уран жиргээ наадамд нийт 153 хүүхэд оролцож, шалгарсан 16 хүүхэд нийслэлийн | Улс, нийслэлийн уралдаан тэмцээнд оролцуулж, амжилт гаргасан байна. | 3,000.00 | Дүүргийн төсөв | НХХ БХ | 0% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | жиргээ" уралдаан зохион байгуулна. | шалгаруулалтад оролцсон. | | | | | |
| | | Нийслэлийн Соёл урлагийн газраас удирдамж, чиглэл ирээгүй байна. | | | | | | |
| 69 | | ЕБС-ийн сурагчдын дунд хүүхдийн найрал дууны наадам зохион байгуулна. | 2019 онд ерөнхий боловсролын 9 сургуулийн 1000 орчим сурагчид оролцсон. | Улс, нийслэлийн уралдаан тэмцээнд оролцуулж, амжилт гаргасан байна. | 7,000.00 | Дүүргийн төсөв | НХХ НСУГ,БХ,ЕБС | 100% |
| | | Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Дагвын Лувсаншаравын нэрэмжит "Хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг" шалгаруулах 28 дахь удаагийн уралдааны нэгдүгээр шатны шалгаруулалтыг 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Монголын хүүхдийн урлан бүтээх төвд зохион байгуулж, ерөнхий боловсролын 8 сургуулийн 500-аад сурагч оролцов. I байрт 2 дугаар сургууль, II байрт Логарифм сургууль, III байрт 3 дугаар сургууль, Шилдэг найруулагч багшаар Логарифм сургуулийн Хөгжмийн багш Д.Пүрэвжаргал, Шилдэг удирдаач багшаар 11 дүгээр сургуулийн Хөгжмийн багш С.Цэрэнпил тус тус шалгарч, дүүргийн Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнууллаа. Энэхүү наадамд оролцсон бусад оролцогч сургуулиудад дүүргийн Засаг даргын БАТЛАМЖ гардууллаа. | | | | | | |
| 70 | | Дээлтэй Монгол наадам зохион байгуулж, оролцоно. | 2017, 2018 онд дэд байрт, 2019 онд Тэргүүн байрт тус тус шалгарсан. | Үндэсний өв соёлыг хадгалж, түгээн дэлгэрүүлсэн байна. | 9,000.00 | Дүүргийн төсөв | НХХ НАЖГ | 100% |
| | | Дээлтэй Монгол 2022 наадамд 8-12 насны хүүхдүүд, Тамгын газрын ажилтан, албан хаагчид, 1-20 дугаар хорооны ажлын алба, иргэд, соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчид, "Дээлтэй Монгол" наадмын бэлэгдэл хөх, улаан, шар, ногоон өнгийн дээл хувцсаар гоён, дээлийн өнгөөр ижилсэн жагсаж, уран бичлэг, уран дарханы урлалын гэр асарт үзэсгэлэн гаргаж, Монгол бичгийн каллиграфийн сургалтыг зохион байгуулж, оролцсон иргэд өөрсдийн нэрсийг уран бичлэгээр бичиж сурсан. Энэ үйл ажиллагаагаараа нийслэлийн хэмжээнд 3-р байрт шалгаран шагнуулсан. | | | | | | |
| 71 | | Хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх зорилгоор урлагийн наадмыг зохион байгуулна. | ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд "Бидний авьяас" Урлагийн наадам зохион байгуулсан. | Хүүхдийн авьяас чадварыг нээж хөгжүүлж, энэ наадмыг уламжлал болгон зохион байгуулна. | 30,000.00 | Дүүргийн төсөв | НХХ БХ,ЕБС, цэцэрлэг | 0% |
| | | Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6 дахь заалтад заасны дагуу урлагийн наадам зохион байгуулах боломжгүй, тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан. | | | | | | |
| 72 | | Соёл урлагийн байгууллагуудтай хамтран хүүхэд, залуучууд, иргэдийг соёлын боловсрол олгох үзвэр үйлчилгээ, арга хэмжээнд хамруулна. | Соёлын цаг хөтөлбөрийг хэрэгжүүлж, мэргэжлийн урлагийн 9 байгууллагын 42 удаагийн тоглолт зохион байгуулж, 3020 үзэгч хамрагдсан. | Хүүхэд, залуучуудад соёл, урлагийн үйлчилгээ хүрсэн байна. | 10,000.00 | Дүүргийн төсөв | НХХ НСУГ | 100% |
| | | Монгол улсын Засгийн газрын 2007 оны Журам батлах тухай 257 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган, угийн бичиг хөтөлдөг 167 өрх, ургийн баяр хийсэн 11 өрх, угийн бичгийн сургалтад хамрагдсан 49 иргэний судалгааг нийслэлийн Соёл урлагийн газарт хүргүүллээ. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Ерөнхий боловсролын 131, 58 дугаар сургуулийн 4-5 дугаар ангийн нийт 113 хүүхдэд "Дүдү музей", "Монголын үндэсний музей" үзүүллээ.<br>"Нүүдэлчин Монгол-2022" соёлын биет бус өвийн их наадмын нэгдүгээр шатны шалгаруулалтын ардын язгуур урлагт 7, уламжлалт гар урлалд 7 нийт 14 өвлөн уламжлагч 2 ай сав төрөлд оролцсоноос ардын язгуур урлагийн төрөлд 2, уламжлалт гар урлал төрөлд 3, уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага төрөлд 2 өвлөн уламжлагч шалгарсан. Уг наадмын 2 дугаар шатны шалгаруулалт Горхи Тэрэлж цогцолборт зохион байгуулагдаж, ардын язгуур урлагийн төрлөөр багаараа 2 дугаар байрт шалгарч, Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнууллаа. | | | | | | |
| 73 | ДЗДҮАХ-2.9.2 | Залуучуудын хөгжлийн зөвлөл байгуулж, үйл ажиллагааг дэмжин ажиллана. | | Хүүхэд, залуучуудын хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулсан байна. | 200,000.00 | Дүүргийн төсөв | НХХ | 100% |
| | | Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2019 оны А/339 тоот захирамжаар 30 байгууллагын дэргэд залуучуудын салбар зөвлөл байгуулагдан мэдээллээ танхимаар 1,394, цахимаар 13,760 иргэнд хүргэлээ.<br>Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, Хүүхдийн зөвлөлтэй хамтран залуучуудын 200 төлөөллийг оролцуулсан "Залуучуудын хөгжилд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам" сэдэвт цахим болон танхимын хэлэлцүүлгийг зохион байгуулж, "Залуучуудын хөгжлийг дэмжих талаар төрөөс баримталж буй бодлого, дүүргийн залуучуудын статистик тоо баримт, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнес, нийгмийн оролцоо, хувь хүний хөгжил, эрүүл мэнд, боловсрол, санал санаачилгыг дэмжих, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замын талаар" илтгэл тавьж, цаашид хийх ажил, арга хэмжээний талаар танилцуулж санал бодлоо солилцлоо. | | | | | | |
| 74 | | Залуучуудыг хотын соёлд суралцуулах, сөрөг зан үйл хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулна. | 15-34 насны ахлах ангийн болон оюутан 100 залуучуудыг хамруулсан. | Нэмж 100 залуусыг хамруулсан байна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>ГБХЗХХ | 100% |
| | | "Нандин үерхэл" нөлөөллийн арга хэмжээг нөхөн үржихүйн эрүүл мэнд, өсвөр үеийн жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга хэлбэр, гэр бүлийн үнэ цэнэ, хосын харилцаа болон үерхэл, хайр дурлалын ялгаа зэрэг сэдвээр ерөнхий боловсролын 4, 35, Логарифм сургуулийн 380 ахлах ангийн сурагчдыг хамруулан зохион байгуулсан.<br>Хорт зуршил, сэтгэцэд нөлөөлөх донтолтоос урьдчилан сэргийлэх 4 удаагийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд 378 залуусыг хамруулан, цахимаар 8,780 иргэнд зохион байгууллаа.<br>Олон улсын Аавуудын өдрийг тохиолдуулан "Миний хайртай аав" гар зургийн уралдаан, аав хүүхдийн дунд хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулж, оролцогсдод дурсгалын зүйл гардуулав.<br>"Хотын соёл-Хариуцлагатай иргэн" аяны хүрээнд 14,15,16,17,18 дугаар хороодод өдөрлөг зохион байгуулж, Амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх 12 модуль 20 удаагийн давтамжтай шаталсан сургалтад эрсдэлд өртөх магадлалтай мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 46 оюутан, Ерөнхий боловсролын 2, 3, 6, 16, 45, 35, 58, 71 дүгээр сургуулийн 1402 сурагч, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авч байгаа 4 хүүхэд нийт 1406 оюутан, сурагчдыг хамруулсан. | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 75 | | Нийслэлийн залуучуудын 10 зөв дадал, Амьдрах ухааны чадвар олгох 12 модуль сургалт зохион байгуулна. | Нийт 3000 өсвөр үеийн залуучуудыг хамруулсан. | Жил бүр 3000 өсвөр үеийн залуучуудыг хамруулсан байна. | 1,000.00 | Дүүргийн төсөв | НХХ ГБХЗХХ | 100% |
| | | Амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх 12 модуль сургалтыг эрсдэлд өртөх магадлалтай Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн коллежийн 40 оюутан, Ерөнхий боловсролын ахлах ангийн 12 сургуулийн 2157 сурагчид, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авч байгаа 11 хүүхэд нийт 2208 хүүхдийг хамруулан зохион байгуулсан.<br>Нийслэлийн залуучуудын 10 зөв дадал сургалтыг Ерөнхий боловсролын 1,6,31,45, МОХ-3, ӨЗБЛАС сургуулийн 832 сурагчдад, 2,3,4,16 сургуулийн 562 сурагчдад, 35,58,71 сургуулийн 489 сурагчдад нийт 1883 сурагчдад үе шаттайгаар зохион байгууллаа. | | | | | | |
| 76 | ДЗДҮАХ-2.9.3 | Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хөшөө дурсгалт газруудын арчлалт хамгаалалтыг сайжруулах хяналт, шалгалт хийж, холбогдох газартай хамтран ажиллана. | Дурсгалт газруудын хадгалалт хамгаалалтад тогтмол хяналт тавин ажиллаж, 42 дурсгалд кадастрын зураглал хийлгэсэн. | Түүх соёлын үл хөдлөх хөшөө дурсгалын арчлалт, хамгаалалтыг сайжруулж, нөхөн сэргээсэн байна. | 4,000.00 | Дүүргийн төсөв | НХХ ТНААХ | 100% |
| | | 20-р хорооны “Бэлхийн Хүннүгийн язгууртны булш” дээр дурсгалын багана босгох асуудлыг дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 4 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 4/10 дугаар тогтоолоор дэмжигдсэн. Уг тогтоолыг дүүргийн Засаг даргын 2022 оны 2/376 тоот албан бичгээр нийслэлийн Аялал жуулчлалын газарт хүргүүлсэн.<br>Дүүргийн Засаг даргын 2022 оны А/128, А/173 дугаар захирамжийн дагуу 1,2,4,6,8,15-р хорооны нийт 31 түүх соёлын хөшөө, баримлыг угааж цэвэрлэн, өнгө үзэмжийг сайжруулан, Данбадаржайлан хийдийн барилгыг хэсэгчилэн засварлалаа.<br>Нийслэлийн соёл урлагийн газартай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 57 түүх, соёлын үл хөдлөх дурсгалын кадастрын хэмжилт хийж, зурагжуулан бүртгэлжүүлэв. | | | | | | |
| | | 2.10 Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжин, гэр бүлийн тогтвортой байдлыг хангаң ажиллана. | | | | | | |
| 77 | НХТЖҮЧ-2.12.1, 2.14.1, 2.14.3, 2.12.4 НЗДҮАХ-2.7.1 ДЗДҮАХ-2.10.3 | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллана. | 70% | 90% | 16,000.00 | Дүүргийн төсөв | ЦГ ГХУСАЗСЗ, ГБХЗХ | 100% |
| | | Хүүхдийн эрх хамгааллын хөдөлгөөний хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх зөрчигдөх, хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эцэг эхчүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, олон нийт, хүүхэд, залуус руу чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах зорилгоор богино хэмжээний видео бэлтгэхэд 550,000 төгрөгний санал бичиж Сүхбаатар дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлд хүргүүлсэн ба Нийслэлийн Сүхбаатар дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын А/77, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын А/70 дугаартай захирамж гаргуулан Хүүхдийн эрх хамгааллын хөдөлгөөний хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх зөрчигдөх, хүүхдийн | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эцэг эхчүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн богино хэмжээний видео контентийг мэргэжлийн байгууллагатай хамтран бүтээж олон нийтэд цахим сүлжээгээр хүргэсэн. Дүүргийн цагдаагийн газраас иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 2022.04.30-ны өдөр Сүхбаатарын талбайд "Нээлттэй хаалга"-ны өдөрлөгийг зохион байгуулж Монгол Улсын үндсэн хууль, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийн талаар мэдээлэл хүргэж ажилласан. Нийт 65 иргэн хуулийн зөвлөгөө мэдээлэл авч, санал асуулгад оролцсон ба иргэдэд гарын авлага бэлтгэн тарааж хууль сурталчилсан.<br>Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, нуугдмал хүчирхийллийг илрүүлэх, зөрчлийн шийдвэрлэлтийг ахиулах, хүчирхийллийн хор уршгийг олон нийтэд таниулах, алба хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор "Хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх" тусгай арга хэмжээг 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл зохион байгуулахаар төлөвлөгөө гарган ажилласан..<br>Арга хэмжээний хүрээнд ахлах байцаагч, мэргэжилтэн нараас гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага мэдээллийг удаа дараа нэг хаяг, утаснаас ирүүлж байгаа 8 айл өрхөөр орж 5 хохирогч, холбогдогчидтой уулзаж гэр бүлийн тэгш бус харилцаа, хохирогчийн эрхийг хамгаалах, хүчирхийллийн хор уршиг, хүлээлгэх хариуцлагын талаар ухуулга нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. | | | | | | |
| 78 | НХТЖҮЧ-2.12.1, 2.14.1, 2.14.3, 2.12.4 НЗДҮАХ-2.7.1 ДЗДҮАХ-2.9.4 | Зөв нөлөөлөл-Зөв иргэн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | - | 299 дүгээр цэцэрлэгийн багш-эцэг, эх- хүүхдийг сэтгэл зүйн болон хувь хүний хөгжлийн сургалтад хамруулсан байна. | 19,000.00 | Дүүргийн төсөв | НХХ | 100% |
| | | "Гэр бүл хөгжлийн институт", "MIND" сэтгэл судлалын төвтэй хамтран 299 дүгээр цэцэрлэгийн 28 багш ажилтан, 90 хүүхэд, 253 эцэг эх, асран хамгаалагчдыг хамруулан "Зөв нөлөөлөл-Зөв иргэн" хөтөлбөрт сургалт зохион байгуулан "Бага насны хүүхдийн сэтгэлзүй болон хөгжлийн онцлог, хэрэгцээ сэтгэл хөдлөл, мэдрэмжийн илэрхийлэл, зан үйлийн онцлог", "Хүүхэд хамгаалал,хууль эрх зүй"-н талаар мэдлэг мэдээлэл олгосон. Эерэг харилцааг бэхжүүлж "Зөв дадлын самбар"-ыг ажиллуулж хэвшүүлсэн. | | | | | | |
| 79 | НХТЖҮЧ-2.12.1, 2.14.1, 2.14.3, 2.12.4 НЗДҮАХ-2.7.1 ДЗДҮАХ-2.10.4 | Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөгсдөд үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаар дэмжин ажиллана. | Нэг цэгийн үйлчилгээний төвөөр нийт 14 насанд хүрэгч, 162 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн. | Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд хамгааллын болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлсэн байна. | - | | НХХ | 100% |
| | | Нэг цэгийн үйлчилгээний төв-хамгаалах байранд цагдаагийн аюулын зэргийн үнэлгээ, хүүхдийн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн нийт 131 үйлчлүүлэгч хүлээн авч, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн. Үүнээс насанд хүрэгч-3, хүүхэд-128 үйлчлүүлсэн бөгөөд хөгжлийн хөтөлбөрөөр дамжуулан хүүхдийн насны онцлогт тохируулан өөртөө үйлчлэх чадвар, харилцааны чадвар, хооллолт, аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулан, үндэсний өв уламжлалыг өвлүүлэх чиглэлээр ажилласан.<br>Азийн хөгжлийн сангийн 15,338,000 төгрөгийн санхүүжилтээр сантехникийн, орон нутгийн төсвийн 42,490,0 төгрөгөөр урсгал засвар хийлээ. | | | | | | |
| 80 | | Алдарт эхийн одонтой эхчүүдийг алдаршуулна. | Дүүргийн 351 эх алдарт эхийн 1, 2 дугаар зэргийн одон авсан. | Алдарт эхийн одонтой эхчүүдийг алдаршуулсан байна. | 150,000.00 | Дүүргийн төсөв | НХХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Алдарт эхийн 1 дүгээр зэргийн одонтой 1711, 2 дугаар зэргийн одонтой 5938, нийт 7649 эхчүүдийн судалгааг нэгтгэн олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан өөрийн ажилладаг салбартаа манлайлсан шилдэг эмэгтэйчүүдийг тодруулан "Алунгоо" ёслолын ажиллагааг зохион байгуулж, 9 номинациар шалгаруулж, "Алунгоо" цом, өргөмжлөлөөр шагнан алдаршууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 495 эхчүүд "Алдарт эхийн одон"-гоо гардан авлаа | | | | | | |
| 81 | | Хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага, оны шилдэг хүүхэд шалгаруулна. | Хүүхэд, гэр бүлд ээлтэй 4 байгууллага шалгарсан. Оны шилдэг хүүхдээр төрийн болон төрийн бус өмчийн ЕБС, хүүхдийн оролцооны байгууллагаас 40 хүүхэд шалгарсан | Хүүхэд, гэр бүлд ээлтэй аж ахуйн нэгж, байгууллага нэмэгдсэн байна. Сурлага, урлаг, спортын амжилт гаргасан сурагчдын амжилт ахисан байна. | 8,500.00 | Дүүргийн төсөв | НХХ | 100% |
| | | Гэр бүлийг дэмжигч шилдэг аж ахуй нэгж, байгууллагаар 14 дүгээр хороо, 1 дүгээр сургууль, 166 дугаар цэцэрлэг, "Өгөөж чихэр боов" ХХК шалгарлаа.<br>"Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ"-г 14 цэцэрлэг, 12 сургуульд хүргэж зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. Байгууллагын дэргэдэх 51 эцэг эхийн зөвлөлийг чадавхжуулах зөвлөгөөнийг зохион байгууллаа.<br>Хүүхдийн чуулганыг зохион байгуулж гарсан санал, санаачилгыг шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад хүргэн амлалт авлаа. Оны онцлох хүүхдээр 40 хүүхдийг шалгаруулан, дүүргийн "Шилдэг хүүхэд" медаль, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулав. | | | | | | |
| 82 | | Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрлөг зохион байгуулна. | Зорилтот бүлгийн 483 /хөгжлийн бэрхшээлтэй/ хүүхэд хамрагдсан. | Хүүхэд - Гэр бүлийн баяр баясгалан өдөрлөг зохион байгуулсан байна. | 20,000.00 | Дүүргийн төсөв | НХХ | 100% |
| | | Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зорилтот бүлгийн 2045 хүүхдийн оролцоотойгоор хүүхдийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэв.<br>Хүүхдийн баярын хүндэтгэлийн нэгдсэн жагсаалд 80 гаруй хүүхэд, эцэг эх оролцлоо. | | | | | | |
| 83 | | Хараа хяналтгүй болон хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулна. | Илрүүлэг арга хэмжээг 4 удаа зохион байгуулж. 23 хүүхдийг илрүүлэн эрүүл мэндийн болон холбон зуучлах үйлчилгээ үзүүлсэн. | Арга хэмжээг улирал бүр зохион байгуулж, хараа хяналтгүй хүүхэдгүй болсон байна. | - | | НХХ | 100% |
| | | "Илрүүлэлт 2022" нэгдсэн арга хэмжээг дүүргийн Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Улаан загалмайн хороотой хамтран томоохон зах, худалдааны төв, авто угаалгын газар, зочид буудлуудад хяналт шалгалтыг хийж хараа хяналт сул, хөдөлмөр эрхлэгч 10 хүүхдийг илрүүлэн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд хамруулалаа. Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн 12 дугаар зөвлөмжийг 49 аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргэлээ.<br>Туул голын эрэг дагуу үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх 16 удаагийн эргүүл шалгалтыг хийж 1766 иргэнд 1007ш сэрэмжлүүлэг, зөвлөмж тараав. | | | | | | |
| 84 | | Хамтарсан багийг чадавхжуулах сургалт, нөлөөллийн арга | Хамтарсан багийн өргөтгөсөн сургалтыг 2 удаа, ажлын байран | Сургууль, гэр бүлийн орчинд хүүхдийн | 7,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>ГБХЗХХ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулна. | дахь сургалт, нөлөөллийн ажлыг 20 удаа зохион байгуулсан. | хүчирхийлэл багассан байна. | | | | |
| | | Хүүхдийн тусламжийн утас 108 болон иргэдээс ирсэн нийт 480 дуудлага мэдээлэлд хамтарсан багаар үйлчилгээ үзүүлсэн. Хамтарсан багт 5 удаагийн зөвлөн туслах, нийгмийн ажилтнуудыг ажлын байранд нь чадавхжуулах, “НАМС программ”-ийн ашиглалт, мэдлэг, чадвар эзэмшүүлэх зэрэг 4 удаагийн сургалт, хамтарсан багийн үйл ажиллагааг дүгнэх, сурталчлах, чадваржуулах “Чадварлаг баг-чанар, үр дүн” арга зүйн ажлыг зохион байгуулсан.<br>Сургууль цэцэрлэгийн орчны аюулгүй байдалд үнэлгээ хийж, School police-н үйл ажиллагаанд дэмжлэг үзүүллээ. | | | | | |
| 85 | | Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжиж, урамшуулна. | Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжиж "Бид хариуцлагатай хамтарсан баг" уралдаан зохион байгуулж 20 хороонд урамшуулал олгосон | Хамтарсан багийн үйл ажиллагаа идэвхжиж, хамтарсан багийн гишүүд тогтвор суурьшилтай ажилласан байна. | 60,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>ГБХЗХХ | 100% |
| | | Дүүргийн 20 хорооны хамтарсан багт хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативын дагуу хамтарсан багийн жилийн ажлын тайлан, кейс шийдвэрлэлтийг танилцууллаа. Хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, багуудад урамшуулал олголоо. | | | | | |
| | | **2.11 Ахмад настны хөгжил, хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлнэ** | | | | | |
| 86 | ДЗДҮАХ-2.11.1 | Ахмад настны хөгжил хамгааллын дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Дүүргийн ИТХ-ын 2020 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 17 дугаар тогтоолоор “Ахмад настны хөгжил хамгааллын дэд хөтөлбөр”-ийг батлуулсан. | Дэд хөтөлбөрийн эхний үе шатыг хэрэгжүүлсэн байна. | 100,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>АХ,<br>ХЗДАА | 100% |
| | | Нийт 17808 ахмадын мэдээллийн санг шинэчлэн баяжилт хийж, программ хангамжийн дата бааз бүрдүүлсэн.<br>Ахмадын хөгжлийн танхим, Сэргээн засах өрөө, Зөвлөгөө мэдээллийн танхимаар 4 удаагийн сургалт, өдөрлөг, 2 удаагийн хэлэлцүүлэг хийж, гүйлтийн зам, фитнес дугуй, массажны сандал, эмчилгээний массажны ор, сэргээн засах өдрийн үйлчилгээнд 1710 гаруй ахмадыг хамруулж, хөдөлгөөний хомсдлоос сэргийлэх, эрүүлжих боломжоор хангасан. Танин мэдэхүйн чиглэлээр Данзанравжаа, Дүрслэх урлаг, Жавзандамба хутагтын ордон музейг 212 ахмадад үзүүллээ.<br>Ахмадын спортын 6-р наадамд 50 тамирчдыг 6 төрлөөр бэлтгэн оролцуулж, софт волейболын төрөлд 2 насны ангиллаар 2 мөнгөн медаль, гүйлт, дартсын төрлөөр хүрэл медаль, граунд гольфийн төрлөөр 20 алтан бөмбөгийн шагнал авсан.<br>Илүүдэл жингүй-Эртэч монгол аянд 1892 ахмад оролцож, Биеийн тамир спортын хорооны талархал, дүүргийн Спортын хорооны өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан. | | | | | |
| 87 | ДЗДҮАХ--2.11.2 | Дүүргийн Ахмадын хөгжлийн төвийн барилга барина. | - | Ахмадын хөгжлийн барилгын ажил эхэлсэн байна. | 900,000.00 | Дүүргийн төсөв | НХХ<br>ТГХШХ<br>АХ,<br>ХЗДАА | 95% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дүүргийн 14 дүгээр хороонд Ахмад хөгжлийн төвийн 2 давхар нийт 350м2 талбайтай барилга барих ажлыг 900 сая төгрөгөөр барилга угрсалтын ажлыг хэрэгжүүлж байна. Барилгын өрлөг угсралт, дээвэр, гадна фасад, шавардлага, цонх, 2 давхарын шалны ажил бүрэн дууссан, цахилгааны кабель татсан, гадна бохир, халаалтын шугам сүлжээ холбосон. Барилга угсралтын ажил нь дууссан гүйцэтгэл 95%-тай хэрэгжиж байна. | | | | | | |
| 88 | | Нийтээр тэмдэглэх Сар шинийн баяр, Монголын ахмадын өдрийг угтсан хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулна. | Нийт 4050 ахмадад хүндэтгэл үзүүлсэн. | Тэмдэглэлт өдрүүдэд хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулсан байна. | 250,000.00 | Дүүргийн төсөв | НХХ АХ, ХЗДАА | 100% |
| | | Сар шинийн баярыг тохиолдуулан 98 ба түүнээс дээш настай 13 ахмад настанд хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардуулсан. Монголын ахмадын өдрийг тохиолдуулан дүүргийн Засаг даргын 2022 оны А/382 дугаар захирамжаар 1-20 дугаар хорооны 6000 гаруй ахмадыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэв. Ахмадаа алдаршуулья хүндэтгэлийн арга хэмжээнд 20 ахмадыг алдаршуулан, нийт 15700 ахмадад хүндэтгэл үзүүллээ. | | | | | | |
| 89 | | Бага хандгайт ОНӨААТҮГ-т Ахмадын сувиллын барилга, гадна тохижилтын зураг, төсөв хийнэ. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2011-2015 онд Ахмадын сувиллын барилга барьж дутуу барьсан. | Барилгын зураг, төслийг хийсэн байна. | 50,000.00 | Дүүргийн төсөв | ТГХШХ | 90% |
| | | Бага хандгайт ОНӨААТҮГ-н сувиллын барилгад засвар хийх зорилгоор барилгын суурь хучилт, хана даацад Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Архитектурын сургуулийн дэргэдэх Ре констракшн төвөөр барилгын оношлогоо, дүгнэлт хийлгэсэн /мэргэжлийн байгууллагаар зураг төсвийг хийлгэж, барилгыг хүчитгэх, засварлах, шинэчлэх ажлыг гүйцэтгэх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан/ бөгөөд тайланг Бага хандгайт ОНӨААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд танилцуулж ажилласан. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас 2018 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр тус барилгыг барьж ашиглалтад оруулах гэрээтэй Голланд байшин ХХК-ыг шүүхэд хариуцагчаар татан нэхэмжлэл гаргасан. Шүүхийн асуудал нь 2022 оны 11 дүгээр сарын байдлаар эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа тул барилгын зураг, төсөв хийлгэх боломжгүй байна. | | | | | | |
| **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО /ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД СҮХБААТАР ДҮҮРЭГ** | | | | | | | | |
| **3.1 Дүүргийн төсвийн хөрөнгийг үр ашигтай төлөвлөж, ил тод мэдээлнэ** | | | | | | | | |
| 90 | ДЗДҮАХ-3.1.1 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 61-63 байгууллагын төсөв, санхүү,төрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэрүүдийг иргэдэд цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан сар, улирал бүр тогтмол мэдээлж байгаа эсэхэд хяналт | Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 61 байгууллагад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан зөвлөмж өгч ажилласан. | Төсвийн зарцуулалт ил тод нээлттэй болсон байна. | - | | ДАА | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тавьж, тайлагнаж ажиллана. | | | | | | |
| | | Сүхбаатар дүүргийн ТЕЗ-ийн хамрах хүрээний төрийн болон орон нутгийн өмчит 61-63 байгууллагын Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсаар дамжуулан хуулийн дагуу мэдээллээ байршуулж байгаа эсэхэд сар бүр тогтмол хяналт тавьж ажилласан. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийн ил тод байдлыг хангаж байгаа талаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 10 байгууллагад "Нийцлийн аудит" хийж, 7 байгууллагад зөвлөмж, 3 байгууллагад албан шаардлага өгч ажилласан. | | | | | | |
| 91 | ДЗДҮАХ-3.1.2 | Дүүргийн төсвийн байгууллагын нягтлан бодогч нарт хувь хүний хөгжлийг дэмжих, харилцааны ур чадвар, стресс менежмент, ажлын бүтээмж, багаар ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх "Эерэг харилцаа ба хандлага" сургалт зохион байгуулна. | Төсвийн байгууллагын санхүүгийн ажилтнуудад ажлын байрын харилцаа хандлагын талаар мэдээлэл өгч ажилласан. | Ажлын байрны бүтээмж өсч гүйцэтгэл үр дүн сайжирсан байна. | 15,990.00 | Дүүргийн төсөв | СТСХ Төсөвт байгуул-лагууд | 100% |
| | | Дүүргийн төсвийн байгууллагын нягтлан бодогч нарт хувь хүний хөгжлийг дэмжих, харилцааны ур чадвар, стресс менежмент, ажлын бүтээмж, багаар ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх "Эерэг харилцаа ба хандлага" сургалт зохион байгуулах ажлын хүрээнд Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарт зориулсан Хан голомт төвийн захирал, багш Ц.Азбаярыг урьж "Ажил амьдралын баланс" сэдвээр сургалт зохион байгуулж, сургалтад нийт дүүргийн төсөвт байгууллагын 55 нягтлан бодогч хамрагдсан. | | | | | | |
| 92 | | Дүүргийн төсвийн байгууллагын санхүүгийн ажилтнуудад төсөв санхүүгийн шинэчлэгдсэн хууль, дүрэм журам танилцуулах сургалт зохион байгуулж, төсвийн сахилга батыг чанд сахих талаар арга хэмжээ авч ажиллана. | Төсвийн байгууллагын санхүүгийн ажилтнуудад мэдээлэл, зөвлөмж өгч гарсан алдаа зөрчлийг залруулан ажилласан. | Төсвийн сахилга бат сайжирч, тайлан бүртгэлийн стандарт ил тод байдал хангагдах боломж бүрдсэн байна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | СТСХ Төсөвт байгуул-лагууд | 100% |
| | | Дүүргийн төсвийн байгууллагын санхүүгийн ажилтнуудад төсөв санхүүгийн шинэчлэгдсэн хууль, дүрэм журам танилцуулах, төсвийн сахилга батыг чанд сахих талаар арга хэмжээний хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 14-ны өдөр Санхүү, төрийн сангийн хэлтсээс Ерөнхий нягтлан бодогч Аудитын шалгалтын явц, зөрчилгүй ажиллахад анхаарах нь, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл өгсөн бол Тайлан мэдээ сургалт хариуцсан мэргэжилтэн Шилэн дансны хөтлөлт, сар улирлын тайлан гаргахад анхаарах асуудлууд, Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн Цалингийн гүйлгээ хийх болон гүйлгээний зардал, ангилал бичихэд анхаарах асуудлуудаар тус тус мэдээлэл өгсөн. Сургалтад нийт дүүргийн төсөвт байгууллагын 55 нягтлан бодогч хамрагдсан. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 93 | ДЗДҮАХ-3.1.3 | Худалдан авах ажиллагааг цахим системээр дамжуулан иргэдэд нээлттэй ил тод мэдээлж, олон нийтийн оролцоог ханган ажиллана. | Тендер шалгаруулалтыг 100% цахим хэлбэрээр, ил тод нээлттэй зохион байгуулсан. | Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталсан байна. | - | | ХААА | 100% |
| | | Сүхбаатар дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь 2022 оны Захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулж, Сангийн яамны Хууль эрх зүйн газраар хянуулан батлуулж, батлагдсан төлөвлөгөөг шилэн дансны систем, tender.gov.mn, sbd.gov.mn сайтууд болон байгууллагын өдөр тутмын нээлттэй самбарт тус тус байршуулж олон нийтэд ил тод мэдээллээ.<br>Батлагдсан төлөвлөгөөний хүрээнд нийт 35536,5 мянган төгрөгийн 156 төсөл арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Тендерийн урилга, гүйцэтгэл, үр дүнгийн мэдээллийг тухай бүрт шинэчлэн user.tender.gov.mn, shilendans.gov.mn, report.ub-procurement.mn , sbd.gov.mn сайтад болон албаны мэдээллийн нээлттэй самбарт тогтмол байршуулан ил тод мэдээлэн ажилласан. | | | | | | |
| 94 | ДЗДҮАХ-3.1.4. | Санхүү, төсөв, төрийн сангийн үйл ажиллагааны үнэн зөв, найдвартай байдал, төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 35-40 байгууллагын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж, зөвлөн туслаж ажиллана. | 2021 онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 35-40 байгууллага нэгжийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд дотоод аудит хийж дүгнэлт гарган зөвлөмж өгсөн. | Хууль, тогтоомж заавар, журам, стандартын хэрэгжилт хангагдаж, байгууллагын үйл ажиллагаа сайжирч, үнэ цэнэ нэмэгдсэн байна. | - | | ДАА | 100% |
| | | Сангийн сайдын баталсан 2022 оны 02-р сарын 14-ны өдрийн СХШХ/01 дугаар "Хууль бус шийдвэрийн улмаас ажлаас халагдсан ажилтнуудад төсвөөс олгосон нөхөн олговор, түүнийг холбогдох хуулийн дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн эсэх асуудлаар хяналт шалгалт хийх" нэгдсэн удирдамжийн дагуу ТЕЗ-ийн хамрах хүрээний 18 сургууль, 35 цэцэрлэг, 2 ТӨААТҮГ, 2 ОНӨААТҮГ, харьяа 8 газар, хэлтсүүд, төсвөөс санхүүжилт авч буй 16 өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шалгалт хийхэд 12 байгууллагын 18 албан хаагчид 83,935.3 мянган төгрөгийн шүүхийн шийдвэрээр нөхөн олговор олгох шийдвэр гарсанаас 74,136.2 мянган төгрөгийг төсвийн хөрөнгөөр барагдуулж, 5,022.0 мянган төгрөгийг ОНӨААТҮГ-н хөрөнгөөр, 3,199.2 мянган төгрөгийг буруутай шийдвэр гаргасан этгээдээр төлүүлэн үлдсэн 6,274.1 мянган төгрөгийн шийдвэр төлөгдөөгүй байна. Шүүхийн шийдвэр нэхэмжлэгчийн талд гарч албан тушаалтны хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, иргэний зөрчигдсөн эрхийг сэргээж ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг төсвөөс болон тухайн байгууллагаас гаргаж олгоод буцааж ажилд нь авсан боловч үндэслэлгүй халагдсан хүмүүс ямар нэгэн | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шалтгаанаар тус байгууллагадаа ажиллаагүй байна. Шалгалтын танилцуулга, холбогдох судалгааг Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдлийн удирдлагын газарт хүргүүлсэн болно. ТЕЗ-ийн хамрах хүрээний байгууллагууд болох ХААА, ЖДҮДТ, Ахмадын хороо, Насан туршийн боловсрол, Бага хандгайт ОНӨААТҮГ, 11, 25, 35, 45, 131-р сургууль, 1, 2, 14, 16, 68, 130, 186, 205, 217-р цэцэрлэгүүдэд аудит хийж, зөвлөмж өгч ажиллалаа. | | | | | | |
| 95 | ДЗДҮАХ-3.1.5 | Орон нутгийн хөгжлийн сангийн журмын дагуу иргэдээс авах санал асуулгыг хэрхэн авах тухай сургалтыг үе шаттай зохион байгуулна. | 225 албан хаагч хамрагдсан. | Сургалтад 1-20 дугаар хорооны Ажлын албаны албан хаагч хамрагдсан байна. | 13,000.00 | Дүүргийн төсөв | ТГХШХ | 100% |
| | | Хороодын ажлын албаны албан хаагчдад 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр танхимаар Орон нутгийн хөгжлийн сангийн журмын шинэчлэлт, Улсын мэдээллийн санд Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллээ хэрхэн оруулах, 2023 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээнд иргэдээс авах санал асуулгыг цахимаар буюу гар утасны аппликейшн ашиглан зохион байгуулах талаар сургалтыг зохион байгуулж, 1-20 дугаар хорооны ажлын албаны 178 албан хаагчийг хамруулсан. | | | | | | |
| 96 | | Сангийн сайдын 86 дугаар тушаалын дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын саналыг хорооны иргэдээс авч, эрэмбэлэн, зөвшилцөн шийдвэрлэж, иргэдэд мэдээлнэ. | Нийт 20 хорооны 18-аас дээш насны 62203 иргэд санал өгөхөөс 49501 иргэн санал өгч дүүргийн хэмжээнд санал асуулга 79.58%-ийн хэрэгжилттэй зохион байгуулагдлаа. | Орон нутгийн санал асуулгад 80-аас дээш хувийг хамруулсан байна. | 13,000.00 | Дүүргийн төсөв | ТГХШХ | 100% |
| | | Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/301 тоот захирамжаар 2023 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээнд иргэдээс авах санал асуулгыг нийслэлийн 9-н дүүргийн хэмжээнд 2022 оны 04 дүгээр сарын 15-аас 06 дугаар сарын 15-ны хооронд цахимаар болон цаасан хэлбэрээр зохион байгуулан ажилласан.<br>Дүүргийн хэмжээнд 1-20 дугаар хорооны 77657 иргэн санал өгөхөөс 32844 иргэн санал өгч дүүргийн хэмжээнд 42.3%-ын хэрэгжилттэй зохион байгуулагдсан. Санал асуулгын хүрээнд нийт 440 төслийн санал ирснийг боловрсуулж, 215 төсөл, арга хэмжээг урьдчилсан жагсаалтад нэгтгэсэн. | | | | | | |
| ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО /НЭЭЛТТЭЙ ХАРИУЦЛАГАТАЙ ДҮҮРЭГ | | | | | | | | |
| 4.1 Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, ил тод хүргэнэ. | | | | | | | | |
| 97 | ДЗДҮАХ-4.1.1 | Хөдөлгөөнт оффис ажиллах журмын дагуу хэлтэс, нэгжүүд иргэдэд үйл ажиллагаагаа сурталчлах, тайлагнах, боломжтой асуудлыг газар дээр нь шийдвэрлэж ажиллана. | 2 баг хагас жил тутам хороодод ажилласан. | Иргэдээс ирүүлсэн хүсэлтийг газар дээр нь шийдвэрлэсэн байна. | 10,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ<br>Бүх хэлтэс | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дүүргийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулах тухай" А/167 дугаар захирамжаар 2022 оныг Хотын иргэний жил болгон зарласантай холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагчдад төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн үйлчилгээг гэрээр хүргэх ажлыг 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс 06 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгууллаа. Дүүргийн 1-20 дугаар хороодын хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагчдад төрийн үйлчилгээг бүх хэлбэрээр хүргэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, халамжийн үйлчилгээг хүргэх, нийгмийн даатгал, улсын бүртгэл, газар эзэмших, өмчлөх тухай зөвлөмж, мэдээллийг өгөх, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхэд онцгой анхааран ажиллах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд: ажлын хэсгийн дарга: М.Алтангэрэл, гишүүд: Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Газар зохион байгуулалтын алба, Бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсийн мэргэжилтнүүд, хороодын засаг дарга нарын хамтарсан Явуулын баг ажиллалаа. Нийт 631 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлснээс хороодын иргэний танхимаар 518 иргэнд гэрээр 83 иргэнд холбогдох хэлтсүүдийн мэргэжилтнүүд зөвлөгөө мэдээлэл өгч, газар дээр нь шийдвэрлэх боломжгүй асуудлыг иргэнд эргэн мэдээлж, санал хүсэлтийг шийдвэрлэн ажилласан байна.<br>Дүүргийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Аян зохион байгуулах тухай А/419 дүгээр захирамжийн дагуу ТЗУХ-ээс И-Монгол академи УТҮГ-тай хамтран, Цахим шилжилт-Төрийн үйлчилгээ аяныг 2022 оны 11 дүгээр сарын 3-ны өдрөөс 12-ны өдрүүдэд дүүргийн бүх хороодод зохион байгууллаа. Аяны хүрээнд дүүргийн иргэдийн цахим ур чадварыг сайжруулах чиглэлээр:<br>• Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E Mongolia аппликейшн ашиглан төрийн үйлчилгээг цахимаар авах, үндэсний цахим шууданг хэрэглэх зааварчилгаа.<br>• Худал мэдээлэл, цахим луйварыг таних, мэдээллийн аюулгүй байдлаа хамгаалах зөвлөмжүүд<br>• Тоон гарын үсэг ба түүний хэрэглээ гэсэн чиглэлүүдээр сургалт зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө зөвлөмжүүдийг өгсний зэрэгцээ дүүргийн Архивын тасаг, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсүүд цахимаар олгож буй үйлчилгээнүүдийн танилцуулга хийж, үйлчилгээгээ үзүүллээ.<br>Аянд дүүргийн 1-20 дугаар хорооны 700 гаруй иргэн хамрагдсан байна. | | | | | | |
| 98 | ДЗДҮАХ-4.1.2 | Хороодын Иргэний танхимд тогтмол зохион байгуулагддаг үйл ажиллагаануудад иргэд, хүүхэд, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах чиглэлээр дэмжлэг туслалцаа үзүүлнэ. | Төсөв байхгүй тул тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломжгүй байсан. | Иргэд, залуучуудын идэвх оролцоо нэмэгдсэн байна. | 20,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ ИТХ-ын ИОХ, Хороод | 100% |
| | | Хороодын Иргэний танхимын үйл ажиллагааг тасралтгүй явуулж, дээд шатны байгууллагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаануудыг иргэдэд сурталчлах, мэдээ мэдээлэл хүргэх, үйл ажиллагааг хэвийн явуулах чиглэлээр дүүргийн Засаг даргын Тамгын газраас тохижилт, засварын ажлыг хийсний зэрэгцээ хороо тус бүрт Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/52 дугаар тушаалаар 2 сая 500 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд зориулан олгосон.<br>Тайлант хугацаанд хороодын Иргэний танхимуудад дараах үйл ажиллагаануудыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран зохион байгуулсан болно. Үүнд: Хороодын Иргэний танхимуудад Ковидын шинжилгээ, үзлэг, Ковид-19-ийн талаарх сурталчилгаа танилцуулга, Дархлаажуулалтын цэгүүд 03 дугаар сарын 01 хүртэл ажиллаж, дүүрэг хороодын иргэдийг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулсан. Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилга, БТСУХ-ноос 2022 оны 02 дугаар сарын 16- | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ны өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл зохион байгуулж буй “Илүүдэл жингүй, Эртэч Монгол” аяны хүрээнд хороо тус бүр хүн амын эрүүл мэндэд тустай, эрүүл дасгал хөдөлгөөнд уриалсан үйл ажиллагаануудыг зохион байгуулж давхардсан тоогоор 900 гаруй иргэн хамрагдав. Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран уушигны эмгэгийг эрт илрүүлэх үзлэг, ХөХҮХ-тэй хамтран зорилтот бүлгийн иргэдэд зориулан хэрэгжих төсөл хөтөлбөрийн хүрээнд Халамжаас- хөдөлмөрт сургалт, зуучлалын өдөрлөг, "Хашаандаа сайхан амьдаръя" ТББ-тай хамтран "Хөршийн холбоо" байгуулж хамтдаа амьдрах орчноо сайжруулах, гэмт хэрэг, хулгай дээрмээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өгөх уулзалт, СБД-ийн ГХУСАЗСЗ, "Чингүн Оюуны урлан" ТББ-тай хамтран Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх сургалтууд, Монголын өрхийн үйлдвэрлэлийг дэмжих холбоотой хамтран Төсөл арга хэмжээнүүдийн танилцуулга зэрэг үйл ажиллагаануудыг хамтран зохион байгуулж давхардсан тоогоор 4000 гаруй иргэн хамрагдав.<br>Иргэний танхимуудад тогтмол зохион байгуулагддаг ахмадуудын хийн дасгал, нийтийн бүжиг, монгол бичгийн дугуйлан, тэмцээн, уралдаан зэрэг үйл ажиллагаанууд давхардсан тоогоор 3500 гаруй иргэд хамрагдсан байна. | | | | | | |
| 99 | ДЗДҮАХ-4.1.3 | Хороодын ажлын алба болон Хороодын иргэний танхимын үйл ажиллагаag хэвийн явуулахад шаардагдах тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана. | Шаардлагатай тоног төхөөрөмж дутагдалтай байна. | Иргэний танхимын үйл ажиллагаа сайжирсан байна. | 300,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ<br>ААТ | 100% |
| | | Хороодын иргэний танхимын үйл ажиллагааг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэхээр 8 суурин компьютер болон сургалтын ширээ 161 ширхэг сургалтын сандал 672 ширхэгийг Дижитал сервис ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгэж 1-20 дугаар хорооны иргэний танхим болон хорооны Засаг даргын ажлын албанд хүлээлгэн өгсөн. | | | | | | |
| 100 | | Засаг даргын Тамгын газар болон хороодын ажлын албаны үйл ажиллагаа явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана. | Үндсэн үйл ажиллагаанд шаардагдах зарим төрлийн тоног төхөөрөмжийн (гэрэл зургийн аппарат) дутагдалтай байна. | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна. | 60,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ<br>ААТ | 100% |
| | | Дүүргийн Худалдан авах ажиллагааны албанаас 2 дугаар хорооны Засаг даргын ажлын албаны байранд шинээр тавилга худалдан авах тендер зарласан байна.<br>Дүүргийн Худалдан авах ажиллагааны албанаас 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр тендер зарлаж Санко маркетинг монголиа ХХК шалгарч 2022 он 04 дүгээр сарын 11 өдөр СБД-ХААА/202201006 тоот гэрээ байгуулан i5 8400 DDR4 8G/128GB SSD HD Grapics Windows 10 enterprise version ерөнхий үзүүлэлтэй 8 ширхэг ухаалга дэлгэц нийлүүлсэн.<br>Монтех дистрибьюшн ХХК-тай гэрээ байгуулан Dell optiflex 7080 /i7-10700 16 gb үзүүлэлттэй 14 ширхэг иж бүрэн компьютер худалдан авсан. | | | | | | |
| 101 | ДЗДҮАХ-4.1.4 | Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хэвлэл мэдээллийн боломжит сувгуудыг ашиглан иргэд, | 2 хэвлэл мэдээллийн хэрэгслээр тайлагнасан. | Иргэдэд төрийн үйлчилгээ, мэдээ, мэдээллийг түргэн шуурхай хүргэсэн байна. | 50,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ<br>Бүх хэлтэс нэгж | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | олон нийтэд тогтмол сурталчилна. | | | | | | |
| | | Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, түүний биелэлтийг хангах ажлын хүрээнд дүүргийн ЗДТГ болон хэлтэс нэгжүүдээс зохион байгуулж буй арга хэмжээ, үйл ажиллагааны мэдээ мэдээллийг төрийн байгууллагын цахим хуудас, хэвлэл, мэдээллийн ТВ2 телевиз, мэдээ мэдээллийн сайтуудаар иргэд, олон нийтэд түгээж ажиллалаа. 2022 оны байдлаар Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хангах ажлын хүрээнд зохион байгуулагдсан 256 үйл явдал, арга хэмжээний мэдээ мэдээллийг бэлтгэн байгууллагын албан ёсны www.sbd.gov.mn вэб сайт, Хөхүүгийн Болормаа, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нээлттэй Сүхбаатар, Сүхбаатар дүүргийн Шуурхай штаб, Сүхбаатар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Түмэнд түгээнэ, Нийслэл Улаанбаатар болон 20 хороо тус бүрийн пейж хуудсуудаар агуулга давхардсан тоогоор 8960 гаруй удаа иргэд, олон нийтэд мэдээлж ажилласан байна. Мөн дүүргийн ЗДТГ болон 1-20 хороонд өдөр тутмын Өнөөдөр болон Өдрийн сонин тус бүр 25ш сонинг захиалгын, ТВ2 телевизтэй 2022 оны 04 дүгээр сарын 21-нд Хамтран ажиллах гэрээ байгуулан мэдээ мэдээлэл, сурвалжлага, нийтлэл түгээн ажиллаж байна. Хэвлэл мэдээллийн дээрх байгууллагуудад нийтдээ 9.810.000 төсвийг зарцуулсан. Цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулах боломжгүй тул тусгасан төсвийн 40,190,000 мянган төгрөгийг хэмнэсэн болно. | | | | | | |
| 102 | ДЗДҮАХ-4.1.5 | Төрийн зарим үйлчилгээг хороодод үе шаттайгаар шилжүүлэх ажлыг НЗДТГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу хэрэгжүүлж, дэмжин ажиллана. | 5, 20 дугаар хороодод архивын лавлагаа, Иргэний бүртгэлийн үйлчилгээг харьяалал харгалзахгүй үзүүлсэн. | Төрийн үйлчилгээг түргэн шуурхай авах боломж бүрдсэн байна. | - | | ТЗУХ Азийн сан НДЗТ | 100% |
| | | НЗДТГ, Азийн сантай хамтран хэрэгжүүлж буй Хотын засаглалыг сайжруулах төслийн хүрээнд 2022 оны 01 дүгээр сараас Иргэний бүртгэлийн 21 төрлийн лавлагаа, 9 төрлийн бүртгэлийн үйлчилгээг харъяалал харгалзахгүйгээр дүүргийн бүх хороо, Нэг цэгийн үйлчилгээний төвүүдээс олгож байна.<br>Нийслэлийн Архивын газраас үзүүлдэг 15 нэр төрлийн үйлчилгээг 2018 оноос нийслэлийн 7 дүүргийн 30 хороонд үе шаттайгаар шилжүүлээд байгаа бөгөөд НАГ-аас 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 04/354 албан бичгээр нийслэлийн 9 дүүргийн 204 хорооноос дээрх зорилтын хүрээнд иргэдээс архивын лавлагааны хүсэлтийг хүлээн авч, иргэнд хариуг олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх үйл ажиллагааг эхлүүлэх чиглэлээр зохион байгуулах ажлын танилцуулгыг ирүүлсэн. Дээрх ажлын хүрээнд дүүргийн Архивын тасаг холбогдох байгуулага, албан хаагчидтай хамтран бэлтгэл зохион байгуулалтыг ханган ажиллаж байна.<br>2022 оныг "Хотын иргэний жил" болгон зарлах тухай А/01 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн 20 дугаар хорооны Засаг даргын ажлын алба, Нийслэлийн архивын газар, Чингүн оюуны урлан ТББ, ахмадын зөвлөлтэй хамтран 2022 оны 04 дүгээр сарын 29-нд иргэний танхимд "Ахмадуудад үзүүлэх төрийн үйлчилгээ" өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгөөр эмэгтэй 55, эрэгтэй 60 настны өндөр настны тэтгэвэртээ гарч байгаа иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн лавлагааг Нийслэлийн архивын газрын ахлах мэргэжилтэн Б.Батэрдэнэ хорооноос цахимаар олгож, Нийслэлийн архивын газрын 15 төрлийн лавлагааг хорооноос хэрхэн авах талаар мэдээлэл өгсний зэрэгцээ ажилласан жилийн лавлагааг 4 иргэн авч, Архивын лавлагаа олгох видео шторкны зураг авалтыг тус хороон дээр хийж танилцуулга youtube сувагт тавигдсан байна. | | | | | | |
| 103 | ДЗДҮАХ-4.1.6 | Бүтээлч санал санаачилгыг нэмэгдүүлэх чиглэлээр болзолт | 2021 онд дүүргийн 36 хэлтэс алба, байгууллагуудын дунд парламентын | Ажлын бүтээмж сайжирсан байна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ Бүх албан хаагчид | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | уралдаан зарлаж, урамшуулан ажиллана. | мэтгэлцээний тэмцээн, мөн дүүргийн ЗДТГ-ын албан хаагчдын мэдээллийн цагийг 6 удаа зохион байгуулсан. | | | | | |
| | | Албан хаагчдын багаар ажиллах ур чадвар, харилцаа хандлагыг сайжруулах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх, шинэ санал, санаачилгыг дэмжих, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Бидний ажил” төслийн уралдаан, “Бүтээлч ажил”-ын уралдааныг 2022 оны 11 дүгээр сарын 26-наас 12 дугаар сарын 05-ны өдрийн хооронд зохион байгуулахаар удирдамжийг боловсруулан, албан хаагчдад хүргэсэн. Төслийн уралдаанд 25 багийн 84 албан хаагч оролцохоор мэдүүлгээ өгсөн. Бүтээлч ажлын уралдааны хүрээнд Атга будаа сайн үйлсийн аян, Хөл дулаан бол бие эрүүл дотоодын үйлдэрвэрлэлтэй танилцах аян, Цахим шилжилт аян зэрэг арга хэмжээнүүдийг эхлүүлэн явагдаж байна. 2022 оны 12 дугаар сарын 15-нд сонгон шалгаруулалт дуусч, нэгдсэн дүнг гаргаж тайлагнана. | | | | | | |
| 104 | | Албан хаагчдыг ажлын бүтээмж, гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг харгалзан үнэлж мөнгөн болон үнэ бүхий зүйлээр урамшуулал олгоно. | 3-5 албан хаагч хамрагдсан. | 10-аас дээш албан хаагч хамрагдсан байна. | 10,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ Бүх албан хаагчид | 100% |
| | | Хамтран ажиллах, хөдөлмөрийн гэрээ, гүйцэтгэлийн тайланг хагас жилээр үнэлж дүгнэн 123 албан хаагчид албан тушаалын үндсэн цалингийн 30-40 хувийн мөнгөн урамшуулал олгосон.<br>Монгол улсын төрийн одон медаль, цэргийн цолоор шагнагдсан 5, нийслэлийн Аудитын газрын санхүүгийн нэгдсэн тайланд стандарт, зөрчилгүй үнэлгээ авсан 6 албан хаагчийг албан тушаалын 1-3 сарын үндсэн цалингаар тус тус шагнаж урамшуулсан. | | | | | | |
| 105 | ДЗДҮАХ-4.1.7 | Холбогдох шүүхийн шийдвэр биелүүлэх үйл ажиллагааг хууль журмын дагуу биелүүлнэ. | Шүүхийн 12 шийдвэрийг биелүүлж, 130000000 төгрөгийн хохирол барагдуулсан. | Шүүхийн шийдвэр биелсэн байна. | 250,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ СТСХ, НШШГГ | 90% |
| | | Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт холбогдох 12 хэрэг маргаан хянагдаж байгаагаас 11 хэргийг бүрэн хааж, Алтан дорнын хүч ХХК-ны нэхэмжлэлтэй хэргийн хохирлыг бүрэн барагдуулаагүй байна. Шүүхийн шийдвэрийг биелүүлэхээр дүүргийн 2022 оны төсөвт тусгагдсан 250,000,000 төгрөгөөс М.Эрдэнэбаатарын нэхэмжлэлтэй хэрэгт 5,029,500 төгрөг, Г.Должинсүрэнгийн нэхэмжлэлтэй хэрэгт 18,226,818 төгрөг, Алтан дорнын хүч ХХК-ны нэхэмжлэлтэй хэрэгт 10,000,000 төгрөг нийт 33,256,318 төгрөг барагдуулсан. | | | | | | |
| 106 | | Эрх зүйн маргаантай асуудлаар хуулийн дагуу дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрыг төлөөлөх ажлыг зохион байгуулна. | 100 гаруй хэрэг, маргаанд төлөөлөн оролцсон. | Байгууллагыг төлөөлөх ажлыг хуульд нийцүүлэн зохион байгуулсан байна. | 1,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ ИХАШШ, ЗХАШШ | 100% |
| | | 2022 оны байдлаар давхардсан тоогоор 130 гаруй удаагийн шүүх хуралд цахимаар болон биеэр оролцож, 63 хэрэгт хариу тайлбар хүргүүлж, 35 удаагийн хүсэлт шийдвэрлүүлж 43 хэрэгт нотлох баримт хүргүүлж, 8 удаагийн газрын үзлэгт явсан. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 107 | | Жагсаал, цуглаан, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулах мэдэгдлийг бүртгэх ажлыг зохион байгуулж нийтийн хэв журам аюулгүй байдлыг хангана. | Жагсаал, цуглаан хийх 31 хүсэлт ирснээс 1 мэдэгдлийг бүртгэн авч, 30 мэдэгдэлд татгалзсан тухай хариуг хүргэсэн. Өлсгөлөн зарлах тухай 2 мэдэгдэл ирүүлснийг хууль тогтоомжийн дагуу хариу өгсөн. | Жагсаал, цуглаан хийх мэдэгдэл, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | - | | ХЭЗХ ЦГ | 100% |
| | | 2022 оны байдлаар дүүргийн Засаг даргад хандан жагсаал, цуглаан, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах 53 хүсэлт ирснээс 23 мэдэгдлийг бүртгэн авч, 30 мэдэгдэлд татгалзсан тухай хариуг хүргэсэн. Жагсаал, цуглаан бүртгэж авахаас хуульд заасан үндэслэлээр татгалзсан шалтгааны улмаас шүүхэд хэрэг маргаан үүсгэсэн тохиолдолд байхгүй болно. Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо их жанжин Д.Сүхбаатарын талбай дээр иргэд, төрийн болон төрийн бус байгууллагаас үзэл бодлоо илэрхийлэн нийслэлийн засаг даргын тамгын газар, сүхбаатар дүүргийн засаг даргын тамгын газраас бүртгэлтэй 135 жагсаал, цуглаан, бүртгэлгүй зохион байгуулагдсан 538, баяр ёслол, хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн худалдаа 200, нийт 873 жагсаал цуглааны үед давхардсан тоогоор 6984 алба хаагч эргүүл, хяналт шалгалтаар ажиллан 30 удаа шаардлага, 18 удаа зөвлөмж хүлээлгэн өгч хяналт тавин зөрчил дутагдалгүй ажилласан. | | | | | | |
| 108 | | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий Олон нийтийн байцаагч нарыг холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр ажиллуулна. | 2021 онд Олон нийтийн байцаагч нарыг ажиллуулах эрх зүйн орчин бүрдээгүй байсан. | Гэмт хэрэг зөрчил буурсан байна. | 609,200.00 | Дүүргийн төсөв | ХЭЗХ ЦГ, Хороод | 100% |
| | | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрт олон нийтийн байцаагч ажиллуулах Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 15-ний "Олон нийтийн байцаагч томилон ажиллуулах тухай" Б/07 дугаартай захирамжийн хүрээнд 100 олон нийтийн байцаагч 1-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт эргүүл хяналтаар ажиллаж хөлсөөр ажиллах гэрээнд заасан урамшуулал авч цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/41 дүгээр захирамжаар Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх Олон нийтийн байцаагчдын ажиллах нөхцөлийг хангах зорилгоор 5,350,000 төгрөгийн ажлын хувцас хэрэгслээр хангаж ажилласан.<br>Олон нийтийн байцаагчаар ажиллаж байгаа 100 иргэнийг 39 сургуулийн хичээл эхлэх, тарах цагуудад сургуулийн орчинд эргүүл хяналтаар ажиллуулж эцэг эхээсээ төөрсөн 42 хүүхдийг эцэг эх асран хамгаалагчид хүлээлгэн өгч давхардсан тоогоор бага насны 11620 хүүхдийг замын хөдөлгөөнд оролцох, явганаар зорчих үеийн аюулгүй байдлыг хангаж дэмжлэг үзүүлсэн.<br>Дүүргийн хэмжээнд 2022 онд 20 олон нийтийн цагдаагийн ажилтан хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэсгийн байцаагч, хороон цагдаа, олон нийтийн байцаагч нарын хамт хариуцсан хороодын нутаг дэвсгэрт бүлэг бөөгнөрөл үүсгэдэг айл өрх, гудамжаар өдөр бүр эргүүлийн үүрэг гүйцэтгэж, хууль тогтоомжийг тайлбарлан таниулж, ухуулга сурталчилгааг давхардсан тоогоор 5120 байгууллага, 11025 иргэнд хийж, гудамж зам, орц хонгилд согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэж биеэ авч явах чадваргүй болсон 22 иргэнийг ар гэр, асран хамгаалагчид, 6 иргэнийг яаралтай түргэн тусламжийн төвд хүлээлгэн өгч эрүүл мэнд, амь насаа эрсдэлд оруулахаас урьдчилан сэргийлж туслалцаа үзүүлсэн. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Цагдаагийн байгууллагад 34 зөрчлийн талаар мэдээлж, 245 иргэнд хууль сануулж, хариуцсан хорооны нутаг дэвсгэрт гэрэлтүүлэггүй байгаа 8 газрын мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдсэн засварлуулж аюулгүй амар тайван орчин бүрдүүлэхэд идэвх санаачлаг гаргаж ажилласан. Нийслэлийн цагдаагийн удирдах газар болон хэлтэс, тасгаас зохион байгуулсан 16 нэгдсэн болон тусгай, нэг бүрчилсэн арга хэмжээнд оролцож иргэдийг эрх зүйн мэдээ, мэдээллийг өгөх, иргэдээс гаргасан 13 санал хүсэлтийг цагдаагийн байгууллагад мэдэгдэн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтны хамтаар тогтмол зохион байгуулсан. | | | | | | |
| 109 | ДЗДҮАХ-4.1.8 | Төрийн албан хаагчдын сургалт хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | 90 хувь | 90 хувьд хүрсэн байна. | 120,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ | 100% |
| | | Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс сар бүр зохион байгуулдаг 13 сэдэвт төлөвлөгөөт сургалт болон бусад сургалтад давхардсан тоогоор 204, бусад төрийн байгууллагуудын мэргэжлийн болон салбарын чиглэлийн сургалтуудад 130 албан хаагч хамрагдсан. Сүлжээний аюулгүй байдлын мэргэшүүлэх сургалтад 2, Алсын хараа 2050 сургалтад 5 албан хаагч хамрагдаж, магистрын хөтөлбөрт 5 албан хаагч суралцаж байна. Мэдээллийн цагаар 4 удаагийн сургалтыг зохион байгуулж бүх албан хаагчдыг хамруулсан. | | | | | | |
| 110 | | "Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах" хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | 20 хувь | 30 хувьд хүрсэн байна. | 500,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ | 100% |
| | | Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлж 25 албан хаагчид 180,000,000 төгрөг, Хөдөлмөрийн тухай хууль болон байгууллагын Дотоод журмын дагуу 15 албан хаагчид 22,600,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. Коронавируст халдварын дараах хүндрэлээс урьдчилан сэргийлэх, албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор 29 албан хаагчийг сувилалд эмчлүүлэхэд нь эмчилгээний төлбөрт 48,251,900 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Албан хаагчдын ажиллах нөхцөлийг хангах чиглэлээр албан өрөөний засвар, фитнес өрөөний засвар, ухаалаг самбар, цаг бүртгэлийн төхөөрөмж худалдан авахад 23,200,000 төгрөг зарцуулсан. Хөтөлбөрт нийт албан хаагчдын 50 хувь нь хамрагдсан. | | | | | | |
| 111 | | Гадаад орны ижил чиг үүрэг бүхий байгууллагаас туршлага судалж нэвтрүүлнэ. | - | Туршлага судалж үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна. | 15,000.00 | Дүүргийн төсөв | ЦГ | 100% |
| | | 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдөр БНСУ-ын Үндэсний цагдаагийн газрын хар тамхитай тэмцэх чиглэл бүхий 4 албан хаагч тус цагдаагийн газрын үйл ажиллагаатай танилцах үед Солонгосын цагдаагийн байгууллага прокурорын байгууллагатай хэрхэн хамтран ажиллаж, албаны шуурхай үйлчилгээг үзүүлдэг талаар нь харилцан яриа өрнүүлж туршлага судлаад байна. БНСУ-ын Тэгү хотын цагдаагийн газрын даргаар ахлуулсан зочид төлөөлөгчид 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газарт хүрэлцэн ирж ,тус газрын үйл ажиллагаа, эрүү, хэв журмын нөхцөл байдалтай танилцан, харилцан туршлага солилцсон. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 112 | НХТЖҮЧ-5.3.3 НЗДҮАХ-4.1.1 ДЗДҮАХ-4.1.9 | Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх хувийг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэнэ. | 2021 онд нийт 4000 гаруй ААН, иргэнд үйлчилж, худалдаа үйлчилгээ эрхлэх 1193 гэрээ байгуулан батламж олгосон. | Дүүргийн Засаг даргын Тамгын газраас олгож буй худалдаа, үйлчилгээ эрхлэх батламж олгох, сунгалт хийлгэх хүсэлтийг цахимаар авч, төрийн үйлчилгээний шат дамжлага багассан байна. | - | | ХХҮХ МХХ, ЦГ, ОБХ, ХЗДАА | 100% |
| | | НЗД-ын 2021 оны “Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, авлига хүнд суртлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/987 дугаар захирамжийн хүрээнд “Онлайн бизнес төв” платформын Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн системд худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудыг бүртгэлжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>- Дүүргийн худалдаа, үйлчилгээний 2500 гаруй ААН-д нийслэлийн нэгдсэн мэдээ мэдээллийн цахим портал /https://service.ulaanbaatar.mn/ цахим сайтыг ашиглан төрийн үйлчилгээний "Онлайн бизнес төвийн үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем"-д үйлчилгээ эрхлэх бүртгэлийг бүртгүүлэх холбогдох мэдээлэл, заавар зааварчилгааг СБД-ийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс цахим хуудас, СБД хоол үйлдвэрлэл, үйлчилгээ фэйсбүүк групп, СБД-Худалдаа, СБД-Зах, худалдааны төвүүд, СБД-үйлдвэрүүд, SBD food чат групп, ХХҮХ-Хороод бүлэг, СБД-ийн 1-10 дугаар хороо, Хойд хороод 11-20 дугаар хороодын мессенжерийн бүлэг, Монголын Үсчин, гоо сайханчдын мэдээллийн нэгдсэн групп, Хүмс засалчдын холбооны пейж хуудсуудаар сурталчлан, Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газартай хамтран цахим бүртгэлийн сургалтыг дүүргийн МХХ, ОБХ, ТНААХ, хороодын Засаг дарга болон зохион байгуулагч, худалдаа, үйлчилгээний 1000 гаруй ААНБ-уудад, нийт 20 удаа зохион байгуулан, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, гарын авлага материалаар хангасан.<br>- ulaanbaatar.mn цахимд холбогдох үйлчилгээг хялбаршуулан шинээр QR код үүсгэн, үйлчилгээг хялбаршуулж, дүүргийн Засаг даргаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд дүүргийн Иргэний танхимд дүүргийн МХХ, ОБХ, ТНААХ-үүд хамтран худалдаа, үйлчилгээ эрхлэгч ААНБ, иргэдэд цахим бүртгэлийг газар дээр нь зааж, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулсан.<br>Нийслэлийн ulaanbaatar.mn сайтын “Онлайн бизнес төв” платформын үйлчилгээ эрхлэх бүртгэлийн системд нийт 824 ААНБ, иргэн хандаж, 462 хүсэлтийг шийдвэрлэж, 110 хүсэлтийг буцааж, 13 хүсэлтэд татгалзсан хариу өгч, 211 хүсэлт хяналтын шатандаа явж байна. | | | | | | |
| 113 | ДЗДҮАХ-4.1.10 | Иргэдэд үйлчлэх хорооны нэгдсэн барилгагүй хороодыг барилгажуулна. | 1, 2, 5, 6, 7, 11, 17 дугаар хороод өөрийн байргүй, түрээсийн байранд байна. | 2, 7 дугаар хороодыг байртай болгосон байна. | - | | ТГХШХ | 100% |
| | | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байсан 2 дугаар хороонд Хороо, ӨЭМТ, Цагдаагийн цогцолбор барилгыг барьж, ашиглалтад оруулан төрийн үйлчилгээг иргэдэд нэг дороос түргэн шуурхай авах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллалаа. | | | | | | |
| 4.2 Архив, албан хэрэг хөтлөлт, мэдээллийн аюулгүй байдлыг хангана. | | | | | | | | |

<table>
<tr><td>114</td><td>ДЗДҮАХ-4.2.1</td><td>Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс, нэгжүүдийн өргөдөл, гомдлын нэгдсэн системийн ашиглалтыг сайжруулах, чадавхыг нэмэгдүүлэн, шийдвэрлэлтийн мэдээ тайланг хуулийн хугацаанд гаргаж, удирдлагуудад танилцуулна.</td><td>Зөрчлийн тоон үзүүлэлт буурсан байна.</td><td>Өргөдөл гомдлын шийдвэрлэлт сайжирсан байна.</td><td>-</td><td></td><td>ТЗУХ</td><td>97%</td></tr>
<tr><td></td><td></td><td colspan="7">Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2022 оны 1 дүгээр сарын 3-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар нийт 1019 өргөдөл хүсэлт ирсэн. Үүнээс хугацаандаа шийдвэрлэгдэж хариу өгсөн 983, судлагдаж байгаа 29 хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 7 өргөдөл хүсэлт байгаа бөгөөд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц 97,00 хувьтай байна.<br>2022 оны 1 дүгээр сарын 3-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 10 цаг 59 минут байна.<br>Дээрх хугацаанд өргөдөл хүсэлтийг өдөрт нь багтаан хүлээж аваагүй, шилжүүлээгүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй болон холдбогдох файл хавсаргаагүй гэх мэт 275 зөрчил бүртгэгдсэн байна.<br>Хэлтсүүдээр харуулбал:<br>Төрийн захиргааны удирдлагын хэлтэс 124 өргөдлөөс 62 зөрчил<br>Хууль эрх зүйн хэлтэс 60 өргөдлөөс 18 зөрчил<br>Санхүү төрийн сангийн хэлтэс 3 өргөдлөөс 1 зөрчил<br>Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс 41 өргөдлөөс 28 зөрчил<br>Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс 487 өргөдлөөс 122 зөрчил<br>Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс 116 өргөдлөөс 10 зөрчил<br>Нийгмийн хөгжлийн хэлтэс 172 өргөдлөөс 14 зөрчил<br>Архивын тасаг 11 өргөдлөөс 12 зөрчил<br>Цэргийн штаб 2 өргөдлөөс 1 зөрчил тус тус бүртгэгдсэн байна.<br>Уг зөрчлийг бууруулах тал дээр анхаарч ажиллах талаар албан хаагч нарт сануулан ажиллаж байна.<br>Хандалтаар нь авч үзвэл:<br>• Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилтын тухай-103<br>• Хог цэвэрлэгээ, тээвэрлэлтийн тухай-67<br>• Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн болон ТҮЦ, павильон, ил задгай худалдаа, үйлчилгээний тухай-58<br>• Ажлаас чөлөөлөгдөх тухай-57<br>• Явган хүний зам, талбайн тохижилтын тухай-55<br>• Бусад-679<br>Хандалт өндөртэй байгаа өргөдөл гомдлын дагуу тодорхой ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.<br>Тухайлбал: Хог цэвэрлэгээ тээвэрлэлтийн чиглэлээр</td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2022 оны 01 дүгээр сард дүүргийн 1-20 дугаар хороодын айл өрх, аж ахуй нэгж байгууллагын хог тээврийн нарийвчилсан хуваарийг Засаг даргын орлогчоор батлуулан Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар тохижилт ХХК, Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-н цэвэрлэгээ, үйлчилгээний ажилд байнгын хяналт тавьж байна.<br>Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 3 байгууллагатай 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл "цэвэр цэмцгэр сүхбаатар дүүрэг" аяныг зохион байгуулж ажиллахаар удирдамж батлуулан 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр байгууллагуудад танилцуулж тухайн өдрөөс эхлээд байна.<br>Тус аяны зорилго байгууллагуудын ажилтан албан хаагчдын идэвхи санаачлагыг нэмэгдүүлэх нийгмийн хариуцлагыг өндөрсгөх, тохижилт, ногоон байгууламж, бүтээн байгуулалт, хог хаягдал, цэвэрлэгээний менежментийг сайжруулах, ажлын шинэ санал санаачлагыг дэмжих, хотын өнгө үзэмжийг дээшлүүлэх замаар иргэдтэй хамтарч ая тухтай, эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцлийг хангах юм. | | | | | | |
| 115 | ДЗДҮАХ-4.2.2 | Дүүргийн архив барих газрыг шийдвэрлэн, барилга барих зураг төсөв хийлгэнэ. | Зураг төсөв хийгдээгүй байна. | Зураг төсөв хийгдсэн байна. | 100,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ | 0% |
| | | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.6 заалтын дагуу зураг төсөв хийгдэх боломжгүй байна. | | | | | | |
| 116 | | Дүүргийн архивт хөмрөг үүсгэгч байгууллагын архивын баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулж стандартад нийцүүлэн, Төрийн архивын нэгдсэн системд дүүргийн архивт хөмрөг үүсгэгч байгууллагуудын захирамжлалын баримтаар цахим нөхөн бүрдүүлэлт хийнэ. | Дүүргийн харьяа байгууллагуудын тоон гарын үсгийн ашиглалтын хувь 90%-тай байна. | Нэг СӨБ-ын архивын өрөөг стандартын шаардлагад нийцүүлэн тохижуулсан байна. | 40,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ | 95% |
| | | Засаг даргын Тамгын даргын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр баталсан цахим нөхөн бүрдүүлэлтийн хуваарийн дагуу 2021 онд үүссэн захирамжлалын баримтыг дүүргийн харьяа 114 байгууллагын 209 хадгаламжийн нэгжийн 9,773 баримтын 17,272 хуудсыг төлөвлөгөөний дагуу цахимжуулсан. 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/331, А/332, А/333 тоот захирамжаар Сургуулийн өмнөх боловсролын 135, 186, 217 дугаар цэцэрлэгийн архивын өрөөг нийт 32,710,000 төгрөгийн засвар хийж цэцэрлэгүүдэд хүлээлгэн өгсөн. | | | | | | |
| 117 | ДЗДҮАХ-4.2.3 | Дүүргийн архивт хөмрөг үүсгэгч байгууллагуудад архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр сургалт, арга зүйн ажлын төлөвлөгөө гарган, мэргэшүүлэх сургалтад | 2021 онд 5 удаагийн танхимын сургалт зохион байгуулж нийт 233 албан хаагч хамрагдаж "Баримт бичиг 5140-2021" | 2022 онд цахим сургалтыг зохион байгуулж, цахим гарын авлага бэлтгэж өгнө. | 30,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хамруулж, ном гарын авлагаар хангана. | стандартын 30 ширхэг ном өгсөн. | | | | | |
| | | Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 7 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 461 байгууллагын 546 албан хаагч оролцсон байна. | | | | | | |
| 118 | | Дүүргийн архивын хөмрөг үүсгэгч байгууллагуудын дунд Болзолт уралдаан зохион байгуулна. | 2021 онд Ковид-19 цар тахлаас шалтгаалан Болзолт уралдаан зохион байгуулагдаагүй. | Архивын хөмрөг үүсгэгч байгууллагын үйл ажиллагааны үр дүн сайжирна. | | | ТЗУХ | 100% |
| | | Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/104 дүгээр захирамжаар дүүргийн харьяа төрийн байгууллагуудын дунд албан хаагчдын хариуцлагыг нэмэгдүүлэхээр 2022 оны 04 дүгээр сарын 01-нээс 06 дугаар сарын 30-ны хооронд 90 хоногийн хугацаатай “Хариуцлагатай хандъя” аяныг зарласан. Уг аяныг зарласнаар байгууллагуудын баримт бичгийн зохион бүрдүүлэлт, стандартын хэрэгжилт, архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт сайжирч, 90 хоногийн хугацаанд 9699 албан бичиг ирсэнээс 9699 албан бичиг бүрэн шийдвэрлэгдсэн бөгөөд ирсэн бичгийн шийдвэрлэлт 98.6 хувьтай болон шийдвэрлэлтийн дундаж хоног 6,9 болсон. | | | | | | |
| 119 | ДЗДҮАХ-4.2.4 | Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр windows лицензтэй үйлдлийн систем, вирусийн лицензтэй программ, холбогдох тоног, төхөөрөмж (firewall), хэрэгслээр хангаж ажиллана. | Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол гарсантай холбоотой албан ёсны антивирусийн программ, windows үйлдлийн систем худалдаж авах ажил хийгдээгүй. Гэхдээ trial хувилбараар ашиглаж байгаа болно. | Албан ёсны анти вирусийн программ ашигласан байна. | 96,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ | 90% |
| | | Засаг даргын Тамгын газар, хороодын интернетийн үйлчилгээг Юнивишн ХХК-аас гэрээний дагуу авч байгаа бөгөөд тус компаниас firewall /галт хана/ төхөөрөмж үнэгүй ашиглуулж, мэдээллийн аюулгүй байдлыг хანган ажиллаж байна. | | | | | | |
| | | 4.3 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ | | | | | | |
| 120 | ДЗДҮАХ-4.3.1 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулна. | Хөтөлбөрийн хэрэгжилтийг 90 хувиас дээш хангуулсан. | Иргэд, олон нийт, хүүхэд, залуучуудад зориулан авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл | 50,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ | 95% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллагаа зохион байгуулсан байна. | | | | |
| | | Нийслэлийн Засаг даргын2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн Төлөвлөгөө батлах тухай А/147 дугаар захирамжаар баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгасан заалтуудаас дүүрэгт хэрэгжих 12 заалтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган, холбогдох хэлтэс, нэгжүүдэд хүргэсэн. Биелэлтийг бүтэн жилээр гаргаж 2022 оны 12 дугаар сард нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах талаарх сургалтыг 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр 48 сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарыг хамруулан зохион байгуулсан. Авлигатай тэмцэх газраас гаргасан 9 төрлийн брошур, 5 төрлийн зурагт хуудас, 1 төрлийн гарын авлагыг хэлтэс, албад, хороодод тараасан. Мөн Авлигтай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Авлигын эсрэг бодлого, үйл ажиллагаа, Авлигын гэмт хэрэг сэдэвт хороодын Хэсгийн ахлагч нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, сургалтад 20 хорооны 129 хэсгийн ахлагч оролцсон.<br>Авлигатай тэмцэх газрын “Авлигатай тэмцэх газар”, “Олон нийттэй харилцах төв” пэйж хуудсуудад бүх албан хаагчдыг нэгдүүлж, авлигын эсрэг сурталчилгааны видео шторк, зурагт хуудас, мэдээ мэдээллүүдийг дүүрэг, хорооны пэйж хуудсуудаар түгээн ажиллаж байна. | | | | | | |
| 121 | | Мэдээллийн ил тод байдлыг хангах, төрийн зарим үйлчилгээг цахимжуулах ажлыг зохион байгуулна. | Төрийн үйлчилгээ хүртээмжтэй, хурдан шуурхай, цахим болгох. | Байгууллагын цахим хуудсыг шинэчлэн төрийн үйлчилгээг иргэдэд цахимаар хурдан шуурхай хүргэнэ. | 40,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ | 95% |
| | | Засаг даргын Тамгын газрын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг хариуцаж ажиллах албан тушаалтны жагсаалтыг батлан гаргаж, жагсаалтад хамрагдах 38 төрлийн мэдээ, тайланг Шилэн дансны тухай болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу shilendans.mn нэгдсэн цахим хуудас, дүүргийн sbd.gov.mn вэб сайт, хэлтсүүдийн мэдээллийн самбарт байршуулан ил тод нээлттэй мэдээллэн ажиллаж байна.<br>Хоол, худалдаа, ахуй үйлчилгээ, үйлдвэр, сүүдвэрчтэй худалдаа, явуулын хоолны газар зэрэг үйлчилгээ эрхлэх хүсэлтийг https://service.ulaanbaatar.mn/ хүлээн авч шийдвэрлэж байна. Иргэдийн цаасаар ирүүлж буй өргөдөл, гомдол санал хүсэлтийг бүх хороонд хүлээн авч, дүүрэг рүү ирэх шаардлагагүй болсон.<br>Төрийн байгууллагын вебсайтаар дамжуулан төрийн удирдлагын ил тод, нээлттэй хариуцлагатай байдлыг хангаж, төр-иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх ялангуяа төрийн захиргааны анхан шатны байгууллагын бодлого, үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх бүх төрлийн мэдээ мэдээллийг иргэдэд хүртээмжтэй болгох, мэдээлэл олж авах орон зай, цаг хугацааны хамаарлыг арилгах, иргэдийн оролцоог шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлэх, мэдээллээр хангах зэрэг асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор sbd.gov.mn цахим хуудсыг шинэчилж, E-Duureg платформыг /апп/ бүтээлээ. Энэхүү платформд иргэд хандаж дүүргийн Засаг даргын Тамгын газартай холбоотой бүхий л мэдээ мэдээлэл, цахим үйлчилгээ авах , санал хүсэлт өгөх, санал асуулгад оролцох, төрийн үйлчилгээний мэдээлэл авах боломж бүрдэж байна. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 122 | ДЗДҮАХ-4.3.2 | "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх" үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хангаж, Эрх зүйн хөтөч ажиллуулна. | Дүүргийн 17 хорооны Нийгмийн ажилтнууд эрх зүйн хөтчийн сургалтад суун гэрчилгээ авч иргэдэд зөвлөгөө өгч ажилласан. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, нийгмийн ажилтан, цэцэрлэгийн арга зүйч, хороодын ажлын албанд 5 удаагийн сургалт хийж, давхардсан тоогоор 190 орчим хүн хамрагдсан. | Иргэдийн эрх зүйн мэдлэгийг сайжруулах чиглэлээр үе шаттай ажил хийсэн байна. | 10,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ | 100% |
| | | 2011, 2022 онд эрх зүйн хөтчийн сургалтад хамрагдсан дүүргийн 20 хорооны Нийгмийн ажилтнууд эрх зүйн хөтчөөр ажиллаж байгаа бөгөөд Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран чадавхжуулах сургалтыг 2022 оны 10 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд зохион байгуулсан. Хороодын эрх зүйн хөтчөөд дамжуулан 700 гаруй иргэдэд эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан байна.<br>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын эрх зүйн мэдлэг, боловсролд зориулсан сэдэвчилсэн сургалтыг дараах сэдвийн хүрээнд албан зохион байгуулсан.<br>- Зөвшөөрлийн тухай хууль<br>- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль<br>- Төрийн хэмнэлтийн тухай хуулиар тус тус зохион байгуулж, албан хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлэн ажилласан.<br>Тус хөтөлбөрийн хүрээнд 2022 онд 25 удаагийн сургалт, хийж, давхардсан тоогоор 108 орчим хүн хамрагдсан. | | | | | | |
| 123 | | "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх" үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хангаж ажиллах хүрээнд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулна. | 5 сургуулийн 400 сурагчдад сургалт зохион байгуулсан. | ЕБС-ын сургууль, хороодын ажлын албадад чиглэсэн сургалтыг зохион байгуулна. | 10,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ<br>ЦГ,<br>Сургалтын төв | 100% |
| | | Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн нэгдсэн төвтэй хамтран байнга болон түр оршин суудаг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй 50 иргэний зан үйлд нөлөөлөх, тогтвортой гэр бүлийг төлөвшүүлэх, архины хор уршгийг таниулах зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр сургалт зохион байгуулсан.<br>Дүүргийн Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын 9 сургуулийн 1334 сурагчдад газ болон түүний хор уршгийн талаар сургалт зохион байгуулсан.<br>Эрэгээр нөлөөлье-2 аян 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр нээлтээ хийж 11 дүгээр сарын 23-ны өдрийг хүртэл хэрэгжинэ.<br>Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 215 хүнсний дэлгүүр болон 7 томоохон худалдаан төвүүдэд шалгалтыг хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаа нарын хамтаар шалгахад зөрчил илрээгүй бөгөөд зөвлөмж тарааж ажилласан. Мөн "Эмийн сан" болон эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм импортлох, | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд хяналт тавих чиглэлээр судалгааг нэгтгэж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 12 эмийн сан болон томоохон эм ханган нийлүүлэх байгууллагуудад хяналт тавихад ямар нэгэн зөрчил, дутагдал илрээгүй, 2022 оны 10 дугаар сард хар тамхи, мансууруулах бодис хэрэглэсэн байж болзошгүй сэжигтэй этгээд 4, сэжигтэй байр байгууламж 1-ийг бүртгэж, судалгаанд авч ажилласан. Зөрчилд холбогдон шалгагдсан 3 иргэний асран хамгаалагч гэр бүлийн гишүүдэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршигын талаар мэдээлэл хийж ажилласан. Харьяа хэлтсийн алба хаагчдын дунд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, шалгахад анхаарах асуудлууд, хойшлуулшгүй ажиллагааны талаар мэдээ, мэдээллийг тухай бүрт нь Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газар фейсбүүк хуудсаар дамжуулан хүргэж ажиллаж байна. | | | | | | |
| 124 | | "Хүн худалдаалахтай тэмцэх" үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хангаж ажиллах хүрээнд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулна. | 5 сургуулийн 400 сурагчдад сургалт зохион байгуулсан. | ЕБС-ын сургууль, хороодын ажлын албадад чиглэсэн сургалтыг зохион байгуулна. | 10,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ ЦГ, Сургалтын төв | 100% |
| | | Хариуцсан нутаг дэвсгэрт байршилтай 12 их дээд сургууль болон хувийн оюутны дотуур байрны судалгаа мэдээллийг гаргаж МУИС-ын гадаад оюутны байр, ШУТИС, МУБИС-ын 5 оюутны байрны 312 оюутан залууст цахим гэмт хэрэг, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар яриа таниулга хийсэн. Дүүрэг дэх Цагдаагийн газарт 2022 оны 10 дугаар сарын байдлаар хүн худалдаалах гэмт хэрэг бүртгэгдээгүй. 2022 онд бүртгэгдсэн 6 бэлгийн хүчирхийллийн хохирогчид сэтгэл санааны гэм хорыг үнэлэх үүднээс Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн алба хаагчид мэргэжилтэн нартай хамтарч мэргэшсэн хүүхдийн сэтгэл зүйчтэй уулзуулж, хариу үйлчилгээ үзүүлэн зохион байгуулсан. Өсвөр насны хүүхдүүдийн дунд хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөргүй байх талаар дүүргийн Прокурорын газраас санаачлан Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газар, Боловсролын хэлтэс, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран Эерэгээр нөлөөлье-2 аянг 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийг хүртэл төрийн бус хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгуулан ажиллаж байна. | | | | | | |
| 125 | | "Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд төлөвлөгөө гаргаж, биелэлтийг хангаж ажиллана. | 79 иргэн, 30 албан хаагч нарт сургалт зохион байгуулсан. | Төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллана. | 15,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ ЦГ, Сургалтын төв | 100% |
| | | Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд төлөвлөгөө гарган Жендэрийн ахисан түвшний сургалтад дүүргийн ЗДТГ-ын 53 төрийн жинхэнэ албан хаагчдаас 47 албан хаагч сургалтад хамруулсан. Жендэрийн үндэсний хорооноос үндэсний хэмжээнд зохион байгуулсан Харилцан хүндэтгэе сарын аяны хүрээнд дүүргийн Засаг даргаас удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн дээр үүрэг өгсний дагуу Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс, нэгжээс тус аянд нэгдэж, зохион байгуулж буй арга хэмжээ, үйл ажиллагаа бүрийг боломжит сувгуудаар иргэд, олон нийтэд сурталчлан таниулах үүргийг Төрийн захиргааны удирдлагын хэлтэст өгсний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Аяны хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газар 34 дэргэдэх нэгж, байгууллага нэгдэж өөрсдийн цахим хуудсанд мэдээ, мэдээллийг түгээж ажилласан. Жендэрийн Үндэсний хороо пейжид нийтлэгдэж буй мэдээ, постер, телевизээр явуулж буй мэдээлэл зэргийг байгууллагын албан ёсны www.sbd.gov.mn вэб сайт, Хөххүүгийн Болормаа, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нээлттэй Сүхбаатар, Сүхбаатар дүүргийн Шуурхай штаб, Сүхбаатар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Түмэнд түгээнэ, Нийслэл Улаанбаатар болон 20 хороо тус бүрийн пейж | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хуудсуудаар сурталчлан таниулсан. Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийг сурталчлах ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, дэргэдэх нэгжийн албан хаагчид, иргэдэд давхардсан тоогоор 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, 170 гаруй иргэд, албан хаагчдад мэдээлэл өгч ажилласан. | | | | | | |
| 126 | | Иргэдэд эрх зүйн соёл түгээх чиглэлээр 2021-2024 онд шинээр батлагдсан хууль, үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | 2021 онд батлагдсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журам. | Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, дэд хөтөлбөрийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлах, сургалт нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулна. | 15,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ | 90% |
| | | Шинээр батлагдан мөрдөгдөж буй Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хүрээнд Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, дэргэдэх нэгжийн албан хаагчид, иргэдэд давхардсан тоогоор 8 удаагийн сургалтыг зохион байгуулж, 150 гаруй иргэд, албан хаагчдад мэдээлэл өгч ажилласан.<br>Мөн шинээр батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд Нээлттэй өдөрлөгийг Тамгын газрын сургалтын төлөвлөгөөний хуваарийн дагуу 05 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж дүүргийн прокурор, өмгөөлөгчтэй хамтран хороодын 38 иргэнд эрх зүйн сургалт хийж мэдээ мэдээлэл, туслалцаа өгч ажилласан. Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 7 хоног бүр хуулийн цаг хийж байна. Мөн иргэдийн эрх зүйн боловсролын дээшлүүлэх зорилгоор 2022 оны 12 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд Иргэдийн эрх зүйн боловсролын дээшлүүлэх аян өрнүүлэхээр төлөвлөж ажиллаж байна. | | | | | | |
| 127 | | Хариуцсан 2 хорооны нутаг дэвсгэрт орчны тохижилт хийх, мэдээллийн самбар байршуулна. | Хариуцсан 2 хорооны нутаг дэвсгэрт мэдээллийн 2 самбар байршуулсан. | Иргэдийн эрх зүйн мэдлэгийг сайжруулах чиглэлээр тодорхой ажил хийсэн байна. | - | | ТНААХ Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ | 100% |
| | | Хариуцсан бүсийн үүсмэл хог хаягдал үүсдэг нийт 3 байршилд "Хог хаяхыг хориглоно" самбарыг Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ байршуулсан. /Санхүүжилт 800,000 төгрөг/ | | | | | | |
| 128 | ДЗДҮАХ-4.3.3 | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, нэгж хоорондын уялдааг хангуулж, гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний тайлангийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын дагуу дүүргийн ЗДТГ-ын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, тайланг тогтоосон хугацаанд нэгтгэж Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэсэн. | Төлөвлөгөө боловсруулагдаж, тайлан баталгаажсан байна. | - | | ТЗУХ Бүх хэлтэс нэгж | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны 187 заалт бүхий төлөвлөгөөг хэлтэс, тасгуудаас төслийг авч нэгтгэн боловсруулж батлуулсан. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн 2022 оны үйл ажиллагааны 32 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, бусад хэлтсийн төлөвлөгөөг журмын дагуу боловсруулсан байдалд хяналт тавьж хүлээн авсан. Байгууллагын 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайлан, нэгдсэн тайлан гарган нэгтгэж, Хяналт шилжилгээ хариуцсан мэргэжилтэнд хүргүүлсэн. Эхний хагас жилийн гүйцэтгэл 71 хувьтай хэрэгжсэн. 2022 оны жилийн эцсийн тайланг 12 дугаар сард нэгтгэнэ. | | | | | | |
| 129 | | Дүүргийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг бэлтгэж, батлуулна. | 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг нэгтгэн ДИТХ-д хүргүүлсэн. | Дүүргийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг нэгтгэн батлуулсан байна. | - | | ТЗУХ | 95% |
| | | Дүүргийн хөгжлийн жилийн 2023 оны төлөвлөгөөний саналыг Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, Тамгын газраас авч нэгтгэн 6 бүлэг 242 арга хэмжээ тусган боловсруулж, нэгтгэн хяналт шинжилгээ хийлгэхээр холбогдох хэлтэст шилжүүлсэн. | | | | | | |
| 130 | | Засаг даргын дэргэдэх байгууллагын төсвийн шууд Захирагчдын гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний тайлангийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | Засаг даргын дэргэдэх 19 байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланд хяналт тавьсан. | Засаг даргын дэргэдэх байгууллагуудын төлөвлөгөө, тайланд хяналт тавьж, удирдлагад танилцуулсан байна. | - | | ТГХШХ | 100% |
| | | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас Сүхбаатар дүүргийн Засаг даргатай байгуулах хариуцлагын гэрээг байгуулсан. Уг гэрээг үндэслэн Дүүргийн Засаг даргаас Дэргэдэх 20 байгууллагын удирдлагуудтай байгуулах гэрээний төслийг авч Засаг дарга хянаж баталгаажуулсан.<br>Эхний хагас жилээр дүүргийн Засаг дарга дэргэдэх байгууллагуудын удирдлагуудтай байгуулсан хариуцлагын гэрээний хэрэгжилтийн тайланг хүлээн авч ХШҮ хийхэд 18 байгууллага тайлангаа ирүүлж, 2 байгууллага тайлангаа тодорхой шалтгааны улмаас ирүүлээгүй байна. Дүүргийн Засаг даргын дэргэдэх байгууллагуудын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай илтгэх хуудсыг дүүргийн удирдлагуудад танилцуулж, баталгаажуулан ТЗУХ-ийн Хүний нөөц, ёс зүйн асуудал хариуцсан Ахлах мэргэжилтэнд pdf файлаар хүргүүлсэн.<br>Жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг 12 дугаар сарын эхээр авахаар албан бичиг хүргүүлэхээр ажиллаж байна. | | | | | | |
| 131 | | Дүүрэгт хэрэгжиж буй бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгтгэн холбогдох газарт хүргүүлнэ. | ЗГҮАХ, НЗДҮАХ, ДЗДҮАХ-ийн хэрэгжилтийг нэгтгэн холбогдох газарт хүргүүлсэн. | Тайлант хугацаанд хэрэгжилтийг хүргүүлсэн байна. | - | | ТГХШХ | 100% |
| | | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 12/2949 дугаар албан бичгээр Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтээс тус дүүргийн Засаг даргын Тамгын газарт хамаарах заалтын биелэлтийг нэгтгэн 2022 оны эхний хагас жилийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээг | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хийж, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 3/1020 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | | | | | | |
| 132 | | Бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан албан хаагчдад сургалт зохион байгуулна. | Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс албадын 27 албан хаагчдад сургалт хийсэн. | 27 албан хаагчдад сургалт хийсэн байна. | 9,000.00 | Дүүргийн төсөв | ТГХШХ | 100% |
| | | Дүүргийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд санал иргүүлж буй ЗДТГ-ын хэлтсүүд болон дэргэдэх хэлтэс албадын 27 албан хаагчдад 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр сургалт, зөвлөгөө өгөх уулзалтыг ЗДТГ-ын 9-р давхрын хурлын танхимд зохион байгуулж, шаардлага хангахгүй төлөвлөгөөний төслүүдийг 1 удаа буцааж, 2 дахь удаа шаардлага хангахгүй байвал тухайн хариуцсан албан хаагчид арга хэмжээ авах тухай НЗД-ын 2022 оны А/1106 дугаар захирамжаар баталсан журам хэрэгжиж буйг мэдэгдсэн. | | | | | | |
| 133 | | Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Дүүрэгт хэрэгжиж буй бодлогын баримт бичгийн биелэлтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж танилцуулсан. | Тайлант хугацаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж танилцуулна. | - | | ТГХШХ | 100% |
| | | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу бодлогын баримт бичгийн зорилт арга хэмжээний хэрэгжилтийг энэ журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу НЗДҮАХ-ийн 2022 оны арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт эхний хагас жилийн байдлаар 56.7%-ийн хэрэгжилттэй, Нийслэлийн хөгжлийн жилийн 2022 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлт 61.2%-ийн хэрэгжилттэй тус тус үнэлэгдсэн байна.<br>Дүүргийн 2022 оны хгжлийн жилийн төлөвлөгөөний хагас жилийн жилийн биелэлт, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайлан, Байгууллагын үйл ажиллагааны 2022 оны эхний хагас жилийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн.<br>Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтэд ХШҮ хийж байна. Дүүргийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн байдлаар ХШҮ хийж дүүргийн удирдлагуудад танилцуулж, шаардлагатай үүрэг даалгаврыг холбогдох хэлтэс, нэгжүүдэд хүргүүлж ажилласан.<br>Дүүргийн ЗДТГ-ын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан болон жилийн эцсээр гарах тайлан мэдээнүүдэд ХШҮ хийхээр төлөвлөн ажиллаж байна. | | | | | | |
| 134 | ДЗДҮАХ-4.3.4 | Улс болон орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэн ажиллана. | 90% | Татварт хамрагдсан татвар төлөгчийн тоо нэмэгдэж төлөвлөгөөг 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. | 20,000.00 | Дүүргийн төсөв | ТХ | 98,8% |
| | | Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогыг үндсэн чиг үүргийн хүрээнд заагдсан ажилбаруудыг шат дараалан хийж ажилласнаар дараах үзүүлэлттэйгээр татварын орлого төвлөрүүлэн ажиллаж байна. 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар өссөн дүнгээр Улсын төсөвт 76,486,411.7 мянган төгрөгийн татварын орлого төвлөрүүлэхээс 83,457,499.0 мянган төгрөг төвлөрүүлж 109,1 | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хувь, Нийслэлийн төсөвт 25,039,467.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 26,851,888.0 мянган төгрөг төвлөрүүлж 107,2 хувь, Дүүргийн төсөвт 233,509,234.3 мянган төгрөг төвлөрүүлэхээс 221,691,809.3 мянган төгрөг төвлөрүүлж 94,9 хувь, нийт орлогын дүн 335,235,113.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 331,900,125.2 мянган төгрөгийг төвлөрүүлж 98,8 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. Татварын орлогын гүйцэтгэлийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2037 татвар төлөгчид нэхэмжлэх хүргүүлж 20,455,912.1 мянган төгрөг, 433 данс хаах мэдэгдэх хуудас хүргүүлж 2,860,368.0 мянган төгрөг, 2 хөрөнгө битүүмжилж 11,803.6 мянган төгрөгийн татварын өрийг барагдуулан ажиллаж байна | | | | | | |
| 135 | | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар болон галт зэвсгийн албан татварыг төсөвт төвлөрүүлэх, бүртгэлтэй хөрөнгийг татварт бүрэн хамруулах, өр барагдуулах ажлыг зохион байгуулна. | 86% | Хууль тогтоомжийн дагуу үл хөдлөхийн албан татварыг 100 хувийн гүйцэтгэлд хүргэж ажилласан байна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | ТХ | 100% |
| | | ҮХЭХ-ийн татварын төрлөөр 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ҮХЭХ-ийн татварын төлөвлөгөө 1,371,325.0 мянган төгрөгөөс 2,097,212.0 мянган төгрөг төвлөрүүлж гүйцэтгэл 100 хувьтай байна. 1364 иргэний 1715 үл хөдлөх хөрөнгөнд 1,516,262.8 мянган төгрөгийн ногдол оруулж, 395,598.9 мянган төгрөгийн төлөлт хийгдсэн байна. Галт зэвсгийн албан татварын төрлөөр 37,500.0 мянган төгрөг, төвлөрүүлэхээс 44,161.0 мянган төгрөг төвлөрүүлж 117%-ийн гүйцэтгэлтэй байна. Галт зэвсгийн шинэчилсэн бүртгэл шилжилт хөдөлгөөний мэдээллийг цэгцлэх шинэчлэх, ажлын хүрээнд нийт ТУНС-д "Хөрөнгийн бүртгэл галт зэвсгийн албан татвар цэсэд бүртгэлтэй судалгааг Нийслэлийн цагдаагийн удирдах газраас ирүүлсэн шинэчилсэн бүртгэлтэй тулгалт хийж зөрүү гаргалаа. Энэ ажлын хүрээнд тухайн цэсийн бүртгэлээс харахад Хуулийн этгээдийн бүртгэлээр 72 татвар төлөгчийн 242 галт зэвсэг, 1614 татвар төлөгч иргэний 3079 галт зэвсэг бүртгэлтэй байна. Нийслэлийн цагдаагийн газрын бүртгэлээс харахад Хуулийн этгээдийн бүртгэлээр 54 татвар төлөгчийн 162 галт зэвсэг, 1181 татвар төлөгч иргэний 1883 галт зэвсэг бүртгэлтэй байна. Тухайн тулгалтаар мэдээлэл зөрүү 512 галт зэвсэг, бүртгэл зөрүү буюу РД-аар татвар төлөгчийн мэдээлэл таарсан боловч галт зэвсгээр ТУНС-д илүү бүртгэлтэй нэг төрлийн галт зэвсгийн нэршлийн хувьд өөр өөр байдлаар бүртгэгдсэн 383 галт зэвсэг, Татварын албаны бүртгэлийн баазад бүртгэлгүй боловч цагдаагийн байгууллагын шинэчилсэн бүртгэлд бүртгэлтэй татвар төлөгчийг шинээр нэмж бүртгэх /шинээр бүртгэх 252 галт зэвсэг/, Татварын албаны бүртгэлийн баазад бүртгэлтэй боловч цагдаагийн байгууллагад бүртгэлгүй 1013 галт зэвсгийн мэдээллийг тодруулахаар ажиллаж байна. Галт зэвсэг эзэмшигч шилжсэн тохиолдолд төрлөөр нь тухайн татварын албанд мэдэгдэж, ногдолтой нь шилжүүлэх ажлын хүрээнд 38 татвар төлөгчийн 49 галт зэвсгийн татварыг төлүүлэн ажиллаж байна. | | | | | | |
| 136 | | Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг барагдуулах ажлыг зохион байгуулна. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамж төлөх нээлттэй ил тод хялбаршуулсан цахим системийг нэвтрүүлнэ. | 100% | Хууль тогтоомжийн дагуу хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 100 хувийн гүйцэтгэлд хүргэж ажилласан байна. | 3,000.00 | Дүүргийн төсөв | ТХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2022.10.31-ний өдрөөр Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөвлөгөө 1,652,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1,940,496.0 мянган төгрөг төвлөрүүлж 117.4 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.<br>Хог хаягдлын үйлчилгээний хураамж төвлөрүүлдэг 3 ААНБ мөн УБЦТС-ын ХҮТ-5 болон ХҮТ-8 хамтран нийлбэр дүнгээр 2,480 ААНБ, бизнес эрхлэгч иргэдээс хураан төвлөрүүлж байна. Хог хаягдлын үйлчилгээний хураамж Татвар төлөгчид хог хаягдлын үйлчилгээний хураамжийг itax.mta.mn хаягаар төлбөрийн даалгавар үүсгэн татварын дансанд төвлөрүүлж байна. | | | | | | |
| 137 | | Газрын төлбөрийг хураан барагдуулах ажлыг зохион байгуулна. | 93% | Татварт хамрагдсан татвар төлөгчийн тоо нэмэгдэж төлөвлөгөөг 100 хувийн гүйцэтгэлд хүргэж ажилласан. | 5,000.00 | Дүүргийн төсөв | ТХ | 100% |
| | | 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Иргэний газрын эрх борлуулсны орлогын албан татварын төлөвлөгөө өссөн дүнгээр 960,000 мянган төгрөг, өссөн гүйцэтгэл 1,494,171 мянган төгрөг буюу 155,6 хувийн гүйцэтгэлтэй байна. Газрын төлбөрийн төлөвлөгөө өссөн дүнгээр 303,586.0 мянган төгрөг, гүйцэтгэл 440.182.0 мянган төгрөг 144.9%-тай байна. Суурь түвшинг 100% болгохын тулд Газрын албанд ногдлыг бүрэн оруулах тал дээр хамтарч ажиллах албан бичиг хүргүүлэн ажиллаж байна. | | | | | | |
| 138 | | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийслэл хотын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 90% | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийслэл хотын албан татварын тухай хуульд хамаарах татвар төлөгчийн тоо нэмэгдсэнээр татварын орлого өссөн байна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | ТХ | 100% |
| | | НХАТ-ын төлөвлөгөө 2022.10.31-ний өдрийн байдлаар 1,119,565.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1,161,636.0 мянган төгрөг төвлөрүүлж гүйцэтгэл 103,7 хувийн гүйцэтгэлтэй байна. НӨАТ-ын төлөвлөгөө 42,180,323.0 мянган төгрөг, гүйцэтгэл 43,979,418.0 мянган төгрөг буюу 104.7 хувийн гүйцэтгэлтэй байна. байна.<br>Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй зах худалдааны төвүүдэд үйл ажиллагаа явуулдаг лангуу түрээслэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд "Татварын Ерөнхий хууль" түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, НӨАТ-ын тухай хууль, НХАТ-ын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, татвар төлөгчдэд зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх, мэдээллээр хангах ажлын хүрээнд хэлтсийн албан хаагчид баталсан хуваарийн дагуу 4 баг болон худалдааны төвүүд дээр ажиллаж байна. Тус ажлын хүрээнд түрээслэгч болон лангуу эзэмшигч солигдож өөрчлөгдсөн бол судалгааг шинэчлэн, төлбөрийн баримт олгодоггүй болон тайлант хугацаанд тайлан ирүүлээгүй иргэдэд 162 мэдэгдэл гардуулж зөрчлийн тухай хуулийн дагуу 27 иргэнийг 4,290.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллалаа. 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс 27-ны өдрүүдэд "Дэлхийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих-2022" арга хэмжээ, 2022 оны 08 дугаар сарын 19-ний өдрөөс 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрүүдэд Хичээлийн шинэ жилийн үзэсгэлэн худалдаан болон Ногооны үзэсгэлэн худалдаа, 2022 оны 09 дугаар сарын 16, 17, 18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Номын баяр" үзэсгэлэнд оролцогч иргэн, аж ахуйн нэгжийг газар дээр нь бүртгэлжүүлэн QR коджуулан төлбөрийн баримт олголтод хяналт тавьж ажилласан. НӨАТСТ-өөр 47 иргэнийн шинээр бүртгэсэн байна | | | | | | |
| 139 | | "Цахим төлбөрийн баримтын систем" | 70% | Худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, | 10,000.00 | Дүүргийн төсөв | ТХ<br>ААНБ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | /ebarimt/ нэвтрүүлэх ажлыг дүүргийн нутаг дэвсгэрт байршилтай 42 томоохон зах, худалдааны төвүүд болон жижиг дунд бизнес эрхлэгчдийг бүрэн хамруулах, тасралтгүй хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна | | хуулийн этгээдийн лангуу, павильон тус бүрт QR код бүхий наалтыг наан байршуулах ажлыг 100 хувийн гүйцэтгэлд хүргэн ажиллана. | | | | |
| | | "Цахим төлбөрийн баримтын систем" /ебаримт/ нэвтрүүлэх ажлыг дүүргийн нутаг дэвсгэрт байршилтай 40 томоохон зах, худалдааны төвүүд болон жижиг дунд бизнес эрхлэгчдийг бүрэн хамруулах, тасралтгүй хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд байрлах "Тэгш Төмөр" ХХК-ийн Урлан захыг нэмж бүртгэлжүүлэн 19 иргэн, 1 аж ахуйн нэгжид QR код бүхий наалтыг наан байршуулж, зөвлөгөө зааварчилгаа өгч ажилласан. Мөн зах худалдааны төвүүдэд ажил бараа үйлчилгээ борлуулж буй бизнес эрхлэгчийг татвар төлөгчөөр бүртгэх, бүртгэлтэй татвар төлөгчийг QR коджуулах, гар утас болон бусад төхөөрөмж ашиглан Tax TUB аппликейшнийг хэрэглэж, татвар төлөгчийн мэдээллийг нягтлах, төлбөрийн баримт олголтод хяналт тавих ажлыг зохион байгуулан хяналт тавин ажиллаж байна. 2022 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 3417 иргэн, хуулийн этгээдэд QR наалт олгож, холбогдсон 2998, ибаримт олгож байгаа 2216 иргэн, хуулийн этгээд байна. Мөн бааз цэгцлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа нь татан буугдсан Дөрвөн-Уул, Гэгээ, Хан-Эрдэнэ худалдааны төвүүдийг системээс хасуулахаар НТГ-т албан бичиг хүргүүлсэн.<br>Сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 12 дугаар тушаалыг хэрэгжүүлэх чиглэлээр тус дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй зах худалдааны төвүүдэд үйл ажиллагаа явуулдаг цахим төлбөрийн баримт олгодоггүй бизнес эрхлэгч, лангуу түрээслэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд "Татварын Ерөнхий хууль" түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, НӨАТ-ын татварын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, татвар төлөгчдөд зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх, мэдээллээр хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд тус хэлтсийн албан хаагчид баталсан хуваарийн дагуу 4 баг болон худалдааны төвүүд дээр ажиллаж байна. Нийт 142 мэдэгдэл гардуулж 26 иргэнд нийт 4140000 төгрөгийн торгууль ногдуулсан байна.<br>ХХОАТ-ын тайлан, НӨАТ-ын татварын тухай хууль, цахим төлбөрийн баримт олголтын талаар 2 удаагийн сургалтыг зохион байгуулан цаашид тасралтгүй сургалт зохион байгуулахаар төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна. | | | | | | |
| 140 | | Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, авто зам ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөрийг төсөвт төвлөрүүлэн ажиллана. | 98.6% | Тээврийн хэрэгслүүдийг татварт 100 хувь хамруулсан байна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | ТХ ЗЦХ | 90,1% |
| | | АТБӨЯХАТ, АБТ, АЗАТ-ийн 2022 оны НЗД-ын 2022.02.10-ны өдрийн А/156-р захирамжийн дагуу тус дүүрэгт авто тээврийн хэрэгсэл эзэмшиж буй иргэн аж ахуйн нэгжийг татварт бүрэн хамруулах урьд оны татварын дутуу төлөлтийг хураан барагдуулахаар ажиллаж байна. Татварын хэлтсийн нэг цэгийн үйлчилгээний авто хариуцсан 1 татварын улсын байцаагч иргэний тээврийн хэрэгслийн татварыг хүлээн авч, 2 байцаагч аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгслийн татварыг хүлээн авч ажиллаж байна. Татварын алба шинэлэг хэлбэрээр цахим татварын системийг нэвтрүүлэн ажиллаж иргэд татвар төлөгч нар хаана ч цахимаар татвар төлөх бүрэн боломжтой болсон. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | АТБӨЯХАТ-н төлөлтийн хувийг цахимаар төлүүлэх ажлыг эрчимжүүлж сургалт сурталчилгааг өдөр тутам хийж гүйцэтгэн ажиллаж байна. 2022.10.31-ний өдрийн байдлаар Нийслэлийн төсөвт АТБӨЯХАТатвар 5,235,282.0 мянган төгрөг, 90.1 хувь, улсын төсөвт Агаарын бохирдлын төлбөр 199,494 мянган төгрөг, 92.6 хувь нийслэлийн авто зам ашигласны төлбөрт 2,096,310 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлэн 88.9 хувийн гүйцэтгэлтэй байна. 2022 оны 10 дугаар сарын 17-ний өдрийн Нийслэлийн замын хөгжлийн газар, Нийслэлийн татварын газар, ТЦА-ны зам тээврийн хяналтын хэлтэс хамтарсан удирдамжид хяналт шалгалтын ажлын хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 19-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд 2 пост гарч тээврийн хэрэгслийн гэрчилгээг хураах тээврийн хэрэгслийн татварын төлүүлэх чиглэлээр хяналтын ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Тээврийн хэрэгслийн ЦАХИМААР ТӨЛЖ ЦАГАА ХЭМНЭЕ нэртэй постерийг Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн фэйсбүүк пэйж хуудсанд байршуулж тээврийн хэрэгслийн татвар төлөх 8 төрлийн боломжоос өөрт хялбар аргаар сонгож үйлчлүүлэхийг уриалж ажилласан бөгөөд ebarimt аппликейшнд автомашины төлбөрийн мэдээлэл очихоос гадна масс мессежийг төлөгдөөгүй тээврийн хэрэгсэл бүрд хүргэж ажилласан. Арилжааны 5 банкны аппликейшн ашиглан АТБӨЯХАТ, АЗАТ, АБТ төлбөрийг хэрхэн төлөх төлөөр видео зааварчилгааг фэйсбүүк пэйж хуудсанд байршуулж ажиллалаа.<br>2022 оны АТБӨЯХ бүртгэл шилжилт хөдөлгөөний мэдээллийг цэгцлэх шинэчлэх, ажлын хүрээнд нийт ТУНС-д "Хөрөнгийн бүртгэл Шинэ АТБӨЯХ бүртгэх" цэсэд бүртгэлтэй 1158 мэдээлэл шинэчлэгдсэн тээврийн хэрэгслийн бүртгэл, Шинээр бүртгэгдсэн 4974 тээврийн хэрэгслийн бүртгэлийг хийж 2022 оны ногдлын мэдээллийг оруулж ажиллаж байна. Төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх зорилгоор нүүрс ачаа тээврийн болон С зөвшөөрөлтэй 2022 онд ногдол өндөр төлөлт хангалтгүй томоохон ААНБ-ын судалгааг байцаагчаар гарган ажилбар хийлгэхээр ЖТТХТ хүргүүлэн ажилласан Мөн албан татварт хамрагдалтыг сайжруулах , төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх зорилгоор 2022 оны 10 дугаар сарын 14 өдрийн тооцооллын мэдээллийг АТӨЯХАТ, АБТ, АЗАТ төрлөөр ЖТТХТ, БТТХТ, Хувь хүний татварын тасгийн байцаагчаар татвар төлөгчийн өрийн мэдээллийг ангилан хүргүүлж ажилласан байна.<br>Монгол Улсын хилээр гараад буцаж орж ирээгүй, эвдэрсэн, байгалийн давагдашгүй хүчин зүйл, гэнэтийн аюул ослоос шалтгаалан эвдэрч цаашид ашиглах боломжгүй болсон иргэн, хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасагдаагүй урд онуудад татварын өр үүссэн **42** татвар төлөгчийн 72 тээврийн хэрэгслийн 43,425,864.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэн татварын өргүй болох тодорхойлолтыг гарган АТҮТ болон ТУНС-ээс хасалт хийн ажиллаж байна.ТУНС-ийн тооцооллын үлдэгдэл 2016, 2017, 2018, 2019, 2020 тус онуудад зөрүүтэй алдаатай **19** ААН байгууллага, **33** Иргэний тооцооллыг үлдэгдлийг МТТ -тай хамтран засварлаж шийдвэрлэн ажиллаж байна.. | | | | | | |
| 141 | | "Татвар төлөгчийн өдрүүд"-ийг зохион байгуулах, татварын хууль, тогтоомжийг сурталчлах, сургалт хийх, татвар төлөгчдөд зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна. | 100% | Албан хаагдын мэдлэг чадвар дээшилсэн байна. | 25,000.00 | Дүүргийн төсөв | ТХ ААНБ | 100% |
| | | Сүхбаатар дүүргийн татварын даргын 2021 оны 4 дүгээр сарын 01-ний А/17 тоот тушаалаар тус хэлтсийн сургалт, сурталчилгаа хариуцсан орон тооны бус зөвлөлийг байгуулсан бөгөөд Татварын албанаас 2022 оныг "Татварын боловсролын жил" болгон зарласантай холбогдуулан 2022 онд хийгдэх сургалт, сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөг 2022 оны 2 дугаар сарын 21-ний өдөр батлуулан ажиллаж байна. 2022 оны 5 дугаар сард зохион байгуулагдсан Татвар төлөгчдийн өдрүүдээр дараах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаа. Үүнд:<br>1. "МИНИЙ МЭДЭХ ТАТВАР" гар зургийн уралдаанд 62 уран бүтээл ирсэн ба шалгарсан бүтээлийг татварын ерөнхий газарт хүргүүлсэн. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2. "ТАТВАР МИНИЙ АМЬДРАЛД" ирээдүйн татвар төлөгчдөд зориулсан ЕБС-ийн 16-р сургууль болон "Үй Цээ" бүрэн дунд сургуулийн ахлах ангийн сурагчдад зориулсан сургалт болж нийт 142 хүүхдүүд оролцсон байна.<br>3. Сүхбаатар дүүргийн засаг даргын тамгын газрын санхүү төрийн сангийн хэлтэс, Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран "Танд зөвлөе" санхүүгийн өдөрлөг зохион байгуулсан.<br>4. Дүүргийн 1-20 хороонд татварын албаны мэдээллийн самбар шинэчлэн байршуулж танилцуулга боршур тараан 2 удаагийн сургалт зохион байгуулж 522 татвар төлөгч оролцсон байна.<br>5. Их тойруу, Жоби, Авто молл, Хүсэл худалдааны төвүүдэд төлбөрийн баримт олголт ХХОАТ-ын тайлан хэрхэн ирүүлэх, шинээр НӨАТ төлөгч болох, буцаан олголт хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар 2 удаагийн сургалт зохион байгуулсан.<br>6. 300-1500,0 сая төгрөгийн орлоготой буцаан олголтод хамрагдах татвар төлөгчдөд зориулсан танхимын сургалтыг "Тод Тауэр"-ын 9 давхарт 2 удаа зохион байгуулж 98 татвар төлөгч хамрагдаж цахим пэйж хуудсаар олон нийтэд түгээн ажилласан.<br>7. Сүхбаатар дүүргийн засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс, Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран "Танд зөвлөе" санхүүгийн өдөрлөгийг 2 өдөр зохион байгуулсан.<br>8. Bloomberg тв, Худалдаа хөгжлийн банкны гудамжны дэлгэц, Нийслэл дэлгэц, Их дэлгүүрийн урд байрлах дэлгэцүүдээр татвар төлөгчдийн өдрүүдээр сурталчилгааг тогтмол цацсан.<br>9. Татвар төлөгчдийн өдрүүдээр Ерөнхий боловсролын сургуулийн 142 сурагчдад, Их дээд сургуулийн 80 сурагчдад, татвар төлөгчдөд 18 Удаа 728 татвар төлөгчдөд сургалтыг танхимаар болон ажлын байранд зохион байгуулсан.<br>Сүхбаатар дүүргийн болон Татварын ерөнхий газрын facebook цахим хаягийг идэвхжүүлэх, дагагчийн тоог нэмэгдүүлэх, тавигдаж байгаа мэдээ, мэдээллүүдийг шэйр хийж, зарим асуултад хариулт өгч ажилласан байна. | | | | | | |
| 142 | | Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу татвар төлөгч хувь хүний тайлан, татварын хөнгөлөлт эдлүүлэх тайлан, бичиг баримтыг цахим татварын системээр хүлээн авах ажлыг зохион байгуулна. | 100% | Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг ханган, татвар төлөгч хувь хүний албан татварын хөнгөлөлт эдлэх иргэдийн тайлан, бичиг баримтыг цахим татварын системээр хүлээн авч авч ажиллана.100 хувь хамруулсан байна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | ТХ | 100% |
| | | 2021 оны Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх 2,525 иргэний 3,072,795,81.55 төгрөгийн буцаан олгох дүнг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Хэлтсийн даргын А/18 тоот тушаалаар баталгаажуулан Нийслэлийн татварын газарт хүргүүлэн ажилласан. | | | | | | |
| 143 | | Цахим татварын систем ашиглан татварын үйлчилгээг хүргэх программ хангамжийн хөгжүүлэлтийг цахим, инновацын багийн | 0% | Татварын үйлчилгээ авахад хялбар болж 60% цахим үйлчилгээг хүргэж ажилласан байна. | 30,000.00 | Дүүргийн төсөв | ТХ<br>ААНБ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | түвшинд хийж, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана. | | | | | | |
| | | Цахим шинэчлэлийн орон тооны бус зөвлөлийн 2022 оны ажлын ерөнхий төлөвлөгөө 2022.02.13-ны өдөр хэлтсийн даргаар батлуулж хуваарийн дагуу ажиллаж байна.<br>Тус төлөвлөгөөний гүйцэтгэлийг 2022 оны эхний хагас жилд бүрэн дуусгахаар төлөвлөсөн бөгөөд олон нийтийн цахим сүлжээнд ашиглах ЧАТБОТ-ын эхний хувилбарыг Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн FACEBOOK хуусад байршуулан ашиглаж байна.<br>Түүнчлэн TaxTUB аппликэйшнд нэмэлтээр хөгжүүлэх бодлогын даалгаврыг боловсруулж Татварын ерөнхий газарт хүргүүлсэн. | | | | | | |
| 144 | | Мэдээлэл, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийх, томоохон зах худалдааны төвүүд, үзэсгэлэн олон нийтийн үйл ажиллагаанд татварын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, зөвлөгөө мэдээлэл өгөн ажиллаж, цахим татварын үйлчилгээтэй холбоотой тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана. | 60% | 100% | 27,000.00 | Дүүргийн төсөв | ТХ | 100% |
| | | 2022 онд хийгдэх сургалт, сурталчилгааны төлөвлөгөө 2022.02.21-ний өдөр хэлтсийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.<br>1. Хувь хүний орлогын албан татварын тайланг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор гарган өгдөгтэй холбогдуулан Сүхбаатар дүүргийн харьяа байгууллагуудын албан хаагчдад сургалт зохион байгуулж Хувь хүний орлогын албан татварын тайланг хүлээн авах ажил зохион байгуулсан.<br>2. Хэлтсийн Facebook page хуудсыг байнга хөтлөн явуулах нэг байцаагчийг томилон ажиллуулж байна.<br>3. Өдөр бүр хэлтсийн page хуудаст “Танд асуух асуулт байна уу” гэсэн пост оруулж татвар төлөгчийн асуусан асуултад комментоор хариулан ажиллаж байна.<br>4.Сүхбаатар дүүрэгт байрлалтай 42 зах худалдааны төвийг сургалт, сурталчилгаа мэдээллээр хангах баг гарган ажиллаж байна.<br>5.Татварын шинэчилсэн хуулиар 90 хувийн буцаан олголт авах татвар төлөгчдөд сургалт зохион байгуулсан.<br>6. Хувь хүний татварын хөнгөлөлттэй холбоотойгоор хэлтсийн page хуудасны чат хэсэгт чатботоор хариулт өгдөг болсон.<br>7. Шинээр байгуулагдсан татвар төлөгчдөд сар бүр сургалт хийж хэвшсэн.<br>8. Реклам, сурталчилгаа хийдэг байгууллагатай хамтран ажиллахаар судалгаа хийж байна. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 145 | | Албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтыг ТББ, татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгтэй хамтран зохион байгуулна. | 30% | 100% | 20,000.00 | Дүүргийн төсөв | ТХ | 100% |
| | | Хэлтсийн даргын тушаалаар Сургалт, сурталчилгааны орон тооны бус зөвлөлийг байгуулж тасаг бүрээс сургалт хариуцсан албан хаагчийг томилон ажиллуулж байгаа бөгөөд энэхүү зөвлөл нь татвар төлөгчдөд болон албан хаагчдад сургалт зохион байгуулах соён гэгээрүүлэх 2 чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулж төлөвлөгөө батлуулан ажиллаж байна. Эдгээр ажлын хүрээнд сар бүр эрдэмтэн багш нарыг урин албан хаагчдад хандлага харилцаагаа сайжруулах хариуцлагатай төрийн албан хаагч байх талаар сэдэл, эрмэлзэл төрүүлэхүйц сургалтуудыг зохион байгуулж байна. Эхний сургалт 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдаж МУБИС-ийн Сэтгэл зүйн тэнхимийн багш н.Энхмаа оролцож "Сэтгэл зүйн эрүүл мэнд" сэдвээр албан хаагчдад сургалт зохион байгууллаа. Энэхүү сургалтад хэлтсийн 69 албан хаагч амжилттай хамрагдлаа. Мөн Залуучуудын боловсрол судлалын төв төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулж албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх тэр дундаа англи хэлний мэдлэгийн түвшинг ахиулан ажиллах, албан хаагчдын хүүхдийг сургалтад хамруулах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулж хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж байна. Төрийн бус байгууллагаас албан хаагчдад сургалт мэдээлэл мэдлэгийг түгээн ажиллахаас гадна олон нийтэд хандсан үйл ажиллагаануудыг хамтран зохион байгуулан ажиллаж байна. Тухайлбал: 2022 оны 01 дүгээр сард "Англи дууг хэн сайн дуулах вэ" ковер дууны уралдааныг зохион байгуулж англи хэл сонирхон судалж суралцаж буй хүүхэд залуусын ирүүлсэн бүтээлүүдээс шалгаруулан эцсийн шатны шалгаруулалтыг Гэгээ цагаан ордонд шилдэг 15 оролцогчийн хамт зохион байгуулж ажиллалаа. Энэхүү ажил нь хэл сурах авьяас чадвараа хөгжүүлэхээс гадна татварын албаны үйл ажиллагааг хүүхэд залууст сурталчлах зорилготой юм. Олон Улсын чанарын стандартын зөвлөх, Тэргүүлэх аудитор Ш.Соёлзулыг урьж "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр татвар төлөгчтэй харилцах, төрийн үйлчилгээг хэрхэн зөв, соёлтой, шуурхай иргэдэд хүргэх мөн албан хаагчид бие биетэйгээ хүндэтгэлтэй харилцах зэрэг харилцааны ур чадварыг нэмэгдүүлэх талаар сургалтад албан хаагчид амжилттай хамрагдлаа. 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Сүхбаатар дүүргийн хяналтын прокурор М.Даваадорж албан тушаалын гэмт хэрэг сэдвээр сургалт орсон. 2022.09.16-ны өдөр Нийслэлийн онцгой байдлын газрын Дэд бүтэц газар хөдлөлийн асуудал хариуцсан мэргэжилтэн ахлах дэслэгч Т. Батбаатарыг урьж "Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хүн ам, эд хөрөнгө, байгаль орчинг авран хамгаалах сэргээн босгох арга ажиллагаанд төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага мэргэжлийн анги ажилтан, албан хаагчид, иргэдийг сургаж дадлагажуулах" сэдвээр, 2022.10.19-ний өдрийн ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газартай хамтран мансууруулах эм сэтгэцэд нөлөөлөх бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор "Ирээдүйгээ хамгаалъя" уриа дор "Анзаар" аяны хүрээнд албан хаагчдад сургалт зохион байгуулж нийт 84 албан хаагч хамрагдсан. | | | | | | |
| 146 | | Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлж, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтын зохион байгуулна. | 80% | Албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж ажилласан байна. | 20,000.00 | Дүүргийн төсөв | ТХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Татварын хэлтсийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлуулан 5 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж ажилладаг.Хөтөлбөрийн 5 дугаар хэсэгт заасан “Эрүүл мэндийн баталгаа,бие бялдраа хөгжүүлэх ”заалтын хүрээнд төлөвлөгөөг дэлгэрэнгүй тусган хэрэгжүүлж байна. 2022 оны 2 дугаар улиралд багтаан нэгдсэн үзлэг шинжилгээ авах ажлыг төлөвлөгөөт ажлыг зохион байгуулж ажиллахаар эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах санал хүргүүлэв.Татварын хэлтсийн даргын зөвлөлийн хурлын шийдвэрээр 2022 онд “Хандлага, Хариуцлага, Хөгжил” зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулж ажиллах шийдвэр гарсан. Энэхүү зорилтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Урлаг соёл, спорт, нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан төлөвлөгөө батлуулж ажиллав.Сургалт хөгжлийн хөтөлбөрийг албаны хэмжээнд төлөвлөгөө гарган ажиллаж байгаа ба уг төлөвлөгөөний хүрээнд сар бүр албан хаагчдад сургалт зохион байгуулан ажиллах, төрийн болон төрийн бус байгууллагын сургалтад албан хаагчдыг хамрагдахад нь дэмжин ажиллах, тодорхой хугацааны чөлөө олгох суралцах нөхцөл бололцоог ханган ажиллав.Эрүүл агаарт гарах, ууланд алхах, спорт үйл ажиллагааг зохион байгуулахдаа цагийг үр бүтээлтэй өнгөрөөх “Цайны завсарлага” буюу сонирхолтой түүх ярих, мэдээ мэдээллийг ханган ажиллах зохион байгуулалтын үйл ажиллагааг зохион байгуулахаар ажлын хэсгүүд ажлаа зохион байгуулж даргын зөвлөлийн шуурхай хуралдаанд танилцуулав.Албан хаагчид “Илүүдэл жингүй, Эртэч монгол” аянд нэгдэж ажлын байрны дасгал хөдөлгөөн хийж хэвшин ажиллаж байна. Анх удаа аав ээж болсон 1 эцэг, 2 эхэд нэг удаагийн буцалтгүй тусламж, эрүүл мэндийн шалтгаанаар нэг албан хаагчид эмчилгээний зардалд буцалтгүй тусламж олгов. | | | | | | |
| 147 | ДЗДҮАХ-4.3.5 | Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй их дээд сургууль, ЕБС-иудтай хамтран эрүүл мэнд, сайн дурын даатгал, нийгмийн даатгалын ач холбогдлын талаар таниулах сургалтыг зохион байгуулна. | 2020 онд тус дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг их дээд сургууль болон бусад ЕБС-иудын төгсөх ангийн сурагчдад нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг цахим хэлбэрээр зохион байгуулж 21500 иргэдийг хамруулсан | 22500 | 1,500.00 | Дүүргийн төсөв | НДХ | 80% |
| | | Тус хэлтэст бүртгэлтэй их, дээд сургууль болон ЕБС-иудын төгсөх ангийн сурагчдад нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын чиглэлээр мэдээлэл олгох сургалт зохион байгуулахаар 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. МУБИС, Этүгэн их сургууль, Этүгэн МСҮТ, Этүгэн ЕБС, ҮУПК, 31, 3, 16 дугаар сургуулийн 800-аад оюутан сурагчдад нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, сайн дурын даатгал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, даатгалын ач холбогдлын талаар танхимын сургалт зохион байгуулж, 800 гаруй оюутан, сурагчдыг ЭМД-д хамруулсан. Мөн 16,000 гаруй дагагчтай тус хэлтсийн пейж хуудсаар нийгмийн даатгалын 5 сангаар 70 постер, 8 видео хичээл оруулж, 1100 гаруй даатгуулагч иргэдийн асуултанд хариулж 1600 гаруй сурталчилгааны материал тараан ажилласан. | | | | | | |
| 148 | | Шинээр бүртгүүлсэн болон ажил олгогч байгууллагын хүсэлтээр нягтлан бодогч нар болон удирдлагуудад нийгмийн даатгалын хууль | 7000 ажил олгогчийн нягтлан бодогч нарт нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан цахим болон мэдээлэл хүргүүлэх | 7500 | 3,000.00 | Дүүргийн төсөв | НДХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тогтоомжийг сурталчлах мэдээлэл өгөх сургалт зохион байгуулна. | хэлбэрээр сургалт зохион байгуулсан. | | | | | |
| | | Тус хэлтэст шинээр бүртгүүлсэн 629, бүртгэлтэй 6375 ажил олгогч байгууллагын захирал, нягтлан бодогч нарт нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаарх мэдээллийг хариуцсан байцаагч нар өөрсдийн ажил олгогч байгууллагын захирал, нягтлан бодогчтой харьцдаг чат группээр өгч, мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан. MNBC олон суваг дамжуулах телевиз, БШУЯ-с хэрэгжүүлж буй "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл", МХЕГ, ОБЕГ, Тавилгын үйлдвэр, 4-р цахилгаан станц, Монхангай группын Миний дэлгүүрийн сүлжээ салбар дэлгүүр, Шунхлай группы шатахуун түгээх салбарын зэрэг 210 гаруй даатгуулагчдад, шинээр бүртгүүлсэн 200 аж ахуйн нэгж байгууллага, ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтад 180 ажил олгогчийн 510 гаруй, мөн шимтгэлийн авлага их хэмжээгээр үүсгэсэн 89 ААНБ-ын 100-аад захирал нягтлан бодогч нарт танхимын сургалтын зохион байгуулан явуулсан. | | | | | | |
| 149 | | Дүүргийн хороодын хэсгийн ахлагч, зохион байгуулагч, нартай хамтран тэтгэвэр тогтоолгох насны иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг танилцуулах сурталчлах ажлыг зохион байгуулна. | 2020 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох 1080 даатгуулагчдад зөвлөгөө мэдээллийг өгөн тэтгэврийг тогтоон олгосон. | 1150 | 1,500.00 | Дүүргийн төсөв | НДХ | 100% |
| | | Дүүргийн 1-20 хорооны 1680 даатгуулагч иргэдэд зөвлөгөө мэдээллийг өгч тэтгэврийг шинээр тогтоон ажилласан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй 65 иргэнд үйлчилгээ үзүүлснээс 20 иргэний гэрт очиж үйлчилсэн. СБД-ийн ЗДТГ-аас зохион байгуулсан аяны хүрээнд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон болон тогтоолгох насанд хүрч буй 171, ажил хөдөлмөр эрхэлж буй 42 нийт 278 даатгуулагч иргэдэд зөвлөгөө мэдээлэл өглөө. ННДГ-ын даргын баталсан "Явуулын үйлчилгээ үзүүлэх" удирдамжийн дагуу 8.9 дүгээр сард Жигжид, Бэлх, Зунжин зуслангийн хэсэг, УИД-ийн болон 100 айл BSB дэлгүүрийн урьд талын талбай, Их тойруу, Бэлх худалдааны төв, Сарлул зах, 100 айлын барилгын материалын дэлгүүрээр явж 2000 орчим даатгуулагч иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. НДБ-ын 80 жилийн ойн хүрээнд "80 ЖИЛ-8 БҮТЭЭЛЧ АЖИЛ" аяны хүрээнд Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох хэлтэс, И-Монгол академи УТҮГ-тай хамтран "ЦАХИМ ШИЛЖИЛТ-ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ" аяныг 2022 оны 11 дүгээр сарын 03-аас 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрүүдэд дүүргийн 1-20 хороонд удирдамийн дагуу зохион байгуулан явуулж 500 гаруй иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | | | | | | |
| 150 | ДЗДҮАХ-4.3.6 | Монгол цэргийн өдөр Зэвсэгт хүчний ойн баярын үйл ажиллагаа, генерал цолтнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулна. | Захирамж, тушаалын дагуу | Дүүргийн иргэдэд цэрэг эх оронч хүмүүжил олгох, Батлан хамгаалах салбарыг сурталчилсан байна. | 20,000.00 | Дүүргийн төсөв | ЦШ ТЗУХ, НХХ, Хороод | 100% |
| | | Монгол Улсад Генерал цол бий болсны 78 жилийн ойг тохиолдуулан тус дүүрэгт оршин суудаг Генералуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2022 оны 04 дүгээр сарын 26-ны | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | өдөр зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Дүүргийн Засаг даргын зөвлөх П.Мөнхбаяр, орлогч М.Алтангэрэл, ЗДТГ-ын дарга Н.Энхболд нар хүрэлцэн ирсэн генералуудад Засаг даргын гарын бэлгийг гардуулан өгч баярын мэнд хүргэж, хүндэтгэл үзүүлсэн. | | | | | | |
| 151 | | Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, аж ахуй нэгж байгууллагуудад хяналт шалгалт явуулна. | Захирамж, тушаалын дагуу | Батлан хамгаалах хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй болсон байна. | 10,000.00 | Дүүргийн төсөв | ЦШ Хороод, ААНБ | 80% |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, Аж ахуйн нэгжүүдэд Батлан хамгаалах хууль тогтоомжийн хяналт шалгалтыг явууллаа. Үүнд: Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль, Хүдэр-Мөнх хк, Зүүн түзэх төв хк, Skytel хк, Баянгол зачид буудал хк, Эхлэл брэнд хк зэрэг 6 байгууллага, аж ахуй нэгжийн 415 иргэний 18-50 насны эрэгтэй алба хаагчдад Батлан хамгаалах хууль тогтоомж болон цэргийн үүргийн биелэлтэд хяналт тавьж, шалган туслах ажлыг зохион байгуулсан. | | | | | | |
| 152 | | Цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний цэргийн мэргэжил олгох болон бэлтгэл офицерын мэргэжил олгох сургалт зохион байгуулна. | Захирамж, тушаалын дагуу | Цэргийн хэргийн мэдлэг дээшилсэн байна. | 2,000.00 | Дүүргийн төсөв | ЦШ Хороод | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн н/01 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн "Цэргийн бэлтгэл албаны сургалт явуулах тухай" н/03 дугаар захирамж, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу тус дүүргийн нэгдүгээр зэргийн цэргийн бэлтгэл үүрэгтнүүдэд мэргэжил олгох сургалтыг Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс 05 дугаар сарын 27-ны өдрүүдэд зохион байгууллаа. | | | | | | |
| 153 | | Удирдах албан тушаалтнуудын цэргийн бэлтгэл сургалт зохион байгуулна. | Захирамж, тушаалын дагуу | Цэргийн хэргийн мэдлэг дээшилсэн байна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | ЦШ | 100% |
| | | Хороодын Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтыг 2022 оны 09 дүгээр сард Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын хурлын заал болон Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн материаллаг баазыг ашиглан сургалтыг зохион байгуулсан. | | | | | | |
| 154 | | Цэргийн штабуудын офицер, ахлагч нарын даргын бэлтгэл сургалт зохион байгуулна. | Захирамж, тушаалын дагуу | Цэргийн хэргийн мэдлэг дээшилсэн байна. | 3,000.00 | Дүүргийн төсөв | ЦШ НЗДТГ-ын ЦШ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ЗХЖШ-ын 2021-2022 оны "Цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөө, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын "Цэргийн штабын 2021-2022 оны цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөө"-ний дагуу ЗХЖШ-аас 2022 оны 02 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгуулсан "Стратегийн команд штабын сургуульд оролцсон.<br>Сургуулийн үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон мэдээ, тайланг нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабт хүргүүлсэн.<br>Дүүргийн харуул хамгаалалтын албаны ажилтнуудтай дайчилгааны зарлан мэдээллийн дохиог ажлын болон ажлын бус цагаар явуулах, томилгоот бүрэлдэхүүнд зарлан мэдээлэл хүргэх талаар сургалт, дадлагыг 2022 оны 02 дугаар сард дүүргийн иргэний танхим болон жижүүрийн байранд зохион байгуулсан. | | | | | |
| 155 | | Оюутан цэрэгт цэргийн мэргэжил олгох сургалт зохион байгуулна. | Захирамж, тушаалын дагуу | Цэргийн хэргийн мэдлэг дээшилсэн байна. | 3,000.00 | Дүүргийн төсөв | ЦШ ҮБХИС | 100% |
| | | Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/303 дугаар захирамж, Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/81 дүгээр захирамжийг тус тус үндэслэн Батлан хамгаалах яамнаас ирүүлсэн нэрийн жагсаалтын дагуу оюутан цэргийн бүртгэлийг Үндэсний Батлан хамгаалахын Их сургуулийн байрлалд 2022 оны 03 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд эрүүл мэндийн үзлэг, 03 дугаар сарын 23-ны өдөр биеийн тамирын үзлэг тус тус хамруулж 2022 оны 06 дугаар сараас Шар хадны сургалтын төвд байрлан 2022 оны 07 дугаар сарын 30 өдөр хээрийн бэлтгэлээс бууж халагдав. | | | | | | |
| 156 | | Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын анхан болон гүнзгийрүүлсэн шатны дадлага олгох сургалт зохион байгуулна. | Захирамж, тушаалын дагуу | Цэргийн хэргийн мэдлэг дээшилсэн байна. | 6,000.00 | Дүүргийн төсөв | ЦШ Хороод | 100% |
| | | Нийслэлийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/771 дүгээр захирамжаар Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын цэргийн албаны бэлтгэл сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 17-30-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан. | | | | | | |
| 157 | | Цэргийн үүрэгтэн бэлтгэл офицеруудын бүртгэл, нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг<br>татлага, халалтыг зохион байгуулна. | Захирамж, тушаалын дагуу | Цэргийн бүртгэл чанартай явагдаж, хяналтын тоог бүрэн биелүүлсэн байна. | 45,500.00 | Дүүргийн төсөв | ЦШ Хороод | 100% |
| | | ЗХЖШ-ын даргын 2022 оны н/67 дугээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/512 дугаар захирамжийг тус тус үндэслэн Улаанбаатар хотод цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн үзлэгийг 2022 оны 05 дугаар сарын 06-08-ны өдөр, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг ЗХЖШ-ын 2022 оны н/220 дугаар тушаал Нийслэлийн Засаг даргын 2022 онб А/1227 дугаар захирамжийг үндэслэн эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулж, Зэвсэгт хүчний Жанжин штабаас өгөгдсөн хугацаат цэргийн албанд татагдах тоон даалгаврыг бүрэн биелүүлж, 2022 оны нэг, хоёр дугаар ээлжийн цэрэг татлагын ажлыг цагдаагийн байгууллагатай хамтран сахилга, зохион байгуулалтын өндөр түвшинд хэрэг зөрчилгүй зохион байгуулсан. | | | | | | |
| 158 | | Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, | Захирамж, тушаалын дагуу | Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлсэн байна. | 11,000.00 | Дүүргийн төсөв | ЦШ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | цэргийн албаа хааж байгаа дайчдын санал сэтгэглийг сонсоно. | | | | | | |
| | | Зэвсэгт хүчний 326 дугаар ангид хугацаат цэргийн алба хааж буй дайчдын цэргийн албаны үйл ажиллагаатай таилцахаар СБД –ийн Засаг дарга Х.Болормаа, цэрэг татлагын товчооны дарга бөгөөд ЗДТГ-ын дарга Н.Энхболд Сүхбаатар дүүргийн 15,16,17 дугаар хорооны засаг дарга нар цэргийн алба хааж байгаа дайчдын санал сэтгэглийг сонсож, мөн Увс аймаг Баруун туруун, Завхан аймаг Тэс сумын хилийн цэргийн ангиудаар СБД-ийн товчооны дарга болон бусад бие бүрэлдэхүүн очиж алба хааж буй цэргийн албаны үйл ажиллагаатай танилцав. | | | | | | |
| 159 | | Дайчилгаатай команд штабын хээрийн сургууль зохион байгуулна. | Захирамж, тушаалын дагуу | Бэлэн байдал дээшилсэн байна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | ЦШ Хороод | 100% |
| | | Дайчилгааны даалгаврын дагуу дүүргийн дайчилгааны төлөвлөгөөнд улирал бүр тодотгол хийсэн. Дүүргийн засаг даргын 2022 оны А/350 дугаар захирамжийн дагуу нэгдсэн дадлагыг Нийслэлийн Цэргийн штаб болон 9 дүүргийн Цэргийн штабуудтай хатарсан сургуулийг 2022 оны 09 дүгээр сарын 12-13 өдрүүдэд зохион байгуулсан. | | | | | | |
| 160 | | Орон нутгийн хамгаалалтын хуулийг сурталчлах, дайчилгаа удирдах бүлэг, цугларах болон шилжүүлэх байр, орон нутгийн цэргийн отрядын удирдах бүрэлдэхүүний сургалт зохион байгуулна. | Захирамж, тушаалын дагуу | Бэлэн байдал дээшилсэн байна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | ЦШ | 100% |
| | | Орон нутгийн хамгаалалтын хуулийг сурталчилах, Дайчилгаа удирдах бүлэг, цугларах болон шилжүүлэх байр, орон нутгийн цэргийн отрядын удирдах бүрэлдэхүүний сургалт зохион байгуулж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Нийслэлийн цэргийн штаб, Сүхбаатар дүүргийн Засаг даргын захирамжаар 2022 оны 10 дугаар сарын 13-15 хооронд Стратег команд штабын нэгдсэн сургуульд оролцох бие бүрэлдэхүүнийг тодотгож 2 дугаар сургууль дээр цуглуулж суман байгуулж Сэргэ-2022 сургуульд оролцсон. | | | | | | |
| 161 | | Нийслэл, дүүргийн Засаг даргын нэрэмжит дүүргүүдийн Ерөнхий боловсролын сургуулийн дунд зохиогдох цэрэг спортын "Дөл" тоглолтыг зохион байгуулна. | Захирамж, тушаалын дагуу | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид цэрэг, эх оронч сэтгэлгээтэй болсон байна. | 6,000.00 | Дүүргийн төсөв | ЦШ НХХ, БХ | 100% |
| | | Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/50 дугаар тушаал, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 36 дугаар зөвлөмжийг үндэслэн дүүргийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 30-ы өдрийн А/105 дугаар захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг спортын Дөл цогцолбор тэмцээнийг 2022 оны 04 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгууллаа.Тэмцээнд 3 дугаар сургууль тэргүүн байранд оров. Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын 2022 оны 02 дугаар сарын | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 23-ны өдрийн А/50 дугаар тушаал, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/474 дугаар зөвлөмжийг үндэслэн дүүргийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 04-ы өдрийн А/270 дугаар захирамжийн дагуу Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн ерөнхий боловсролийн 3 дугаар сургуулийг Улсын аварга шалгаруулах Цэрэг спортын Дөл тэмцээнд амжилттай оролцож шагналт 5 дугаар байранд оров. | | | | | | |
| 162 | ДЗДҮАХ-4.3.7 . | Мал, тэжээвэр амьтад, хөдөө аж ахуйн тооллогыг дүүргийн нутаг дэвсгэрт чанартай зохион байгуулна. | Мал, тэжээвэр амьтдын улсын тооллогыг жил бүр явуулж дүүргийн нутаг дэвсгэрт тэжээвэр амьтад өсгөн үржүүлж буй өрх, ААНБ-ыг тооллогод 100.0% бүрэн хамруулсан. Хөдөө аж ахуйн тооллогыг 2017 онд зохион байгуулж, үр дүнг тархаасан. | Тооллогод бүрэн хамруулсан байна. | 9,000.00 | Дүүргийн төсөв | СХ ЗДТГ Хороо Иргэд ААНБ | 80% |
| | | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 74 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн “Хөдөө аж ахуйн тооллого явуулах тухай” А/751 дугаар захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын А/223 дугаар захирамж гарч, Засаг даргын орлогчоор ахлуулсан дүүргийн Тооллогын комисс, 12-20 дугаар хороодод салбар Ажлын хэсгийг байгуулан, тооллогын бэлтгэл ажил, тоолох үе шатанд шаардагдах төсөв, тооллогын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллав. Үүнд:<br>- Дүүргийн нутаг дэвсгэрт тооллогын бэлтгэл ажлыг бүрэн хангах, тооллогыг чанартай зохион байгуулах, тооллогын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэхэд шаардагдах 5.8 сая төгрөгийн төсвийг батлуулан, хороод, тоологч, шалгагч нарыг холбоо, тээвэр, шатахууны зэрэг шаардлагатай зардлаар хангаж, ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллалаа.<br>- Дүүргийн Тооллогын комиссоос комиссын гишүүд, 20 дугаар хорооны Засаг дарга болон тоологч, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарын бүрэлдэхүүнийг оролцуулан, 20-р хорооны Цолмонгийн амны олон төрлийн тариалангийн талбайтай өрхөөс дүүргийн тооллогын ажлыг 06 дугаар сарын 17-ны өдөр албан ёсоор эхлүүлэх арга хэмжээг авсан.<br>- Тоологч нарт өрх, аж ахуйн нэгжийн хүрээ жагсаалтыг байршлаар нь жигд хуваарилан өгч, тооллогын өдрүүдэд маршрут, норм гарган, ажилласнаар бэлтгэгдсэн 6 тоологч, 1 шалгагч тооллогын хугацаанд 12-20 дугаар хорооны 603 өрх, аж ахуйн нэгжид хүрч, таблет төхөөрөмжөөр тооллогын асуулгыг авч, хиймэл дагуул ашиглан өрхийн байршлыг тодорхойлон, тооллогыг хугацаанд нь 100 хувийн гүйцэтгэлтэй, чанартай зохион байгуулж явууллаа.<br>- Мөн тооллогын үеэр Нийслэлийн ХХААГ-ын Газар тариалан, мал аж ахуйн хэлтсийн 2 ажилтан тус дүүргийн 18-р хорооны 12 өрхөөр, НТК-ын Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 16-р хорооны өрх, аж ахуйн нэгжээр тоологчтой хамт явж, тооллогын явц, тоологчийн мэдээлэл цуглуулалтын бодит байдалтай танилцан, хамтран ажиллав.<br>- Тооллогын үед энэ удаагийн тооллогын зорилго ач холбогдол, Монгол Улсын хүнсний аюулгүй байдал, хангамжийг хянах, үнэлэх, дүн шинжилгээ хийх зэргээр хөгжлийн бодлогыг тодорхойлоход шаардлагатай суурь мэдээллийг бүрдүүлэх зэргээр ХАА-н салбарын үйлдвэрлэл эрхлэгч өрх, иргэн, аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн Уриалгыг хэлтэс, дүүргийн пейж хуудсаар уриалж, сурталчлан ажиллав. Мөн Тооллогын бичлэг, лого, зурагт хуудсыг хэлтэс, хороод, ажилтнуудын facebook хаяг болон | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | олон дагагчтай тухайлбал дүүргийн Засаг дарга *Болормаа Хөххүү пэйж хуудас,* Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн ХАА-н групп, хороодын пейж хуудсаар цахимаар шэйрлүүлэн сурталчиллаа.<br>Мал, тэжээвэр амьтдын 2022 оны тооллого оны эцэст 12 сард явагдана. | | | | | | |
| 163 | ДЗДҮАХ-4.3.8 | Хороодын "Хүн ам, өрхийн мэдээллийн сан"-г бүрэн бүрдүүлэх, баяжуулах, Албан ёсны статистикийн мэдээллийг цахимжуулна. | 2020 онд ХАӨМС-гийн төрөлт-2552, нас баралт-690 мэдээллийн санд бүрэн оруулж баяжуулсан. Мэдээллийн сангийн алдаа засварлалтыг 98.1%-д хүргэж бууруулсан. Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээнд 11999 ААНБ-ыг 100.0% бүрэн хамруулж, үр дүнг сар, улирлаар тооцож тархаасан. | Төрийн мэдээллийн нэгдсэн сан их өгөгдлийн суурь болсон ХАӨМС-г үнэн зөв хөтлөгдөж, тогтмол баяжуулалт хийгдэж, мэдээллийн чанар, бодит байдал дээшилсэн байна. | 5,000.00 | Дүүргийн төсөв | СХ<br>ЗДТГ<br>Хороо<br>Иргэд | 80% |
| | | Дүүргийн "Хүн ам, өрхийн мэдээллийн сан" (ХАӨМС)-г бүрэн бүрдүүлэх, баяжилтыг хийж сангаа сайжруулах Дүүргийн "Хүн ам, өрхийн мэдээллийн сан" (ХАӨМС)-г бүрэн бүрдүүлэх, баяжилтыг хийж сангаа сайжруулах чиглэлээр 20 хороодыг мэргэжил арга зүйгээр хангаж дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:<br>• ХАӨМС-гийн баяжилт, чанар, алдаанд онцгой анхаарч, шинэ төрсөн болон нас барсан иргэдийн мэдээллийг тухай бүр нь санд оруулах арга хэмжээг авч, сангийн алдааг засварлах ажил үргэлжлэн хийгдэж байна. 2022 оны эхний 10 сарын байдлаар шинээр төрсөн 1620 хүүхэд, нас барсан 510 хүний мэдээллийг санд оруулах арга хэмжээг авав. Мөн шилжин ирсэн, явсан иргэдийн мэдээллийг шинэчлэн оруулаа.<br>• ХАӨМС-гийн алдааг сар бүр уншуулан хороодод хүргүүлж, засуулах, шалтгаан тайлбарыг тодруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>Статистикийн байгууллага үүсэж хөгжсөний 98 жил, дүүрэгт Статистикийн алба байгуулагдсаны 30 жилийн ойн хүрээнд 20 хороодын дунд анхан шатны нэгжийн анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах чиглэлээр эрчимжүүлсэн 10 хоногийн аяныг зарлаад байна. Аяны үр дүн 11 дүгээр сард гарна. | | | | | | |
| 164 | | Дүүргийн Нийгэм, эдийн засгийн эмхэтгэл, танилцуулга бэлтгэн хэвлэх, тархаана. (1992-2021) | Эдийн засаг, нийгмийн жилийн танилцуулгыг бэлтгэн, удирдлагууд болон холбогдох хэлтэс, албадын албан хэрэгцээнд хүргүүлж ажилласан. | Дүүргийн эдийн засаг, нийгмийн 2022 оны сар бүрийн танилцуулга, сүүлийн 20 жилийн үзүүлэлтээр жилийн танилцуулгыг бэлтгэн тархаасан байна. | 3,000.00 | Дүүргийн төсөв | СХ<br>ЗДТГ<br>Хороо<br>Иргэд<br>ААНБ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | "Дүүргийн эдийн засаг, нийгмийн байдал"-ын сарын 12, салбарын 11, нийт 12 төрлийн танилцуулга, мөн жилийн танилцуулгыг бэлтгэн, дүүргийн удирдлагууд, дэргэдэх хэлтэс, албад, иргэдэд цахимаар тархааж, нийслэл, дүүргийн вэб сайт, хэлтсийн facebook болон 20 хороодын пейж хуудсуудаар дамжуулан цахим орчинд түгээн, хэрэглэгч, олон нийтэд мэдээллийг ил тод тархааж ажиллав. | | | | | | |
| 165 | ДЗДҮАХ-4.3.9 | Албан ёсны Статистикийн мэдээг цахимжуулахад дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мэдээлэгч ААНБ-ууд, Хороодын ажлын албанд сургалт зохион байгуулна. | 20 хороодын Засаг дарга, Зохион байгуулагч, Нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нийт 225 албан хаагчийг оролцуулсан сургалт зохион байгуулсан. | Батлагдсан төлөвлөгөөний дагуу мэргэжил, аргазүйн сургалтыг зохион байгуулсан байна. | 3,000.00 | Дүүргийн төсөв | СХ<br>ЗДТГ<br>Хороо | 70% |
| | | Сар, улирал, жилийн мэдээг цахимжуулах ажлын хүрээнд ҮСХ-ноос 2022 оны 02 дугаар сараас эхлэн бүх салбарын мэдээг *sudalgaa1212.mn* цахим мэдээллийн системд оруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулан, одоогоор 9 салбарын мэдээг тус системээр дамжуулан мэдээлж ажиллалаа. Салбаруудын мэдээг шинэ системээр авах болсонтой холбогдуулан албан хаагчид хариуцсан салбарын мэдээллийг цахимжуулах ажлыг гүйцэтгэж байна.<br>Статистикийн мэдээлэгч анхан шатны нэгж болох дүүргийн 20 хорооны ажлын албаны ажилтнуудад төлөвлөгөөт болон цаг үеийн чадавхжуулах сургалтыг цахимаар болон танхимаар зохион байгуулж, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарын 200 гаруй албан хаагчдыг хамруулан, статистикийн мэдлэг, боловсролыг нь дээшлүүлэн ажиллалаа.<br>Хүн ам, өрхийн мэдээллийн санд мэдээллийн баяжилт хийх, сангийн ач холбогдлын талаар ажлын байрны дадлагажуулах сургалтыг 20 дугаар хорооны хэсгийн ахлагч нарт, мөн газар тариалангийн бүс хороодын зохион байгуулагч нарт бүсчилсэн сургалтыг тус тус зохион байгуулан чадавхжуулав.<br>Дүүргийн мэдээлэгч аж ахуйн нэгжийн ажилтнуудад зориулсан сургалтыг Статистикийн өдрийг тохиолдуулан 11 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөөд байна. | | | | | | |
| 166 | ДЗДҮАХ-4.3.10 | Улсын бүртгэгч нарын төрийн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай тоног, төхөөрөмж, хэрэгслээр хангаж ажиллана. | 5, 8, 10, 11, 12 дугаар хороодыг иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангасан. | Үлдсэн хороодыг иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангасан байна. | 45,000.00 | Дүүргийн төсөв | БүХ | 100% |
| | | Дүүргийн ЗДТГ-ын хөрөнгөөр дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст 2022 онд 15 пос машин шийдвэрлүүлэн үйлчилгээний хураамжийг иргэн, хуулийн этгээдэд чирэгдэлгүй түргэн шуурхай үзүүлж байна. | | | | | | |
| 167 | ДЗДҮАХ-4.3.11 | Албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, ёс зүйн сургалтыг үе шаттай зохион байгуулах, иргэдэд холбогдох хууль тогтоомжийг сурталчлан ажиллана. | 43 албан хаагчийг сургалтад хамруулсан. | Албан хаагч болон иргэдийн хууль тогтоомжийн мэдлэг дээшилсэн байна. | 8,000.00 | Дүүргийн төсөв | БүХ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | -Хэлтсийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Оргил ННҮТ-ын хамт олон дүүргийн Хурлын танхимд "Харилцаа хандлага, стресс бууруулах нь" сэдэвт сургалт зохион байгуулж,уг сургалтад Канадын зан чанарын холбооны сургагч багш У.Хосбаяр хичээл заасан.<br>-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг "Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн практик хэрэглээ" сэдэвт сургалт зохион байгуулж хуульч Г.Цэцгээ хичээл заасан.<br>-"Эрүүл амьдралын зөв дадал зуршил" сэдвээр Н.Бэхбат багш Илүүдэл жингүй эртэч монгол аяны хүрээнд хэлтсийн хамт олонд сургалт зохион байгуулсан.<br>-Албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах, хөрвөх чадвартай улсын бүртгэгч бэлтгэх, албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хүлээн авах, олгох цонхонд хуваарь гарган ажлын байран дээр дадлагажуулан ажиллаж байна. Мөн хороодын улсын бүртгэгч нарыг зөвхөн хариуцсан бүртгэлээс гадна эд хөрөнгө эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, иргэний бүх төрлийн бүртгэлийг хийх зохих түвшний мэдлэгтэй, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх чадвартай болгохоор УБЕГ, НУБГ сургалтанд бүрэн хамруулж Хүний нөөцийн системд бие даан судлаж улсын бүртгэгч нар биенийгээ орлон ажиллах, төрийн албыг тасралтгүй явуулах, иргэдэд хөнгөн шуурхай үйлчлэхэд хүндрэл үүсэхгүйгээр ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Шинээр томилогдсон хорооны улсын бүртгэгч нарыг хэлтэс дээр хуваарь гарган ажиллуулж, бүртгэлтэй холбоотой хууль тогтоомж дүрэм журмыг судлуулж, бүртгэл хөтлөхөд анхаарах асуудлыг нэг бүрчлэн тайлбарлан зөвлөгөө өгч ажиллаж байна.<br>-Иргэний улсын бүртгэгч Ц.Өлзийжаргал, Н.Дэлгэр, Г.Алтантуяа, Б.Мөнхтамир, Н.Долгорсүрэн, Д.Дашням, Б.Хандмаа, Г.Батгэрэл нар эрхзүйн боловсрол эзэмшихээр сургуульд элсэн орж суралцаж байна.<br>-Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, улсын бүртгэл хөтлөхөд шаардлагатай мэдлэг олгох, ажлын ур чадвар, дадлага эзэмшүүлэхэд зорилтын хүрээнд: Улсын бүртгэлийн байгууллагаас Дотоод хэргийн их сургуультай хамтран зохион байгуулж буй "Эрх зүйн багц" сургалтад улсын бүртгэгч 16 улсын бүртгэгч хамрагдан суралцаж сертификат гардан авсан.<br>-УБЕГ, НУБГ, Төрийн албаны зөвлөл, АТГ болон бусад газраас зохион байгуулсан 28 сургалтад албан хаагчдийг хамруулаад байна. | | | | | |
| 168 | ДЗДҮАХ-4.3.12 | Сургуулийн өмнөх боловсрол, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын чанарт хяналт хийнэ. | Хууль тогтоомжийн хэрэгжилт 76% хэрэгжсэн. | Хяналт шалгалтад хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийн түвшин, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг нэмэгдүүлсэн байна. | 200.00 | Дүүргийн төсөв | МХХ | 100% |
| | | Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын 01/91 дугаартай удирдамжийн дагуу Сүхбаатарт үйл ажиллагаа явуулж буй ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад 2022-2023 оны хичээлийн жилийн бэлтгэл үйл ажиллагааг шалгахаар 17 цэцэрлэг, 18 ерөнхий боловсролын сургууль, нийт 35 сургалтын байгууллагад урьдчилан сэргийлэх шалгалт хийлээ. Шалгалтын явцад 30 зөрчил илрүүлж, 28 зөрчлийг шалгалтын хугацаанд арилгуулж, 2 сургуульд улсын байцаагчийн хугацаатай 2 албан шаардлага хүргүүлж ажиллалаа. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын "Хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулж ажиллах тухай" албан бичгийг 101 боловсролын байгууллагад хүргүүлэн ажиллалаа. | | | | | | |
| 4.4 Дүүргийн гадаад харилцааг өргөжүүлнэ. | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 169 | ДЗДҮАХ-4.4.1 | Хамтын ажиллагаат 3 улсын 5 хот, дүүргүүдтэй хамтын ажиллагааг салбар бүрт өргөжүүлж, 1 ба түүнээс дээш улсын хот, дүүргүүдтэй шинээр харилцаа тогтооно. | БНСУ-ын 2 дүүрэг, БНХАУ-ын 1 хот, 1 дүүрэг, Япон улсын 1 хот | Хамтын ажиллагаа бэхжсэн байна. | 165,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ ГХЯ, НЗДТГ | 80% |
| | | Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар нь БНСУ-ын 2 дүүрэг, БНХАУ-ын 1 хот, 1 дүүрэг, Япон улсын 1 хоттой хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллаж байна. | | | | | | |
| 170 | ДЗДҮАХ-4.4.2 | Уламжлалт харилцаат хот, дүүргүүдээс жил бүр зохион байгуулагддаг сургалт, хурал, үзэсгэлэн яармагт оролцуулна. | Жил бүр албан хаагчдыг сургалт, хурал, үзэсгэлэнд хамруулсан. | Албан хаагчдын ажлын идэвх сайжирсан байна. | 150,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ Бүх хэлтэс, нэгж | 90% |
| | | Засаг даргын Тамгын газрын болон хороодын 23 албан хаагчийг дүүрэгтэй хамтын ажиллагаатай гадаад улсын хот, дүүрэг болон бусад байгууллагуудын туршлага судлах арга хэмжээнд оролцуулж, албан томилолтоор ажиллуулсан. | | | | | | |
| 171 | ДЗДҮАХ-4.4.3 | Уламжлалт харилцаат 2 улсын 3 дүүрэг болон шинээр хамтын ажиллагаа тогтоосон улсын хот, дүүргүүдэд эмч, сувилагч, багш, сурагч солилцооны хөтөлбөрийг нэмэгдүүлнэ. | Харилцаат 2 улсын 3 дүүрэгтэй сурагч солилцооны хөтөлбөр хэрэгжсэн. | Хөтөлбөрт хамрагдах эмч, сувилагч, багш, сурагчдын тоо нэмэгдсэн байна. | 100,000.00 | Дүүргийн төсөв | ТЗУХ Дүүргийн харьяа ЭМТ, ЕБС | 90% |
| | | Япон Улсын Нагано мужийн Саку хоттой хамтран хэрэгжүүлдэг Хүүхэд солилцооны хөтөлбөрийг 2022 оны 11 дүгээр сарын 09-14-ний өдрүүдэд хэрэгжүүлсэн. Тус хөтөлбөрт дүүргийн нутаг дэвсгэрт харъяалагдах Ерөнхий боловсролын сургуулийн 8 сурагч хамрагдсан. | | | | | | |
| 172 | ДЗДҮАХ-4.4.4 | Үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллана. | 2021 онд АХБ-ны хөрөнгө оруулалтаар Сүхбаатар дүүргийн 68 дугаар цэцэрлэгт 120 хүүхдийн хүчин чадал бүхий өргөтгөлийн барилга ашиглалтад орсон. | Санхүүжилт шаардлагатай салбар нэгжид төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. | - | | ТЗУХ ОУ-ын байгууллагууд | 80% |
| | | Азийн хөгжлийн банкны 3,6 тэрбум төгрөгний санхүүжилтээр 240 хүүхдийн ортой 10 бүлэгтэй 17 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажлын гүйцэтгэгчээр Тамга уул ХХК ажиллаж, барилгын ажлыг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлэн гүйцэтгэж байна. | | | | | | |
| | | 4.5 Иргэдийн аюулгүй байдлыг хангаж, хэв журмыг сахиулна. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 173 | ДЗДҮАХ-4.5.1 | Иргэд, ААН байгууллага, оюутан, сурагчдад гамшиг аюул ослоос урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулна. | 53 байгууллагын 1895 ажилтан албан хаагчдыг хамруулан 53 удаа 72.30 цаг зохион байгуулсан. 32 шторк гарсан. | Аж ахуйн нэгж байгууллага- 120, иргэдэд-25 Оюутан, сурагч-40 сургалт зохион байгуулсан байна. | 24,000.00 | Дүүргийн төсөв | ОБХ МУЗХ, ААНБ | 100% |
| | | Гамшиг, ослоос хамгаалах чиглэлээр удирдах албан тушаалтнуудад зориулсан сургалтыг 3 удаа зохион байгуулж, нийт 66, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтны сургалтыг 68 удаа зохион байгуулж, нийт 2,145 ажилтан, албан хаагч хамрагдсан бөгөөд үүнээс эрэгтэй 1029, эмэгтэй 1116 ажилтан, албан хаагч байна. | | | | | | |
| 174 | | Гамшгаас хамгаалах сайн дурын бүлэг байгуулж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана. | Гамшгаас хамгаалах сайн дурын бүлгийн гишүүн 10 хүнд 5 цагийн сургалтыг зохион байгуулсан. | Дүүргийн 1-20 дугаар хороонд 5 хүний бүрэлдэхүүнтэй сайн дурын бүлэг ажилласан байна. | 124,800.00 | Дүүргийн төсөв | ОБХ МУЗХ, Хороод | 50% |
| | | Сүхбаатар дүүргийн Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн бэлтгэл ажлын хүрээнд бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийн дарга Н.Энхболд, Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа Д.Бэхбаяр нар Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дах хэсэг, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны "Журам батлах тухай" А/315 дугаар тушаалын дагуу дүүргийн алба, мэргэжлийн ангиудад урьдчилсан үзлэгийг 2022 оны 05 дугаар сарын 02-04 ний өдрүүдэд хуваарийн дагуу хийж, заавар зөвлөмж өгч ажилласан.<br>Бэлэн байдлын үзлэгийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны А/315 дугаар тушаалын хавсралтаар баталсан 17 заалт бүхий дүгнэх хүснэгтээр үнэлгээг дүгнэж ажилласан. | | | | | | |
| 175 | | Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд "Хэн хэзээ ч хаана ч бэлэн бай" сургалт дадлагыг зохион байгуулах, сургагч багш бэлтгэнэ. | - | Сургалт зохион байгуулах 24 удаа 2000 хамрагдсан байна. | 12,000.00 | Дүүргийн төсөв | ОБХ СБД-ийн ЗДТГ | 60% |
| | | Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг "Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын удирдах ажилтанд "Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх", "Гамшиг, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ", "Байгууллагын галын аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ" Гамшгаас хамгаалах тогтолцоо, гамшигтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, дүүргийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангиудын харилцан уялдаа, хамтын ажиллагааны талаар нэгдсэн мэдлэг, ойлголтыг олгох, гамшгийн үеийн удирдлага зохион байгуулалт, бэлэн байдлыг хангах зорилгоор дүүргийн Онцгой комиссын удирдах бүрэлдэхүүний сургалтыг Шангрила Улаанбаатар зочид буудлын хурлын танхимд зохион байгуулсан. | | | | | | |
| 176 | ДЗДЗАХ-4.5.2 | "Олон нийтийн цагдаа", "Оюутан цагдаа" арга хэмжээг эрчимжүүлж, | - | 90% | 5,000.00 | Дүүргийн төсөв | ЦГ ГХУСАЗСЗ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | шилдэг олон нийтийн цагдаа, оюутан цагдааг шалгаруулан урамшуулна. | | | | | |
| | | Сүхбаатар дүүргийн 1-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт 23 олон нийтийн цагдаа үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд ковид-19 цар тахалын үеийн вакцинжуулалт, шинжилгээний хэв журмаын хамгаалалтад үр дүнтэй ажилласан 1 олон нийтийн цагдааг 150.000 төгрөгний үнэ бүхий витамины цуглуулгаар шагнасан.<br>Мөн хариуцсан нутаг дэвсгэрт 2022 оны 02 дугаар сараас эхлэн 100 олон нийтийн байцаагч цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа бөгөөд эхний хагас жилд идэвхи санаачлагатай ажилласан 3 олон нийтийн байцаагчийг Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газрын даргын талархал болон дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан.<br>Дулааны улиралд "Оюутан эргүүл" ажиллуулах 24 цэг хүн хүчний тооцоо судалгаа саналыг холбогдох газарт хүргүүлсэн. | | | | | |
| 177 | ДЗДҮАХ-4.5.4 . | Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана. | - | 90% | 80,000.00 | Дүүргийн төсөв | ЦГ ГХУСАЗСЗ | 100% |
| | | Хариуцсан нутаг дэвсгэрт 2022 онд гудамж талбайд байршилтай 367 байршлын 660 чиглэлийн теле-камер, 47 хөдөлгөөнт камер нийт 681 теле-камер байгаагаас бүрэн ажиллагаатай 193, ажиллахгүй байгаа 488 телекамер байсан. Сүхбаатар дүүргийн камер хариуцсан инженер, ашиглалтын үеийн хэвийн үйл ажиллагааг хариуцсан "Тэнгэр цэгцрээ" ХХК-д 67 удаагийн дуудлага мэдээллийг тухай бүр өгч ажилласнаар гэмтэлтэй байсан 92 камерыг бүрэн ажиллагаанд оруулан цахим эргүүл, хяналт шалгалтаар ашиглаж байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд үр дүнгээ өглөө.<br>Ашиглалтын үеийн засвар үйлчилгээг хариуцсан байгууллагатай хамтран камерын чиг, үзэгдэх орчинд нэг бүрчлэн үзлэг хийж ашиггүй тусгалтай 3 телекамерын чиглэлийг өөрчлүүлэн, 96 теле-камерын тоос, тортог, линзийг арчиж цэвэрлэн теле-камерын үйл ажиллагааны хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажилласан.<br>Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл шуурхай удирдлагын төвөөс Сүхбаатар дүүрэгт улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2012-2021 онд 28 удаагийн төсөл хөтөлбөрийн хүрээнд нэр бүхий 18 гүйцэтгэгч байгууллагын байршуулсан 865 теле-камерыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд энэ оны 04 дүгээр сарын 22-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу нутгийн захиргааны байгууллага нь иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж талбайд байршуулан ашиглаж байгаа дүрс бичлэгийн техник, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хадгалалтын аюулгүй байдал, хэвийн ажиллах нөхцөл, боломжийг байнгын бүрдүүлж, арчлах хамгаалах, шаардагдах, зардлыг хариуцах үүрэгтэй болсон тул цагдаагийн газрын өмчид бүртгэлтэй гудамж талбайн дүрс бичлэгийн техник, хэрэгслийг нутгийн захиргааны байгууллагыг өчид шилжүүлэх ажлыг зохион байгуулж цаашид хэвийн үйл ажиллагааг хангах, тогтмол хамтран ажиллах ажлын чиглэлийн дагуу доорх ажлыг зохион байгууллаа.<br>Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл шуурхай удирдлагын төвөөс ирүүлсэн тоогоор Сүхбаатар дүүрэгт улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2012-2021 онд 865 теле-камер байршуулсан, 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Сүхбаатар дүүргийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсээс ашиглалтын үеийн засвар үйлчилгээ хариуцсан байгууллагатай хийсэн үзлэг тооллогоор 654, цагдаагийн газраас 2022 оны 08 сарын 15-ны өдрөөс 9 дүгээр сарын 15-ны өдрүүдэд гудамж талбайн дүрс бичлэгийн техник хэрэгслийг тоолсон тооллогоор 857 теле-камер тоологдсон ба тоон мэдээлэл харилцан адилгүй байна. | | | | | |

| | | |
|---|---|---|
| | | Цагдаагийн газраас гудамж талбайн дүрс бичлэгийн техник хэрэгслийг дүүргийн өмчид шилжүүлэхээр нэгдсэн тооллогын ажлыг 1 сарын хугацаанд 1-18 дугаар хороо, байршил, цэг бүрээр зургаар баримтжуулж бэлэн болголоо.<br>Тус тооллогоор хэвийн ажиллагаатай 356, ажиллагаагүй 501, дүрс бичлэгийн техник хэрэгсэл байршуулсан боловч шон дээр байхгүй 15 тоологдсон, гурван байгууллагын теле-камерын тоо зөрүүтэй нөхцөл байдлууд тогтоогдож байх тул дүүргийн засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан, ажлын хэсгийн хурлаар дээрх асуудлыг тодорхой болгон цагдаагийн газрын өмчид бүртгэлтэй гудамж талбайн дүрс бичлэгийн техник хэрэгслийг дүүргийн өмчид хүлээн авах ажлыг зохион байгуулж хамтран ажиллах талаар мэдээллийг хүргүүлсэн.<br>Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын системд иргэд байгууллагаас теле-камерын стандарт шаардлага хангасан талаар дүгнэлт гаргуулахаар 2022 онд 386 хүсэлт ирүүлсний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулсан стандарт шаардлага хангаагүй 68 иргэд, байгууллагын хүсэлтийг татгалзан шийдвэрлэж 318 байгууллагын гадна талд 769, дотор талд 1936 нийт 2705 теле-камерыг цогц системээр шаардлага хангасан байдлаар байршуулсан тул үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлд дүгнэлт, саналыг холбогдох газарт цахимаар хүргүүлж ажилласан.<br>Хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 260 байгууллагын 2140 теле хяналтын камерт нэгдсэн үзлэг шалгалтыг зохион байгуулж дотор орчинд байрлах 1586 телекамераас 133 ажиллагаагүй, гадна талд, гудамж талбай, байгууллагын орчныг хяналтад авсан 554 телекамераас 37 камер эвдрэл, гэмтэлтэй, ажиллагаагүй байсныг байгууллагын удирдлагуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу байгууллагын орчны аюулгүй байдлыг хангах, телекамерын бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хангах талаар хугацаатай үүрэг өгч, хэвийн үйл ажиллагаанд оруулж ажилласан.<br>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрт олон нийтийн байцаагч ажиллуулах саналыг дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргүүлж, Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 15-ны "Олон нийтийн байцаагч томилон ажиллуулах тухай" Б/07 дугаартай захирамж гаргуулан 100 олон нийтийн байцаагчийг томилуулан сарын 47.000.000 төгрөг, жилийн 564.00.000 төгрөгний урамшууллын асуудлыг дүүргийн засаг даргын тамгын газраас шийдвэрлүүлсэн.<br>Олон нийтийн байцаагчаар ажиллаж байгаа 100 иргэнийг 39 сургуулийн хичээл эхлэх, тарах цагуудад сургуулийн орчинд эргүүл хяналтаар ажиллуулж эцэг эхээсээ төөрсөн 38 хүүхдийг эцэг эх асран хамгаалагчид хүлээлгэн өгч давхардсан тоогоор бага насны 11726 хүүхдийг замын хөдөлгөөнд оролцох, явганаар зорчих үеийн аюулгүй байдлыг хангаж дэмжлэг үзүүлсэн.<br>Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/116 дугаар тушаалаар батлагдсан "Хүүхэд хамгаалагч" төслийн гэрээг тус дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Сүхбаатар дүүргийн цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, хүүхэд хамгаалагч ахмад ажилтан нарын дунд дөрвөлсөн гэрээг байгуулан тус дүүргийн 1-20 дугаар хороонд 20 хүүхэд хамгаалагч ахмад ажилтан хичээл эхлэх болон тарах цагуудад хүүхдийг гэрээс сургууль, сургуулиас гэр хүртэлх замыг бүрэн хяналтад авч, эргүүлийн үүрэг гүйцэтгэн, аюулгүй зорчиход дэмжлэг үзүүлэх ажиллаж байна.<br>Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн нараас "Сургуулийн эргүүл" /School police/-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж, сургуулиас гарсан хуваарийн дагуу асран хамгаалагч нарын эргүүлийн үйл ажиллагаанд авто болон явган эргүүл, хүүхэд хамгаалагч нараас хэмжлэг үзүүлэхээс гадна Олон нийтийн байцаагчаар ажиллаж байгаа 100 иргэнийг 19 сургуулийн хичээл эхлэх, тарах цагуудад сургуулийн орчинд эргүүл хяналтаар ажиллуулж эцэг эхээсээ төөрсөн 34 хүүхдийг эцэг эх асран хамгаалагчид хүлээлгэн өгч давхардсан тоогоор бага насны 12670 хүүхдийг замын хөдөлгөөнд оролцох, явганаар зорчих үеийн аюулгүй байдлыг хангаи дэмжлэг үзүүлсэн нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоо туслалцаа авсны үр дүн юм.<br>Гэмт хэрэг, зөрчил, замын хөдөлгөөний осол гэмтлээс урьдчилсан сэргийлэх, мэдээлэл сурталчилгааны чиглэлээр 2022 онд бэлтгэн олон нийтэд 12 төрлийн шторк, контентийг бэлтгэж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж ажиллаа.<br>Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэж болзошгүй болон хорихоос хугацааны өмнө болон хугацаа дуусч суллагдсан, архины хамааралтай цагдаагийн байгууллагын бүртгэл хяналтад авагдсан этгээдүүдийн амьдралын хэв маягийг өөрчлөх, зөв хандлагыг төрүүлэх, орлогын эх үүсвэртэй болгож тогтвортой гэр бүлийг төлөвшүүлэх зорилгоор Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр халамж |

| | | |
|---|---|---|
| | | үйлчилгээний хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран **"Зөв санаа-зөв сонголт"** тусгай арга хэмжээг 2022 оны 02 дугаар сарын 09-ны өдөр зохион байгуулсан.<br>Арга хэмжээнд Сүхбаатар дүүргийн 1-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт оршин суудаг гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэж болзошгүй 36, хорихоос хугацааны өмнө болон хугацаа дуусч суллагдсан 11, архины хамааралтай 24 нийт 71 иргэнийг хамруулан ажлын байранд 26 иргэнийг зуучлахаар бүртгэж, хууль эрх зүй, сэтгэл зүйн зөвлөгөөг 36 иргэнд үзүүлсэн.<br>Сүхбаатар дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран гэр бүлийн таарамжгүй харилцаатай нөхөр, эхнэрийн зан төлөвийг өөрчлөх, гэр бүлийн үнэ цэнийг мэдрүүлэх, тогтвортой гэр бүлийг төлөвшүүлэх зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Гэрлэх ёслолын ордоны их танхимд 14 гэр бүлийн 28 иргэнийг хамруулан **"Гэр бүлийн үнэ цэнэ"** сургалтыг зохион байгуулсан.<br>Сургалтад дүүргийн Эрүүл мэндийн нэгдсэн төвөөс  эмч, нийгмийн ажилтан оролцож архины хор уршиг болон архины сайн дурын эмчилгээ үйлчилгээ явуулдаг байгууллагын талаар иргэдэд мэдээлэл хүргэсэн.<br>Мөн дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсээс хувь хүний харилцаа, хандлагын талаар яриа таниулга хийж 9 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн.<br>**"Илрүүлэлт"** нэг, хоёр, гурав дугаар улирлын арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрт зохион байгуулж ажиллаа.<br>"Хүүхэд хамгаалал" арга хэмжээний хүрээнд хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд байрлах ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмзэг цэгийн судалгааг гаргаж хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан.<br>Арга хэмжээний хүрээнд гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй, хөдөлмөр эрхэлж буй хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, эцэг эхийн хараа хяналт сул 77 хүүхдийг субъектийн судалгаа хяналтын сангийн нэгдсэн бүртгэлд авч, Дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан багт холбон зуучлах  хариу үйлчилгээ үзүүлсэн.<br>Бага насны хүүхдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн Засаг даргын тамгын газар, Боловсролын хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Улаан загалмайтай хамтран Сургуулийн өмнөх цэцэрлэгийн насны бэлтгэд бүлгийн хүүхдүүдийн дунд "Замын хөдөлгөөний цагаан толгой-2022" тэмцээнийг зохион байгуулахаар 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр тэмцээний удирдамжийг  батлуулан 2022 оны 05 дугаар сарын 08, 09-ний өдөр нийт 18 цэцэрлэгийн 144 хүүхэд, 36 эцэг, эх, 36 багш нар хурд хүч, авхаалж самбаа, мэдлэг чадвараа уралдуулсанаас 51-р цэцэрлэгийн баг тэргүүн байр эзэлж "Цом, Өргөмжлөл, Алтан медаль"-аар, 14-р цэцэрлэгийн баг дэд байр эзэлж "Өргөмжлөл, Мөнгөн медаль"-аар, 234-р цэцэрлэгийн баг 3-р байр эзэлж "Өргөмжлөл, хүрэл медаль"-аар шагнаж тэмцээнд оролцсон сургуулиудын хүүхэд, багш нийгмийн ажилтан, эцэг эхчүүдэд баяр хүргэж шагналыг гардуулан нийт 18 багийн 144 хүүхэд багачуудад гарын бэлэг гардуулж өгсөн.<br>Хүүхдийг аливаа төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газар, прокурорын байгууллагатай хамтран зохион байгуулсан **"Эергээр нөлөөлье"** соён гэгээрүүлэх, нөлөөллийн аяныг 2 сарын хугацаанд амжилттай зохион байгуулсан.<br>Энэхүү арга хэмжээний хаалтын үйл ажиллагаанд нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч, дүүргийн Засаг дарга Х.Болормаа болон бусад төлөөлөгчид, сургуулиудын захирал, нийгмийн ажилтан, "Эерэг нөлөөлөл" бүлгэмийн сурагчид оролцсон.<br>Соён гэгээрүүлэх, нөлөөллийн аяны хүрээнд хүүхдийг аливаа төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлаараа ерөнхий боловсролын 29, ӨЗБЛАС, 1-р сургууль, Монгол улсын Консерватори эхний байрт шалгарсан юм.<br>Улсын Их Хурлын Гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэгийн санаачилгаар Сүхбаатар дүүргийн ЕБС-иудын 6-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулсан "Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх "Баярлалаа Сүхбаатар" видео контент бүтээх уралдаан"-ыг дэмжин оролцож хамтран зохион байгуулсан.<br>Уралдаанд 12 сургуулийн сурагчдаас үед тэнгийн дээрэлхэлтийн шалтгаан нөхцөлийг арилгах санаа, сэдлийг үе тэнгийнхэндээ өгөх богино хэмжээний зохиомж контент ирүүлж бүтээл, үзэл санаагаа үе тэнгийнхэндээ үзүүлж сонирхуулсан нь хүүхэд өсвөр үе өөрсдөө, үлгэрлэж, өөрсдөөсөө суралцах, санаа авах үр дүнтэй ажил болсон. |

Сурагчдын дунд зохион байгуулсан уралдааныг хамтран үр дүнтэй зохион байгуулсанд Сүхбаатар дүүргээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг 2022 оны 06 дугаар сарын 04-ний өдөр тус цагдаагийн газарт талархал ирүүлсэн.

Дулааны улиралд "Оюутан эргүүл" ажиллуулах 24 цэг хүн хүчний тооцоо судалгаа саналыг холбогдох газарт хүргүүлсэн.

"Би гэр бүлдээ хайртай" спортын өдөрлөгт 1-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт оршин суудаг гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэж болзошгүй 20 өрхийн 60 иргэнийг хамруулж гэр бүлийн гишүүдийн дунд хөгжөөнт буухиа тэмцээн, 12-13 насны хүүхдүүдийн дунд сагсан бөмбөгийн шидэлт, ээжүүдийн дунд танин мэдэхүйн тэмцээн, аавуудын дунд сагсан бөмбөгийн 3х3 зэрэг 4 төрлийн спортын тэмцээнийг зохион байгуулж амжилттай оролцсон иргэдэд өргөмжлөл, медаль, бэлэг гардуулан өгсөн.

Спортын өдөрлөгт амжилттай оролцсон болон хүрэлцэн ирсэн 25 хүүхдэд гэр бүлийн өдрийг тохиолдуулан сурлага хөдөлмөрийн өндөр амжилт хүсч бэлэг тараан өгч гэр бүлийн хамт дурсгалын зураг авахуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/151 дүгээр тушаал, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан "Хүүхэд таныг хамгаалъя" арга хэмжээний хүрээнд Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын 47 сургуульд "Хувь хүний үнэт зүйл" сэдвээр дамжуулан албаа сурталчлах, үнэт зүйлд тулгуурлан ажил, мэргэжлээ сонгох, бусдыг хүндэтгэх, сургуулийн орчинд үе тэнгийн дээрлхэлтээс урьдчилан сэргийлэх талаар ойлголтыг өгөх сургалт яриа таниулгын үйл ажиллагаа 2022 оны 05 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа.

Дээрх арга хэмжээний хүрээнд Цагдаагийн ерөнхий газраас батлагдсан хуваарын дагуу удирдах албан тушаалтнаас 47 сургуульд сургал зохион байгуулах байснаас 40 сургуулийн 214 бүлгийн 6634 ахлах ангийн сурагч хамрагдсан.

Цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтнуудаас 7 сургуулийн өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн үйл ажиллагаатай танилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээллийг өгч, үе тэнгийнхэндээ үлгэр дууриал, хүмүүжил төлөвшилт, авьяас чадвар, урлаг спортоор бусдыгаа манлайлсан 64 сурагчид талархал, гарын бэлэг , 3 сургуульд дурсгалын зүйл гардуулсан.

Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан хариуцсан нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хор уршгийн талаар мэдээлэл өгөх зорилгоор Дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ"-г хариуцсан нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын 15 сургууль, 14 цэцэрлэгийн хүүхэд хамгааллын баг, 18 хорооны хамтарсан баг, иргэд, оршин суугчидтай хамтран 2022.09.01-15-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Арга хэмжээний хүрээнд удирдамж төлөвлөгөө гарган, хуваарийн дагуу сургууль, цэцэрлэг тус бүр дээр явуулын багаар ажиллаж хүүхэд хамгааллын үйл ажиллагааг дэмжих, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэхээс гадна "Асран хамгаалагч"-ийн зөвлөл, "Өсвөрийн сэргийлэгч бүлгэм", "Нийгмийн ажилтан", "Сэтгэл зүйч", "Эмч", "Хүүхэд хамгааллын баг" бусад сайн дурын бүлгэмийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг ажил арга хэмжээг оновчтой хамтран зохион байгуулах, хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, осол гэмтлээс хамгаалах үйл ажиллагааг бүх нийтийн оролцоотойгоор хэрэгжүүлэхийг зөвлөн туслах ажлыг хэрэгжүүлсэн.

Сэтгэл зүйн мэргэжлийн багаар зориулалтын өрөөнд 110 хүүхдийг хүлээн авч сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж үйлчилгээ үзүүлэхээс гадна 15 сургуулийн 1391 сурагчид "Гэмт хэрэг, зөрчлийн тухай ойлголт, үе тэнгийн дээрэлхэлтийг таслан зогсоох, сургуулийн орчинд хүүхдийг гадуурхахгүй байх" зэрэг сэдвээр яриа таниулга хийсэн.

Гудамж талбайд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрт гэрээт харуул хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 61 гэрээт харуул хамгаалалтын албаны судалгааг гаргаж, 18 гэрээт харуул хамгаалалтын албаны 36 алба хаагч, 4 автомашиныг эргүүлд татан оролцуулж нийт 609 аж ахуй нэгж байгууллагын гадна орчинд хяналт тавьж, сэжиг бүхий 154 иргэнийг шалгасан.

Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу цагдаагийн газраас 2021 онд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийнхээ хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил, үйл ажиллагааны тайланг баталсан хуваарийн дагуу 2022 оны 01 дүгээр сарын 10-11-ний өдрүүдэд зохион байгууллаа.

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Иргэд оршин суугчдад тайлан тавих үйл ажиллагааг хөтөлбөр төлөвлөгөөний дагуу 20 байршилд иргэдийн халдвар хамгааллын дэглэмийг сахиулан хороодын Засаг даргын ажлын албанаас 28 ажилтан, 115 алба хаагч, 18 олон нийтийн цагдаагийн ажилтны хүчээр зохион байгуулж 667 иргэн тайлангийн хуралд оролцож цагдаагийн байгууллагаас зохион байгуулсан ажил арга хэмжээний үр дүнтэй танилцаж санал, хүсэлт өгч, асуулт тавьж, хариулт авсан.<br>Тайлангийн хуралд оролцсон газар, хэлтэс, тасгийн дарга, чиглэлийн ахлах байцаагч нараас цагдаагийн газраас зохион байгуулсан үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл өгч 36 иргэний асуултад хариулт өгч, асуудлыг шуурхай шийдвэрлэж 32 иргэний саналыг холбогдох газарт уламжлан, саналын дагуу тодорхой ажлыг цагдаагийн газрын төлөвлөгөөнд тусган удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан. | | | | | | |
| 178 | ДЗДҮАХ-4.5.5 | Дүүргийн ногоон бүс бүхий хороодод урамшуулалт морин эргүүлүүд ажиллуулж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлнэ. | Хороод болон байгаль хамгаалагч нарын оролцоо сайжирсан. | Ногоон бүс бүхий 9 амуудад 9 урамшуулалт морин эргүүлүүд 6 сар ажилласан байна. | 13,440.00 | Дүүргийн төсөв | ОБХ | 70% |
| | | Хавар, намрын хуурайшилтын үед 2022 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийн хугацаанд 9 морин эргүүлийг цалинжуулан ажиллуулсан. Морин эргүүлүүд Сүхбаатар дүүргийн Бэлх, Сэлх, Хадат, Гоодой, Багабаян, Хандгайт, Янзага зэрэг уулын амуудад ногоон бүсэд 60 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, эргүүлийн үүргийг гүйцэтгэлээ. Хяналт шалгалтын явцад 79 зөрчлийг илрүүлэн, газар дээр нь арилгуулах арга хэмжээ авч, 368 ширхэг санамж, тараах материал хүргүүлэн ажилласан. | | | | | | |
| 179 | ДЗДҮАХ-4.5.6 | Зам тээврийн осол ихээр болон давтан бүртгэгддэг уулзвар, зам, байршлуудад хөдөлгөөн зохион байгуулалтыг өөрчлөн төлөвлөх замаар осол, хэргийн гаралтыг бууруулна. | 55% | 70% | 5,500.00 | Дүүргийн төсөв | ЦГ, ЗЦХ ТЦА, ЗХУТ, ЗХТЗИГ, Г ХУСАЗСЗ | 70% |
| | | Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газраас 2022 онд хэрэгжүүлэх нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний календарчилсан төлөвлөгөөний дагуу 01 дүгээр сард зохион байгуулагдсан “Хар цэг” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчигдөж тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг зөрчил бүртгэгддэг хар цэгийн судалгааг гаргаж ажилласан.<br>Судалгаагаар тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг ихээр үйлдэгддэг 11 хар цэгийг тодорхойлж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллах чиглэлээр эргүүл хяналтыг тогтмол тавьж ажиллах чиглэлээр анхаарч ажиллаж байна.<br>Дүүргийн нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй баригдсан граж бусад обьектыг буулгах ажлын хүрээнд 10 дугаар хороо 16 дугаар сургуулийн зүүн тал, 2 дугаар хороо зэрэг газруудад замын хөдөлгөөний үзэгдэх орчин хязгаарлагдан баригдсан гаражын буулгаснаар замын хөдөлгөөны осол гарч болзошгүй 4 цэгийн шатгаан нөхөл арилж аюулгүй байдал хангагдлаа.<br>Тус цагдаагийн газрын даргаас 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Сүхбаатар Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргад “Шаардлагатай техник хэрэгсэл шийдврлүүлэх тухай” 26и/406 дугаартай албан бичгээр замын хөдөлгөөний зохиомол түгжрэл үүсгэдэг, замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг, зөрчил үйлдэгддэг, замын тэмдэг, тэмдэглэл тавигдах шаардлагтай газруудын судалгааг гарган хүргүүлснээр Сүхбаатар дүүргийн засаг дарга 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/121 дугаартай захирамж гаргаж дээрх гудамж замуудад 10,580,000 төгрөгний үнэ бүхий тэмдэг, | | | | | | |

<table>
<tr><td></td><td></td><td colspan="7">тэмдэглэл шинээр байрлуулахаар шийдвэрлэсэн. Одоогийн байдлаар гүйцэтгэгч “Титэм дизайнь” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгэх шатанд явж байна.<br>Цагдаагийн газрын даргаас 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Сүхбаатар Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргад “Шаардлагатай техник хэрэгсэл шийдвэрлүүлэх тухай” 26и/406 дугаартай албан бичгээр замын хөдөлгөөний зохиомол түгжрэл үүсгэдэг шалтгаан нөхцөлийг арилгах, замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг, зөрчил үйлдэгддэг, замын тэмдэг, тэмдэглэл тавигдах шаардлагатай газруудын судалгааг гарган хүргүүлэн ажилласнаар дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөр техник, замын хяналтын чиглэлээр дараах ажил арга хэмжээг шийдвэрлүүлж ажилласан.<br>1. Сүхбаатар дүүргийн засаг дарга 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/121 дугаартай захирамж гаргаж МУ-ын ХУИС-ийн урд зам, дүүргийн 8 дугаар хороон Оюутны гудамж Бага тойруугийн гудамжийг холбосон автозам, мөн дүүргийн 7 дугаар хороон Эрхүүгийн гудамжнаас Сүхбаатар дүүргийн засаг даргын тамгын газрын байр хүртэлх орон сууцны хороолол доторх автозам, мөн дүүргийн 10 дугаар хороо ерөнхий боловсролын 16 дугаар сургуулиас Жоби худалдааны төв хүртэлх орон сууцны хороолол дотор автозам, мөн дүүргийн 6 дугаар хороо Их сургуулийн гудамжийг Сүхбаатарын гудамжтай холбосон автозам, мөн хорооны Залуучуудын гудамжийг Их сургуулийн гудамжтай холбосон автозамуудад 10,580,000 төгрөгний үнэ бүхий тэмдэг, тэмдэглэл шинээр байрлуулж ажилласан.<br>2. Сүхбаатар дүүргийн засаг дарга 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн “Түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд дүүргийн зарим зам, уулзварт тэмдэг тэмдэглэгээ байршуулж, хөдөлгөөн зохицуулалт хийх заримт арга хэмжээний тухай” А/365 дугаартай захирамжийн дагуу дүүргийн 1 дүгээр хороо Чингэлтэй өргөн чөлөө Бамбарууш кафены баруун замд 30 ширхэг, 90 метрийн урттай хөдөлгөөн тусгаарлах хайс байрлуулсан мөн дүүргийн 3 дугаар хороо Сөүлийн гудамж Хангай зочид буудлын зүүн замд замын хөдөлгөөний зохион байгуулалт өөрчлөх шаардлагатай 17 ширхэг тэмдэг байрлуулж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажилласан.<br>Дээрх ажил арга хэмжээг зохион байгуулж ажилласнаар хариуцсан дүүргийн нутаг дэвсгэрт хүн нас барсан хэрэг 3 бүртгэгдсэнийг өмнө оны мөн үед бүртгэгдсэн 12 тохиолдолтой харьцуулахад 75 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.</td></tr>
<tr><td>180</td><td></td><td>Хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, гэр бүлийн хүчирхийлэл, зам тээврийн осол, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулна.</td><td>40%</td><td>70%</td><td>28,000.00</td><td>Дүүргийн төсөв</td><td>ЦГ, ЗЦХ</td><td>100%</td></tr>
<tr><td></td><td></td><td colspan="7">Гэр бүлийн хүчирхийлэл, Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны салбар төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулсан 10 ажлын биелэлтийг 97 хувьтай гүйцэтгэж Нийслэлийн цагдаагийн удирдах газарт хүргүүлсэн.<br>Тухайлбал Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Хүүхдийн эрхийн тухай хууль”, үүнтэй холбоотой журам, заавар, зөвлөмжийг бие даан судлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар хүүхдийн асуудал хариуцсан 6 мэргэжилтэнд бичгээр зааварчилга өгч, ажлын байранд чиглүүлэн дадлагажуулж мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.</td></tr>
</table>

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийн эрхийг хангахад чиглэгдсэн "Ээрэгээр нөлөөлье", "Сонсъё-хамгаалъя", зэрэг 6 арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.

"Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн үндэсний чуулган" 2022 оны 05 дугаар сард төрийн ордонд зохион байгуулагдах үед тус цагдаагийн газраас 2 алба хаагч оролцуулсан.

Чуулган уулзалтаас гарсан зөвлөмжийг хүүхэд хамгааллын чиглэлээр бусад чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж ажилласан.

Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газраас "Хүүхэд бүрийн төлөө" арга хэмжээний хүрээнд Сүхбаатар дүүргийн прокурорын байгууллагатай хамтран хяналтын прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтнуудад баг насны хүүхэд хохирсон гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэхэд анхаарах асуудал, шалтгаан нөхцөлийг тогтоох, хамтарсан багтай хамтран баг насны хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж ажиллаа.

Сүхбаатар дүүргийн хяналтын прокурорын байгууллагаас "Зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, хүүхэд хохирсон зөрчлийн шийдвэрлэлтийг сайжруулахад анхаарах асуудал", "Мөрдөн шалгах ажиллагаанд хүүхдийн эрхийг хангах хамгаалах, хүүхэд хохирсон гэмт хэргийн шийдвэрлэлтийг сайжруулахад анхаарах асуудал", "Гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагаа", "Хамтарсан багийн үйл ажиллагаанд хүүхдийн эрхийг хамгаалахад анхаарах асуудал" сэдвээр эрх бүхий албан тушаалтнуудыг оролцуулан сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Сургалт, хэлэлцүүлэгт цагдаагийн байгууллагаас 96 мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, Прокурорын байгууллагаас 15 хяналтын прокурор оролцсон.

Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, хохирогч төвтэй, холбон зуучлах, эрх зүйн туслалцаа үйлчилгээ үзүүлэх, хохирогчийн сэтгэл зүйн онцлог сэдвүүдээр Цагдаагийн ерөнхий газар, төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан багц сургалтад 24 алба хаагчдыг суралцуулж чадавхжуулсан.

Бага насны хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн 4, ахлах мэргэжилтэн 2, мөрдөгч 2, тасгийн дарга 2 нийт 10 алба хаагчийг цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулсан мэргэшүүлэх сургалтад хамруулсан.

Шаардлагатай тохиолдолд бага насны хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах талаар цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн мөрдөн байцаах тасагт 2 эмэгтэй мөрдөгчийг томилуулан хүүхэд төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажилласан.

Хүүхдийг аливаа төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газар, прокурорын байгууллагатай хамтран зохион байгуулсан "Эергээр нөлөөлье" соён гэгээрүүлэх, нөлөөллийн аяныг 2 сарын хугацаанд амжилттай зохион байгуулсан.

Энэхүү арга хэмжээний хаалтын үйл ажиллагаанд нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч, дүүргийн Засаг дарга Х.Болормаа болон бусад төлөөлөгчид, сургуулиудын захирал, нийгмийн ажилтан, "Эерэг нөлөөлөл" бүлгэмийн сурагчид оролцсон.

Соён гэгээрүүлэх, нөлөөллийн аяны хүрээнд хүүхдийг аливаа төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлаараа ерөнхий боловсролын 29, ӨЗБЛАС, 1-р сургууль, Монгол улсын Консерватори эхний байрт шалгарсан юм.

Улсын Их Хурлын Гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэгийн санаачилгаар Сүхбаатар дүүргийн ЕБС-иудын 6-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулсан "Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх "Баярлалаа Сүхбаатар" видео контент бүтээх уралдаан"-ыг дэмжин оролцож хамтран зохион байгуулсан.

Уралдаанд 12 сургуулийн сурагчдаас үед тэнгийн дээрэлхэлтийн шалтгаан нөхцөлийг арилгах санаа, сэдлийг үе тэнгийнхэндээ өгөх богино хэмжээний зохиомж контент ирүүлж бүтээл, үзэл санаагаа үе тэнгийнхэндээ үзүүлж сонирхуулсан нь хүүхэд өсвөр үе өөрсдөө, үлгэрлэж, өөрсдөөсөө суралцах, санаа авах үр дүнтэй ажил болсон.

Сурагчдын дунд зохион байгуулсан уралдааныг хамтран үр дүнтэй зохион байгуулсанд Сүхбаатар дүүргээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг 2022 оны 06 дугаар сарын 04-ний өдөр тус цагдаагийн газарт талархал илгээсэн.

Тус цагдаагийн газраас тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 6 төрлийн 18 шторк контентийг мэргэжлийн байгууллага, олны танил иргэдтэй хамтран бүтээж хэвлэл мэдээллийн байгууллага, цахим хуудсаар олон нийтэд хүргэсэн.

Бага насны хүүхдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн Засаг даргын тамгын газар, Боловсролын хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Улаан загалмайтай хамтран Сургуулийн өмнөх цэцэрлэгийн насны бэлтгэд бүлгийн хүүхдүүдийн дунд "Замын хөдөлгөөний цагаан толгой-2022" тэмцээнийг зохион байгуулахаар 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр тэмцээний удирдамжийг батлуулан 2022 оны 05 дугаар сарын 08, 09-ний өдөр нийт 18 цэцэрлэгийн 144 хүүхэд, 36 эцэг, эх, 36 багш нар хурд хүч, авхаалж самбаа, мэдлэг чадвараа уралдуулсанаас 51-р цэцэрлэгийн баг тэргүүн байр эзэлж "Цом, Өргөмжлөл, Алтан медаль"-аар, 14-р цэцэрлэгийн баг дэд байр эзэлж "Өргөмжлөл, Мөнгөн медаль"-аар, 234-р цэцэрлэгийн баг 3-р байр эзэлж "Өргөмжлөл, хүрэл медаль"-аар шагнаж тэмцээнд оролцсон сургуулиудын хүүхэд, багш нийгмийн ажилтан, эцэг эхчүүдэд баяр хүргэж шагналыг гардуулан нийт 18 багийн 144 хүүхэд багачуудад гарын бэлэг гардуулж өгсөн.

**"Илрүүлэлт"** нэг, хоёр, гурав дугаар улирлын арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрт зохион байгуулж ажиллаа.

"Хүүхэд хамгаалал" арга хэмжээний хүрээнд хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд байрлах ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмзэг цэгийн судалгааг гаргаж хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан.

Арга хэмжээний хүрээнд гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй, хөдөлмөр эрхлэж буй хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, эцэг эхийн хараа хяналт сул 77 хүүхдийг субъектийн судалгаа хяналтын сангийн нэгдсэн бүртгэлд авч, Дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан багт холбон зуучлах хариу үйлчилгээ үзүүлсэн.

Дэлхийн гэр бүлийн өдрийг угтаж дүүргийн 1-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт оршин суудаг хүүхдийн эрх зөрчдөг, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй иргэдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, гэр бүлийн дулаан уур амьсгалыг бүрдүүлж хүүхдийн эрхийг хангах зорилгоор "Би гэр бүлдээ хайртай" спортын өдөрлөгийг 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан.

"Би гэр бүлдээ хайртай" спортын өдөрлөгт 1-20 дугаар хорооны нутаг дэвсгэрт оршин суудаг гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэж болзошгүй 20 өрхийн 60 иргэнийг хамруулж гэр бүлийн гишүүдийн дунд хөгжөөнт буухиа тэмцээн, 12-13 насны хүүхдүүдийн дунд сагсан бөмбөгийн шидэлт, ээжүүдийн дунд танин мэдэхүйн тэмцээн, аавуудын дунд сагсан бөмбөгийн 3x3 зэрэг 4 төрлийн спортын тэмцээнийг зохион байгуулж амжилттай оролцсон иргэдэд өргөмжлөл, медаль, бэлэг гардуулан өгсөн.

Спортын өдөрлөгт амжилттай оролцсон болон хүрэлцэн ирсэн 25 хүүхдэд гэр бүлийн өдрийг тохиолдуулан сурлага хөдөлмөрийн өндөр амжилт хүсч бэлэг тараан өгч гэр бүлийн хамт дурсгалын зураг авахуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/151 дүгээр тушаал, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан "Хүүхэд таныг хамгаалъя" арга хэмжээний хүрээнд Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ерөнхий боловсролын 47 сургуульд "Хувь хүний үнэт зүйл" сэдвээр дамжуулан албаа сурталчлах, үнэт зүйлд тулгуурлан ажил, мэргэжлээ сонгох, бусдыг хүндэтгэх, сургуулийн орчинд үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх талаар ойлголтыг өгөх сургалт яриа таниулгын үйл ажиллагаа 2022 оны 05 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа.

Дээрх арга хэмжээний хүрээнд Цагдаагийн ерөнхий газраас батлагдсан хуваарын дагуу удирдах албан тушаалтнаас 47 сургуульд сургал зохион байгуулах байснаас 40 сургуулийн 214 бүлгийн 6634 ахлах ангийн сурагч хамрагдсан.

Цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтнуудаас 7 сургуулийн өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн үйл ажиллагаатай танилцаж мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээллийг өгч, үе тэнгийнхэндээ үлгэр дууриал, хүмүүжил төлөвшилт, авьяас чадвар, урлаг спортоор бусдыгаа манлайлсан 64 сурагчид талархал, гарын бэлэг , 3 сургуульд дурсгалын зүйл гардуулсан.

Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан хариуцсан нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хор уршгийн талаар мэдээлэл өгөх зорилгоор Дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ"-г хариуцсан нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын 15

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сургууль, 14 цэцэрлэгийн хүүхэд хамгааллын баг, 18 хорооны хамтарсан баг, иргэд, оршин суугчидтай хамтран 2022.09.01-15-ны өдрүүдэд зохион байгууллаа.<br>Арга хэмжээний хүрээнд удирдамж төлөвлөгөө гарган, хуваарийн дагуу сургууль, цэцэрлэг тус бүр дээр явуулын багаар ажиллаж хүүхэд хамгааллын үйл ажиллагааг дэмжих, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэхээс гадна "Асран хамгаалагч"-ийн зөвлөл, "Өсвөрийн сэргийлэгч бүлгэм", "Нийгмийн ажилтан", "Сэтгэл зүйч", "Эмч", "Хүүхэд хамгааллын баг" бусад сайн дурын бүлгэмийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг ажил арга хэмжээг оновчтой хамтран зохион байгуулах, хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, осол гэмтлээс хамгаалах үйл ажиллагааг бүх нийтийн оролцоотойгоор хэрэгжүүлэхийг зөвлөн туслах ажлыг хэрэгжүүлсэн.<br>Сэтгэл зүйн мэргэжлийн багаар зориулалтын өрөөнд 110 хүүхдийг хүлээн авч сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж үйлчилгээ үзүүлэхээс гадна 15 сургуулийн 1391 сурагчид "Гэмт хэрэг, зөрчлийн тухай ойлголт, үе тэнгийн дээрэлхэлтийг таслан зогсоох, сургуулийн орчинд хүүхдийг гадуурхахгүй байх" зэрэг сэдвээр яриа таниулга хийсэн.<br>Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор Тээврийн цагдаагийн албаны 2022 оны календарьчилсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан "Гарцаар гарцгаая", "Явган зорчигч", "Сургууль орчмын бүс", "Хамгаалах малгай", "Don"t Drink and Drive", "Шөнийн хяналт, шалгалт", "Хичээл эхэллээ", "Хамгаалах суудал", "Хүүхдийн суудал", "Шар дарцаг", "Аажуу явбал аяндаа хүрнэ дээ" зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг хариуцсан нутаг дэвсгэрт зохион байгуулж, хийж гүйцэтгэсэн ажлын мэдээг өдөр бүр Тээврийн цагдаагийн албаны ерөнхий жижүүр болон Сүхбаатар дүүргийн цагдаагийн газрын жижүүрт хүргүүлж, хоногийн мэдээнд тусгуулж ажиллалаа.<br>Тайлангийн хугацаанд Сүхбаатар дүүргийн засаг даргын 2022 оны "Тэмцээн зохион байгуулах тухай" А/170 дугаартай тушаалын хүрээнд Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн газар хамтран сургуулийн өмнөх насны хүүхэд, эцэг эхчүүдэд замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд зөв соёлтой оролцох дадлыг багаас нь эзэмшүүлэх, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, хууль, дүрмийн мэдлэг олгох зорилгоор "Замын хөдөлгөөний цагаан толгой" тэмцээнийг 2022 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс 09-ний өдрүүдэд зохион байгуулахад 51 дүгээр цэцэрлэг 1 дүгээр байр эзэлсэн.<br>Дээрх арга хэмжээнд зохион байгуулагдахад шаардагдах 11,526,000 /арван нэгэн сая таван зуун хорин зургаан мянга/ төгрөгийг Сүхбаатар дүүргийн засаг даргын 2022 оны "Тэмцээн зохион байгуулах тухай" А/170 дугаартай тушаалаар шийдвэрлүүлсэн.<br>Хүүхдийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ерөнхий боловсролын 3-5 дугаар ангийн хүүхдүүдийн дунд зохион байгуулагдах "Ногоон гэрэл-цагаан шугам" тэмцээнийг 11 дүгээр сард дүүргийн ерөнхий боловсролын 10 сургуулийн дунд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. | | | | | | |
| 181 | | Гудамж замд үүрэг гүйцэтгэх алба хаагчдын аюулгүй байдлыг хангах нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх бичлэг хийх хүчин чадалтай энгэрийн камераар хангана. | 70% | Алба хаагчдын энгэрийн камераар бичсэн бичлэгийг хуулах төхөөрөмж, шалгалт хийх багажийн нөөц бүрдүүлсэн байна. | 23,000.00 | Дүүргийн төсөв | ЦГ, ЗЦХ | 70% |
| | | Гудамж замын хяналт шалгалтыг эрчимжүүлэх, алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор "Сүхбаатар дүүргийг 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө"-ний хүрээнд дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөр нэг бүр нь 400,000 төгрөгний үнэтэй 20 ширхэг энгэрийн камер худалдан авах 8,000,000 төгрөгийг шийдвэрлүүлэн нийлүүлэгч байгууллагаас энгэрийн камерыг хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. | | | | | | |
| 182 | | Алба хаагчдыг албан үүргээ гүйцэтгэхэд | 50% | Алба хаагч болон шалгуулагчийн эрүүл | 29,920.00 | Дүүргийн төсөв | ЦГ, ЗЦХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. | | мэндэд хор нөлөөгүй үлээсэн агаарыг өөр чиглэлээр гадагшлуулдаг орчин үеийн drager брэндийн drager alcotest 5000 маркийн согтолт тандагч багаж, тоног төхөөрөмжөөр хангасан байна. | | | | |
| | | Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтсээс гудамж замын хяналт шалгалтыг эрчимжүүлэх, алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор "Сүхбаатар дүүргийг 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө"-ний хүрээнд дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөр энгэрийн камер 20, гар станц 28, гар станцны батериа 23, зөөврийн хард 1 нийт 24,600,000 төгрөгний үнэ бүхий техник хэрэгслийг шийдвэрлүүлэн нийлүүлэгч байгууллагаруу санхүүжилтийг шилжүүлсэн байна. мөн 6 дугаар сард шалгах багаж 10, согтуурал тандагч багаж 25 нийт 28,250,000 төгрөгний үнэ бүхий техник хэрэгслийг шийдвэрлүүлэн алба хаагчдад тараан олгож албаны бэлэн байдал хангасан.<br>X cover шалгагч гар утас 14 ширхэгийг 18.172.000 төгрөгөөр, 1 ширхэг хөдөлгөөнт камер 2 сая төгрөгөөр НЦУГ-аас хоорондын тооцоогоор хүлээн авч нөөцөнд аваад байна. | | | | | | |
| 183 | | Зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажил хийнэ. | 70% | Замын хөдөлгөөнд оролцогчдод зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, хэргийн хор уршгийн талаар сурталчилсан шторк хийж олон нийтийн сүлжээ, телевизээр нэвтрүүлсэн байна. | 24,000.00 | Дүүргийн төсөв | ЦГ, ЗЦХ ГХУСАЗСЗ, ГБХЗ Хэлтэс | 100% |
| | | Дүүргийн ерөнхий боловсролын 4, 6, 31, 1, 58, 16, орос монголын хамтарсан 3, Хөгжим бүжигийн колежид зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 21 удаагийн сургалт зохион байгуулахад давхартсан тоогоор 1254 сурагч хүүдүүд хамрагсан. Дүүргийн нутаг дэвсгэрт гарсан зам тээврийн ослын шалтгаан нөхцөлийг тогтоож төрийн болон төрийн бус байгууллагад хугацаатай албан мэдэгдэл 48-г хүргүүлж хариуг авч давхардсан тоогоор 9 байгууллагын 189 хүнд сургалт зохион байгуулж ажилласан. | | | | | | |
| 184 | ДЗДҮАХ-4.5.9 | Сууц өмчлөгчдийн холбоодод хяналт шалгалт хийх, шилдэг тохижилттой иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулж урамшуулах, холбогдох хууль | Дүүргийн нутаг дэвсгэрт 196 СӨХ үйл ажиллагаа явуулж байна. | 196 сууц өмчлөгчдийн холбоодод хяналт шалгалтын ажлыг хийж, шилдэг тохижилттой СӨХ шалгаруулан урамшуулсан байна. | 13,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тогтоомжийг сурталчлах сургалт зохион байгуулна. | | | | | | |
| | | 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр дүүргийн 1-11 дүгээр хороонд үйл ажиллагаа явуулдаг 200 сууц өмчлөгчдийн холбооны гүйцэтгэх захирал, 1-20 дугаар хорооны олон нийтийн байцаагч, дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөлөөс мэргэжилтэн албан хаагчид оролцож сууц өмчлөгчдийн холбооны хууль тогтоомж болон Манай хороо-Миний гудамж аяны шилдэг СӨХ шалгаруулах болзолт уралдааны талаарх мэдээллийг танилцуулан цаашид хэрэгжих ажил тулгамдаж буй асуудлын талаар санал солилцон мэдээлэл хүргэн ажилласан болно.<br>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3-т сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх; гэж заасны дагуу санхүүжилт гараагүй болно. | | | | | | |
| | | **4.6 Хүнсний аюулгүй байдлыг хангах ажиллана.** | | | | | | |
| 185 | НХТЖҮЧ-4.3.1<br>НЗДҮАХ-3.4.3<br>ДЗДҮАХ-4.6.1 | Хоол үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбарын ажилтнуудыг чадавхжуулах сургалтад хамруулж, үйлчилгээний стандартын шаардлагыг хангуулна. | Стандартыг мөрдүүлэх чиглэлээр 50 ААН-д сургалт зохион байгуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. МСҮТ-тэй хамтран мэргэшүүлэх сургалтад 70 хүн хамруулсан. | 500 ажилтныг мэргэжлийн сургалтад хамруулж, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлсэн байна. | 5,500.00 | Дүүргийн төсөв | ХХҮХ<br>НАЖГ, МХХ, ТББ | 100% |
| | | Аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөн туслах чиглэлээр нийт 7 удаагийн сургалт, семинаруудыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, 535 хүнийг сургалтанд хамруулж ажиллалаа. Үүнд:<br>1. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолын хүрээнд "Ногоон титэм аналитикс" ХХК-тай хамтран 100 гаруй иргэн, аж ахуйн нэгжид танилцуулга хийж, холбогдох стандартууд, "Тохирлын үнэлгээ, тохирлын гэрчилгээ олгох" танилцуулга, ulaanbaatar.mn сайтны "Онлайн бизнес төв" платформын үйлчилгээ эрхлэх бүртгэлийн системд бүртгүүлэх зааварчилгааг танилцууллаа.<br>2. Швейцарын хөгжлийн агентлаг (SDC) болон Ай Хотел ХХК-ийн хамтран хэрэгжүүлж буй "MyHotel-Аялал жуулчлал, Байрших үйлчилгээний салбар дахь цахим шилжилт" төсөл танилцуулах сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр, НАЖГ, Швейцарын хөгжлийн агентлаг (SDC) болон "Ай Хотел" ХХК-тай хамтран зохион байгуулж амралтын газар 5, зочид буудал 26, дэн буудал 7 нийт 38 аж ахуйн нэгжийг хамрууллаа.<br>3. Захирагчийн ажлын албаны даргын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн Сургалт зохион байгуулах тухай А/73 дугаар тушаалын хүрээнд батлагдсан хөтөлбөрийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 31, 10 дугаар сарын 04-ний өдрүүдэд тус тус 2 удаагийн сургалтыг дүүргийн ЦГ, МХХ-тэй хамтран зохион байгуулж хоол үйлдвэрлэлийн 131, худалдааны 71, нийт 202 аж ахуйн нэгж хамрагдаж, холбогдох стандартууд, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудыг аттестатчилах тухай А/79 дүгээр тушаалыг танилцуулсан.<br>4. Хотын стандарт, хяналтын газраас Хотын стандартыг мөрдөх, хэрэглэх талаар мэдлэг олгохоор 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр аялал жуулчлалын салбарын 40 томоохон аж ахуйн нэгүүдэд сургалт зохион байгууллаа.<br>НЗД-ын 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн "Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх тухай" А/1120 дугаар захирамжийн хүрээнд 2022 оны 09 дүгээр сарын 16, 20-ны өдрүүдэд НЭМҮТ-өөс | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хүнсний аюулгүй байдал сэдэвт сургалт зохион байгуулж, томоохон зах, худалдааны төв, сүлжээ дэлгүүр, хоол үйлдвэрлэл үйлчилгээний, нийт 8 газрыг хамруулан, сертификат олгосон. | | | | | | |
| 186 | | Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагддаг уламжлалт баярын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ. | Нэгдсэн арга хэмжээг тусгай төлөвлөгөөний дагуу тэмдэглэн өнгөрүүлж, баярын худалдаа, үйлчилгээг зохион байгуулан, жилд дунджаар 200 гаруй аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг дэмжин ажилласан. | Нийт 200 гаруй ААН, иргэдийг татан оролцуулсан байна. | 1,500.00 | Дүүргийн төсөв | ХХҮХ МХХ, ЦХ, ОБХ | 100% |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийт-180 гаруй аж ахуйн нэгж байгууллагыг уламжлалт болон нийтийг хамарсан 10 удаагийн арга хэмжээнд оролцуулсан. Үүнд:<br>1. Улаанбаатар Марафон-2022 олон улсын гүйлтийн тэмцээн, Автомашингүй өдөр нэгдсэн арга хэмжээнд Бээжингийн гудамжинд худалдаа, үйлчигээг зохион байгуулан ажилласан.<br>2. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр Д.Сүхбаатарын талбайн арга хэмжээнд дүүргийн ЖДҮДТ-тэй хамтран 9 асарт нийт-20 аж ахуйн нэгж, иргэнийг хамруулан ажилласан.<br>3. "Амралтын өдрийн худалдаа" арга хэмжээг 2022 оны 05 дугаар сарын 21, 22, 6 дугаар сарын 18, 19-ны өдрүүдэд Б.Цэрэндоржийн гудамжинд зохион байгуулж, 30 гаруй үйлдвэрлэл эрхлэгчид худалдаа гаргаж, 15,296,000 төгрөгийн борлуулалт хийсэн.<br>4. 2022 оныг “Иргэний жил” болгон зарласантай холбогдуулан худалдаа, үйлчилгээний 83 газарт ДЗД-ын “Уриалга” хүргүүлэн, шаардлага тавьж 20 газарт налуу зам хийлгэсэн.<br>5. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжихтэй холбогдуулан мэдэгдлийг олон нийтэд сурталчлан, 20 сүлжээ дэлгүүрт хяналт, шалгалт хийж, хуулийг танилцуулан, хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг чиглэл өгч ажилласан.<br>6. Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойн баяраар Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/106 дугаар тушаалын дагуу дүүргийн Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс 7 сарын 9-12-ны өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнгийн 15-16 дугаар секторыг хариуцан ажиллаж, хуушуурын 23, худалдааны 37 нийт 60 асарт хяналт тавин ажилласан.<br>7. Горхи Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт 2022 оны 08 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд “Нүүдэлчин соёл” соёлын фестивальд 5 хоол үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжийг оролцуулсан.<br>8. “Улаанбаатар үндэсний хоолны өдөрлөг” арга хэмжээнд 8 хоол үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж халуун хоол цайгаар үйлчилсэн.<br>9. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/140 дүгээр тушаалын дагуу 2022-2023 оны хичээлийн шинэ жилийн өргөтгөсөн худалдааг нийт 6 байршилд зохион байгуулан ажилласан.<br>Нийслэлийн 383 жилийн ойн Их хотын хямдрал нэгдсэн арга хэмжээнд ААН-үүд 2022 оны 10 дугаар сарын 26-29-ны өдрүүдэд 10%-72% хямдрал, урамшуулал зарлан нийслэлийн иргэддээ бэлэг барин, идэвхитэй оролцлоо. | | | | | | |
| 187 | | Ахуйн үйлчилгээний шинэлэг технологийг сурталчлах, | Шинээр батлагдсан стандартуудын сургалтад 120 гаруй | 2 удаагийн сургалт, үзүүлэх сургуульд 30-40 бизнес | 6,500.00 | Дүүргийн төсөв | ХХҮХ УБЗАА | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлчилгээний соёлыг төлөвшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулж, бизнес эрхлэгчдийг дэмжиж ажиллана. | ААН, иргэнийг хамруулсан. | эрхлэгчдийг, нийслэлийн уралдаан тэмцээнд 15-20 үсчин, гоо засалчдыг дэмжиж оролцуулна. | | | | |
| | | Ахуйн үйлчилгээний салбарын ажиллагсдыг дэмжих, дүүргийн үсчин, гоо засалч, хумс засалчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, орчин үеийн шинэ арга техник, технологиос харилцан суралцах, туршлага солилцох, улсын аваргын Үсчин, гоо засалч, хумс дизайн урлалын XXV их наадамд оролцох дүүргийн аварга үсчин, гоо засалчдын баг бүрэлдэхүүнийг шалгаруулах Сүхбаатар дүүрэг-Чингэлтэй дүүрэг-2022 тэмцээнийг 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулахаар дүүргийн Засаг даргын захирамжаар 3,0 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэсэн байсан боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3 дахь заалтын дагуу тэмцээний зардлыг хасч, мэргэжлийн холбоод болон ААНБ-ын зардлаар хийхээр шийдвэрлэж, Эрдэнэт хотод 2022.10.03-ны өдөр зохион байгуулагдсан Улсын аварга шалгаруулах уралдаанд дүүргийн үсчин, хумс урлал, гоо засалчдын багийг Монголын мастер үсчин Д.Одонгоогоор ахлуулсан дүүргийн 10 салоны 35 хүний бүрэлдэхүүнтэй баг амжилттай оролцсон.<br>Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд,Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн баталсан худалдаа, үйлчилгээний байгууллагуудын дагаж мөрдүүлэх Худалдаа үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага UCS 1201B, Худалдаа үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавигдах ерөнхий шаардлага UCS 1202B, Хог хаягдлын менежмент UCS 1701A:2022 хотын стандартуудыг танилцуулах сургалтыг Хотын стандарт, хяналтын газартай хамтран зохион байгуулж, ахуйн үйлчилгээний 20 ААНБ-ын төлөөллийг оролцуулж, шинээр батлагдсан хотын стандартуудын талаар санал бодлоо солилцож, дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн.<br>Монголын мэргэжлийн хумс засал, гоо сайхны нэгдсэн холбоотой хамтран Хэрэглэгчдэд зориулсан хумс заслын үйлчилгээний ерөнхий шаардлага MNS 6843:2020 стандартыг сурталчлан танилцуулах сургалтыг 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж, дүүргийн гоо сайхны 12 салоны 26 хумс засалчдыг хамруулан, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн. | | | | | | |
| 188 | | Тогтвортой үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудыг дэмжих, салбарын тэргүүний ААНБ, иргэдийг тодруулж урамшуулна. | Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний нийт 600 гаруй ААН, иргэнийг шагнаж урамшуулсан. | ААНБ-уудын үйл ажиллагаа идэвхэжсэн байна. Нийт 5 ААНБ, 60 иргэнийг шагнаж урамшуулна. | - | | ХХҮХ ЖДҮДТ, ХЗДАА | 100% |
| | | Салбартаа тэргүүлэн олон жил үр бүтээлтэй ажилласан аж ахуйн нэгжүүдээс ХХААХҮЯ-ны "Салбарын тэргүүн"-12, "Жуух бичиг"-42, дүүргийн Хүндэт тэмдэг -2, Хөдөлмөрийн алдар -5, нийт 61 хүнийг шагналд тодорхойлж, дэмжин ажиллалаа. | | | | | | |
| 189 | ДЗДҮАХ-4.6.2. | Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэн, зуслангийн бүсүүдэд байнгын хяналт тавьж, мал оруулахгүй байх чиглэлээр | Дүүргийн нутаг дэвсгэр 2018 онд малгүй болсон. Гэр хороололд нийт 33 өрхийн 478 орчим шувуу, 4399 гаруй өрхийн 5022 гаруй нохой байна. | Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, нохой, шувуунд вакцин хийж, ариутгал халдваргүйтгэл хийнэ. | - | | ХХҮХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана. | | | | | | |
| | | Дүүргийн 2021 оны мал тооллогын дүнгээр гарсан 4063 өрхийн 4763 нохой, 37 өрхийн 691 шувуу, 26 өрхийн 413 тэжээвэр амьтдын тоон статистик мэдээлэл болон дэлгэрэнгүй судалгааг Овоот гол ХХК болон дүүргийн МХХ-т тус тус хүргүүлж, НЗД-ын 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн Мал эмнэлгийн арга хэмжээний тухай А/295 дугаар захирамжийн хэрэгжилтийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт байгаа гэрийн тэжээвэр, бүртгэлтэй нохойн халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах тоо, шаардагдах эм биобэлдмэл, ариутгал халдваргүйтгэл хийх талбай, бодисын тооцооллыг гаргаж, Нийслэлийн мал эмнэлгийн газраас хуваарилсан 3000 тун вакциныг хүлээн авч, дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/147 дугаар захирамжаар вакцинжуулалт, туулгалт, халдваргүйтгэлийн ажилд шаардагдах зардал 8,625,000 төгрөгийг Орон нутгийн нөөц хөрөнгөнөөс гаргаж, санхүүжүүлэн, Мал эмнэлэг үйлчилгээний нэгж Овоот гол ХХК, хороодын ажлын албатай хамтран 2985 нохойд туулга, вакцинжуулалт хийж, ариутгал халдваргүйтгэлийн арга хэмжээг бүрэн авч дууссан.<br>Дүүргийн нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй мал аж ахуй эрхэлж буй 13, 18, 19, 20 дугаар хорооны 19 айл өрхийн 733 толгой малыг гаргах чиглэлээр Ажлын хэсгээс 4 удаагийн хяналт шалгалт явуулж, МХХ-ийн 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 02/17/68 дугаартай мэдэгдэл, ЦХ-2 хэлтсийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн шаардлагыг малтай өрхүүдэд өгч, гүйцэтгэлд нь хяналт тавьж, 9 өрхийн 545 малыг гаргасан.<br>БЗД-ээс орж ирсэн эзэнгүй 38 адууг тууж, Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-ын хашаанд хаших ажиллагаа явуулж, дүүргийн ЦХ-с малын эзнийг тодруулж, дахин хариулгагүй мал оруулж ирвэл холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авахыг сануулж, малыг нь буцаан өгсөн. Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалтын дагуу 4 иргэнд тус бүр 50,0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан.<br>Чингэлтэй, Баянзүрх дүүргүүдээс мал орж ирэх нь байнга давтагдаж байгаа тул дүүргүүдийг нэгдсэн бодлого чиглэлээр хангаж ажиллах талаар НХХААГ-т 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр 8/528 дугаар албан бичиг, БЗДЗДТГ-т 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдөр 1/1235 дугаар албан бичгийг хүргүүлж, холбогдох арга хэмжээ авахуулахаар хандсан.<br>Одоогийн байдлаар 18, 19, 20 дугаар хорооны 11 өрхийн 255 толгой малыг гаргахаар холбогдох арга хэмжээ аван ажиллаж байна. | | | | | | |
| 190 | | Худалдаа үйлчилгээний бүх газруудад аттестатчиллын шалгалт явуулж, үйлчилгээний газруудын стандартын шаардлагыг хангуулна. | 2021 онд 10 удаагийн хяналт явуулж, давхардсан тоогоор 700 ААН, иргэний үйл ажиллагааг шалгасан. | Худалдаа-100, хоол үйлдвэрлэл-200, аялал жуулчлал-80, ахуйн үйлчилгээ-30, ЖДҮ-10, нийт-420 байгууллагад хяналт шалгалт явуулна. | 3,800.00 | Дүүргийн төсөв | ХХҮХ<br>МХХ<br>ЦХ | 100% |
| | | Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар баталсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад аттестатчиллын шалгалт явуулах тухай” удирдамжийн дагуу шалгалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулж, худалдааны 129, хоол үйлдвэрлэлийн 224, нийт 353 аж ахуйн нэгжийг хяналт шалгалтад хамруулллаа. Шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдэд “Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газарт тавих шаардлага MNS4946:2019” стандарт, Худалдаа, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд тавих дотоод хяналтын хэрэгжилтийг хангуулахаар ажлын байрны хяналт шалтгалтыг зохион байгуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн ажиллалаа. Шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 80 орчим хувь нь стандарт шаардлага хангасан, 20 орчим хувьд нь хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулан ажилласан.<br>Нийслэлийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журмын шинэчлэн боловсруулсан төсөлд Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсээс Хууль, эрх зүйн хэлтэс, дүүргийн Цагдаагийн газар, хороодын Ажлын | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | албатай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 250 гаруй ААН-ээс санал авч, журмын шинэчилсэн төслийн хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Журмын төслийн хэлэлцүүлэгт 328 аж ахуйн нэгжийн 322 буюу 98 хувь нь дэмжсэн, 6 буюу 2 хувь нь дэмжээгүй, 85 иргэний 78,8 хувь нь дэмжсэн, 21,2 хувь дэмжээгүй гэсэн дүнтэй байна.<br>Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй худалдаа, үйлчилгээний байгууллагуудын гадна орчинд хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих налуу зам хийх боломжтой газруудын судалгааг гаргахад налуу замаа сайжруулах боломжтой буюу налуу замтай ч бариулгүй, налуу замгүй ч дотроо лифттэй, налуу зам хийх боломжтой зэрэг стандарт хангуулж болохуйц 16 газарт хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангаж ажиллах УРИАЛГА гарган хүргүүлсэн. Дээрх аж ахуйн нэгжүүдээс уриалгыг дэмжин 11 газар налуу замаа сайжруулан стандарт хангаж, 4 газар шинээр налуу зам хийсэн байна. | | | | | | |
| 191 | | Түргэн үйлчилгээний цэгт холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна. | 2019 онд 21 ТҮЦ, 2020 онд 10 ТҮЦ, 2021 онд 9 ТҮЦ-ийг нүүлгэж, 60 ТҮЦ-д нийтийн эзэмшлийн зам талбай чөлөөлөх тухай мэдэгдэх хуудас өгсөн. | Дүүргийн нутаг дэвсгэр дэх ТҮЦ-үүдэд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт, шалгалт явуулж, эрүүл ахуйн шаардлага хангуулан, шинээр зөвшөөрөлгүй байрлуулсан ТҮЦ-үүдийг нүүлгэнэ. | 10,000.00 | Дүүргийн төсөв | ХХҮХ<br>ГЗБА, ЦГ | 50% |
| | | НЗД-ын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай А/596 дугаар захирамжтай холбоотойгоор нийтийн эзэмшлийн гудамж, талбайд зөвшөөрөлгүйгээр тавигдаж байгаа ТҮЦ, павильон эрс нэмэгдэж байна - дүүргийн нутаг дэвсгэрт 2022 оны 11 сарын байдлаар 46 ТҮЦ шинээр нэмэгдсэн.<br>НИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 34-р тогтоолоор батлагдсан Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журмын 3.2-т Зөвлөлийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын захирамжаар батална гэж заасны дагуу дүүргийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай А/285 дугаар захирамж гарч, дүүргийн Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөл байгуулагдсан. Зөвлөл 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдөр хуралдаж нийтийн эзэмшлийн зам талбайд тавигдсан иргэдийн зорчих хөдөлгөөнд саад учруулж байгаа, санал гомдол ихээр ирүүлж буй ТҮЦ-үүдийн газар чөлөөлөх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:<br>- Дүүргийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн Нийтийн эзэмшлийн зам, талбай, орц, гарц чөлөөлөх тухай А/312 дугаар захирамжийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн гомдлын дагуу нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд зөвшөөрөлгүй байрлуулсан нэн тэргүүнд нүүлгэх шаардлагатай 10 түргэн үйлчилгээний цэгт нийтийн эзэмшлийн газар чөлөөлөх албан шаардлагыг дүүргийн газар зохион байгуулалтын албанаас хүргүүлж, одоогоор 6 цэгийг албадан нүүлгэж, нийтийн эзэмшлийн талбайг чөлөөлсөн.<br>- Мөн дүүргийн Газар зохион байгуулалтын албанд 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний зам дээр шинээр тавигдсан, иргэдээс санал гомдол ихээр ирүүлж байгаа, нэн даруй нүүлгэх шаардлагатай 27 ТҮЦ-ийн газар чөлөөлөх 8/1572 дугаар албан бичгийг хүргүүлэн тухайн ТҮЦ-үүдэд албан шаардлага хүргүүлэн ажиллаж байна. | | | | | | |
| 192 | | Дүүргийн Худалдаа үйлчилгээг зохицуулах | 2021 онд Засаг даргын дэргэдэх 2 Зөвлөл 8 удаа | Тухайн цаг үеийн асуудлаар хуралдаан | 5,000.00 | Дүүргийн төсөв | ХХҮХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Зөвлөл болон Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйлийг устгах, улсын орлого болгох Зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллана. | хуралдаж, холбогдох шийдвэрийг гарган, хэрэгжилтийг хангуулан ажилласан. | зохион байгуулж, чанар, стандартын шаардлага хангахгүй бараа, бүтээгдэхүүнийг устгалд оруулах, улсын орлого болгох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна. | | | ТЗУХ, СТСХ, МХХ | |
| | | Зөвлөл нь дүүргийн Засаг даргын 2019 оны А/467 дугаар захирамжаар байгуулагдсанаас хойш харъяалах нутаг дэвсгэрийн прокурорын байгууллагад тайлан мэдээг, журмын 5.8 дахь хэсэгт хагас, бүтэн жилээр нэгтгэн ирүүлнэ гэж заасны дагуу 2021 оны жилийн эцсийн тайлан мэдээг нэгтгэн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн даргын 2022 оны 02 дугаар 24-ний өдрийн 8/230 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, устгах талаар шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Засаг даргын дэргэдэх Зөвлөл нь 2022 оны байдлаар 1 удаа хуралдаж, зөвлөлийн ажиллах чиглэлийг баталж, үйл ажиллагаагаа хэвийн явуулахаар тогтсон.<br>Дүүргийн прокурорын газарт Зөвлөлийн үйл ажиллагааны талаарх саналыг 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 8/95, 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 3/121 дугаартай албан бичгүүд хүргүүлэн, хариу ирэх хугацаанд Зөвлөлийн үйл ажиллагааг түр зогсоосон байсан.<br>НИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор батлагдсан Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журмын хүрээнд дүүргийн Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/285 дугаар захирамжаар шинэчлэн баталсан. Худалдаа үйлчилгээг зохимцуулах зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж, дүүргийн нутаг дэвсгэрт явуулын үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэн, ААН-ын хүсэлт болон худалдаа үйлчилгээний талаарх цаг үеийн асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж ажиллалаа.<br>Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, худалдаа, үйлчилгээ чөлөөтэй эрхлэх нөхцлийг бүрдүүлэх, орлогыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын дэргэдэх “Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн хурал 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хуралдаж, нийтийн эзэмшлийн зам талбайд улирлын чанартай түр сүүдрэвчтэй худалдаа, явуулын хоолны үйлчилгээ эрхлэх 20 хорооны нийт 71 байршлыг баталж, хамтран ажиллах гэрээг худалдаа үйлчилгээний 9, явуулын хоол үйлдвэрлэлийн 9 нийт 18 иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулан ажиллалаа.<br>Зуны түр худалдаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн гэрээний хугацаа 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс дуусгавар болсонтой холбогдуулан 18 иргэн, аж ахуйн нэгжид мэдэгдэн, нийтийн эзэмшлийн зам, талбайг чөлөөлсөн.<br>Эмзэг цэг-Хяналт шалгалт” Төрийн хяналт шалгалт явуулахгүй байх тухай Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу нутаг дэвсгэрт согтууруулах ундаагаар үйлчилдэг байгууллага аж ахуйн нэгжүүдэд шалгалт хийгдээгүй ба Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль зөрчсөн 633 зөрчилд 255 хайрцаг тамхи, 645ш 0.5гр пиво, 25ш 0.5гр хураан 19575000 төгрөгний шийтгэл ногдуулсан. | | | | | | |
| 193 | | Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавина. | 2021 оны байдлаар тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоо 139 байна. | Хуулийн хэрэгжилт хангагдана. | 500.00 | Дүүргийн төсөв | ХХҮХ<br>МХХ<br>ЦГ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ Ерөнхий шаардлага MNS 5021-1:2019 стандарт, хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан, тамхины хяналтын тухай хуулийн дагуу ерөнхий боловсролын сургууль, сургуулийн дотуур байрнаас 500 метрийн зайд үйл ажиллагаа явуулдаг явуулдаг шинээр тамхины тусгай зөвшөөрөл шинээр авах-6, сунгалт хийлгэх-28 нийт-34 аж ахуйн нэгжид дүүргийн Засаг даргын 6 удаагийн захирамжаар тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгож, хяналт тавин ажиллаж байна.<br>Жил бүрийн 03 дугаар сарын 15-ны өдөр буюу Олон улсын хэрэглэгчийн өдрийг тохиолдуулан Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ШӨХТГ-ын санаачилгыг дэмжиж, "21 насанд хүрээгүй хүнд сордог электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглох", худалдааны газруудад электрон тамхины худалдааг зогсоох, иргэд олон нийт, сургуулийн сурагчдад тамхины хор хөнөөлийг сурталчлах зорилгоор дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн "Хүүхэд –эрхэм хэрэглэгч" аян зохион байгуулах тухай А/49 дүгээр захирамжийн хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. Аяны хүрээнд ДЭМБ, НЭМҮТ-өөс гаргасан мэдээллийг орчуулан "Хүүхэд-Эрхэм хэрэглэгч" зурагт хуудсыг А3 болон А4 хэмжээтэйгээр нийт 8000 ширхэгийг хэвлүүлэн ерөнхий боловсролын 27 сургуульд, 183 СӨХ, ЕБС-ийн ойр орчмын дэлгүүр, ТҮЦ, 20 Өрхийн эмнэлэг, 20 хорооны ажлын алба, томоохон зах, худалдааны төвүүд зэрэг зорилтот байршлууд болон хүн хамгийн ихээр цугладаг байршлуудад тараан байршуулж, электрон тамхины хор нөлөөг сурталчлан таниулсан.<br>Ерөнхий боловсролын 24 сургуулийн эмч, нийгмийн ажилтнууд 10-12 дугаар ангийн нийт 5950 суралцагчдад электрон тамхины хор уршгийн талаар мэдээлэл олгох яриа таниулга, ярилцлагуудыг зохион байгуулж, электрон болон бусад тамхи, тамхин бүтээгдэхүүний хэрэглээ болон мэдлэгийн түвшинг үнэлэх асуумж судалгааг цахим хэлбэрээр авч ажилласан. | | | | | |
| 194 | НЗДҮАХ-1.1.2<br>НЗДҮАХ-3.3.3<br>ДЗДҮАХ-4.6.3 | Хүн амын махны хэрэглээг нэмэгдүүлэх, үнэ тогтворжуулах зорилгоор нөөцийн махны жижиглэнгийн болон бөөний өргөтгөсөн худалдаа зохион байгуулна. | Нийт 43 хүнсний дэлгүүрээр 401.72тн мах, өргөтгөсөн худалдаагаар 74.38тн мах худалдаалагдсан. | Дүүргийн хүн амын хүнсний хангамж нэмэгдэнэ.<br>Жижиглэнгийн худалдааг 35 дэлгүүрт, өргөтгөсөн худалдааг 4 цэгт зохион байгуулсан байна. | 2,500.00 | Дүүргийн төсөв | ХХҮХ<br>УБЗАА | 100% |
| | | Хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, үнийн тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд УБ хотын ЕМ-ийн баталсан Нийслэлийн хүн амын махны хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах талаар авах зарим арга хэмжээний тухай А/18 дугаар тушаалын дагуу нөөцийн махны худалдааг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөөс эхлүүлж, 51 дэлгүүрээр нийт 193,7 тн мах, 9 удаагийн өргөтгөсөн худалдаагаар 9 байршилд 68,6 тн, нийт 321,441 тн мах худалдаалсан. | | | | | |
| 195 | | Дүүргийн иргэдийн эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх нөхцөлийг сайжруулж, төрөл бүрийн сургалт зохион байгуулж, төмс, хүнсний ногооны борлуулалтын сүлжээ цэгүүдийн тоог нэмэгдүүлнэ. | Хавар, намрын цахим сургалтад нийт 50 гаруй өрхийн тариалан эрхлэгчдийг хамруулсан. 7 борлуулалтын цэгт 32 хүнийг ажлын байраар хангасан. | 2 удаагийн сургалтад 100 иргэнийг хамруулж, 30-40 ногоочдыг дэмжсэн байна. | 3,500.00 | Дүүргийн төсөв | ХХҮХ<br>НХХААГ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Засгийн газрын Эх орны Эрүүл хүнс уриан дор зохион байгуулагдаж буй Атрын 4 дүгээр аяны хүрээнд ХХААХҮЯ-аас 80 хувийн хөнгөлөлттэй үнээр олгож буй нийт 10 нэр төрлийн хүнсний ногооны үрийн үнийн 20%-н хөнгөлөлтөд шаардагдах 229232 төгрөгийг ДЗДТГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/53 дугаар тушаалаар Бараа үйлчилгээний зардлаас гаргаж, дүүргийн өрхийн тариалан эрхлэгчдэд үнэгүй олгосон.<br>Дүүргийн хэмжээнд 1 ААН, 155 өрхийн тариалан эрхлэгчид 0,2467 га-д төмс, 1,566 га-д хүнсний ногоо тариалж, 2021 оны 11 дүгээр сарын 01-ний байдлаар 3,944 тн төмс, 19,934 тн хүнсний ногоо хураан авч, хүнсний хэрэгцээгээ хангаж байна.<br>МУ-ын ЗГ-ын 2022 оны 74 дүгээр тогтоол, НЗД-ын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/751 дүгээр захирамжийн дагуу хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг 2022 оны 06 дугаар сарын 20-ноос 07 дугаар сарын 08-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 551 өрхийн тариалан эрхлэгчдийг хамруулан, тооллого явуулахад шаардагдах 5850000 төгрөгийн зардлыг ДЗД-ын 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/223 дугаар захирамжаар шийдвэрлэсэн.<br>Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийг тогтворжуулах, хэрэгцээт хүнсээ дотоодын үйлдвэрлэлээр хангах, импортыг орлох, экспортыг дэмжих зорилтын хүрээнд ХХААХҮЯ, УБЗАА, НҮБ-ын ХХААБ, МХХ-той хамтран "Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл нэгдсэн арга хэмжээ-2022" өргөтгөсөн худалдаанд дүүргийн 3 өрхийн тариалан эрхлэгчийг дэмжин оролцуулж, УБ хотын ЕМ-ийн баталсан Шинэ ургацын төмс, хүнсний ногооны үзэсгэлэн худалдаа зохион байгуулах удирдамжийн дагуу байнгын худалдааны 3 цэг, Эрхүүгийн гудамж, Их тойруу худалдааны төв, 32-ын тойруу, 16 дугаар хорооны Төрийн банкны дэргэд, нийт 7 байршилд Төв, Сэлэнгэ, Ховд аймгийн шинэ ургацын ногооны худалдаа гаргаж, 15 ногоочдыг ажлын байраар хангаж, 92,2 тн төмс, 24 нэр төрлийн 172,816 тн хүнсний ногоо, 30 кг байгалийн жимс, 770 шил даршилсан ногоо, 50 шил зөгийн бал худалдаалж, 690 039 000 төгрөгийн борлуулалт хийж, дүүргийн хүн амын хүнсний хэрэгцээг хангасан. | | | | | | |
| 196 | | Хүн амын хүнсний хэрэгцээ, гамшгийн үед хэрэглэх хүнсний хангамжийн тооцоог шинэчилж, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийн, мэдээ тайланг тогтмол гаргана. | Дүүргийн хүнсний хангамж бүрдүүлэх арга хэмжээнд худалдааны 10, нийтийн хоол үйлдвэрлэлийн 10, нийт 20 ААНБ-ыг татан оролцуулсан. | Дүүргийн хүнсний хангамжийн тооцоо, хүнсний нөөцийн мэдээ үнэ зөв гарсан байна. | - | | ХХҮХ | 100% |
| | | Дүүргийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дүүргийн ОБХ-тэй хамтран Гамшгаас хамгаалах төлөвлөлт, зохион байгуулалт сэдэвт танхимын сургалтыг болзошгүй эрсдэлийн үед хамтран ажиллах худалдааны 8, хоол үйлдвэрлэлийн 9, хүнсний үйлдвэрийн 2, нийт 19 ААН-ийн захирал, менежерүүдэд зохион байгуулж, Болзошгүй гамшгийн үед хүнс, бараа материал, хүн хүч, техник хэрэгсэл нийлүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, заавар, зөвлөгөө өгсөн.<br>Хүнсний тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хуулиуд болон Хүнсний кластерын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд ХХААЯ болон Дэлхийн зөн-Монгол Олон улсын байгууллагаас өгсөн Зөвлөмж, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалаар батлагдсан "Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ"-гээр жишсэн 1 хүний 1 хоногийн хүнснээс авах илчлэг, шим тэжээлийн тооцооллын дагуу Газар хөдлөлтийн гамшгийн үеийн орон нутгийн хүн амын хүнсний нөөц тооцох аргачлалыг үндэслэн дүүргийн 2021 оны хүн амын статистик тоон үзүүлэлтэд тулгуурлан жишсэн хүн ам /116352,6/-ын хүнсний хэрэгцээ, гамшгийн үед хэрэглэх хүнсний хангамжийн тооцоо болон хүн хүч техник хэрэгслийн тооцоог шинэчлэн гаргаж, Хүнсний хангалтын багийн гамшгийн эрсдлээс хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийсэн. | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дүүргийн хүнсний нөөцийн хэмжээ болон хүнсний хангамж, хүртээмжийн тооцоолол, томоохон зах худалдааны төвүүд, мэргэжлийн ангиудын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн мэдээллийг цахим групп чат, мэйл хаяг гэх мэт цахим сүлжээний бүхий л хэлбэрүүдийг ашиглан түргэн шуурхай авч, УБ хотын ХҮХҮХ-т 14 хоног тутамд хүргүүлэн ажиллаж байна.<br>Томоохон зах худалдааны 4 төв, тусгай зөвшөөрөлтэй 232 дэлгүүр болон гэрээт мэргэжлийн ангиудын хүнсний нөөцийн мэдээг нэгтгэн, дүүргийн жишсэн хүн амд тооцон үзэхэд гол нэрийн 12 төрлийн хүнсний бүтээгдэхүүний нөөц харилцан адилгүй 1-22 хоногийн хүрэлцээтэй байна.<br>ДЗД-ын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/360 дугаар захирамжийн дагуу 2022 оны 09 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулийн арга хэмжээнд Санхүү, хангалтын албаны чиг үүргийг гүйцэтгэж, мэргэжлийн ангиудаас Сансар-32, Хаан бууз, Бест бейкери ХХК-ийн 17 ажилтныг татан оролцуулсан. | | | | | |
| 197 | ДЗДҮАХ-4.6.4 | Хүнсний бүтээгдэхүүний хаяг шошгын стандартыг хангуулна. | Хоол хүнсний шим тэжээлийн талаарх мэдээллийг 100 ААН хоолны цэсдээ тусгасан. | Хоолны цэсэд тухайн бүтээгдэхүүний шим тэжээлийн үзүүлэлтийг 140-150 ААНБ тусгаж хэвшүүлсэн байна. | 1,000.00 | Дүүргийн төсөв | ХХҮХ МХХ | 100% |
| | | Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйлчилгээ эрхлэгч нийт 200 гаруй иргэн, аж ахуйн нэгжид зохион байгуулсан 3 удаагийн танхимын сургалт, 2 удаагийн ажлын байранд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх шалгалтаар хаяг шошго, хоолны цэсэнд илчлэг шим тэжээлийн мэдээллийг тусгах талаар зөвлөгөө мэдээлэл өгч, шаардлага тавьж ажилласан. Нийт хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн 80 гаруй хувь нь хоолны цэсэнд илчлэгийн мэдээлэл бүрэн тавьсан байна. | | | | | |
| ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО /АМЬДРАХАД ТААТАЙ ДҮҮРЭГ/ | | | | | | | |
| 5.1 Иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газрыг бий болгоно | | | | | | | |
| 198 | НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.1 ДЗДҮАХ-5.1.1 | Хүүхэд, залуус, ахмад настнуудад зориулсан хүүхдийн тоглоом, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн төрөлжсөн талбайг шинээр байгуулах болон шинэчилж, тохижуулах ажлын зураг, төсөл хийж, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэнэ. | Хүүхэд, залуус, ахмад настнуудад зориулсан хүүхдийн тоглоом, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн төрөлжсөн тохижилтын зураг, төсөл хийж байсан. | Иргэдээс ирсэн саналын дагуу жил бүр хороодод үе шаттайгаар хэрэгжүүлсэн байна. | 500,000.00 | Дүүргийн төсөв | ТГХШХ | 100% |
| | | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 689.8 сая төгрөгөөр орон сууц, гэр хорооллын дундах хүүхдийн тоглоомын талбай, амрах талбайг байгуулах ажлын хүрээнд 4-р хорооны 24, 24а байрны гадна, 10-р хорооны 24-р цэцэрлэгийн баруун талд, 15 дугаар хорооны Дамбадаржаагийн 16-р гудамж, 91-р худгийн гадна, 84-р гудамжид нийт 3838.1 м2 талбайд тохижилтын ажил бүрэн хэрэгжүүлсэн. 11 дүгээр хорооны Хангай хотхоны 504, 514-р байрны дунд 1630.7м2 талбайд тохижилт хийх ажлыг хэрэгжүүлсэн. | | | | | |
| 199 | НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.1 | Иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх бүхий ногоон байгууламж, тохижилт, | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 3, 7, 17, 19 дүгээр хороонд | ТЭЗҮ боловсруулж, Хөрөнгө оруулалтыг шийдвэрлэсэн байна. | 200,000.00 | Улс, Нийслэл, Дүүргийн төсөв | ТГХШХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ДЗДҮАХ-5.1.2 | цэцэрлэгт хүрээлэн байгуулна. | тохижилт, ногоон байгууламж хийж байсан. | | | | | |
| | | Дүүргийн 1-р хороо, Жамъянгүний гудамжид Өглөөний гудамжинд иргэд иж бүрэн тохижилтыг 259.7 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. | | | | | | |
| 200 | | Сэлбэ голын тохижилтыг сэргээн засварлаж, шинээр тохижуулна. | Сэлбэ голын тохижилтыг сэргээн засварлаж, шинээр тохижуулна | Хөрөнгө оруулалтыг шийдвэрлэсэн байна. | 1,000,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 30% |
| | | Дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт Сэлбэ голын засвар, тохижилт хийх 500 сая төгрөгийн дүүргийн төсвөөр шийдвэрлэж, засварын ажлын зураг төслийг боловсруулан ажиллаж байна. Засвар тохижилтын ажлыг 2023 онд хэрэгжүүлэн ажиллана. | | | | | | |
| 5.2 Тохижилт, ногоон байгууламжуудыг нэмэгдүүлнэ. | | | | | | | | |
| 201 | НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.1 ДЗДҮАХ-5.2.1 | Дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайд гэрэлтүүлэг, камержуулалт хийнэ. | 2021 онд дүүргийн 1-8, 10, 16 дугаар хороонд нийтийн эзэмшлийн гудамж талбайд шинээр 145ш гэрэлтүүлгийг 411.8 сая төгрөгөөр, орон сууцны 1-8 дугаар хороонд хуучны 263ш денат гэрэлтүүлгийг лед гэрэлтүүлгээр солих ажлыг 148.9 сая төгрөгөөр хийсэн. | Иргэдээс ирсэн саналын дагуу жил бүр хороодод үе шаттайгаар хэрэгжүүлсэн байна. | 900,000.00 | Улс, Нийслэл, Дүүргийн төсөв | ТГХШХ | 100% |
| | | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1, 6, 8, 9 дүгээр хороодод 175 цэгт камер, 2283м камерын цахилгаан хангамж хийх ажлыг 900.3 сая төгрөгөөр, 19-р хороонд 27 цэгт гэрэлтүүлэг хийх ажлыг 230 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн. | | | | | | |
| 202 | | Камерын арчлалт, хамгаалалтыг хэрэгжүүлнэ. | 581 камер ашиглаж байна. | Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 216,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, орчны хяналтыг сайжруулах зорилгоор ашиглаж байгаа 629 ширхэг хяналтын камерын арчлалт хамгаалалтыг сайжруулж, ашиглагчаар Тэнгэр цэгцрээ ХХК-тай гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Нийт 216,000,000 төгрөгийн санхүүжилт зарцуулсан. | | | | | | |
| 203 | | Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн арчлалт, хамгаалалтыг хэрэгжүүлнэ. | 6444 гэрлийн арчлалт хамгаалалтыг хариуцан ажиллаж байна. | 6444 гэрлийн арчлалт хамгаалалтыг хэрэгжүүлсэн байна. | 1,199,624.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн 6444 ширхэг гэрэлтүүлгийн арчлалт хамгаалалтыг Гэрэлтүүлэг чимэглэл ХХК, Спейшл тим ап ХХК, БМЖЛ ХХК-иуд хариуцан ажиллаж байна. Гэрэлтүүлгийн асалт, арчлалт хамгаалалтын ажлын гүйцэтгэлийг гэрээнд заасан нөхцлийн дагуу сард 3 аас доошгүй удаа хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, иргэдээс ирүүлсэн | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэдээллийн дагуу засвар үйлчилгээг тогтмол хийж байгаа бөгөөд гэрэлтүүлгийн асалт 98,9%-тай байна. Нийт 1,199,624,000 төгрөгийн санхүүжилт зарцуулсан. | | | | | |
| 204 | | Хөрөнгө оруулалтаар хийгдэх хяналтын камер, гэрэлтүүлгийн ажлын гүйцэтгэлд хяналт тавина. | Нийтийн эзэмшлийн 6444, авто замын 4417 гэрлийн арчлалт хамгаалалтыг хариуцан ажиллаж байна. | Гэрэлтүүлгийн тоо хэмжээ нэмэгдсэн байна. | - | | ТНААХ | 100% |
| | | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 19 дүгээр хороонд 27 ширхэг гэрэлтүүлгийн ажлыг Тэнгэр цэгцрээ ХХК гүйцэтгэж, ажлыг дүүргийн Ажил хүлээж авах комисс хянан шалгаж хүлээн авсан. | | | | | |
| 205 | НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.1 ДЗДҮАХ-5.2.2 | Иргэд, аж ахуй нэгж байгууллагатай хамтран ногоон байгууламж нэмэгдүүлнэ. | Тохижилттой талбайд гацуур, нарс, монос зэрэг гоёлын бут сөөг таригдаж байгаа болно. | Ногоон байгууламжийн тоо нэмэгдсэн байна. | - | | ТНААХ | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/179 дүгээр Захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллгаа эрхэлж байгаа аж ахуй нэгж байгууллага, иргэдэд гаднах орчиндоо мод тарих өмнөх онуудад тарьсан мод, бутны арчлалт хамгаалат хийх үүрэг болгосоны дагуу аж ахуй нэгж байгууллага 7620 ширхэг мод бут сөөг тарьсан байна.<br>Намрын бүх нийтийн мод тарих өдөрлөгөөр 3000 ширхэг бургас тарьж нийт 2022 онд 10620 ширхэг бургас таригдсан байна. | | | | | |
| 206 | НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.2 ДЗДҮАХ-5.2.3 | Орон сууцны хороолол доторх авто замын нөхөн сэргээлтийн ажил, гэр хороололд шинээр хатуу хучилттай зам нөхнө. | 2021 онд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 9822м2 асфальтан замын нөхөөс хийгдсэн байна. | 2022 онд 1000м2 асфальтан зам нөхсөн байна. | 500,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 50% |
| | | Дүүргийн 1-10 дугаар хорооны орон сууцны хороолол дундах эвдрэлтэй 68 байршлын 1389м2 авто замыг 152,790,000 төгрөгөөр засварлахаар тооцоо судалгаа гарган дүүргийн худалдан авах ажиллагааны албанаас цахимаар тендер зарласан боловч аж ахуйн нэгж оролцоогүй тул дахин хүсэлт гарган тендер зарлахаар бэлтгэл ажлыг хангаад байна. | | | | | |
| 207 | | Нийтийн эзэмшлийн явган замын нөхөн сэргээлтийн ажил, батлагдсан стандартын дагуу болгон өөрчлөн, шинэчлэх ажлыг хэрэгжүүлэнэ | Дүүргийн 1-20 дугаар хороонд нийт 125,290.8 м2 талбай явган зам байна. | Дүүргийн 1-20 дугаар хороонд засварлах, шинэчлэх шаардлагатай 37587.2 м2 явган замыг засварласан байна. | 563,808.00 | дүүргийн төсөв | ТНААХ | 100% |
| | | Дүүргийн засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/176 дугаар Захирамжаар нийтийн эзэмшлийн 2 байршил болох 4 дүгээр хороо Партизаны гудамжинд 100м2, 6 дугаар хороо нэгдсэн үндэстэний гудамжинд 40м2 явган замыг аж ахуй нэгж байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 9,680,000 төгрөгөөр нөхөн засварласан болно.<br>Мөн дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 9 дүгээр хороонд 2795м2 явган замыг 170,725,000 төгрөгөөр шинэчлэн засварласан.<br>Нийслэлийн замын хөгжлийн газраас тус дүүрэгт засварлах шаардлагатай 6 байршил болох Их сургуулийн гудамжны авто замын зүүн тал, МТ ХХК-ийн төв оффисийн урд, Мэдээлэл технологийн паркийн зүүн талд, Петровис ххк төв оффисийн урд, Жамьянгүны гудамж , Blue sky төвийн урд, Их сургуулийн гудамжны авто замын баруун тал, Герман элчингийн зүүн талд, ЧӨЧ KFC Монгол телевизийн авто зогсоол, МУБИС-ийн урд зам, МУИС -ийн авто бусны буудлын зүүн талд нийт 8278м2 явган замыг засварлаад байна. | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Виктор Ус ХХК дүүргийн 19 дүгээр хороо Шарга морьтын гүүрнээс гоодойн амны чиглэлд 1,6 км дугуйн замын ажлыг 1,500,000,000 төгрөгөөр гүйцэтгэж байна. | | | | | | |
| 208 | | Гэр хорооллын гудамж талбайд сайжруулсан шороон замын засвар, арчлалт хамгаалалтыг хийнэ. | Гэр хорооллын намгархаг, ус тогтдог сул шороон хөрс бүхий иргэд зорчиход хүндрэлтэй байдал үүссэн засварлах шаардлагатай 24728 метр зам байна. | Дүүргийн 11-20 дугаар хороонд 24728 у/метр сайжруулсан шороон замыг засварлаж иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 1,236,400.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |
| | | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар гэр хорооллын 6 байршилд 4398,3 у/метр сайжруулсан шороон замыг 736,198,000 төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна. Мөн гэр хорооллын засвар үйлчилгээ хийх шаардлагатай 12,13,14,15,16,17,18,19,20 дугаар хорооны 9 байршилд 11,5 км шороон замыг засварлахаар 147,210,00 төгрөгний төсөв тооцоог гарган дүүргийн худалдан авах ажиллагааны албанаас тендер зарласан боловч одоогоор байгууллага шалгараагүй, санал ирүүлээгүй тул дахин нээлттэй тендер зарлахаар бэлтгэл ажил хангагдсан.<br>Гэр хорооллын зам засвар үйлчилгээг хийхээр 1 грейдер, 1 индүү, 1 экскаватор механизм худалдан авч Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн.<br>Тус байгууллагын үндсэн дүрэмд өөрчлөлт оруулж 2023 оноос дээрх машин механизмаар зам засварын ажлыг хийлгэхээр төлөвлөгөө, судалгааг гаргаж бэлтгэл ажил хангаад байна. | | | | | | |
| 209 | НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.1 ДЗДҮАХ-5.2.4 | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн усан оргилуурын арчлалт хамгаалалт, засвар үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавина. | Дүүргийн хөрөнгөд бүртгэлтэй нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд 12 усан оргилуур байна. | 12 усан оргилуурын засвар үйлчилгээ, ашиглалтын зардлыг хариуцан байнгын ажиллагаатай болгосон байна. | 73,700.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |
| | | Нийслэлийн удирдах ажилтаны 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн шуурхай зөвлөгөөнөөр өгөгдсөн үүрэг даалгаварт дүүргийн нутаг дэвсгэрт байгаа Усан оргилуурыг 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ажиллуулах үүрэг даалгавар өгсөн.<br>Тус үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/177 дугаар Захирамжаар усан оргилуурын засвар үйлчилгээ хийх ажлыг зохион байгуулахыг үүрэг болгосон.<br>Тус Захирамжийн хүрээнд дүүргийн Засаг даргын тамгын газрын даргатай байгуулсан ажил гүйцэтгэх 86 дугаар гэрээний дагуу Повер бласт ай ти ХХК нь 1 дүгээр хороо Хорооны байрны зүүн талд, 2 дугаар хороо 26 байрны урд талд, 4 дүгээр хороо 69 байрны урд талд, 5 дугаар хороо 39-р байрны хойд талд, 6 дугаар хороо 12/2 байрны хажууд, 7 дугаар хороо 4,6 дугаар байрны дунд, 10 дугаар хороо 24 байрны урд талд, 32б байрны хажууд байрлах усан оргилуурын засвар үйлчилгээг хийж гүйцэтгэн СӨХ-д хүлээлгэн өгсөн болно. Нийт 17,908,786 төгрөгийн санхүүжилт зарцуулсан. | | | | | | |
| 210 | | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажлын арчлалт хамгаалалт, засвар үйлчилгээний | 1-20 дугаар хорооны 186 байршлын 123254.34м2 талбайн сүүдрэвч, 4505м2 хүүхдийн тоглоом, 397 ширхэг чийрэгжүүлэлтийн | Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилтын ажлын цэвэрлэгээ, үйлчилгээ хийсэн байна. | 1,029,989.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | гүйцэтгэлд хяналт тавина. | тоног төхөөрөмж 836 ширхэг сандал, 452 ширхэг хогийн сав, 17106 м2 спорт талбайн тохижилт бүтээн байгуулалтын ажлын засвар, цэвэрлэгээ үйлчилгээг хийнэ. | | | | | |
| | | Дүүргийн 1-20 дугаар хороонд Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 173 байршлын 153 ширхэг сүүдрэвч 4405 м2 хүүхдийн тоглоомын талбай, 380 чийрэгжүүлэлтийг төхөөрөмж , 801 ширхэг сандал, 425 ширхэг хогийн сав, 16786 м2 спорт талбай, засвар үйлчилгээг хийлгэхээр 12 бүс болгон аж ахуйн нэгж байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 7 хоногт 3-4 удаагийн давтамжтайгаар цэвэрлэгээ, үйлчилгээг хийлгэн гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.<br>Жилийн эцсийн байдлаар эвдрэл гэмтэл засаж будах шаардлагатай Сүүдвэрч 89, Сандал 719, Хогийн сав 402, засвар үйлчилгээг хийсэн байна. Нийт 1,029,989,000 төгрөгийн санхүүжилт зарцуулсан. | | | | | | |
| 211 | НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.1 ДЗДҮАХ-5.2.5 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд бүх нийтийн мод тарих өдрийг зохион байгуулна. | 2021 онд бүх нийтийн мод тарих өдрөөр дүүргийн хэмжээнд нийт 229 ААНБ-ын 2400 гаран иргэн 6885 ширхэг мод, 444м2 цэцэг, 4971,1м2 зүлэг ногоон байгууламж шинээр нэмэгдсэн. | Ногоон байгууламжийн тоо нэмэгдсэн байна. | 350,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |
| | | 2022 оны 04 дүгээр 15-ны өдөр Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас “Монгол генерал” ТТБ-ын санаачилгыг дэмжиж, өнөөдөр зэвсэгт хүчин, цагдаа, тагнуул, хилийн цэрэг, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас төрөн гарсан генерал цолтнууд Богд Зонхова хайрханд мод тарилаа. Ийнхүү Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд эрхэм генералууд голт бор, агч бүхий 150ш модыг тарин энд ойн төгөл байгуулсан.<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Ойн тухай хууль, хаврын бүх нийтээр мод тарих арга хэмжээг нийслэлийн хэмжээнд “Ногоон хот-Иргэний оролцоо” уриатайгаар 13 дахь жилдээ зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээний хүрээнд Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, 1-20 дугаар хорооны Засаг даргын ажлын албаны хамт олон өнгөрөгч амралтын өдрүүдэд нийтдээ 7620 ш улиас, хайлаас мод тарив. Тухайлбал, дүүргийн 14 хорооны нутаг дэвсгэрт байрлах Сэлбэ цэцэрлэгт хүрээлэнд нийслэлийн Шийдвэр гүйцэтгэх газрын алба хаагчидтай хамтран 1000ш улиас, 20 дугаар хороо, Гүнжийн булагт “Чинаагийн Галсан сан” ТББ-тай хамт 250м урт газарт 2000ш хайлаас модыг тус тус тарилаа. Мөн 1 дүгээр хороо 1, 2-р байрны дунд, 2 дугаар хорооны 31-р байрын хойд талын нийтийн эзэмшлийн талбайд ургамлан хашлага байгуулахаар 1000ш хайлаас модыг “Хашаандаа сайхан амьдаръя” ТТБ-тай хамтран тарих ажлыг зохион байгуулж ажилласан болно.<br>Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тус дүүрэг нь дүүргийн Засаг даргын албан даалгавар гарч үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, иргэн аж ахуйн нэгж байгууллага гадна орчиндоо мод бут сөөг тарих, гадна орчны ногоон байгууламжийн цэвэрлэгээ арчлалт хамгаалалт хийх талаар үүрэг өгөгдсөний дагуу 2022 онд нийт 14880 ширхэг мод , бут сөөг тарьж, 91 аж ахуйн нэгж байгууллага нийслэлийн байгаль орчны газрын төрийн санд 1,432,000 төгрөг хандивласан байна. Үүнээс: | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1. Хаврын бүх нийтээр мод тарих арга хэмжээг нийслэлийн хэмжээнд "Ногоон хот-Иргэний оролцоо" уриатайгаар 13 дахь жилдээ зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээний хүрээнд Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, 1-20 дугаар хорооны Засаг даргын ажлын албаны хамт олон өнгөрөгч амралтын өдрүүдэд нийтдээ 7620 ш улиас, хайлаас мод тарьж арчлалт хамгаалалтыг хариуцан ажиллаж байна.<br>2. Намрын улиралд гэр хорооллын айл өрхөөс хүсэлт ирүүлсэн 1096 айлд 3000 ширхэг жимс жимсгэний бут сөөг, 400 ширхэг нарс, нийт 3400 ширхэг мод олгож арчлалт хамгалаалт, тарих аргачлалыг зааж бүртгэл мэдээллийг авч мэдээллийн сан үүсгэж жил бүр хяналт тавин ажиллах талаар иргэдэд мэдээлэл өгч ажилласан болно.<br>Мөн Хашаандаа сайхан амьдарья ТББ, Чинаагийн галсан сан ТББ, Танайд мод тарья ТББ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулан дүүргийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагатай хамтран сэлбэ голын урсгалыг нэмэгдүүлэх, хамгаалах зорилгоор эрэг дагуу 3860 ширхэг бургас тарьсан байна.<br>Өмнөх онуудад тарьсан мод, бут сөөгний арчлалт хамгаалалтыг мэргэжлийн байгууллагад хариуцуулан арчилгааг тогтмол хийснээр мод тарих ажлын үр дүн, ургалтын хувь өндөр байх давуу тал болж байна. Нийт 380,000,000 төгрөгийн санхүүжилт зарцуулсан. | | | | | | |
| 212 | | Нийтийн эзэмшлийн гудамж талбайн мод бутыг хэлбэржүүлэх, шохойдож шуулт хийнэ. | Дүүргийн 1-18 дугаар хорооны 160 байршилд 2818 ширхэг мод, бут сөөгт тайралт хийх, хэлбэржүүлэх, шохойдох ажлын судалгааг боловсруулсан болно. | Нийтийн эзэмшлийн мод, бут сөөгийн ургалт сайжирсан байна. | 120,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |
| | | Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хашаан доторх нийт 1452 ш мод 1217 ш бутыг хэлбэржүүлэх ажлыг 4 багц болгон мэргэжлийн аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан болно. Нийт 150,000,000 төгрөгийн санхүүжилт зарцуулсан. | | | | | | |
| 213 | | Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалт хийнэ. | 2021 онд дүүргийн нийтийн эзэмшлийн 2428ш мод, 18500м2 орц дундын ногоон байгууламжийн усалгааг хариуцан ажилласан. | Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн ургалт сайжирсан байна. | 80,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ Хороод, СТСХ | 100% |
| | | Дүүргийн нийтийн эзэмшлийн орон сууц гэр хороолол дундах 2487ш мод бут сөөг 20850м2 орц дундын ногоон байгууламжийн усалгаа арчилгааг 3 аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан 2022.05.01-07.31 өдрийн хороонд арчилгаа тордолгоог хийлгэн гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна. Нийт 137,661,300 төгрөгийн санхүүжилт зарцуулсан. | | | | | | |
| 214 | | Рашаан булгийн эх хамгаалах гэрээт ажилтан ажиллуулна. | Дүүргийн 15, 16, 20 дугаар хороонд байрлах Зуун модны эхэн дахь Энх мөнхийн рашаан, Гүнжийн булаг, зуун модны рашааны эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалан, орчны бохирдлыг | Тохижуулсан рашаан булгийн эд хөрөнгө бүрэн бүтэн, орчин нь бохирдолгүй болсон байна. | 5,400.00 | Дүүргийн төсөв | ТНААХ Хороод, СТСХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бууруулахаар 3 байгаль хамгаалагч ажиллаж байна. | | | | | |
| | | Дүүргийн 15, 16, 20 дугаар хороонд байрлах Зуун модны эхэн дахь Энх мөнхийн рашаан, Гүнжийн булаг, зуун модны рашааны эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалан, орчны бохирдлыг бууруулахаар 3 байгаль хамгаалагч ажиллуулан сар бүр урамшуулал олгож байгаа болно. Нийт 5,400,000 төгрөгөөр цалинжуулсан. | | | | | | |
| 215 | НХТЖҮЧ-6.2.8, НЗДҮАХ-5.2.6 ДЗДҮАХ-5.2.6 | Нүхэн жорлонгоос үүдэлтэй хөрсний бохирдлыг бууруулах талаар иргэдтэй хамтран ажиллана. | НҮБ-ын Хабитат төслөөс хэрэгжүүлж буй үерийн усыг давах туулах төслийн хүрээнд дүүргийн 12, 13, 16 дугаар хороонд 60 айл өрхийн бохирын цооног, жорлон, мөн 18 дугаар хороонд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Чандмань хангай ХХК нь үер усны аюулд тогтмол өртдөг 300 өрхөд бохирын цооног, жорлонг шинэчлэн засварлах ажлыг хийж гүйцэтгэхээс 2021 онд 110 айл өрх, ирэх онд үлдсэн айл өрхийн бохирын цооногийг шинэчлэн засварлахаар он дамжин хэрэгжихээр болсон. | Гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлонг сайжруулсан байна. | 100,000.00 | | ТНААХ | 100% |
| | | Нийслэлийн байгаль орчны газартай хамтран 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр зуслангийн бүсд нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй баригдсан 110 ширхэг жорлонд албан шаардлага хүргүүлэн хугацаатай үүрэг даалгавар өгсөний дагуу 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр буулгаж жорлон буусан хэсэгт нөхөн сэргээлт ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэсэн байна.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Байгаль орчин аялал жуулчлалын яамны Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос Сэлбэ голын хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор Улс туяарах ХХК 15, 16, 17, 20 дугаар хороонд 400 айлын ариун цэврийн байгууламжийг хийж байгаа болно. | | | | | | |
| 216 | ДЗДҮАХ-5.2.8 | Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-т хог хаягдал тээвэрлэх машин механизмыг нэмэгдүүлнэ. | 2021 онд 18 машин хог тээвэрлэлт хийгдэж байна. | Орон сууцны хороолол дунд шахдаг 8 машин, задгай тэвштэй 4 | 4,200,000.00 | дүүргийн төсөв | ТНААХ ТГХШХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | машин худалдан авсан байна. | | | | |
| | | БНСУ-ын "Hyundai motor" албан ёсны дистрибьютор компаниас тусгай зориулалтын хогийн шахдаг 12 автомашиныг худалдан авахаар гэрээ байгуулж, 12 дугаар сард нийлүүлэхээр болсон. Нийт 4,096,400,000 төгрөгийн санхүүжилт зарцуулсан. | | | | | | |
| 217 | | Гудамж, талбай, автозам засварын машин механизмыг нэмэгдүүлнэ. | Нийтийн эзэмшлийн зам талбай засвар үйлчилгээг хийх автозам засварын машин механизм байхгүй байна. | Нийтийн эзэмшлийн зам засвар үйлчилгээг хийхээр 1 грейдер, 1 индүү, 1 экскаватор механизм худалдан авсан байна. | 1,300,000.00 | дүүргийн төсөв | ТНААХ | 100% |
| | | Нийтийн эзэмшлийн зам засвар үйлчилгээг хийхээр 1 грейдер, 1 индүү, 1 экскаватор механизм худалдан авч Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгөөд байна. /Гэрээ байгуулсан дүн 1,291,019,000 / | | | | | | |
| 218 | | Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын гараашийг өргөтгөн багтаамжийг нэмэгдүүлнэ. | 2021 онд автобаазад 3 тээврийн хэрэгсэл байрлуулж, засвар үйлчилгээг зохион байгуулсан. | Хог тээврийн машин механизмын засвар үйлчилгээ хийх, хог тээвэрлэх рейсийн тоо нэмэгдэх, гүйцэтгэл чанаржсан байна. | 460,249.00 | дүүргийн төсөв | ТНААХ Сүхбаатар Дэвшил менежмент ААТҮГ | 100% |
| | | Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын конторын болон автогаражын зориулалттай барилгуудад барилгын хана, хучилтын болон бусад даацын бүтээцүүдийн болон барилгын оношлогоо, лабораторийн шинжилгээг ШУТИС-ийн харьяа Ре констракшн төвөөр дүгнэлт гаргуулахад хөрсний бүтэц, хана шаардлага хангахгүй дүгнэлт гарсан тул тус ажил хэрэгжээгүй болно. | | | | | | |
| 219 | | Сүхбаатар Дэвшил менежмент ААТҮГ-ын автобазын орчин нөхцөлийг сайжруулж, засвар үйлчилгээ хийнэ. | Барилгын суулт өгсөн, хананыг хучиттэх шаардлагатай. | Орчин нөхцөл сайжирсан байна. | 100,000.00 | дүүргийн төсөв | ТНААХ Сүхбаатар Дэвшил менежмент ААТҮ | 100% |
| | | Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-ын конторын болон автогаражын зориулалттай барилгуудад барилгын хана, хучилтын болон бусад даацын бүтээцүүдийн болон барилгын оношлогоо, лабораторийн шинжилгээг ШУТИС-ийн харьяа Ре констракшн төвөөр дүгнэлт гаргуулахад хөрсний бүтэц, хана шаардлага хангахгүй дүгнэлт гарсан тул тус ажил хэрэгжээгүй болно. | | | | | | |
| 220 | | Сүхбаатар Дэвшил ОНӨААТҮГ-т машин механизмын зогсоол, засвар үйлчилгээний өргөтгөл барина. | 2021 онд 25 автомашин багтаамжтай. | 12 автомашины зогсоолоор нэмэгдүүлсэн байна. | 1,000,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ Сүхбаатар Дэвшил менежмент ААТҮ | 100% |
| | | Авто баазыг өргөтгөх ажлыг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Нэкст стандарт ХХК түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр хийж гүйцэтгэн ажиллаж байна. /Гэрээ байгуулсан дүн 999,952,800 / | | | | | | |
| 221 | | Дэвшил менежмент ААТҮГ байгууллагын | Хөдөлмөрийн нөхцөл сайжруулах ажлыг үе | Хөдөлмөрийн аюулгүй байдал, | 10,000.00 | Дотоод нөөц | ТНААХ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | гадна орчны тохижилт хийх, ногоон байгууламж бий болгоно. | шаттай зохион байгуулж байна. | эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангаан, тохижуулах ажлыг гүйцэтгэсэн байна. | | | Сүхбаатар Дэвшил менежмент ААТҮ | |
| | | Байгууллагын гадна тохижилт, эрүүл ахуй, орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор: Чацаргана 44ш, хайлаас 78ш, улиас 20ш, цээнэ 12ш, Гоёлын наранцэцэг 100 ширхэгийг тарьж ургуулсан болно. | | | | | | |
| 222 | НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.2 ДЗДҮАХ-5.2.9 | Авто зогсоол, ногоон байгууламж, сул шороон хучилт, явган хүний зам, гүүр, шат, худаг усан сан барина. | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд тохижилт бүтээн байгуулалтын 64 төсөл хэрэгжүүлсэн. | Иргэдээс ирсэн саналын дагуу жил бүр хороодод үе шаттайгаар хэрэгжүүлсэн байна. | 200,000.00 | Улс, Нийслэл, Дүүргийн төсөв | ТГХШХ | 100% |
| | | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2, 10,16 дугаар хороодод авто зогсоол, 16-р хороонд гүүр, ус зайлуулах, 18-р хороонд явган хүний гүүр, 9 дүгээр хороонд 2795.1м2 явган зам, 7-р хороонд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохижилтын нийт 1 тэрбум төгрөгийн төсөвтэй 7 төсөл хэрэгжүүлсэн. | | | | | | |
| 223 | НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.2 ДЗДҮАХ-5.2.10 | Угсармал орон сууцны байрнуудын дулааны алдагдлыг бууруулах зорилгоор дээврийн болон фасад засварлах, дулаалах ажлыг хийнэ. | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт болон Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 12 орон сууцны дээвэр, фасадын засварын ажлыг 940 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн. | Иргэдээс ирсэн саналын дагуу жил бүр хороодод үе шаттайгаар хэрэгжүүлсэн байна. | 200,000.00 | Улс, Нийслэл, Дүүргийн төсөв | ТГХШХ | 100% |
| | | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3-р хорооны УС11, 40, 6-р хорооны 36, 7-р хорооны 40 байрны нийт 2516.4м2 дээвэр, 8-р хорооны 32-р байрны 1233м2 фасад засварлах засварын ажлыг 359.7 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн. | | | | | | |
| 224 | НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.2 ДЗДҮАХ-5.2.11 | Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан шинээр тавих авто замын зураг, төсөл хийнэ. | Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөг үндэслэнэ | Зураг, төсөл хийлгэсэн байна. | 50,000.00 | Улс, Нийслэл, Дүүргийн төсөв | ТГХШХ | 100% |
| | | "15-р хороо, Дамбадаржаа 81-р гудамжнаас доод салхит 11-р гудамж хүртэл гүүрний ажлын зураг төсөл боловсруулах" Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын 2022.02.25-ны өдрийн БХБХ2022/01-039 дугаартай даалгаврыг тус тус батлуулж, Худалдан авах ажиллагааны алба руу зөвлөх үйлчилгээний тендер зарлуулахаар захиалгыг хүргүүлсэн. Тус зураг төслийн ажлыг Ангад аривжих ХХК гүйцэтгэж гэрээний хугацаанд хүлээлгэн өгсөн. | | | | | | |
| 225 | | Нийтийн эзэмшил, орон сууцны хороолол дундах ногоон байгууламжийн арчлалт хамгаалалт хийхэд Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-т | ногоон байгууламж хэлбэржүүлэх, засах багаж тоног төхөөрөмж байхгүй байна. | ногоон байгууламжийн арчилгаа цэвэрлэгээ хэлбэржүүлэлт, тайралт хийх багаж | 30,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | багаж тоног төхөөрөмжөөр хангана. | | тоног төхөөрөмжтэй болсон байна. | | | | |
| | | Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-т ногоон байгууламжийн алба шинээр байгуулагдаагүй байсан тул ногоон байгууламжийн арчилгаа, цэвэрлэгээ хэлбэржүүлэлт тайралт хийх ажлыг 2023 оноос байгууллагын үндсэн дүрэмд өөрчлөлт оруулснаар хэрэгжих боломжтой байна. Мөн цахилгаан хадуур-8ш, гар хадуур 42 ш, хайч 14 ш, тармуур 30ш, савар-10ш зэрэг багаж хэрэгслийг ОНӨААТҮГ-т авч ажиллаж байна | | | | | | |
| 226 | | Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байрлах байгууламж /хогийн сав, хөшөө, хайс хашаа г.м/, авто болон явган замын засвар үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэнэ. | Нийтийн эзэмшлийн 3192м хайс хашаа, 28 хогийн сав, 26 сандал, 299 шон, 161 тэмдэг тэмдэглэгээ, 5 автобусны шилэн буудлыг угааж цэвэрлэсэн. | Орчны өнгө үзэмж сайжирна. | 4,900.00 | Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ | ТНААХ Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн "Түүх соёлын үл хөдлөх хөшөө, баримал, дурсгалт газруудын арчлалт хамгаалалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" А/128 тоот захирамжийн дагуу 2022 оны 04 дүгээр сарын 17,18-ны өдрүүдэд Сүхбаатар дүүргийн 1,2,4,6,8,15 дугаар хороодын нутаг дэвсгэрт байрлах 31-н түүх соёлын үл хөдлөх хөшөө баримал дурсгалын газруудыг угааж арчин, өнгө үзэмжийг сайжруулан ажилласан.<br>Хариуцсан бүсийн 14 хорооны нийтийн эзэмшлийн 3192м хайс хашаа, 28 хогийн сав, 30 сандал, 252 шон, 121 тэмдэг тэмдэглэгээ, 1 хөшөө, 5 автобусны шилэн буудлыг хуваарийн дагуу 14 хоног тутамд угааж цэвэрлэсэн. | | | | | | |
| 5.3 Агаарын бохирдлыг бууруулж, хог хаягдлын менежментийг сайжруулна. | | | | | | | | |
| 227 | | Сайжруулсан түлшний хэрэглээнд хяналт тавьж, борлуулалтын цэгийн тоог нэмэгдүүлэх талаар дэмжиж, хяналт тавьж ажиллана. | Дүүргийн хэмжээнд 9-11-20 дугаар хороонд нийт 58 борлуулалтын цэг сайжруулсан шахмал түлшийг иргэдэд худалдаалж байна. | Сайжруулсан түлшний борлуулалтын цэг, дундын бөөний цэгийг нэмэгдүүлсэн байна. | - | | ТНААХ | 100% |
| | | 1 дүгээр улиралд сайжруулсан түлш иргэдэд худалдаж борлуулах 75 цэг гэр хороололд ажиллаж иргэдэд сайжруулсан түлш борлуулсан болно.<br>2022-2023 оны өвлийн улиралд дүүргийн хэмжээнд 63 цэг ажиллахаас 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар 61 цэг ажиллаж байна.<br>Гэр хорооллын 4 агуулахад 11797,5тн сайжруулсан түлш нөөцлөөд байна. | | | | | | |
| 228 | | Агаарын бохирдлыг бууруулах, утаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэхийн тулд иргэн, хуулийн этгээдэд сургалт зохион байгуулж, зөвлөмж, сэрэмжлүүлэг хүргүүлэн ажиллана. | 2020 онд гэр хорооллын айл өрхүүдэд 4 удаа заавар зөвлөмж хүргүүлэн ажилласан. | Гэр хорооллын айл өрхүүдэд утаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж брошюр тарааж мэдээллээр хангасан байна. | 10,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах арга хэмжээний тухай А/346 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 3 дугаар хуралдааны тэмдэглэл, дүүргийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/122 дугаар захирамжийн "Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх арга хэмжээ 2-р заалтын хүрээнд 2022 оны 4 дүгээр сарын 26-нд харъяа хэлтэс газруудад зөвлөмж хуудсыг тарааж өгсөн. 2022 оны 04 дүгээр сарын 27, 28 ны өдрүүдэд 13 хэлтэс, 11 хорооны хэсгийн ахлагч, олон нийтийн цагдаа, мэргэжилтэн албан хаагчид бүрэн бүрэлдэхүүнээр 10:00-19:00 цагийн хооронд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлгийг сайжруулсан түлш хэрэглэдэг айл өрхөд тараах ажлыг хийж гүйцэтгэлээ.<br>Уг ажлын зорилго нь угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах, дүүргийн төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, арга хэмжээг зохион байгуулахад чиглэн ажилласан байна.<br>2022 оны 04 дүгээр сарын 27, 28-ны өдрүүдэд айл өрхөд зөвлөмж хуудас тараах талаар хэлтэс, хороодод зөвлөмж зааварчилгааг өгч ажиллаа. Нийт 13000 ширхэг зөвлөмж хуудас тараасан байна.<br>Угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллах ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/369 дүгээр захирамжаар байгуулагдан төлөвлөгөөний дагуу ажил гүйцэтгэж байна.<br>дүүргийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/369 дүгээр захирамжаар иргэдийн угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулан ажиллаж байна.<br>Таванатолгой түлш ХХК-ны Хэрэглэгчдэд үйлчилэх албатай хамтран гэр хорооллын хэсгийн ахлагч, олон нийтийн байцаагч нарт 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр сайжруулсан түлшний хэрэглээ, угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх төхөөрөмжийн засвар үйлчилгээ, хэрэглээнд хэрхэн хяналт тавих заавар арга зүйн сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн. Мөн 10 дугаар сарын 29-ны өдөр дүүргийн жижиг дунд үйлдвэрлэлийн төвтэй хамтран агаар, орчны бохирдлыг бууруулах ногоон технологи-2022 үзэсгэлэнг зохион байгуулж байгаль орчинд ээлтэй технологи, инновац нэвтрүүлсэн 10 гаруй аж ахуйн нэгж байгууллага хамтран ажиллаж зохион байгуулсан. | | | | | | |
| 229 | НХТЖҮЧ-6.2.8, НЗДҮАХ-5.2.6 ДЗДҮАХ-5.3.2 | Дүүргийн суурьшлын бүсийн хөрсний эрүүл ахуйн нөхцөл шаардлагад хяналт шинжилгээ хийж, дүгнэлт өгнө. | Хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 100% хэрэгжүүлнэ. | Эрсдэл буурсан байна. Эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд сурталчилсан байна. | 500.00 | Дүүргийн төсөв | МХХ ХХҮХ | 100% |
| | | МХЕГ-ын тэргүүн дэд даргын баталсан 01/15 дугаартай удирдамжийн дагуу 05, 09 дүгээр сард тус дүүргийн суурьшлын бүсийн 21 цэгээс 42 сорьц авч, шинжлүүлэхэд лабораторит шинжлүүлэн "Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм хэмжээ" MNS 3297-91 стандарттай харьцуулахад периферингс титрийн үзүүлэлтээр нийт сорьцын 60-72.6 хувь нь цэвэр болон бага, 27.4 - 40 хувь нь дунд бохирдолттой байна. | | | | | | |
| 230 | НХТЖҮЧ-6.1.1, НЗДҮАХ-5.3.1 ДЗДҮАХ-5.3.3 | Дүүргийн усан хангамжийн эх үүсвэр буюу гүний худаг, ус түгээх байр, төвлөрсөн усан хангамжийн цэгүүдэд шинжилгээ хийж дүгнэлт гаргана. | Удирдамжийн хүрээнд 4 шугамын худаг, 12 хэрэглэгчийн цэгээс дээж, сорьц авч, НМХГ-ын төв лабораторид шинжилгээнд хамруулсан. | Ундны усны эх үүсвэрийн хамгаалалт сайжирч, баталгаат байдал хангагдсан байна. | 500.00 | Дүүргийн төсөв | МХХ ХХҮХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | МХЕГ-ын тэргүүн дэд даргын баталсан 01/17 дугаартай удирдамжийн хүрээнд Сүхбаатар дүүргийн нутагт үйл ажиллагаа явуулж буй УСУГ-ын харъяа Зөөврийн ус түгээх албаны гэр хорооллын зөөврийн ус түгээх цэг 6, шугамын худаг, гүний худаг 33, төвлөрсөн усан хангамжийн 19 хэрэглэгчийн цэгийн унд ахуйн усны чанар найрлагын байдалд хяналт шинжилгээг удирдамжийн дагуу хийлээ. Шинжилгээ, сорилын дүнгээр нийт 225 сорьц авч, нян судлал, химийн шинжилгээ хийлгэхэд 98.3 хувь нь "Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ" MNS 0900:2018 стандартын шаардлага хангасан байна. ОХУ-ын ЭСЯ-ны хэрэглэгчийн цэг, Санзай, Мөнх оргилын гүний худгийн ББЕТ, иргэн н.Ганбаатарын барилгын ундны усны төмрийн хэмжээ дээрх стандартаас их гарч, давтан шинжилгээгээр 3 сорьц шаардлага хангасан байна. Улсын байцаагчийн 18 дүгнэлт давтан шинжилгээ нянгийн бохирдолттой гарсан Санзай амралтын газар албан шаардлагаар үүрэг өгч, биелэлтийг тооцон ажиллаж байна.<br>2022 онд орон сууцны байруудын 148 айл өрх, 65 аж ахуйн нэгж байгууллагад нийт 598 ширхэг усны тоолуур шинээр суурилуулж, хэрэгцээний халуун, хүйтэн усны ф15мм-ф80мм хүртэлх хэмжээтэй 340 уртаас метр шугам шинэчлэн сольсон. 1-5 хорооны айл өрх, аж ахуйн нэгжийг тоолууржуулах ажил явагдаж нийт 57% ажиллаж байна. Аж ахуйн нэгж, байгууллагуудыг үйл ажиллагааны чиглэлээс нь хамааруулж ресторан, цайны газруудад албан бичиг хүргүүлэн шинээр элс, тос баригч суурилуулан ажиллаж байна. | | | | | | |
| 231 | НХТЖҮЧ-6.3.1, НЗДҮАХ-5.3.5 ДЗДҮАХ-5.3.4 | Байгаль орчин, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна. | Төлөвлөгөөт хяналт шалгалт 100% хэрэгжилттэй зохион байгуулагдсан байна. | Хууль бус үйлдлийг таслан зогсоож урьдчилан сэргийлсэн байна. | 500.00 | Дүүргийн төсөв | МХХ ХХҮХ | 100% |
| | | Хяналт шалгалтаар 43 иргэнийг хамруулан 38 тарвага, 2 чоно, 5ш загасыг гарал үүслийн бичиг, дагалдах тодорхойлолтгүй худалдан авсан, агнуурын бүс нутгаас бусад газарт амьтныг тээвэрлэсэн, ойн сан бүхий газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан, 10ш тогос шувууг зөвшөөрөлгүйгээр өсгөн үржүүлж нутагшуулсан зөрчилд 18,810,000 төгрөгийн шийтгэл, 21,827,800 төгрөгийн нөхөн төлбөр ногдуулан зөрчлийг арилгуулан ажиллалаа. | | | | | | |
| 232 | НХТЖҮЧ-6.2.1, НЗДҮАХ-5.2.1 .ДЗДҮАХ-5.3.6 | Агаарын чанарыг сайжруулах бүсэд агаар бохирдуулагч эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэн, ААНБ-д хяналт шалгалт хийж, бүсийн дэглэм мөрдүүлнэ. | Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бүрдүүлдэг бүдүүн ширхэглэгт тоосонцрын хэмжээг 50% бууруулсан. | Агаарын бохирдол буурсан байна. | 500.00 | Дүүргийн төсөв | МХХ | 100% |
| | | МХЕГ-ын даргын баталсан "Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд зөвшөөрөлгүй түүхий нүүрс түлж байгаа эсэхэд урьдчилан сэргийлэх хяналт хийх тухай" 01/04 дугаартай удирдамжийн хүрээнд СБД-ийн 9-20 дугаар хорооны 6940 айл өрх, 272 аж ахуйн нэгжийн түлшний хэрэглээ, түүхий нүүрс түлж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж ажиллалаа. Мөн иргэдэд зуух, пийшингийн аюулгүй байдлыг хангах, яндан хөөлөх, угаар мэдрэгчийн зайг солих, гэртээ агааржуулалт хийх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. Хяналт шалгалтын хүрээнд 6940 өрх, 272 аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг хавсралт хүснэгтээр гаргаж, зуухны төрөл, хэрэглэж буй түлш, угаар мэдрэгчийг зурагжуулан, энэ талаар санал хүсэлтийг сонсож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.<br>СБД-ийн 19 дүгээр хорооны 400 айл өрхүүдэд угаарын хийн хордлогоос сэргийлэх тухай зөвлөмж, сэрэмжлүүлэг тарааж ажилласан. | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 233 | НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.1 ДЗДҮАХ-5.3.5 | Нийтийн эзэмшлийн авто замын халтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлнэ. | Нийтийн эзэмшлийн 522071.7 м2 зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан ажиллаж байна. | Нийтийн эзэмшлийн 522071.7 м2 зам талбай халтиргаа гулгаа үүсэхээс урьдчилан сэргийлсэн байна. | 270,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |
| | | Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн халтиргаа, гулгаанаас урьдчилан сэргийлэхийн тулд 342,5 тн давс, 71 тн тусгай бодис нөөцлөн бэлтгэл ажлыг хангасан болно. Нийт 529,895,000 төгрөг зарцуулсан. | | | | | | |
| 234 | | Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ хийнэ. | Нийтийн эзэмшлийн 152 байршлын 522071.7м2 зам талбай цэвэрлэгээг хариуцан ажиллаж байна. | Нийтийн эзэмшлийн 152 байршлын 522071.7м2 зам талбай цэвэрлэгээг хийсэн байна. | 1,096,815.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |
| | | Нийтийн эзэмшлийн 152 байршлын 522071,7м2 зам талбайн цэвэрлэгээг хариуцан 4-20 дугаар хороог Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ-т, 1-3 дугаар хороог Сүхбаатар тохижилт ХХК долоо хоногт 4-5 удаагийн давтамжтайгаар цэвэрлэгээ үйлчилгээг хийж байна. Нийт 1,019,780,280 төгрөгийн санхүүжилт зарцуулсан. | | | | | | |
| 235 | | Зориулалтын бус газар хог хаядаг иргэн, аж ахуйн нэгжийг илрүүлж, хуулийн дагуу хариуцлага ногдуулах ажлыг зохион байгуулна. | 2021 онд зориулалтын бус газар хог хаясан 41 зөрчил илрүүлж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн болно. | Орчны бохирдол буурсан байна. | - | | ТНААХ | 100% |
| | | Нийт зориулалтын бус газар хог хаясан 12, авто машины гэмтэл, хулгай, танхайн хэрэгтэй холбогдуулан 6 зөрчил илрүүлж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Мөн хог тээвэрлэгч байгууллагын хог тээвэрлэлтийг хуваарийн дагуу хийгдэж буй эсэхэд хяналт тавин зориулалтын бус үүсмэл хогийн цэг үүсдэг 3 байршилд хог тээвэрлэгч байгууллагатай хамтран мэдээлийн самбар байршуулаад байна. | | | | | | |
| 236 | | Их цэвэрлэгээ зохион байгуулна. | 2021 онд дүүргийн нутаг дэвсгэрт 6 удаагийн цэвэрлэгээ зохион байгуулсан. | 8 удаагийн их цэвэрлэгээ зохион байгуулсан байна. | 200,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |
| | | 2022 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр, 3 дугаар сарын 19, 04 дүгээр сарын 23, 07 дугаар сарын 02-ны өдрүүдэд нийт 4 удаагийн их цэвэрлэгээний ажил явагдаж давхардсан тоогоор 5824 аж ахуй нэгж байгууллага, 30140 иргэн оролцож, нийт 1144,5 тонн хог хаягдлыг цэвэрлэж тээвэрлэсэн. Нийт 56,877,000 төгрөгийн санхүүжилт зарцуулсан. | | | | | | |
| 237 | | Хог хаягдлын үйлчилгээг сайжруулж, хог тээврийн нарийвчилсан хуваарь гаргаж мөрдүүлэх, хог хаягдлын үйлчилгээний орлогыг нэмэгдүүлж алдагдлыг багасгана. | Дүүргийн нутаг дэвсгэрийн ахуйн хог хаягдлыг тээвэрлэх ажлыг хог тээврийн аж ахуй нэгж байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлж | Хог хаягдлыг хуваарийн дагуу тээвэрлүүлж, ил задгай хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлсэн байна. | 822,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажлын гүйцэтгэлээр санхүүжилт олгож байна. | | | | | |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрийн ахуйн хог хаягдлыг тээвэрлэдэг Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар тохижилт ХХК, Сүхбаатар дэвшил менежмент ОНӨААТҮГ –н хог хаягдлын нарийвчилсан хуваарийг дүүргийн Засаг даргын орлогчоор батлуулан хороодын Ажлын албанд хүргүүлж, хог хаягдлын тээвэрлэлтэнд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Нийт 1,019,769,840 төгрөгийн санхүүжилт зарцуулсан. | | | | | | |
| 238 | | 1-20 дугаар хороонд Тохижилт, хог хаягдлын олон нийтийн 20 байцаагч ажиллуулна. | 2021 онд 1-20 дугаар хороонд 20 хог хаягдлын олон нийтийн байцаагчтай хөлсөөр ажиллах гэрээ байгуулж ажилласан. | Хог хаягдлын үйлчилгээ сайжирсан байна. | 180,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |
| | | Дүүргийн нутаг дэвсгэрийн хог хаягдлын хяналтын сайжруулах зорилгоор 1-20 дугаар хороонд Хог хаягдлын олон нийтийн байцаагч нарыг сар бүр 750,000 төгрөгийн цалинтай ажиллуулж байна. Нийт 180,000,000 төгрөгийн санхүүжилт зарцуулсан. | | | | | | |
| 239 | | Хороодод зам талбай цэвэрлэх иргэдийн бүлэг ажиллуулна. | 2021 онд 1-20 дугаар хороонд 40 иргэдтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулж ажилласан. | Зам талбайн хог хаягдал багассан байна. | 254,400.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |
| | | Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/11 дүгээр захирамжаар 2022 оны 01 дүгээр сараас хороо тус бүр дээр 2 иргэдийн бүлгийн ажилчид сар бүр урамшуулал авч хорооны нутаг дэвсгэрийн ил задгай түүвэр хог хаягдлыг цэвэрлэн ажиллаж байгаа болно. Нийт 254,400,000 төгрөгийн санхүүжилт зарцуулсан. | | | | | | |
| 240 | | Олон нийтийн байцаагч нарын чадавхжуулах сургалт зохион байгуулна. | 2021 онд 1-20 дугаар хороонд 20 хог хаягдлын олон нийтийн байцаагчдыг хамруулсан 2 удаагийн сургалт зохион байгуулсан | Тохижилт, хог хаягдлын олон нийтийн байцаагч чадваржсан байна. | 19,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |
| | | 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсээс хог хаягдлын олон нийтийн байцаагч нартай уулзалт зохион байгууллаа.<br>Энэ удаагийн уулзалтад хотын хөгжлийг дэмжих Шинэ тосгон холбоо ТББ, Сүбаатар дэвшил ОНӨААТҮГ-ын тээвэрлэлтийн албаны дарга Б.Билгүүтэй, диспичер н.Даваадулам , Сүхбаатар менежмент ААТҮГ-ын захирал Г. Ганхуяг, Сүхбаатар тохижилт ХХК-ны мэргэжилтэн М. Оюунзаяа, Мэргэжлийн хяналтын байцаагч О. Цэндхүү нар оролцлоо.<br>Уулзалтаар Улаанбаатар хотын түүхт 383 жилийн ойг угтан дүүргийн нутаг дэвсгэр, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах, хог тээвэрлэлтийг хурдасгах, аж ахуйн нэгжүүдэд орчныхоо 50 м хүртэлх талбайн газрын ашиглалт цэвэрлэгээ үйлчилгээг хэрхэн хариуцаж ажиллах, олон нийтийн байцаагчийн төлөвлөгөө, тайлан гаргах зэрэг сургалт, уулзалт хийсэн. | | | | | | |
| 241 | | Шарилжгүй Улаанбаатар аян үргэлжлүүлнэ. | 2021 онд нийтийн эзэмшлийн 32500м2 хөл газрын ургамал цэвэрлэсэн. | Хөл газрын ургамал цэвэрлэгдсэн байна. | 50,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | "Шарилжгүй Улаанбаатар" аяны хүрээнд "Сүхбаатар Дэвшил" ОНӨААТҮГ-ын Тохижилт үйлчилгээний албаны 55, "Сүхбаатар тохижилт" ХХК-ны 10 зам талбайн үйлчлэгчид өөрсдийн хариуцсан талбайн шарилж луулийг цэвэрлэж ажилласан.<br>1 дүгээр хороо 3200м2 2,8тн, 2 дугаар хороо 2800м2 1,5тн, 3 дугаар хороо 300м2 2,5тн, 14 дүгээр хороо 7500м2 11,4тн, 15 дугаар хороо 82000 м2 7тн, 17 дугаар хороо 120000м2 30тн, Санзайн зуслангийн нийтийн эзэмшлийн зам дагуух нийт 81300 м2 талбайн 26,5тн,Сэлх гудамж 42100м2 талбайн 10,5тн, Сэлх зуслан 7500м2 талбайн 1,8тн, Бэлх зуслан 58900м2 талбайн 14,9тн,Тоосгоны үйлдвэр 12600м2 талбайн 2,5тн, Шарга морьт 44100м2 талбайн 11,8тн, Гоодой зуслан 36000м2 талбайн14,2тн, Баянбулаг зуслан 7200м2 талбайн 2тн, СБД-ийн Спорт цогцолбор 9000м2 талбайн 2,3тн мөн 4-11-р хорооны байшин хороолол дундах нийтийн эзэмшлийн 68060м2 талбайн 33,7тн хөл газрын ургамлыг цахилгаан хадуур-8ш, гар хадуур 42 ш, хайч 14 ш, тармуур 30ш, савар-10ш багаж ашиглан хадаж, хайчилж цэвэрлэсэн.<br>Нийт гарсан хог хаягдал шарилж луулийг цаг тухайд нь ачуулж Цагаан даваан нэгдсэн хогийн цэгт буулгасан. Нийт 779260м2 талбайн 280,4тн хөл газрын ургамал шарилж луулийг ачуулсан. | | | | | | |
| 242 | | Хогийн сав байршуулна. | 2020 онд 28ш, хогийн сав байршуулсан байна. | 10 Сургууль, 17 цэцэрлэгт хогийн сав байршуулсан байна. | 170,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ ТГХШХ, СТСХ | 100% |
| | | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1-20 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд 256ширхэг сандал 150ш хогийн сав байршуулсан болно. Нийт 170,000,000 төгрөгийн санхүүжилт зарцуулсан. | | | | | | |
| 243 | НХТЖҮЧ-9.4.1, 9.4.2, 9.4.3, 9.4.4, 9.4.5, 9.4.6, ЗДҮАХ-6.1.4, ЗДҮАХ-6.1.7 | Шар ус болон үерийн ус зайлуулах шугам сүлжээний урсгал засварын ажлыг хэрэгжүүлнэ. | Шаардлагатай байршилд ус зайлуулах хоолой суурилуулах, суваг шуудуу ухах, сэргээн засварлах ажлыг зохион байгуулсан байна. | 12-18 дугаар хороодод ус зайлуулах хоолой тавих, суваг шуудуу сэргээж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 370,000.00 | Дүүргийн төсөв | ТНААХ | 100% |
| | | Дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрээр урсдаг голын голдирол халианы усаар дүүрч хамгаалалтын даланг дүүргэн орчны 132 айл өрхийг усанд автуулах эрсдэлтэй байдал үүссэн тул дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Дүүргийн 18, 20 дугаар хорооны айл өрхийг халиа дошин, шар усны үерээс урьдчилан сэргийлэх тухай А/41, А42 дугаар захирамж гарч, захирамжийн биелэлтийг хангах ажлын хүрээнд 2022 оны 02 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд 1200 метр голын голдирлыг техник ажиллуулан сэргээж ухах ажлыг зохион байгуулаад байна. | | | | | | |
| **ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| 6.1. Газар зохион байгуулалтын ажлуудыг эрчимжүүлнэ. | | | | | | | | |
| 244 | НХТЖҮЧ-9.1.1, 9.1.2, 9.1.3, НЗДҮАХ-6.1.1 ДЗДҮАХ-6.1.1 | Дүүргийн гэр хороолол, зуслангийн бүсэд өмчлүүлэх боломжтой нэгж талбарын судалгааг гарган, "Зуслангийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө"-ний дагуу дүүргийн хэмжээнд газар өмчлүүлэх ажлыг | 291 иргэнд газрыг нь өмчлүүлж өгөхөөр 2021 оны ГЗБТ-нд тусгасан. | Иргэдийн хувийн өмч нэмэгдсэн байна. | - | | ГЗБА НГЗБА, ГӨХ, | 54% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эрчимжүүлэх, иргэдэд зөвлөгөө мэдээллийг шуурхай хүргэх, өмчлөх боломжтой иргэдийн хүсэлтийг авч холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулна. | | | | | | |
| | | Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 11/33 дугаар тогтоолоор, "Нийслэлийн 2022 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө" -ний 2-р бүлэг Газар зохион байгуулалтын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний 2,1-д Өмчлүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээг тогтоосон. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор нийслэлийн иргэдэд 2022 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил зориулалтыг баталснаас Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт 729 нэгж талбарын 40,29 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлөлүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнээс Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны газар өмчлөлийн ажлын хэсгийн 4 удаагийн хурлаар газар өмчлүүлэх тухай хүсэлт ирүүлсэн нийт 400 иргэний газар өмчлөх тухай хүсэлтийг шийдвэрлэж үлдсэн 329 иргэдийн хүсэлтийг хүлээж авахаар газар өмчлөлийн ажлыг эрчимжүүлэх аяны хүрээнд хороод дээр ажиллахаар төлөвлөн ажиллаж байна. | | | | | | |
| 245 | НХТЖҮЧ-9.4.1, 9.4.2, 9.4.3, 9.4.4, 9.4.5, 9.4.6, НЗДҮАХ-6.1.4 ДЗДҮАХ-6.1.3 | Тохижилт бүтээн байгуулалт хийх ажлын байршлуудыг Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд саналыг боловсруулан хүргүүлнэ. | Дүүргийн Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын саналыг Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар хүргүүлдэг. | Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах саналыг боловсруулан хүргүүлсэн байна. | - | | ТГХШХ | 100% |
| | | Нийслэлийн 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах 56 төсөл арга хэмжээний саналыг 2022 оны 10-р сарын 14-ны 6/1835, 2022 оны 10-р сарын 24-ны 6/1892 тоот албан бичгүүдээр саналыг хүргүүлж ажилласан. | | | | | | |
| 246 | | Гэр хорооллын мухар гудамж, зуслангийн орц, гарц, орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам талбайн газрын зөрчлийг арилгаж, түргэн тусламж, гал унтраах аврах ажиллагааг саадгүй нэвтрэх боломжийг бүрдүүлнэ. | 2021 онд 52 байршилд 122 төрлийн газрын зөрчил арилгасан. | Зуслангийн бусийн орц гарцыг нээх түргэн тусламж, гал унтраах, аврах ажиллагааг шуурхай хүргэх, нэвтрэх чадварыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. | 40,000.00 | Дүүргийн төсөв | ГЗБА НГЗБА, ДЗДТГ | 100% |
| | | Тус дүүргийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ханган газар ашиглалтыг сайжруулах, нийтийн эзэмшлийн зам, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, бусдын орц, гарцыг хаасан 68 байршил, дүүргийн 15, 16 дугаар хорооны | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нутаг дэвсгэрт гэр хорооллын мухар гудамжний 6 байршил, дүүргийн Засаг даргын 2022 оны А/312 дугаар захирамжийн хүрээнд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ханган газар ашиглалтыг сайжруулах, явган хүний зам талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, зөрчил арилгах, тохижилт бүтээн байгуулалтын ажлын талбай чөлөөлөх, иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлж буй өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, орчны аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн эзэмшлийн зам, талбайд зөвшөөрөлгүй байрлуулсан болон тохижилт бүтээн байгуулалтын талбай дахь түргэн үйлчилгээний цэгүүдийг нүүлгэж, нийтийн эзэмшлийн зам талбайн газар чөлөөлсөн. | | | | | | |
| 247 | | Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилтай холбоотой Улаан шугам, цэг тэмдэгт тогтоох, Газрын кадастр, Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх ажлуудыг хийнэ. | Барилга байгууламж, бүтээн байгуулалтын ажлууд дээр Улаан шугам, цэг тэмдэгт тогтоох, газрын кадастр, төлөв байдал,чанарын хянан баталгаа, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн. | Дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдэх бүтээн байгуулалтын ажлыг бүртгэлжүүлнэ | 50,000.00 | Дүүргийн төсөв | ТГХШХ | 100% |
| | | 14 дүгээр хорооны 1461703653 нэгж талбарын дугаартай цогцолбор газарт Газрын кадастр, Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 6-р сарын 20-ны А/830 тоот захирамжаар газар эзэмших захирамж Дүүргийн Засаг даргын Тамгын газарт эзэмшүүлэхээр гарсан. | | | | | | |
| 248 | | Дүүргийн нутаг дэвсгэр дэх нийтийн эдэлбэрийн газар, гудамж, зам талбайд зөвшөөрөлгүйгээр явган хүний зам хааж байрлуулсан гарааш, объектууд, эзэмшил, ашиглалтад байгаа газраа дур мэдэн нэмж хашсан хашаа зэргийг албадан буулгах, нүүлгэн шилжүүлж газрыг чөлөөлнө. | 2021 онд 10 байршилд 67 гарааш буулгаж газар чөлөөлсөн. | 2022 онд 494 гарааш буулгаж газар чөлөөлсөн байна. | 400,000.00 | Дүүргийн төсөв | ГЗБА | 100% |
| | | Тус дүүргийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ханган газар ашиглалтыг сайжруулах, нийтийн эзэмшлийн зам, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, бусдын орц, гарцыг хаасан 68 байршил, дүүргийн 15, 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт гэр хорооллын мухар гудамжний 6 байршил, дүүргийн Засаг даргын 2022 оны А/312 дугаар захирамжийн хүрээнд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ханган газар ашиглалтыг сайжруулах, явган хүний зам талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, зөрчил арилгах, тохижилт бүтээн байгуулалтын ажлын талбай чөлөөлөх, иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлж буй өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, орчны аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн эзэмшлийн зам, талбайд зөвшөөрөлгүй байрлуулсан болон тохижилт бүтээн байгуулалтын талбай дахь түргэн үйлчилгээний цэгүүдийг нүүлгэж, | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нийтийн эзэмшлийн зам талбайн газар чөлөөлж 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар 100 хувийн хэрэгжилттэй ажилласан бөгөөд 70 сая төгрөгийн төсвийг зарцуулаад байна.<br>Мөн нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн хэмжээнд 24 байршлын 551 гарааш чөлөөлөхөөр төлөвлөгдсөнөөс 17 байршлын 314 гарааш, дүүргийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 5 байршлын 103 гараашийг тус тус чөлөөлж нийт 417 гараашийг буулгаж авто зогсоол болон тохижилтын ажлыг хийх боломжийг бүрдүүлж 292 сая төгрөгийн төсвийг зарцуулаад байна. | | | | | | |
| 249 | НХТЖҮЧ-9.1.1, 9.1.2, 9.1.3, НЗДҮАХ-6.1.1 ДЗДҮАХ-6.1.4 | Газар зохион байгуулалт, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэхэд шаардлагатай материал, судалгаагаар хангаж ажиллана. | Газар зохион байгуулалт, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэхэд шаардлагатай материал, судалгаагаар хангаж ажилласан. | Газар зохион байгуулалт гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан шаардлагатай мэдээллээр хангагдсан байна. | - | | ГЗБА НГЗБА, НХБХГ | 100% |
| | | Сүхбаатар дүүргийн Хуурай мухар, Бэлх зуслангийн бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол хийж байгаатай холбогдуулан 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр тус дүүргийн 19 дүгээр хорооны иргэний танхимд иргэдтэй нээлттэй хэлэлцүүлэг хийж гүйцэтгэгч Ланд овнер ХХК-аас хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотголын талаар мэдээ, мэдээлэл хийж иргэдээс ирүүлсэн асуултанд хариулан санал хүсэлтийг авч ажилласан. | | | | | | |
| 250 | ДЗДҮАХ-6.1.6 | Дүүргийн хэмжээнд байгаа Геодезийн цэг тэмдэгтийг тоолж бүртгэх нөхөн сэргээх устсан цэг тэмдэгтийг шилжүүлэн суулгах нарийвчилсан хэмжилт хийж бүртгэлжүүлэх ажлыг хийнэ. | 2020 онд дүүргийн хэмжээнд байгаа Геодезийн цэг тэмдэгтийг тоолж бүртгэх ажлыг гүйцэтгэж тайланг НГЗБА-нд хүргүүлсэн. | Геодезийн цэг тэмдэгтийг тоолж бүртгэх нөхөн сэргээх устсан цэг тэмдэгтийг шилжүүлэн суулгах нарийвчилсан хэмжилт хийж бүртгэлжүүлэх ажлыг хийж гүйцэтгэн тайлагнасан байна. | 7,500.00 | Дүүргийн төсөв | ГЗБА ДЗДТГ | 100% |
| | | Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хүрээнд тус дүүргийн Газар зохион байгуулалтын алба нь 2022 онд дүүргийн хэмжээнд ашиглагдаж байгаа Геодезийн цэг тэмдэгтийг тоолж бүртгэх ажлыг гүйцэтгэж холбогдох тайланг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлээд байна. | | | | | | |
| 251 | НЗДҮАХ-6.1.3. | Иргэн, хуулийн этгээдэд зориулсан газрын удирдлагын нэгдсэн цахим систем нэвтрүүлнэ. | Газрын удирдлагын нэгдсэн цахим систем нэвтрүүлэх бэлтгэлийг хангаж ажиллаж байна. | Газрын удирдлагын нэгдсэн цахим систем нэвтрүүлсэн байна. | - | | ГЗБА НГЗБА, ГЗБГЗЗГ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | www.egazar.gov.mn вэб сайт, гар утасны egazar аппликейшныг ашиглаж, цахимаар хэрхэн үйлчилгээ авах, газар ашиглах, эзэмших, гэрчилгээ цахимжсантай холбогдуулан иргэдэд мэдээ, мэдээлэл өгч ажиллалаа. Албаны Facebook хуудасны мэдээллийг шинэчилж албан хаагч нарын ажил, үүрэг, хариуцсан хороо, зуслангийн амны дэлгэрэнгүй мэдээллийг байршуулж, QR код уншуулан шууд холбогдох, мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн. | | | | | | |
| 252 | НЗДҮАХ-6.1.3. | Дүүргийн хаягийн мэдээллийн санг шинэчлэн Улсын хаягийн нэгдсэн системд бүрэн холбоно. | Дүүргийн хаягийн мэдээллийн санг шинэчлэн Улсын хаягийн нэгдсэн системд холбох бэлтгэл ажлыг бүрэн хангасан. | Улсын хаягийн нэгдсэн системд бүрэн холбогдсон байна. | - | | ГЗБА НГЗБА, ГЗБГЗЗГ | 100% |
| | | Монгол Улсын Засгийн газарын 2022 оын 180 дугаар тогтоолоор Хаягжуулалтын нэгдсэн системийг нийслэл, дүүргүүдийн хэмжээнд Газрын цахим системийн үйл ажиллагаанд бүрэн нэвтэрч Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газраас тэмдэгжүүлэлтийн ажил хийгдэж 100 хувийн хэрэгжилттэй ажиллаж байна. | | | | | | |
| 253 | ДЗДҮАХ-6.1.5 | Гэр хорооллыг дахин төлөвлөлтийн бүтээн байгуулалтын ажлыг иргэд, олон нийтэд мэдээлнэ. | Дүүргийн 14 дүгээр хороонд Сэлбэ дэд төв, 17 дугаар хороонд Дамбадаржаа дэд төв баригдаж байна. Дүүргийн 9, 11, 12, 15 дугаар хороонд гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжиж байгаа. | Иргэдийг мэдээллээр хангасан байна. | 8,000.00 | Дүүргийн төсөв | ТГХШХ | 100% |
| | | Монгол улсын засгийн газар, Азийн хөгжлийн банк болон Европын хөрөнгө оруулалтын банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа Сэлбэ дэд төв, Дамбадаржаа дэд төвийн ажлын явцын мэдээллүүдийг сар тутамд хороодын ажлын албаар дамжуулан иргэдэд мэдээллэн ажиллаж байна. Сэлбэ дэд төвийн хүрээнд авто зам 6.8км, 2ш гүүр, ус дулаан хувиарлах төв 15ш, дулааны шугам 9.97км, цэвэр усны шугам 9.34км, бохир усны шугам 14.9км, хөрсний ус доошлуулах шугам 4.1км, тохижилт 3га газарт хийгдсэн. Сэлбэ дэд төвийн төслийн хэрэгжилт 100% -тай.<br>Дамбадаржаа дэд төвийн зураг, төслийн ажил 100%, газар чөлөөлтийн ажлын явц 86.3%, Худалдан авах ажиллагааны явц 26.3%, Барилга угсралтын ажил 0.25%-тай хэрэгжиж байна.<br>Дүүргийн 18 дугаар хороонд Бичил дэд төвийн бүтээн байгуулалтын ажлыг “Эй Жи Зэт” ХХК гүйцэтгэж байна. Ажлын явцын мэдээг хороодын ажлын албаар дамжуулан иргэдэд мэдээлэлж ажиллаж байна. Бичил дэд төвийн төслийн хэрэгжилт 83% -тай.<br>Бичил дэд төвийн барилга: 25х18х7,8 м хэмжээтэй 2 давхар барилга.<br>Гадна цэвэр ус: Ф150мм-ийн голчтой Цайрдсан ган хоолой 2500 метр.<br>Гадна бохир ус: Нийт ажлын тоо хэмжээ 5900 метр.<br>10кВ-н ЦДШ Гадна цахилгаан угсралтын ажил: Нийт ажлын тоо хэмжээ 10кВ -н агаарын шугамын ажил нийт трассын урт 1600 метр. 10кВ-н кабель шугамын ажил 2700 метр.<br>0.4кВт-н ЦДШугам: Нийт ажлын тоо хэмжээ 5200 метр. Барилга нь 2х630 КВА хаалттай дэд өртөө угсрах ажил: 2 ширхэг ХТП угсрах | | | | | | |

| | | |
|---|---|---|
| | | Гадна холбооны ажил: Нийт ажлын тоо хэмжээ. 800 метр газарт суваг угсралт. Холбооны 24 core маркын шилэн кабель 1600 метр татах. Агаарын шилэн кабель татах нийт 4500 метр.<br>Халаалтын зуухны дулаан механик: 0,7MW чадалтай ус халаагч зуух 1 ширхэг 0,35MW чадалтай ус халаагч зуух 2 ширхэг угсрах. Ялтсан дулаан солилцуур бүхий иж бүрдэл дулааны зангилаа угсралт /1200кВт/.<br>Цэвэр усны нөөцийн сав 72 тн, Энгийн галын болон Ахуйн усны насосны зангилгаа.<br>Нүүрсний агуулахын барилга: 6х6х3,6м хэмжээтэй 1 давхар. |

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА — Х.БОЛОРМАА

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА — Н.ЭНХБОЛД

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА — В.ГОМБОДОРЖ

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — М.ОЧМАА